Ийм нөхцөл байдалд 2016 оны 6 сард бүх нийтийн сонгууль болж, МАН-ын байгуулсан шинэ Засгийн газар 2017 онд ОУВС-аас дэмжлэг хүсч, албан ёсны хүсэлт гаргасан. 2017 оны 5 сард ОУВС-гийн Захирлуудын зөвлөл МУ-ын Засгийн газрын хүсэлтийг хэлэлцэж, 430 сая долларын санхүүжилт (SDR)⁹ бүхий 3 жилийн хугацаатай Өргөтгөсөн санхүүжилтын хөтөлбөрт хамруулахаар шийдвэрлэсэн. Мөн Дэлхийн банк (цаашид “ДБ” гэх), АХБ зэрэг дэмжигч байгууллага болон Хятад, Япон, Солонгос зэрэг донор орнууд нийт 5.5 тэрбум ам долларын тусламж үзүүлсэн. Эдгээр тусламжийн хөрөнгөөр гадаад өрөө төлж, олон улсын хэмжээнд Монголд итгэх итгэлийг сэргээх боломжтой болсон.

Үүний дараа дэлхийн зах зээл дээр уул уурхайн түүхий эдийн үнэ дахин өссөн нь МУ-ын эдийн засагт эерэг нөлөөлж, төсвийн болон төлбөрийн тэнцэл сайжирч эхэлсэн. ДНБ-ий бодит өсөлт 2017 онд + 5.3%, 2018 онд + 7.2% болж сэргэсэн. (2-8 хүснэгтийг харна уу).

2019 оны 4 сард АХБ 2019 оны ДНБ-ий өсөлтийг өмнөх онтой харьцуулахад 6.7%, 2020 онд 6.3% өснө гэж таамаглаж байсан боловч 2019 онд эдийн засгийн өсөлт 5.2% байв. 2020 оны 1-6 сарын бодит ДНБ-ий өсөлт өмнөх оны мөн үеэс хасах 9.7% болж, өмнөх оны мөн үеэс (7.8%) 17.5 нэгжээр буурсан. Иймд ҮСХ 2020 оны эдийн засгийн өсөлтийг хасах 5.4% гэж зарласан. Эдийн засгийн өсөлт хасах дүнтэй гарсан нь уул уурхайн салбар болон үйлчилгээний салбарын өсөлт буурсантай холбоотой гэж дүгнэсэн¹⁰.

Хүснэгт 2-8: Инфляци, ажилгүйдэл, ядуурлын түвшин (%)

Он	2016	2017	2018	2019	2020
ДНБ-ий өсөлт	1.2	5.3	7.2	5.2	-5.4
Инфляцийн түвшин	1.3	6.4	8.1	5.2	2.3
Ажилгүйдлийн түвшин	10	8.8	7.8	10	9.9
Ядуу хүн амын эзлэх хувь	29.6	-	28.4	-	-

Эх сурвалж: ҮСХ, Монгол, 2021

⑤ ДНБ -ий өсөлт ба ажилгүйдлийн түвшний өөрчлөлт

⁸ Үмэхара Наоки (2019) "МУ-ын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал-ОУВС-гийн хөтөлбөрийн хугацаа дуусахаас болон УИХ-ын сонгууль болохоос нэг жилийн өмнө-", Олон улсын валютын хүрээлэн (ИМА), 4-6 хуудас.

⁹ Special Drawing Rights/SDR буюу зээлжих тусгай эрх гэдэг нь гишүүн орнуудын хөрөнгийн нөөцөд зузаатгал арга хэрэгсэл бөгөөд ОУВС нь 1969 онд бий болгосон олон улсын нөөц хөрөнгө юм. <https://www.imf.org/ja/About/Factsheets/Sheets/2016/08/01/14/51/Special-Drawing-Right-SDR> (мэдээлэл авсан огноо: 2021-5-26)

¹⁰ ЯГХБ (2020), МУ-ын эдийн засгийн тойм (2020 оны 9 сар), PPT материалын 9 дүгээр слайд. https://www.jetro.go.jp/ext_images/_Reports/01/42b17b571a6a457b/20200008.pdf (мэдээлэл авсан огноо: 2021-5-26).


Сүүлийн 10 жилийн хугацаанд ажилгүйдлийн түвшин 7-10 хувьтай байв¹¹. Өнгөрсөн хугацаанд эдийн засгийн жилийн өсөлт хасах 1.3%-аас нэмэх 17.3% болж их хэлбэлзэж ирсэн (зураг 2-5). Эдийн засаг 2020 оны 3 дугаар улиралд сэргэх шинж тэмдэг илэрсэн боловч төлөвлөснөөс доогуур байна.

Барилга, үйлдвэр, гадаад худалдаа, тээвэр, уул уурхайн салбарын сэргэлт удаашралтай байгаа нь коронавируст халдварын дэгдэлтийн сөрөг нөлөө, улсын төсвийн хөрөнгө оруулалтын зарцуулалт хангалтгүй байгаатай холбоотой. Улмаар 2020 оны 11 сард коронавируст халдварын эсрэг төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь уул уурхай, хөдөө аж ахуй, харилцаа холбооноос бусад эдийн засгийн салбарт нөлөөлж, 2020 оны 4 дүгээр улиралд эдийн засгийн байдал хүндэрсэн. Цаашид эдийн засгийн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөх нь коронавируст халдварын тархалт хэр удаан үргэлжлэхээс ихээхэн хамаарна.

Мөн МУ-ын хувьд, ДНБ-ий өсөлт нь ажилгүйдлийн түвшнийг бууруулах хангалттай уялдаатай биш байгааг анхаарах шаардлагатай. ДНБ-д уул уурхайн салбар голлох байр суурийг эзлэх боловч, уул уурхайн нөлөөгөөр эдийн засагт өсөлт бий болох нь хөдөлмөр эрхлэлтийг их хэмжээгээр нэмэгдэхэд нөлөөлөхгүй. Хүснэгт 2-6-д тусгасан үйлдвэрлэлийн салбар тус бүрийн ажиллагчдын тоог харахад, 2020 оны 4 дүгээр улиралд, уул уурхайн салбарт ажиллагчдын тоо нийт ажиллагчдын 3.9% байна. Уул уурхай нь нийт ажилгүйдлийн түвшинг бууруулах гол салбар болж чадахгүй юм.

⑥ Макро эдийн засаг (тойм)

2020 онд банкны төгрөгийн хугацаатай хадгаламжийн хүү 10.7-12.7%¹²-тай байв. 10 орчим жилийн өмнө 2012 онд гадаад валютаар Засгийн газрын бондыг арилжаалж, эрсдэл багатай гэж тооцоолж байв. Валютын ханшны хэлбэлзлээс шалтгаалан доллараар гаргасан МУ-ын Засгийн газрын бондын үнэ мэдэгдэхүйц буурсан ч, тухайн үед АНУ-ын тоон зөөлрүүлэх бодлогын хүү



¹¹ Ажилгүйдлийн түвшин гэдэг нь ажилгүй иргэдийн тоог эдийн засгийн идэвхитэй хүн амьд харьцуулж гаргасан үзүүлэлт. Монголд ажилгүйдлийн түвшинг, ажиллах хүчний судалгаа (Labor Force Survey) -гаар тодорхой болсон ажилгүй иргэдийн тоонд үндэслэлэж гаргадаг. Ажилгүй иргэн гэдэг нь судалгааны өмнөх долоо хоногт ажил эрхлээгүй байсан хэдий ч ажил хайж байгаа мөн ажил хийх бэлтгэл хангагдсан ахмад настай хүн амыг хэлдэг. ҮСХ нь 2002 оноос хойш жил бүрийн 4-р улиралд ажиллах хүчний судалгаа явуулж байна. 2019 оноос ажиллах хүчний судалгааны загвар шинэчлэгдсэн ба жилд нийт 13,280 өрх (улиралд 3,320 өрх) энэ судалгаанд хамрагдаж байна.

¹² Монголбанкны мэдээлэлд тулгуурлав (судалгааны багийн хийсэн судалгаа).

бараг тэг байсан тул дэлхийн хөрөнгө оруулагчдын сонирхолыг татаж, нэлээд зарагдсан¹³. Долларын бонд гаргах тохиолдолд Засгийн газарт ачаалал үүсэх тохиолдол бий. Тухайлбал бонд эргэн төлөгдөх үед валютын ханш нь бонд гарах үетэй харьцуулахад унасан тохиолдолд Засгийн газар бондын суурь хүүн дээр нэмж нөхөн олговор төлөх шаардлагатай болдог¹⁴. 2020 оны гадаад валютын нөөцийг 2-9 хүснэгтэнд тусгав. 2020 оны сүүлээр гадаад валютын нөөц өмнөх оноос 185 сая 600 мянган ам.доллараар нэмэгдэж, 4 тэрбум 534 сая 200 мянган ам долларт хүрсэн.

МУ-ын экспортын гол бүтээгдэхүүний (алт, зэс) олон улсын зах зээлийн үнийн өсөлт, коронавирусын халдварт өвчнөөс шалтгаалан эдийн засгийн үйл ажиллагаа удааширч, импорт буурсан нь гадаад худалдааны тэнцэл болон валютын нөөц сайжрах нөхцөл болсон.

Хүснэгт 2-9: Гадаад валютын нөөц

Он/сар	2016/12 сар	2017/12 сар	2018/12 сар	2019/12 сар	2020/12 сар
Нөөц (доллар)	1,296.3	3,008.1	3,549.1	4,348.6	4,534.2

Эх сурвалж: Mongolbank of Mongolia, 2021. www.mongolbank.mn (Unit: million USD)

Сүүлийн 4 жилийн чиг хандлагыг авч үзвэл инфляцийн түвшин бага 2.3%-тай байна. Тухайлбал 2017 онд 6.4%, 2018 онд 8.1%, 2019 онд 5.2%, 2020 онд 2.3%-тай байв. Банкны одоогийн бодит хүүгийн түвшин хэвээр байвал банкууд дахь мөнгөн хадгаламжийн үнэ цэнэ хэвээр байна гэсэн найдвар төрүүлж байна.

2020 оны 12 сарын байдлаар жилийн инфляцийн түвшин улсын хэмжээнд 2.3%, Улаанбаатар хотод 1.9% байв. Коронавируст халдварт өвчний дэгдэлтээс болж дотоодын зах зээлийн эрэлт хэрэгцээ хумигдан, эрэлтэд суурилсан инфляцид сөрөг нөлөөлөх төлөвтэй байна. Монгол банкны мэдэгдлээс үзвэл нийлүүлэлтийн хүчин зүйлээс шалтгаалан үнийн огцом хэлбэлзэл гарахгүй бол инфляци бага хэвээр байх бөгөөд аажмаар өснө. Монгол банк 2021 онд инфляцийн түвшинг 6 хувьд барина гэж төлөвлөж байна.

Төлбөрийн тэнцэл 2020 оны 3 дугаар улиралд 207 сая ам.долларын ашигтай (ДНБ-ий 1.6%) гарч, өмнөх оноос 398 сая 400 мянган ам.доллараар өссөн. Үүнд экспорт сэргэж, импорт хумигдан, орлогын дансны алдагдал багасч, урсгал тэнцэл 148 сая 700 мянган ам долларын ашигтай гарсан нь нөлөөлсөн.

2020 онд худалдааны тэнцэл 2019 онтой харьцуулахад 53%-аар өссөн (хүснэгт 2-10). Экспортын бараа бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 0.5%, импортын бараа бүтээгдэхүүний үнэ 13 хувиар тус бүр буурсан. Зэсийн болон төмрийн хүдрийн үнэ өссөн нь 2020 оны 4 дүгээр улирлын гадаад худалдаанд эерэг нөлөөлсөн.

Хүснэгт 2-10: Гадаад худалдааны тэнцэл

Он	2016	2017	2018	2019	2020
Гадаад худалдааны тэнцэл	1,558.2	1,863.3	1,136.7	1,492.3	2,282.4

Эх сурвалж: YCX, Монгол, 2021 (Unit: USD millions)

¹³ ЖАЙКА (2015) Монгол Улсын тэтгэврийн тогтолцооны талаар мэдээлэл цуглуулах судалгаа, 3-4 хуудас.

¹⁴ Дээр дурдсан материал (2015), 3-4 хуудас.

2-11 хүснэгтэнд тусгасанчлан МУ-ын мөнгөн тэмдэгт (төгрөг)-ийн ам.доллартай харьцах ханш 2016 оноос хойш суларсаар ирсэн. 2020 оны эхээр төгрөгийн ам.доллартай харьцах ханш буурсан хэдий ч 10 сарын дунд үеэс өсч, 12 сарын сүүлээр 2,849.5 төгрөгт хүрсэн.

Мөн гадаад валютын цэвэр урсгал 2020 оны эхний 10 сар хасах байсан бол 11 сард 134 сая 400 мянган ам.доллараар өсч, төгрөгийн ханш сулрах дарамт багассан. Төгрөгийн болон гадаад валютын хадгаламжийн хүүгийн зөрүү харьцангуй тогтвортой байна. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш өссөн нь төгрөгийн харьцангуй өгөөжийг нэмэгдүүлж байна.

Хүснэгт 2-11: Төгрөг ба долларын ханш (MNT-USD)

Он	2016	2017	2018	2019	2020 (expected)
1 USD = MNT	2,147.74	2,440.63	2,472.67	2,663.94	2,849.5

Эх сурвалж: YCX, Монгол, 2021

⑦ Засгийн газрын санхүүгийн байдал

Төсвийн тэнцэл 2018 оныг үл тооцвол алдагдалтай хэвээр байна.

Хүснэгт 2-12: Монгол улсын засгийн газрын төсвийн тэнцэл ба ДНБ-д эзлэх хувь

Он	2016	2017	2018	2019	2020
Орлого	5,835,043.80	7,274,861.60	9,225,947.40	10,801,620.80	9,421,647.2
Зарлага	9,495,332.90	9,017,318.60	9,222,928.50	11,426,391.60	13,960,787.5
ДНБ	23,942,866.40	27,876,297.20	32,411,224.10	37,280,841.40	36,958,550.1
Санхүүгийн тэнцэл	-3,660,289.10	-1,742,456.90	3,019.00	-627,770.70	-4,539,140.3
ДНБ-д эзлэх алдагдлын хувь(%)	-15.29%	-6.25%	0.01%	-1.68%	-12.3%

Эх сурвалж: YCX, Монгол, 2021 (Unit: USD millions)

Төсвийн алдагдлын ДНБ-тай харьцуулсан харьцаа 2016 онд 15.29%, 2017 онд 6.25% байв. 2018 онд 0.01%-ийн ашигтай гарсан бол 2019 онд дахин 1.68% болж алдагдалд орсон. 2020 онд коронавируст халдварын эсрэг арга хэмжээний хүрээнд зарим аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг хөнгөлөх, импортын болон гаалийн албан татварыг хөнгөлөх арга хэмжээ авсантай уялдан төсвийн орлого буурсан. Ижил хугацааны төсвийн зарлага нь 2016 оноос хойших 5 жилийн хугацаанд хамгийн дээд хэмжээнд хүрч, төсөв алдагдалтай гарсан.

2-2 Нийгмийн хамгааллын тогтолцооны өнөөгийн байдал

2-3-1 Нийгмийн хамгааллын тогтолцооны тойм (холбогдох хууль тогтоомж)

Нийгмийн хамгаалал нь хувь хүнд тулгарах эрсдэл, өвчин, осол гэмтэл, төрөлт, хөгжлийн бэрхшээл, нас баралт, насжилт, ажилгүйдэл зэрэгтэй холбоотой асуудал, ядуурлаас урьдчилан сэргийлж, ядуу иргэдэд дэмжлэг үзүүлж, тэдний амьдралыг тогтворжуулж, орлогыг нь баталгаажуулан, эрүүл мэнд, асрамжийн тусламж үйлчилгээ зэрэг нийгмийн тусламж үйлчилгээг

хүргэх тогтолцоо юм¹⁵. Японд "Нийгмийн хамгаалал гэдэг нь иргэдийн амьжиргааны тогтвортой байдал алдагдсан үед тэдний эрүүл, аюулгүй амьдралыг баталгаажуулахын тулд төрөөс амьжиргааг дэмжих тэтгэмж олгохыг хэлнэ"¹⁶ гэж сүүлийн үед тодорхойлох болсон.

Нийгмийн хамгааллын тогтолцоо нь ерөнхийдөө 4 давхаргаас бүрддэг. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих "нийгмийн халамж", дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэний наад захын хэрэгцээг нь хангахад чиглэсэн "улсаас олгох тэтгэвэр, тэтгэмж", тэтгэвэрт голлож суурилсан "нийгмийн даатгал", иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн орчноор хангахад чиглэсэн "эрүүл мэнд, нийтийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ"-нээс бүрддэг.

1990 оноос хойш олон удаа холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн одоогийн нийгмийн халамж, улсаас олгох тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгалын тогтолцоо бүрэлдсэн (2-13 хүснэгт). 2021 онд Нийгмийн халамжийн тухай хуулийг шинэчлэхээр төлөвлөж байгаа тул нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээ сайжирна гэсэн хүлээлттэй байна.

Монголд эрэгтэйчүүд 60 нас, эмэгтэйчүүд 55 нас хүрээд, нийгмийн даатгалын өндөр насны тэтгэвэрт хамрагдах шалгуур хангаж байвал өндөр насны тэтгэвэр авдаг. Нийгмийн даатгалын шалгуур хангаагүй хүн төрөл бүрийн халамжийн үйлчилгээгээр дамжуулан тэтгэмж тэтгэвэр авдаг.

Хүснэгт 2-13: МУ-ын нийгмийн хамгаалал, халамжийн холбогдох хуулийн жагсаалт

1. Хүн амын бүлгүүдийн эрхийг хангах хуулиуд	
Гэр бүлийн тухай хууль(Family Law)	1999
Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль(Law on Gender Equality)	2011
Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль(Law on the Rights of Disabled Person)	2016
Хүүхдийн эрхийн тухай хууль(Law on Child Right)	2016
Хүүхэд хамгааллын тухай хууль(Law on Child Protection)	2016
Ахмад настны тухай хууль(Law on Senior Citizen)	2017
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (Law on Combating Domestic Violence)	2016
Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль(National Human Rights Commission of Mongolia Act)	2020
2. Нийгмийн халамжийн багц хууль	
Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль (Law on Rewarding Mothers who Raised Many Children)	2011
Нийгмийн халамжийн тухай хууль (Social Welfare Law)	2012
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх эцэгт тэтгэмж олгох тухай хууль (Law on Providing Benefits to Mothers or Single parent with many children)	2017
Алдар цолтон, ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хууль (Law on Allowances and Concessions for Honorary (Merit) Senior Citizens)	2017
3. Нийгмийн даатгалын багц хууль	
Нийгмийн даатгалын тухай хууль (Law of Mongolia on Social Insurance)	1994
Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль (Law on Pensions and Benefits Provided by the Social Insurance Fund)	1994
Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль (Law on Unemployment Benefits Paid by the Social Insurance Fund)	1994
Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний	1994

¹⁵ ILO (2017) "World Social Protection Report 2017-19: Universal social protection to achieve the Sustainable Development Goals". Geneva: International Labour Organization, https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---dgreports/---dcomm/---publ/documents/publication/wcms_604882.pdf (мэдээлэл авсан огноо: 2021-5-23).

¹⁶ Нийгмийн хамгааллын тогтолцоог хэлэлцэх зөвлөл (1993), Нийгмийн хамгааллын алсын харааг тодорхойлох хорооны анхдугаар тайлан, 7 хуудас. <http://www.ipss.go.jp/publication/j/shiryu/no.13/data/shiryu/syakaifukushi/458.pdf> (мэдээлэл авсан огноо: 2021-5-26).

тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль (Law on Benefits Provided by the Social Insurance Fund against Employment Injury and Occupational Diseases)	
Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль Law on Pensions and Benefits for Military service personals (*Цэргийн албан хаагч нь нийгмийн даатгал төлдөггүй ба тэдний тэтгэврийг улсын төсвөөс санхүүжүүлдэг)	1994
Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль (Law on Personal Account for Pensions Insurance Premium)	1999
Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл байгуулах тухай УИХ-ын тогтоол (Resolution of the Parliament Establishing the National Social Insurance Council)	2012-10-24, 2015, 2016, 2021 онд шинэчилсэн
Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (Law on Health Insurance)	2015
4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний болон нийгмийн хамгааллын холбогдох хууль тогтоомж	
Монгол улсын үндсэн хууль (Constitution of Mongolia)	1992
Хоршооны тухай хууль (Cooperative Law of Mongolia)	1998
Иргэний хууль (Civil Code of Mongolia)	2002
Боловсролын тухай хууль (Law on Primary and Secondary Education)	2002
Дээд боловсролын тухай хууль (Law on Higher Education)	2002
(Law of Mongolia on Medicines and Medical Devices)	2010
Аж ахуйн нэгжийн тухай хууль (Company Law of Mongolia)	2011
Эрүүл мэндийн тухай хууль (Health Law)	2011
Эрүүгийн хууль (Criminal Code of Mongolia)	2015
Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль (Law on Medical Care Services)	2016
5. Хөдөлмөр эрхлэлт/хөдөлмөрийн харилцааны хууль	
Хөдөлмөрийн тухай хууль (Labor Law of Mongolia)	1999
Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль (Law of Mongolia on Sending Workers Abroad and Receiving Workers and Specialists from Abroad)	2001
Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль (Law on Vocational Training and Education)	2002
Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль (Minimum Wages Law)	2008
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (Law on Occupational Safety and Health)	2008
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (Employment Promotion Law)	2011
Төрийн албаны тухай хууль (Public Service Act)	2020

Эх сурвалж: Судалгааны баг судлав.(2021 оны 4 сар)

Хүснэгт 2-14: Эмзэг бүлгийн одоогийн нөхцөл байдлын тойм¹⁷

Асуудал	Ядуурлын бодит байдал
Ажил хийх ур чадвар хангалтгүй	Ядуу 5 хүн тутмын 3 орчим нь ажилд орсон боловч ихэнх нь ур чадвар бараг шаардахгүй, цалин багатай үйлчилгээний ажил байсан. Мөн ижил ядуу, ажил эрхэлж байгаа хүмүүсээс 30-с дээш хувь нь анхан шатны ур чадвар шаардагдах ажил хөдөлмөр эрхэлж байгаа ба 40% нь гар урлал, худалдаа, үйлчилгээний салбарт ажиллаж байна.
Аж ахуйн нэгж, байгууллагын ажилчдын цалингийн ялгаа	Аж ахуйн нэгж, байгууллагад ажил эрхэлж байгаа иргэдээс, ядуу иргэдийн жилийн дундаж орлого 3,755,000 төгрөг, ядуу биш иргэдийн жилийн дундаж орлого 8,781,000 төгрөг байна.
Ажилгүй хүн ам ба эдийн засгийн идэвхигүй хүн амын ядуурлын хувь өндөр	Хөдөлмөрийн насны хүн амын (15 наснаас дээш) дотор ажилгүй хүн ам ба эдийн засгийн идэвхигүй хүн амын ядуурлын хувь тус бүр 40%, 34% байна. Үүнтэй харьцуулахад, аж ахуйн нэгж, байгууллагад ажилладаг иргэдийн 21%, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн зөвхөн 17 % нь ядуу амьдарч байна. Ажилгүй, эдийн засгийн идэвхигүй байна гэдэг нь хөдөлмөр эрхэлж орлого олдоггүй гэсэн үг ба хэрэглээ буурч, ядуурал дунд байх магадлал өндөр болно.
Боловсролын түвшний ялгаа	25-аас дээш насны хүн амын дунд, ядуу биш 10 иргэний 5 нь дээд боловсрол эзэмшсэн, эсвэл түүнтэй ижил түвшний боловсролтой, нөгөөтэйгүүр ядуу иргэдийн хувьд 10 хүний 1 нь дээд сургуулийн түвшний боловсрол эзэмшсэн байна.
Залуу ажиллах хүчний жендерийн тэгш бус байдал	25-29 насны залуучуудын дотор, эрэгтэйчүүдийн 58% нь дээд боловсрол, эсвэл мэргэжлийн боловсрол эзэмшсэн байгаа бол эмэгтэйчүүдийн 70% нь дээд боловсрол, мэргэжлийн боловсрол эзэмшсэн байна. Гэсэн хэдий ч ажиллах хүчний оролцооны түвшингээр авч үзвэл эрэгтэйчүүд 72% байгаа бол эмэгтэйчүүд 54%-тай байна.
Гар утас ба интернетийн хүртээмжийн ялгаа	Ядуу иргэд, хөдөөний иргэдийн дунд гар утасны хэрэглээ сайжирч байна. Гэвч интернетийн хэрэглээ, хүртээмж ядуу иргэдэд 25% байгаа бол ядуу биш иргэдийн интернетийн хэрэглээ 64%-д хүрээд байна.
Зээлийн хэрэглээний ялгаа	Ядуу биш иргэдийн 21% нь орон сууцны зээл авсан байгаа бол ядуу иргэдийн дөнгөж 3% нь орон сууцны зээлэнд хамрагдсан байна. Ядуу биш иргэд орон сууц, автомашин зэрэг хөрөнгө худалдан авахын тулд зээл авдаг бол явуу иргэд өрхийн хэрэглээндээ зориулж зээл авах хандлагатай байдаг. Мөн ядуу биш өрхийн ашигласан зээлийн дундаж хэмжээ ядуу өрхөөс 3 дахин өндөр байна.
Дэд бүтцийн суурь үйлчилгээ хүртэх боломжгүй	Гэр хорооллын оршин суугчдын дунд үндсэн үйлчилгээний хүртээмж ялгаатай хэвээр байна. Ядуу иргэний долоо нь дэд бүтцийн суурь үйлчилгээ (ундны ус, ариун цэврийн байгууламж, халаалт) -г авч чаддаггүй байсан. Ядуу иргэдийн (алслагдсан хөдөө орон нутаг эсвэл хотын гэр хороолол) орон гэр, байршлаас хамаарч энэхүү хүртээмжгүй байдал их ажиглагдах хандлагатай байна.
Хүүхдийн ядуурлын түвшин өндөр	Ядуу давхаргын 5 хүний 2 нь 15 нас хүрээгүй хүүхэд. Ядуурал нь хүүхдийн тоо ба тэжээгчдийн хувьтай нягт хамааралтай байна. Олон хүүхэдтэй өрхийн хувьд тэдгээр хүүхдүүд нь өндөр настнуудаас ч ядуу байх магадлал өндөр байна.

2-14 хүснэгтэнд ядуу иргэдэд тулгарч буй асуудлыг тусгав. Эдгээр асуудлаас ядууралд өртөх болсон зарим нөхцөл байдлыг харж болно. Ялангуяа ядуу, эмзэг бүлгийн иргэд хөдөлмөрт бэлтгэх,

¹⁷ ДБ ба ҮСХ (2020) “МУ-ынядуурлын дүр төрх” 2018 оны тайланд үндэслэв, хуудас 13-15в

хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэмжлэг авсан ч, хангалттай ур чадваргүйгээс болж ажилд орж чадахгүй, эсвэл бага цалинтай ажил эрхлэх хандлагатайгаас үүдэн, эцэст нь амьжиргаагаа даахад хүндрэлтэй болж, ядуурлаас гарч чадахгүйд хүргэж, ядуурлын тойрогт өртдөг гэж үзэхэд хүргэж байна.

Тухайн өрхөд асаргаа шаардлагатай хүн байвал гэр бүлийн хүрээнд өөрсдөө асрах нь түгээмэл байдаг. Иймд эмэгтэйчүүд ихэвчлэн гэр бүлээ асарч, байнгын ажил эрхэлж чаддаггүй асуудал байна¹⁸. Халамжийн тэтгэмж олгохтой холбоотой асуудал, нийгэм, соёлын орчноос үүсэлтэй жендэрийн асуудал нь ядуурлыг өдөөх хүчин зүйлийн нэг гэж үзэж болно.

2-4-2 Нийгмийн халамжийн тухай хуулинд заасан ядуу, эмзэг бүлгийн тодорхойлолт

Ядуу, эмзэг бүлгийн иргэнийг тодорхойлоход Нийгмийн халамжийн тухай хуулийн (2012) “Нийгмийн халамж”-ийн тодорхойлолт чухал баримт болдог. Уг хуулийн 3 дугаар зүйлд “Нийгмийн халамж” гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг.

Нийгмийн халамжийн тухай хуулиар ядуу, эмзэг бүлгийн иргэдээс хамрагдагчийг тодорхойлж, тэдний амьжиргаа, нийгмийн халамжийг дээшлүүлэх дэмжлэг туслалцааг үзүүлдэг. Нөгөөтэйгүүр эдгээр хүмүүсийг нийгэмд сайтар хамруулж чаддаггүй (нийгмээс ялгаварлан гадуурхах) асуудал ч гардаг.

Нийгмийн гадуурхалын хүчин зүйлийг соёл, түүхээс гадна эдийн засгийн бүтцийн нөлөө талаас судлах боломжтой. МУ-ын хувьд нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэж буй арга барил нь нийгмийн гадуурхал үүсэхэд нөлөөлдөг гэж үзэж болно. Дээр дурдсанчлан Монголд нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэхдээ тэтгэмжийг давхардуулж, ядуу биш иргэнийг ч хамруулах зэргээр нийгмийн халамжийн бага хэмжээтэй нөөцийг үр дүнтэй, өгөөжтэй ашиглаж чадахгүй байна.

Хүснэгт 2-15: Нийгмийн халамжийн тухай хуулийн 3-р зүйлд заасан дэмжлэг туслалцаанд хамрагдагч ба түүний тодорхойлолт

Зүйл заалт	Дэмжлэг туслалцаанд хамрагдагч (Тоо нь хуулийн зүйл заалт)	Тодорхойлолт
3.1.2	Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй	Амьжиргааны түвшин нь ядуурлын шугамаас доогуур, ҮСХ болон төрийн захиргааны төв байгууллагын хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон өрхөөс сонгогдсон иргэн

¹⁸ Ц.Цэрэнлхам (2019), Нийгмийн халамжийн зорилтот бүлгийн ажил эрхлэлтийн байдал, (АХБ L3086-MON-ы хүрээнд боловсруулав: “Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний нэмэлт санхүүжилт” Төслийн зөвлөх үйлчилгээ (2021 оны 5 сар, Төслийн багийн олж авсан мэдээллээс)

	шаардлагатай гэр бүлийн гишүүн-иргэн	
3.1.3	Хүнд нөхцөлд байгаа хүүхэд	Тухайн нөхцөл байдлаасаа шалтгаалан өнчин өсөх, туйлын ядуу амьдрах, үл ойшоогдох, биеэ үнэлэх, хүчирхийлэл дарамт амсах зэргээр сэтгэлзүй, бие махбодиороо золиос болсон хүүхэд
3.1.4	Ахмад настан	Монгол улсын иргэн бөгөөд 60-аас дээш насны эрэгтэй, 55-аас дээш насны эмэгтэй
3.1.5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн	Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогын улмаас бусдын адил нийгмийн амьдралд оролцох чадвар нь 12 сараас дээш бүрэн хязгаарлагдсан хүн
3.1.6	Байнгын асаргаа шаардлагатай иргэн	Бие дааж, мөн бусдын туслалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй, эсхүл оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүн
3.1.7	Бүтэн өнчин хүүхэд	18 нас хүрээгүй хүүхэд бөгөөд эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл хоёул нас барсан, сураггүй алга болсон, эсхүл эрх зүйн чадамжгүй, мөн эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан этгээд (шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд), түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, мөн асрамждаа авсан эх /эцэг/ нь нас барсан хүүхэд
3.1.8	Өрх толгойлсон эх, эцэг	Ганц бие эх/эцгийг хэлнэ. Төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй нь шүүхээр тогтоогдоогүй эсхүл хүүхэд нь гэрлэсэн, мөн нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсхүл сураггүй алга болсон, эсхүл эрх зүйн чадамжгүй, эсхүл эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан (шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд) этгээд

Эх сурвалж: МУ-ын Нийгмийн халамжийн тухай хууль (2012) 3-р зүйл

2-15 хүснэгтэнд дурдсанчлан Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан “Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн”-д анхаардаг. Гэхдээ хүнсний дэмжлэг авахын тулд тухайн өрх нь ӨМНС-д бүртгэгдсэн байх ёстой.

Өрхийн ядуурлын байдлыг тодорхойлохын тулд орлогыг орлуулан тооцох арга (цаашид “ООТА” гэх) ашиглан судалгаа хийдэг. Гэхдээ уг судалгаагаар тухайн гэр бүлд тулгарч буй асуудлуудыг бүрэн тодорхойлж чаддаггүй тул зайлшгүй шаардлагатай хүнд тусламж хүрдэггүй.

2-5 Нийгмийн хамгааллын салбарт бусад хөгжлийн түнш орнуудаас үзүүлж буй тусламж дэмжлэгийн нөхцөл байдал

Монголд донор орнууд дэмжлэг үзүүлсээр ирсэн. АХБ, ДБ, ОУХБ, Олон улсын хэмжээний ТББ, Швейцар, Солонгос зэрэг улсын хамтын ажиллагааны талаар хавсралт материал 1-д тусгав. 2-16 хүснэгтэнд донор орнуудын санхүүжилтээр ХНХЯ болон бусад холбогдох байгууллагууд хэрэгжүүлж буй нийгмийн хамгааллын салбарын төслийг нэгтгэж бичив. Гол донор байгууллагаар АХБ, ДБ-ыг нэрлэж болно. АХБ 1995 оноос өнөөг хүртэл МУ-ын нийгмийн хамгааллын салбарт хамтран ажилласаар ирсэн.

Хүснэгт 2-16: Гол донор байгууллагуудаас үзүүлж буй тусламж

Тусламжийн нэр/хугацаа	Тусламжийн гол агуулга	Мөнгөн дүн
Азийн хөгжлийн банк (АХБ)		
Үр дүнтэй нийгмийн халамжийн системийн чадавхи бэхжүүлэх төсөл (2020—2022)	Нийгмийн ажилтан ба нийгмийн хамгааллын бодлого хариуцсан ажилтнуудын чадавхийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. Ялангуяа олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх, мониторинг хийх, улмаар бодлогын чанартай яриа хэлэлцээ, өмгөөлөл хийх чадавхийг бэхжүүлэх зорилготой. Төслийн мөнгөн дүн нь 600,000 ам доллар ба АХБ-ны зээлээр хэрэгжиж буй төслүүдтэй харьцуулахад хөрөнгийн хэмжээ бага.	Буцалтгүй тусламж 600,000 ам.доллар
Ковид-19 цар тахлын үед Нийслэлийн гэр хорооллын жижиг дунд үйлдвэрлэгчдэд дэмжлэг үзүүлэх төсөл (2021—2022)	ЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн үйлчилгээнд хүрэх боломж, хэрэгцээний талаар судалгаа явуулсан. Мөн жендерийн мэдрэмжтэй чадавхийг бэхжүүлэх сургалт явуулна. Үүнээс гадна ЖДҮ-ийн бизнес боломжийг хөгжүүлэх, өргөжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. Энэ техникийн хамтын ажиллагаа нь Улаанбаатар хотын үйлчилгээ, гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр зэрэг олон шатлалт санхүүжилтийн төсөлтэй (MFF) холбоотой юм.	Буцалтгүй тусламж 300,000 ам.доллар
Цочролд хариу үзүүлэх нийгмийн хамгааллын хоёр дахь төсөл (2021—2023)	КОВИД-19 цар тахлын үед ядуу өрхөд дэмжлэг үзүүлэх зорилготой төсөл. Гол нь ядуу өрхийн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг санхүүжүүлэх, өрхийн амьжиргааны чадавхийг нэмэгдүүлэх, ирээдүйн цочрол, хямралд Засгийн газрын хариу арга хэмжээ авах чадварыг сайжруулахыг зорьж, нийгмийн халамжийн хөтөлбөр, халамжийн системийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулна.	Зээл 46.4 сая ам.доллар
Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл (2015—2021)	Эдийн засаг, ХАА, барилга, зам тээврийн салбарын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг (МСҮТ) төгсөгчдийн хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх зорилготой. Мөн ижил тэргүүлэх салбар дахь МСҮТ-ийн менежер, багш нарын сургалтын аргыг сайжруулна. Мөн мэдээллийн технологийн салбарт ажил мэргэжлийн чиг баримтаа олоход нь дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаа багтаж байна.	Зээл АХБ 25 сая ам.доллар (МУ-ын Засгийн газар 3.59 сая ам.доллар)
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн урт хугацааны тусламж үйлчилгээг хөгжүүлэх төсөл (2019—2021)	Өнгөрсөн хугацаанд Азийн 6 оронд (Индонез, Монгол, Шриланк, Тайланд, Тонга, Вьетнам) хэрэгжүүлсэн судалгааны төслийн үргэлжлэл юм. Энэ удаагийн төсөлд Индонез, Монгол, Шриланк, Вьетнам улсыг хамруулсан. Энэ нь насжилттай нийгэмд урт хугацааны тусламж үйлчилгээ, системийг хөгжүүлэх зорилготой юм. Төрийн албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх, олон нийтэд түшиглэсэн урт хугацааны тусламж үйлчилгээний загварыг боловсруулах, орон нутгийн түвшинд урт хугацааны тусламж үйлчилгээний талаархи мэдлэгийг хуваалцах, сүлжээг бэхжүүлэх зэрэг үйл ажиллагаа багтаж байна.	Буцалтгүй тусламж 2 сая ам.доллар
Дэлхийн банк (ДБ)		
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл (2017-2021)	Ажил хайгч иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Үйлчилүүлэгч төвтэй үйлчилгээг бэхжүүлсэнээр ажилд ороход үүсдэг хориг саадыг багасгах зорилготой. Хөдөлмөрийн зах зээлийг идэвхижүүлэхийн тулд хөтөлбөрийг сайжруулан ажиллаж байна. Тодорхой хэлбэл, а) Хөдөлмөр эрхлэхэд чиглүүлсэн цогц сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх б) Бичил бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх с) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг багтаж байна. Мөн ажил хайгч иргэдэд, чанартай мэдээлэлд үндэслэж шийдвэр гаргахад нь туслах зорилгоор хөдөлмөрийн зах зээлд ажиглалт/дүн шинжилгээ хийж, төслийн хяналт, менежментийг сайжруулна.	Зээл 25 сая ам.доллар
Онцгой байдлын үеийн хөнгөлөлт ба хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл	Ажил хайгч болон бичил бизнес эрхлэгчдийн хөдөлмөрийн зах зээлд оролцох боломжийг сайжруулан, КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй хямралд өртсөн ажилчдад дэмжлэг үзүүлнэ. Төрөөс үзүүлж буй	Зээл 20 сая ам.доллар

(2021-2023)	үйлчлүүлэгч төвтэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд дэмжлэг үзүүлнэ. Мөн хөдөлмөрийн зах зээлийн хөтөлбөрийг (Жнь: Засгийн газрын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл) сайжруулан ажиллаж байна. Хөдөлмөрийн зах зээлд ажиглалт/дүн шинжилгээ хийх, төслийн хяналтыг сайжруулах ажил багтаж байна. КОВИД-19 цар тахал (нийгмийн даатгал) үүссэнтэй холбоотой ажиллагсдад түр хугацааны дэмжлэг үзүүлж байна.	
Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)		
Ур чадварыг хөгжүүлэх төсөл (2018-2021)	Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс (GIZ) хэрэгжүүлэгч байгууллагад шууд санхүүгийн дэмжлэг үзүүлж байна. Хэрэгжүүлэгч байгууллага болох АХБ болон ХНХЯ нь барилгын компани дээр дагалдагчийг ажиллуулан, үйлдвэрлэлийн дадлагажуулагчид сургалт явуулан, барилгын олон чиглэлээр албан бус хэлбэрээр эзэмшсэн ур чадварыг үнэлэх үйл ажиллагаа явуулж байна. Ажлын байран дээрх сургалтыг явуулж (ОJT), мөн хөдөлмөрийн зах зээлд дүн шинжилгээ хийх нэгдсэн мэдээллийн санг бий болгон, өндөр зэрэглэлийн дижитал интерфейс ашиглан сургалтыг явуулж байна.	Буцалтгүй тусламж Мөнгөн дүн тодорхойгүй. GIZ-аас шууд санхүүждэг.
Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)		
Эдийн засгийг төрөлжүүлж, хүртээмжтэй өсөлтийг хангах хүрээнд албан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл (2019—2021)	Албан эдийн засагт шилжихийг дэмжиж, ажил хайгч, ажилчдын шийдвэр гаргах үйл явцад санал бодлоо илэрхийлэх боломжийг олгох замаар албан бус эдийн засагт ажиллаж байгаа иргэдийг дэмжинэ. Уг төсөл нь засгийн газар, үйлдвэрчний эвлэл, ажил олгогчд эздийн байгууллага гэсэн гурван байгууллагын дунд хэрэгжиж байна. Тодруулж хэлбэл, гурван байгууллагын түншлэлийг бэхжүүлэх стратеги боловсруулна. Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо (цаашид "МАОЭНХ" гэх), Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо (цаашид "МҮЭХ" гэх)-ны үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, чанарыг дээшлүүлэх, хөдөлмөрийн үр ашгийг дээшлүүлэхэд ур чадвар тал дээр дэмжлэг үзүүлэх ба албан бус салбарт ажиллаж буй залуучууд, эмэгтэйчүүдийг албан эдийн засагт шилжихэд дэмжлэг үзүүлнэ.	Буцалтгүй тусламж 76.42 сая ам.доллар

Эх сурвалж: Судалгааны баг судалсанаар (2021 оны 5 сар)

2-17 хүснэгтэнд нийгмийн халамжийн салбарт донор орнууд болон олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлж буй тусламж дэмжлэгийг чиглэл бүрээр жагсааж бичив. Уг хүснэгтээс АХБ, ДБ, ОУХБ зэрэг байгууллагууд төрөл бүрийн тусламж үзүүлж буйг харж болно.

Энэ тайлангийн 8 бүлэгт Японы тусламжийн дунд болон урт хугацааны чиглэл, цаашид хэрэгжүүлэх тусламжийн талаар санал боловсруулахдаа бусад донор орнуудын тусламж дэмжлэгтэй давхцуулахгүй байхад анхаарсан. АХБ, ДБ бараг бүх чиглэлээр дэмжлэг үзүүлж ирсэн туршлагатай тул эдгээр байгууллагуудтай хамтран ажиллаж, хамтын хүч үүсгэх боломжтой чиглэлээр дэмжлэг үзүүлэх шаардлагатай юм.

Хүснэгт 2-17: Олон улсын байгууллагуудаас үзүүлж байгаа дэмжлэг тусламжийн тойм (дэмжлэг үзүүлэх чиглэл тус бүрээр)

Дэмжлэг үзүүлэх чиглэл	Үйл ажиллагаа ба дэмжлэг үзүүлж буй байгууллага
Олон талт	Бүх нийтийн нийгмийн хамгаалал (ОУХБ)
Бэлэн мөнгөний дэмжлэг	Хүүхдэд олгох тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх (АХБ)
Нийгмийн даатгал	Нийгмийн даатгалын тогтолцоог үнэлэх ба шинэчлэлт хийх (ДБ ба АХБ), нийгмийн даатгалын шимтгэлийн суутгал (ДБ)
Албан бус салбар	Албан бус салбарын статистик мэдээлэлтэй танилцах (ОУХБ), Албан бус салбарыг албан салбар болгох (ОУХБ)
Үйлчилгээ үзүүлэх/тогтолцоо бэхжүүлэх	Үйлчилүүлэгч төвтэй үйлчилгээ үзүүлэх аргачлалыг сайжруулах (ДБ), коучинг ба заах арга (АХБ ба Дэлхийн зөн), төгсөлтийн арга (АХБ), Орон нутгийн амьжиргааг дэмжих зөвлөлд үзүүлэх дэмжлэг (АХБ), Бүс нутгийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээтэй холбоотой бодлогод хийх үнэлэлт дүгнэлт (АХБ)
Нийгмийн ажилтныг бэлтгэх	Нийгмийн ажилтанд зориулсан сургалт (Social-emotional skills/хэрэглээний сэтгэл судлал) (ДБ), Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэсийн барилгын засвар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газруудын байрыг засварлах (саад бууруулагчтай) (ДБ), сургалтын хөтөлбөр боловсруулах* (АХБ), шинэ нийгмийн ажилтнуудад зориулсан сургалт* (АХБ), нийгмийн ажилтны ажлын ачааллын судалгаа *(АХБ), одоо ажиллаж буй нийгмийн ажилтнуудад зориулсан сургалт (АХБ)
Бизнес эрхлэгчдийг дэмжих	Бизнес эрхлэгчдэд үзүүлэх санхүүгийн дэмжлэг (зээл) (ДБ), Бизнес эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэг (ОУХБ), Бизнес эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэг*(сургалт багтсан) (ДБ)
Мэдээлэл/тоо баримт	Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох аргыг сайжруулах (ДБ), Өрхийн нэгдсэн мэдээллийн санг сайжруулах (АХБ), e-Welfare ба техник хангамжийг сайжруулах (АХБ)
Залуучуудын хөдөлмөр эрхлэлт	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт (ДБ/Швейцарын хөгжлийн агентлаг/ОУХБ)
Ур чадварын дэмжлэг	Технологийн инновацийг дэмжих (ДБ), Эрэлт хэрэгцээтэй ур чадварын судалгаа (ур чадвар ба ажил мэргэжлийн ангилал) (ДБ)
Хөдөлмөрийн зах зээл	Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн (job matching) системийг сайжруулах (ДБ +БНСУ), Хөдөлмөрийн зах зээлийн шинжилгээ (ДБ), Хөдөлмөрийн зах зээлийн шуурхай мэдээлэл боловсруулах (ДБ)
Жижиг дунд үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэг	Дотоодын аж ахуйн нэгжүүдийн экспорт/гадаад худалдааны хөгжил (МАОЭНХ-той хамтарсан) (ОУХБ), Жижиг дунд үйлдвэрлэлд үзүүлэх санхүүгийн дэмжлэг*(АХБ), Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ОУХБ), Бичил үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэг (ОУХБ), Жижиг дунд үйлдвэрлэлд зориулсан жендерийн сургалт

Материал, ярилцлагад үндэслэн судалгааны баг боловсруулж гаргав (2021 оны 5 сар)

* тэмдэглэгээтэй хэсэг нь төлөвлөлтийн шатанд явж байгаа мөн, эхлэх хугацаа нь тодорхойгүй ажлууд

Гуравдугаар бүлэг. Нийгмийн халамжийн тогтолцоо, үйлчилгээний өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудал

3-1 Нийгмийн халамжийн бодлого, хэрэгжилтийн тогтолцоо

1990-ээд оны эхээр ардчилсан засаглал, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэний дараах МУ-ын нийгмийн халамжийн салбар¹⁹ үндсэн хоёр онцлогтой. Нэгдүгээрт нийгмийн халамжийн тогтолцоо нь социализмын үед (1990-ээд оноос өмнө) бүрэлдсэн халамжийн зарим үйлчилгээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж ирсэн онцлогтой. Тухайлбал улс оронд хувь нэмэр оруулсан ахмад настан болон олон хүүхэдтэй эхэд олгож ирсэн тэтгэмжийг дурдаж болно. Хоёрдугаарт ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эмэгтэйчүүд, хүүхдүүд зэрэг эмзэг бүлгийн иргэдийг санхүүгийн бэрхшээлээс хамгаалахын тулд халамжийн шинэ үйлчилгээг нэвтрүүлсэн. Тухайлбал “хүүхдийн мөнгө” хөтөлбөр (цаашид “ХМХ” гэх), хоол хүнс худалдан авахад дэмжлэг үзүүлж хүнсний талон олгох хөтөлбөр (цаашид “ХЭБ” гэх), хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр, жирэмсэн болон хүүхдээ асарч буй эхэд олгох тэтгэмж, орон нутагт суурилсан нийгмийн халамжийн үйлчилгээ зэргийг дурдаж болно.

1995 оноос Нийгмийн халамжийн тухай хуулийг анх хэрэгжүүлж эхлэн, одоогийн нийгмийн халамжийн тогтолцооны суурийг тавьсан. 1998 онд Нийгмийн халамжийн тухай хуулийг шинэчлэн, нийгмийн халамжийн тогтолцоог даатгалын системээс салгаж, нийгмийн халамжийн шинэ тогтолцоог хэрэгжүүлж эхэлсэн. 2000 оноос 2012 онуудад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, 2005, 2012 онд Нийгмийн халамжийн тухай хуулийг шинэчлэн найруулсан байна. Одоо үйлчилж буй Нийгмийн халамжийн тухай хууль 2012 онд шинэчлэгдсэн.

Нийгмийн халамжийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш МУ-ын нийгмийн халамжийн тогтолцооны хамрах хүрээ их хэмжээгээр тэлж, дараах 3-1-1 хэсгийн 3-1 хүснэгтэнд дурдсанчлан 6 хууль, Засгийн газрын тогтоол, сайдын тушаалаар 60 гаруй төрлийн нийгмийн халамжийн үйлчилгээг²⁰ хэрэгжүүлдэг.

Нийгмийн даатгалд өндөр насны тэтгэвэр, эрүүл мэндийн даатгал, ажилгүйдлийн даатгал, үйлдвэрлэлийн ослын даатгал, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн даатгал хамаардаг. Нийгмийн даатгалыг 2-13 хүснэгтэнд дурдсан Нийгмийн даатгалын тухай хууль (1994 он), Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль (1994 он), Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль (1994 он), Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль (1994 он), Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль (1994 он), Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль (1999 он), Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоол [2012 (2015, 2016, 2021 онд шинэчилсэн)], Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар (2015 он) зохицуулдаг.

¹⁹ Нийгмийн халамжийн үйлчилгээ нь өмнөх бүлгийн 2-3 "Нийгмийн хамгааллын тогтолцооны өнөөгийн нөхцөл байдал"-д дурдсан "Улсаас олгох тэтгэвэр, тэтгэмж" болон "Нийгмийн халамж"-тай адил утгатай.

²⁰ Дэлгэрэнгүй мэдээллийг 3-2-1 "Нийгмийн халамжийн үйлчилгээний агуулга"-аас харна уу.

3-1-1 Нийгмийн халамжийн холбогдох хууль тогтоомж

Нийгмийн халамжийн тогтолцоонд хамаарах 6 хуулийн агуулгыг тухайн хуулийг баталсан оны хамт 3-1 хүснэгтэнд тусгав.

Хүснэгт 3-1: Монгол улсын нийгмийн халамжийн голлох хуулиудын тойм

1. Хуулийн нэр	Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль
Хэрэгжиж эхэлсэн он/баталсан он	2011 он
Товч агуулга	Энэ хуулинд 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлж, өсгөсөн эхчүүдийг урамшуулах (алдарт эхийн 2-р одон) болон 6 хүүхэд төрүүлж, өсгөсөн эхчүүдийг урамшуулах (алдарт эхийн 1-р одон) тухай тусгасан.
2. Хуулийн нэр	Нийгмийн халамжийн тухай хууль
Хэрэгжиж эхэлсэн он/баталсан он	2012 он
Товч агуулга	Энэ хууль нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамжийн үйлчилгээний төрөл, хамрах хүрээг тодорхойлох, нийгмийн халамжийн сан байгуулах, зарцуулах, нийгмийн халамж, нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн халамжийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох зэрэгтэй холбоотой харилцааг зохицуулдаг.
3. Хуулийн нэр	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай хууль
Хэрэгжиж эхэлсэн он/баталсан орсон он	2016 он
Товч агуулга	Энэ хууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хэрэгжүүлэх, хамгаалах талаар мөн төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үүрэг, оролцоо, баримтлах зарчмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулна.
4. Хуулийн нэр	Ахмад настны тухай хууль
Хэрэгжиж эхэлсэн он/баталсан он	2017 он
Товч агуулга	Энэ хууль нь ахмад настны эрхийг хангах, амьжиргаа, хөгжил, нийгмийн оролцоог дэмжих, нийгмийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулах ба мөн төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үүргийг тодорхойлж, тэдгээрийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох зорилготой.
5. Хуулийн нэр	Эх, олон хүүхэдтэй эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль
Хэрэгжиж эхэлсэн он/баталсан он	2017 он
Товч агуулга	Энэ хууль нь жирэмсэн эх, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, дөрөв хүртэлх насны ихэр хүүхэдтэй эх, эцэг, гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.
6. Хуулийн нэр	Алдар цолтон, ахмад настанд төрөөс нэмэлт, хөнгөлөлт олгох тухай хууль
Хэрэгжиж эхэлсэн он/баталсан он	2017 он
Товч агуулга	Энэ хууль нь Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон, төрийн шагналт, төрийн соёрхолт, ахмад дайчин, Улсын ударник, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэж, баталсан /1990-1992 он/ Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

Эх сурвалж: Судалгааны багийн судалсанаар (2021 оны 3 сар)

Үүнээс гадна нийгмийн халамжтай холбоотой дор дурдсан хууль, Засгийн Газрын тогтоол бий.

- Нийгмийн халамжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоол (Government Resolution on Some Measures in Respect of the Implementation of Laws on Social Care)

3-1-2 Нийгмийн халамжийн бодлого

Дараах 3-2 хүснэгтэнд нийгмийн халамжийн холбогдох бодлогуудын гол агуулгыг товч тусгав.

Хүснэгт 3-2: Нийгмийн халамжийн холбогдох бодлого

1. Бодлогын нэр	2020-2024 онд хэрэгжих Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
Хэрэгжиж эхлэх он	2020 он
Товч агуулга	Нийгмийн халамжтай холбоотой агуулга 2.5.7. Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн, ядуурлыг бууруулах зорилготой. 2.5.9. Орлого багатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. 2.5.13. Тусгай хэрэгцээ /байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээл/-тэй 0-16 насны хүүхдээ асран, ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эх /эцэг/-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс төлнө.
2. Бодлогын нэр	Нийгэм эдийн засгийн хөгжлийн 5 жилийн хүрээ (2020-2025 он)
Хэрэгжиж эхлэх он	2020 он
Товч агуулга	Зорилго 3.1. Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэх 3.1.3. Шинэчлэлд нийгмийн халамжийг хамруулах ба нийгмийн халамжийн үйлчилгээний ил тод, хүртээмжтэй байдлыг хангана. 3.1.4. Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ. 3.1.5. Нийгмийн даатгалын сангийн болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг инфляцийн түвшин болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ.
3. Бодлогын нэр	Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого
Хэрэгжиж эхлэх он	2020 он
Товч агуулга	Зорилго 3.1. Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын тогтолцоог хөгжүүлнэ.(Нийгмийн халамж/нийгмийн хамгааллын тогтолцооны шинэчлэл) 1-р үе шат : Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэх үе (2021-2030 он) 3. Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ. 4. Нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэнээр эмзэг бүлгийн иргэдийг хамгаална. 5. Эмзэг бүлгийн өрх, иргэд зэрэг хамрагдах хүрээг цомхотгож, халамжийн дэмжлэг ба үйлчилгээг хангалттай хэмжээнд үзүүлнэ. 2-р үе шат: Эрсдэлээс сэргийлэх нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулах үе (2031-2040 он) 4. Ядуу, эмзэг бүлгийн хэрэгцээ, мөн орон нутгийн онцлогт нийцсэн халамжийн шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлнэ. 5. Ахмад настанд урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулна. 3-р үе шат: Амьдралын чанарыг сайжруулахуйц нийгмийн хамгааллын цогц үйлчилгээ үзүүлэх үе (2041-2050 он) 2. Өрх, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нийгмийн халамжийн үйлчилгээг хөгжүүлнэ.

Эх сурвалж: Судалгааны багийн судалсанаар (2021 оны 3 сар)


3-1-3 Нийгмийн халамжийг хэрэгжүүлэх тогтолцоо

ХНХЯ нийгмийн халамжийн бодлого боловсруулж, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал, хуулийн төслийг Засгийн газар, УИХ-д өргөн барих зэргээр нийгмийн халамжийн бодлого хариуцдаг. Мөн ХЭБ, ХМХ зэрэг нийгмийн халамжийн үйлчилгээ, тэтгэвэр тэтгэмжид дүн шинжилгээ хийж, шалгуур тогтоодог.

Дээрх 2-6 зурагт дурдсанчлан ХНХЯ-ны удирдлаган дор 4 агентлаг ажилладаг. ХХҮЕГ нь нийгмийн халамжийн салбарын бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага юм. ХХҮЕГ нь орон нутагт харьяа газруудтай. Эдгээр харьяа газрууд нь нийгмийн халамжийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлчилгээ үзүүлдэг. ХХҮЕГ нийгмийн халамжийн үйлчилгээнд хяналт тавьж, удирдлагаар хангах үүрэг хүлээдэг. 21 аймагт Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Улаанбаатар хотын 9 дүүрэгт Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс (цаашид “ХХҮХ” гэх) ажилладаг. 21 аймагт 330 сум, Улаанбаатар хотын 9 дүүрэгт 169 хороо бий. Эдгээр 330 сум, 169 хороонд нийгмийн халамжийн үйлчилгээг хэрэгжүүлдэг. Нийслэлийн засаг даргын тамгын газрын харьяанд Нийгмийн халамжийн газар, Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар бий.

Үүнээс гадна Амьжиргааг дэмжих зөвлөл (цаашид “АДЗ” гэх) бий. Уг зөвлөл нь нийгмийн халамжийн үйлчилгээ, тэтгэмжийг шийдвэрлэх процесст тодорхой хэмжээний үүрэг гүйцэтгэдэг. АДЗ нь бүх сум, хороонд ажилладаг. Хүнсний эрхийн бичиг, асаргааны тэтгэмж олгох, халамжийн тэтгэмжийн өргөдөл хүлээн авч, бүртгэх эсэхийг шийддэг.

Мөн нийгмийн халамжийн үйл ажиллагаатай холбоотой санал гомдлыг шийдвэрлэх чиг үүрэгтэй ажилладаг. АДЗ нь нийгмийн ажилтан 1, төрийн байгууллагын төлөөлөгч 2, иргэдийн төлөөлөгч 2, төрийн бус байгууллагын төлөөлөгч 2, нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй. 2021 оны 3 сарын байдлаар улсын хэмжээнд АДЗ-д нийт 3961 гишүүн ажиллаж байна. Нийгмийн халамжийн (хөдөлмөр эрхлэлт) салбарын тогтолцоог 3-1 зурагт тусгав.



3-2 Нийгмийн халамжийн үйлчилгээний агуулга болон хамрах хүрээг шинэчлэхээр хийгдэж буй ажил, шийдвэрлэх асуудал

3-2-1 Нийгмийн халамжийн үйлчилгээний агуулга

ХНХЯ-наас хэрэгжүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээ нь дээр дурдсан 6 хуульд үндэслэсэн 60 гаруй үйлчилгээнээс бүрддэг. Эдгээр үйлчилгээ нь тэтгэмж авагчийн хүйс, нас, хүүхдийн тоо, хөгжлийн бэрхшээл зэргийг харгалзан нарийн ангилагддаг. Тэтгэмж авах шаардлага хангасан хүн мөнгөн тэтгэмж, хөнгөлөлт авах боломжтой. Эдгээр 60 гаруй үйлчилгээг холбогдох хууль болон ХНХЯ-ны үйл ажиллагаанд үндэслэн дараах 12 хөтөлбөрт ангилдаг. Цаашид уг тайланд эдгээр 12 төрлийн хөтөлбөрийг "нийгмийн халамжийн хөтөлбөр" гэж нэрлэнэ.

1. Нийгмийн халамжийн тэтгэвэр
2. Нийгмийн халамжийн тэтгэмж
3. “Эхийн алдар” одонтой эхчүүдийн тэтгэмж (Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах хөтөлбөр)
4. Хүүхдийн мөнгөн тэтгэмж
5. Хүнсний эрхийн бичиг олгох хөтөлбөр
6. Олон нийтийн оролцоотой нийгмийн халамжийн үйлчилгээ
7. Мэргэжлийн байгууллагын асрамжийн үйлчилгээ

8. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх хүнсний эрхийн бичиг авдаг иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн үйлчилгээ
9. Эхчүүдэд зориулсан тэтгэмж (“Цалинтай ээж” хөтөлбөр)
10. Ахмад настанд олгох тусламж, хөнгөлөлт
11. Алдар цолтон ахмад настанд олгох нэмэгдэл, хөнгөлөлт
12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусламж, хөнгөлөлт

Эдгээр 12 нийгмийн халамжийн хөтөлбөрийн агуулгын талаар 3-3 хүснэгтэнд дурдав.

Хүснэгт 3-3: Нийгмийн халамжийн хөтөлбөрийн агуулга

No.	Хөтөлбөрийн төрөл	Хамрагдах бүлэг, тэтгэвэр хүртэгч, төрөл	Мөнгөн хэмжээ ба давтамж
1	Нийгмийн халамжийн тэтгэвэр	Дараах иргэд нийгмийн халамжийн тэтгэвэр авах эрхтэй 1) (Өндөр настны тэтгэвэр авах эрх үүсээгүй)60-аас дээш насны эрэгтэй, 55-аас дээш насны эмэгтэй 2) 16 насанд хүрсэн одой иргэн 3) Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн 4) Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд 5) 4 ба түүнээс олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг (45-аас дээш насны эмэгтэй, 50-иас дээш насны эрэгтэй)	Сар бүр 188,000 төгрөг 1)-5)-д хамаарах хүмүүст ижил дүнгээр олгоно.
2	Нийгмийн халамжийн тэтгэмж	Нийгмийн халамжийн тэтгэмж нь дараах 2 төрлөөс бүрдэнэ. 1. Асаргааны тэтгэмж 2. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж Дараах хүмүүст асаргааны тэтгэмж олгоно. 1) Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж байгаа хүн 2) Хүчирхийллийн улмаас сэтгэлзүйн болон биемахбодийн хохирол хүлээж, хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг асран хамгаалж байгаа хүн 3) Ганц бие өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авч асрамжилж байгаа хүн 4) Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэн 5) Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэн Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг дараах хүмүүс авах эрхэй. 1) 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн 2) Гэнэтийн аваар осол, гамшгийн улмаас орон гэрээ алдсан өрх 3) Хорих ангиас суллагдсан, өөрийн орон гэргүй иргэн 4) 4 ба түүнээс дээш хүүхэдтэй, орон гэргүй, өрх толгойлсон эх, эцэг 5) Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 6) Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн (улирал тутамд мөнгө олгох)	1)-4) Сар бүр 84,500 төгрөг 5) Сар бүр 123,100 төгрөг 1)-4) Нэг удаа 1.2 сая төгрөг 5)Сар бүр 188,000 төгрөг 6)Улирал тутамд 84,500 төгрөг
3	Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох урамшуулал	1) 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүд (Алдарт эхийн одон I) 2) 6 ба түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүд (Алдарт эхийн одон II)	1) Жилд 1 удаа 100,000 төгрөг 2) Жилд 1 удаа 200,000 төгрөг

	(“Алдарт эхийн одон” хөтөлбөр)		
4	Хүүхдийн мөнгөн тэтгэмж	18 хүртэлх насны бүх хүүхэд (2020 оны 4 сарын 1-ээс 2021 оны 7 сарын 1 хүртэл Ковид-19 цар тахлын эсрэг арга хэмжээний хүрээнд сар бүр 100,000төгрөг)	Сар бүр 20,000 төгрөг
5	Хүнсний эрхийн бичиг олгох хөтөлбөр	ООТА-ын оноогоор тодорхойлсон өрх	Сар бүр том хүн нэг бүр 16,000 төгрөг, хүүхэд 8,000 төгрөг
6	Олон нийтийн оролцоотой нийгмийн халамжийн үйлчилгээ	Гэрээ байгуулсан ТББ нь дараах бүлгийн иргэдэд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ 1) Өндөр настан 2) Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 3) Хүнд нөхцөлд байгаа хүүхэд 4) Хүчирхийллийн хохирогч 5) Хорих газраас суллагдсан иргэн 6) Согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн 7) Эмчилгээгүй өвчтэй хүн 8) Орон гэргүй хүн 9) Амьжиргааны дэмжлэг шаардлагатай иргэн 10) Ганц бие эх, эцэг 11) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрх 12) 3 ба түүнээс дээш хүүхэдтэй ганц бие эх, эцгийн хүүхэд	Үйлчилгээний төлбөр нь үйлчилгээ үзүүлэх ТББ зэрэг хувийн байгууллагад олгогдоно ²¹ .
7	Мэргэжлийн байгууллагын асаргааны үйлчилгээ	Дараах ахмад настан ба хүүхдүүдэд зориулсан асаргааны үйлчилгээ 1) Ганц бие ахмад настан 2) Ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэн 3) Хүндрэлтэй нөхцөлд байгаа 18 нас хүрээгүй хүүхэд 4) 4 нас хүрээгүй 3 ихэр болон 4 ихэр хүүхэд	
8	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх хүнсний эрхийн бичиг авдаг иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн үйлчилгээ	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ авдаг иргэдийг эрүүл мэндийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх	Хамрагдах эрхтэй
9	Эхчүүдэд зориулсан тэтгэмж (“Цалинтай ээж хөтөлбөр”)	Дараах эхчүүд/ганц бие эх, эцэг, жирэмсэн эх 1) Жирэмсэн эх (жирэмсэний 5 дахь сараас төрөх хүртлээ нийт 5 сар) 2) 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх 3) 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг 4) 0-4 насны ихэр, гурван ихэр хүүхэд	1) Сар бүр 40,000 төгрөг 2) Сар бүр 50,000 төгрөг 3) Улиралт тутамд 420,000 төгрөг 4) Нэг удаа (Ихэр хүүхдэд 2 сая төгрөг, 3 ихэр хүүхдэд 9 сая төгрөг)
10	Ахмад настанд олгох тусламж, хөнгөлөлт	Дараах өндөр настнууд (55-аас дээш насны эмэгтэй, 60-аас дээш насны эрэгтэй) нь дараах тэтгэмж авч, хөнгөлөлт эдлэх эрхтэй. 1) Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу оршуулгын тэтгэмж авах боломжгүй ахмад настнуудад оршуулгын нэг удаагийн мөнгөн тусламж олгох 2) Жилд 1 удаа үр хүүхэдгүй өндөр настанд түлш худалдан авахад зориулж бэлэн мөнгөний дэмжлэг, мөн орон сууцны төлбөр төлөхөд нь дэмжлэг үзүүлэх 3) Жилд нэг удаа хүндэт донор ахмад настанд түлш худалдан авахад зориулж бэлэн мөнгөний дэмжлэг, мөн орон сууцны төлбөр төлөхөд үзүүлэх дэмжлэг 4) Хүндэт донор ахмад настан магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд амарч сувилуулсан	1) 1 удаа 1 сая төгрөг 2), 3) Жил бүр 140,000 төгрөг 4), 5) Жилд 1 удаа зардлыг шинэчлэн тогтооно.

²¹ “Орон нутгийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ”-ний дэлгэрэнгүй мэдээллийг “3-3-ын албан бус нөөцийн нөхцөл байдал”-аас харна уу.


		тохиолдолд төлбөрийг бүрэн, тээврийн хэрэгслийн нэг талын зардлын хөнгөлөлт 5) Эмнэлэгт үзүүлэх зорилгоор орон нутгаас ирсэн өндөр настны замын тал зардлыг, магадлан итгэмжлэгдсэн рашаан сувилалаар үйлчлүүлсэн тохиолдолд төлбөрийн 50%-ийн буцаан олголт 6) Ахмад настан магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд амарч сувилуулсан тохиолдолд төлбөрт үзүүлэх хөнгөлөлт 7) Хөл, гар, шүдний протез хийлгэсэн зардалд үзүүлэх дэмжлэг 8) Сонсгол, хараа дэмжих хэрэгсэлийн төлбөрийн хөнгөлөлт 9) Нийслэлээс 1000 километр ба түүнээс хол алслагдсан газарт байнга оршин суудаг ахмад настанд Нийслэлд ирэх үеийн замын тал зардлын буцаан олголт 10) Ахмад настанд үзүүлэх хүндэтгэл 65 болон түүнээс дээш настай ахмад настанд олгох тэтгэмж (Насны хишиг хөтөлбөр нь наснаас шалтгаалан олгох мөнгөн хэмжээ нь ялгаатай) Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ: Хуулинд 9 төрлийн үйлчилгээ тусгагдсан байдаг боловч ихэнх үйлчилгээ нь хэрэгждэггүй.	6) Хөнгөлөлт өдрийн 20,000 төгрөг (Жилд нэг удаа 10 хүртэлх хоногоор) 7) Засгийн газраас тогтоосон дундаж зардал (3 болон 5 жилд нэг удаа) 8) Засгийн газраас тогтоосон дундаж зардал (5 жилд нэг удаа) 9) Жилд 1 удаа зардлыг шинэчлэн тогтооно. 10) Хагас жилд 1 удаа 10,000 төгрөг жилд 2 удаа 50,000-250,000 төгрөг
11	Алдар цолтон ахмад настанд олгох нэмэгдэл, хөнгөлөлт	Дараах ахмад настууд хамрагдана. 1) Монгол улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон ахмад настанд олгох нэмэлт тусламж 2) Дайнд оролцсон ахмад дайчид эсвэл дайнд амь үрэгдсэн ахмад дайчдын эхнэр, нөхөрт олгох мөнгөн тусламж 3) МУ-ын төрийн шагналт, төрийн соёрхолт, ахмад дайчин, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн цолтой ахмад настанд олгох мөнгөн тусламж 4) Улсад хувь нэмрээ оруулсан ахмад настан нийслэлээс аймагт, аймгаас нийслэлд ирэх, буцах нэг удаагийн замын зардал 5) Улсад хувь нэмэр оруулсан ахмад настан магадлан итгэмжлэгдсэн рашаан, сувилалаар үйлчлүүлсэн тохиолдолд төлбөрийг болон 2 талын замын зардлыг буцаан олгох 6) Улсад хувь нэмэр оруулсан ахмад настанд жилд нэг удаа түлш худалдан авахад зориулж бэлэн мөнгөний дэмжлэг, мөн орон сууцны төлбөр төлөхөд нь үзүүлэх дэмжлэг	1), 2) Сар бүр 200,000 төгрөг 3) Сар бүр 150,000 төгрөг 4),5) Жилд 1 удаа зардлыг шинэчлэн тогтооно 6) Жил бүр 280,000 төгрөг
12	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусламж, хөнгөлөлт	1) Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн/хүүхдэд түлш худалдан авахад зориулж олгох бэлэн мөнгө 2) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хиймэл хөл хийлгэх зардал олгох дэмжлэг 3) Нийгмийн даатгалын хөнгөлөлтөд хамрагдахгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний хиймэл эрхтэн хийлгэсэн төлбөрт үзүүлэх дэмжлэг 4) Хөгжлийн бэрхшээлтэй иргэн/хүүхдэд зориулсан хиймэл эрхтэн бэлэн эмнэлгийн багаж төхөөрөмжийн төлбөрийн хөнгөлөлт 5) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэг, сургуульд явах унааны зардлын хөнгөлөлт 6) Харааны, сонсголын болон ярианы бэрхшээлтэй хүмүүсийн харилцааны зардалд үзүүлэх дэмжлэг 7) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд орон нутгийн рашаан сувилалд эмчилгээ хийлгэсэн зардал замын зардлын хөнгөлөлт	1) Жилд 1 удаа 140,000 төгрөг 2)-4) Засгийн газраас тогтоосон дундаж зардал (3 жилд 1 удаа) 5) Жилд 1 удаа 200,000 төгрөг 6) Жилд 1 удаа 20,000 төгрөг 7)-10) Жилд 1 удаа

	8) Хөгжлийн бэрхшээлтэй иргэн орон нутгийн рашаан сувилалд сувилуулах тохиолдолд эмчилгээний зардлын 50% болон нэг талын замын зардалд үзүүлэх хөнгөлөлт 9) Бүрэн хараагүй хүн рашаан сувилалд сувилуулсан тохиолдолд эмчилгээний зардлын 75%-д үзүүлэх хөнгөлөлт 10) Нийслэлээс 1000 км ба түүнээс алслагдсан бүсэд байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй иргэн Нийслэлд ирж буцах үеийн нэг талын замын зардалд үзүүлэх дэмжлэг 11) Хөгжлийн бэрхшээлтэй цэцэрлэгт явдаг хүүхдэд үзүүлэх хоолны төлбөрийн хөнгөлөлт 12) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд зуны амралтад амарсан тохиолдолд төлбөрийн 50%-д үзүүлэх хөнгөлөлт 13) Хөгжлийн бэрхшээлтэй иргэн/хүүхдийн оршуулгын зардалд үзүүлэх мөнгөн тусламж 14) Пара олимпийн тэмцээнээс медаль авсан иргэнд олгох тэтгэмж	11), 12) Тохиолдлоос шалтгаалан ялгаатай 13) 1 удаа 1000,000 төгрөг 14) Олгох давтамжийн тоог тэтгэврийн хэмжээгээр үржүүлсэн дүн
--	---	---

Эх сурвалж: Судалгааны баг судалсанаар (2021 оны 3 сар)


3-2-2 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж буй хүмүүс

2019 оны байдлаар нийгмийн халамжийн үйлчилгээ авах иргэдийн тоо нийт хүн амын 58 хувийг эзэлж байна ²². Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчдын (олон төрлийн үйлчилгээ авагч иргэнийг хамруулаад) үзүүлэлтийг харвал 2018 онд ХМХ-т хамрагдагчдын тоо буурсантай уялдан тэтгэмж авдаг хүмүүсийн тоо хэсэг хугацаанд буурсан. Гэхдээ ерөнхийдөө жил бүр нэмэгдсээр байна. 2017 онд 2.3 сая, 2020 онд 2.5 сая хүрээд байна (3-2 зураг)





Нийгмийн халамжийн хөтөлбөр бүрээр авч үзвэл, ХМХ-т хамрагдагсдын тоо хамгийн их, 2019 онд нийт тэтгэмж авагчдын 45%, 2020 онд 46 хувийг эзэлж байв. Үүний дараа ахмад настанд олгох нэмэлт, хөнгөлөлт, “Эхийн алдар” одонтой эхчүүдийн тэтгэмж, ахмад настанд олгох тэтгэмж, хоол хүнс худалдан авахад дэмжлэг үзүүлэх ХЭБ хөтөлбөр, эхчүүдэд (ганц бие эх, эцэг) олгох тэтгэмж ордог (3-3 зураг).

²² 2 орныг шууд харьцуулахад амаргүй юм. 2019 оны байдлаар Японд нийгмийн халамжинд хамрагдагсдын хувь 1.64% байна.



Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчдын дунд ядууст зориулсан хөтөлбөр болох хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ²³ хүртэгчдийн эзлэх хувь 9.5% (2016), 13.4% (2017), 11.5% (2018), 10.7% (2019), 9.5% (2020) болсон байна.

2020 оны байдлаар нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагч иргэдийн 42.5% нь нийслэлийн, 57.5% нь орон нутгийн иргэд байна (3-4 зураг). 2020 онд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдсан иргэдийг хот, хөдөөгөөр харьцуулж үзэхэд 33.8% нь нийслэлийн, 66.2% нь орон нутгийн иргэд байна (3-5 зургийг харна уу).



²³ Японд олгодог тэтгэмж нь ядууралд өртөхөөс сэргийлэх болон ядуурлаас аврах зорилготой. Японы амьжиргааг дэмжих тусламж болон МУ-ын хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ нь ядуурлаас аврах зорилгоор ажил гэж хэлж болно. Гэвч Японы амьжиргааг дэмжих тэтгэмж нь орлого ба хөрөнгөөс нь шалтгаалж хязгаарлалт тогтоодог бол Монголд хэрэгжиж байгаа хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ нь хөрөнгийн (ООТА-ын оноо) хэмжээнд үндэслэж хязгаарлалт тогтоодог.


Эдгээр үзүүлэлтээс орон нутагт ядуу өрх олон байгаа мэт харагддаг. Гэхдээ ХЭБ хөтөлбөрт хамрагдагчдын амьжиргааны түвшин тогтоох ООТА-ын босго оноо²⁴ хот, орон нутагт ялгаатай байдаг тул орон нутагт ядуу өрх олон байдаг гэж үзэж болохгүй юм.

Улмаар иийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчдын тоог бүс нутгаар харьцуулж үзвэл нийслэлийн Баянзүрх дүүрэг, Сонгинохайрхан дүүрэгт хамгийн их, дараа нь Баянгол дүүрэг, Хан-Уул дүүрэг орж байна. Эдгээр 4 дүүрэгт нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчдын 31% нь амьдардаг.

3-2-3 Нийгмийн халамжийн салбарын төсөв санхүү


① Нийгмийн халамжийн үйлчилгээний зардал

Ашигт малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэдэг “Хүний хөгжил сан”-гаас санхүүжилт авсанаар 2011 онд нийгмийн халамжийн салбарын зардал ДНБ-ий 7 хувьтай тэнцэх (925.5 тэрбум төгрөг) болсон. Зардал хамгийн өндөр түвшинд хүрсэн энэ үетэй харьцуулвал 2018 онд нийгмийн халамжийн зардал нэрлэсэн дүнгээр 31%, бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн ерөнхий түвшин болон инфляцийн түвшинг харгалзаж үзвэл бодит дүнгээр 56% тус бүр бага дүнтэй байна. Цар тахлын үед иргэдийн амьжиргааг эрсдлээс хамгаалахын тулд Засгийн газар өрхөд олгох тэтгэмжийн зардлыг нэмсэн. Үүний улмаас 2020 онд нийгмийн халамжийн зардал 2019 онтой харьцуулахад 2.4 дахин нэмэгдэж, ДНБ-ий 4.3%-д хүрсэн (3-6 зураг).



²⁴ Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдагчдын ООТА-ын онооны хэмжүүрийг харьцуулж үзвэл хотод (УБ хотын дүүрэг) 292.5, орон нутагт 310 байна.


3-7 зурагт нийгмийн халамжийн 12 хөтөлбөр тус бүрийн зардлын өөрчлөлтийг тусгав. Цар тахлын эсрэг арга хэмжээний хүрээнд 2020 оны 4-р сараас эхлэн сар бүр хүүхдэд олгох мөнгийг 5 дахин нэмсэн (20 мянган төгрөг байсаныг нэмж 100 мянган төгрөг болгосон). Үүний дүнд хүүхдийн мөнгөний зардал 2019 онд 230 орчим тэрбум төгрөг байсан бол 2020 онд 1 тэрбум 50 сая төгрөгт (4.6 дахин өссөн) хүрсэн. 3-8 зурагт хүүхдийн мөнгөнөөс бусад нийгмийн халамжийн хөтөлбөрөөс зарлагын өөрчлөлтийг тусгав. 2020 оны 5-р сараас хойш ядуу иргэдэд сар бүр олгодог ХЭБ-ийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлж, нийгмийн халамжийн сангаас эмзэг бүлэгт²⁵ (хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тэтгэвэргүй ахмад настан, өнчин хүүхэд, олон хүүхэдтэй эцэг эх) олгох халамжийн тэтгэврийг 100 мянган төгрөгөөр тусгайлан нэмсэн. Иймд 2020 онд ХЭБ, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ өссөн.



Цар тахлын эсрэг арга хэмжээний хүрээнд хүүхдийн мөнгийг нэмэхэд голлож анхаарсан. Үүнээс гадна ерөнхийдөө нийгмийн халамжийн үйлчилгээний зардал өссөн дүнтэй гарсан. (зураг 3-9)²⁶.

²⁵ 2020 оны 5-р сарын ҮСХ болон ДБ-ны тайланд дурдсанаар 2018 онд ядуурлын шугам сард нэг хүнд 166,580 төгрөг байв. 2018 оны байдлаар нийт хүн амын 28,4% нь уг ядуурлын шугамаас доогуур түвшинд амьдарч байна.


²⁶ Зураг 3-8 "Нийгмийн халамжийн зардлын өөрчлөлт"-нд тусгасан нийгмийн халамжийн зардалтай (хүний хөгжил сан, ХМХ-ийг хамруулж тооцоогүй) адил тоо баримт юм. Харахад ойлгомжтой тул тусгайлан сонгосон болно.



② Нийгмийн халамжийн үйлчилгээний зардлыг бусад орнуудтай харьцуулах нь

2015 онд ДБ Зүүн Ази төдийгүй дэлхийн бусад орнуудтай харьцуулахад МУ-ын нийгмийн халамжийн зардал өндөр байна гэж дүгнэсэн. ДБ-ны 2018 оны тайланд дурдсанаар улс орнууд хоорондоо ялгаатай ч ерөнхийдөө Зүүн Ази болон Номхон далайн орнууд ДНБ-ий дунджаар 1%-ийг нийгмийн халамжид зарцуулж байна. Дэлхийн хэмжээнд авч үзвэл нийгмийн халамжийн зардал ДНБ-ий 0.2-6.5% хооронд хэлбэлздэг. Нийгмийн халамжийн зардал дунджаар ДНБ-ий 1.54%-ийг эзэлдэг²⁷.

Дэлхийн 125 орны нийгмийн халамж, даатгал, хөдөлмөрийн зах зээлийн хөтөлбөрийн үзүүлэлтийг тусгасан ДБ-ны ASPIRE (The Atlas of Social Protection Indicators of Resilience and Equity)²⁸-ийн мэдээллээс үзвэл МУ-ын нийгмийн халамжийн зардлын ДНБ-д эзлэх хувь 2.52% байна. Үүнээс мөнгөн тэтгэмж ДНБ-ий 1.72%-ийг эзэлж байгаа нь хөрш орнууд болон Азийн бусад орнуудтай харьцуулахад өндөр хувь юм (зураг 3-10).



²⁷ World Bank (2018) The State of Social Safety Nets, <http://documents1.worldbank.org/curated/en/427871521040513398/pdf/124300-PUB-PUBLIC.pdf> (мэдээлэл авсан огноо:2021-3-23).

²⁸ World Bank, ASPIRE, <https://www.worldbank.org/en/data/datatopics/aspire> (мэдээлэл авсан огноо:2021-3-23).

3-2-4 Нийгмийн халамжийн үйлчилгээний хүний нөөц

① Нийгмийн халамж хариуцсан төрийн захиргааны байгууллагын ажилтны тоо

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд олон байгууллага, хүний нөөц оролцдог. Дээр дурдсанчлан ХНХЯ-ны удирдлаган дор Засгийн газрын хэрэгжүүлэгч 4 агентлаг, бусад холбогдох байгууллага, нийгмийн халамж, даатгал, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар ажилладаг. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь ХНХЯ-ны харъяа байгууллага юм. Дээрх байгууллагуудад 2020 оны байдлаар нийт 7,512 хүн ажиллаж (гэрээт ажилтанг тооцоогүй) байна. Нийгмийн хамгааллын салбарын холбогдох байгууллагын ажилтан, албан хаагчийн тоог 3-4 хүснэгтэнд тусгав.

Хүснэгт 3-4: Нийгмийн хамгааллын салбарын холбогдох байгууллагын ажилтан, албан хаагчийн тоо (2020 он)

№.	Яам/агентлаг/аймаг/дүүрэг зэрэг	Мэргэжлийн боловсон хүчин	Хүний тоо
1	Яам	ХНХЯ-ны ажилтан, албан хаагч	119
2	Агентлаг	Нийгмийн даатгалын ерөнхий газрын ажилтан, албан хаагч	89
3		Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий (ХХҮЕГ) газрын ажилтан, албан хаагч	67
4		Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн ерөнхий газрын (ГБХЗХГ) ажилтан, албан хаагч	49
5		Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын (ХБХХЕГ) ажилтан, албан хаагч	35
6	Судалгааны институт	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн (ХНХСИ) ажилтан	40
7	Нийслэлийн 9 дүүрэг	Дүүргийн хөдөлмөр, халамжийн хэлтсийн ажилтан, албан хаагч (хорооны нийгмийн ажилтнаас бусад)	307
8		169 хороонд ажилладаг нийгмийн ажилтан (нийгмийн халамж ба хөдөлмөр эрхлэлт хариуцсан)	172
9		Нийгмийн даатгалын хэлтсийн (НДХ) ажилтан, албан хаагч	408
10		Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын (ГБХЗХГ) ажилтан, албан хаагч	202
11	21 аймаг	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын ажилтан, албан хаагч (сумын нийгмийн ажилтнаас бусад)	657
12		330 суманд ажилладаг нийгмийн ажилтан (нийгмийн халамж ба хөдөлмөр эрхлэлт хариуцсан)	411
13		Нийгмийн даатгалын хэлтсийн ажилтан, албан хаагч	542
14		Нийгмийн даатгалын хэлтсийн нийгмийн даатгал хариуцсан байцаагч	359
15		Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын (ГБХЗХГ) ажилтан, албан хаагч	310
16	Төвүүд	Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв	64
17		“Өнөр бүл” хүүхдийн асрамжийн газар	103
18		Батсүмбэр дэх Ахмад настны үндэсний төв	127
19		Олон улсын хүүхдийн “Найрамдал” төв	158
20		БНСУ дахь хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв	6
21		Мэргэжлийн боловсрол, сургалт үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв	45
22		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв	96
23		Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэр	30
24		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв	189
25		МСҮТ-ийн багш	518

26	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ)	МСҮТ-ийн ажилтан	2,409
Нийт			7,512

Эх сурвалж: ХНХЯ-ын Санхүү, төлөвлөлтийн газар (2021)

- ② Нийгмийн халамж хариуцсан төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн онцлог, тулгарч буй асуудал

2018 онд ХХҮЕГ нийгмийн халамжийн салбарт ажиллаж буй 924 төрийн албан хаагчаас (аймгийн ХХҮХ-ийн 636, дүүргийн ХХҮХ-ийн 288 албан хаагч) судалгаа авсан²⁹. Судалгааны дүнд тодорхойлсон халамжийн салбарын хүний нөөцийн онцлогыг дор тусгав.

А) Харьцангуй залуу


Судалгаанд хамрагдагсдын 8.7% нь 20-25 нас, 20.0% нь 26-30 нас, 27.0% нь 31-35 нас, 15.1% нь 36-40 нас, 5.7% нь 41-45 нас, 8.8% нь 46-50 нас, 14.7% нь 51-ээс дээш настай байв. Талаас илүү хувь нь 20-35 насны залуучууд байна.

В) Албан хаагчдын дийлэнх нь эмэгтэйчүүд байна

Судалгаанд оролцогчдын 28.1 хувь нь эрэгтэй, 71.9 хувь нь эмэгтэйчүүд байв.

С) Мэргэжлийн боловсон хүчин цөөн

Мэргэжлийн байдлаар нь авч үзвэл 16.1% нь нийгмийн ажилтан, 14.1% нь эдийн засагч, 26.9% нь санхүүгийн мэргэжилтэн, нягтлан бодогч, 10.6% нь багш, 8.8% нь хуульч, 23.5% нь бусад төрлийн мэргэжилтэй байна (зураг 3-11).



Д) Ажилласан жил харьцангуй цөөн

38.8% нь төрийн албан хаагчаар 1-5 жил, 28.0% нь 6-10 жил, 12.2% нь 11-15 жил, 7.4% нь 16-20 жил, 6.2% нь 21-25 жил, 7.4% нь 26-аас дээш жил ажилласан байна. Бараг 70% нь 10-аас доош жил ажиллаж байна. Эдгээр үзүүлэлтээс ажлаас гарах хүмүүс их байдаг нь харагдаж байна.

- ③ Нийгмийн ажилтны өнөөгийн байдал, тулгарч буй асуудал

“Нийгмийн хамгааллын салбарын ажилтны тоо”-ны талаар 3-4 хүснэгтэнд дурдсанчлан 2020 онд Улаанбаатар хотын 9 дүүргийн ХХҮХ-д 307 албан хаагч, 169 хороонд 172 нийгмийн ажилтан, 21 аймгийн ХХҮХ-т 657, 330 сумд 411 нийгмийн ажилтан ажиллаж байна. Өөрөөр хэлбэл нийгмийн халамж үйлчилгээний ажлыг 1547 хүн (964 нь ХХҮХ-ийн албан хаагч, 583 нь нийгмийн ажилтан) хариуцан ажиллаж байна.

²⁹ 2020 онд дүүрэг, аймгийн ХХҮХ, газрын албан хаагчийн тоо 964 байв. (судалгааны он өөр боловч 2018 оны судалгаанд оролцсон 924 албан хаагч нийт албан хаагчдыг төлөөлнө гэж үзэж болно.

Нэг нийгмийн ажилтан халамжийн үйлчилгээнд хамрагдах 4380 үйлчлүүлэгчийг хариуцдаг. Өдөрт нэг ажилтан дунджаар 18 хүнд үйлчилж байна³⁰. Ажлын цагаар тооцвол нэг үйлчлүүлэгчид дунджаар 26 минут зарцуулдаг³¹ байна. Гэхдээ энэ нь дундаж хугацаа юм. Нэг нийгмийн ажилтан хариуцах үйлчлүүлэгчийн тоо Говь-Сүмбэр аймаг, Хан-Уул дүүрэгт хамгийн их буюу 6750 байна (зураг 3-12)³². Өдөрт дунджаар 28 хүнд үйлчилдэг, ажлын цагаар авч үзвэл нэг үйлчлүүлэгчид 17 минут зарцуулдаг³³. Эдгээр үзүүлэлтээс нийгмийн ажилтны ажлын ачаалал өндөр байгаа нь харагддаг. Мөн нэг нийгмийн ажилтанд ногдох үйлчлүүлэгчийн тоо харьцангуй бага болон их газрыг харьцуулахад 3 дахин ялгаатай байв. Иймд орон нутгын ялгааг арилгах нь шийдвэрлэх шаардлагатай асуудал юм.

Мөн Японд халамжийн хэлтсийн ажилтны орон тоог тусламж шаардлагатай өрхийн тооноос хамааран захирамжаар тогтоодог бөгөөд нийслэл, мужид тусламж шаардлагатай өрхийн тоо 390



Зураг 3-12: Аймаг, дүүрэг тус бүрийн 1 нийгмийн ажилтанд ногдох нийгмийн халамж хүртэгчийн тоо (2020 он)

Эх сурвалж: ХХҮЕГ (2021) Статистик мэдээг ашиглаж, судалгааны баг гаргав.

³⁰ Жилийн ажлын 240 хоногоор тооцдог.

³¹ Нэг өдрийн ажлын цагийг 8 цагаар тооцдог.

³² Багахангай дүүрэгт нийгмийн ажилтан байхгүй тул 3-14 зурагт оруулж тооцоогүй.

³³ 2021 оны 3-р сарын сүүлчийн байдлаар Японд нийгмийн ажилтан 257,293, асаргааны халамжийн ажилтан 1,754,486, сэтгэцийн эрүүл мэндийн халамжийн ажилтан 93,544 (нийт 2,105,323) ажиллаж байна (<http://www.sssc.or.jp/touroku/tourokusya.html>). Эдгээр ажилтан хүн амын тоонд 1.7%-ийг эзэлдэг. Харин МУ-ын 1,547 нийгмийн ажилтан хүн амын тоонд 0.05%-ийг эзэлж байна. Хоёр улсын халамжийн хөтөлбөр ялгаатай тул энэ удаад үйлчилгээ авагчдын тоогоор харьцуулаагүй болно. Нийгмийн ажилтаны хүн амын тоонд эзлэх хувиар харьцуулахад МУ-ын нийгмийн ажилтаны тоо Японоос цөөн байгааг харж болно.

ба түүнээс бага байх тохиолдолд жишиг орон тоог 6 хүнээр тогтоосон байдаг ба нэмэгдсэн 65 өрх тутамд 1 ажилтан нэмж ажиллуулдаг. Хотын статустай газруудад 240 ба түүнээс цөөн тооны өрхөд 3 ажилтан, нэмэгдсэн 80 өрх тутамд 1 ажилтан нэмж ажиллуулна. Хотхон, тосгонд 60 ба түүнээс цөөн өрхтэй бол 2 ажилтан, нэмэгдсэн 80 өрх тутамд 1 ажилтан нэмж ажиллуулах³⁴ ба ихэвчлэн тусламж шаардлагатай 80 өрх тутамд 1 ажилтантай байхаар тооцдог. Мөн 2021 оны 3-р сарын сүүлийн байдлаар Япон улсад нийгмийн халамжийн ажил үүрэг гүйцэтгэдэг нийгмийн халамжийн ажилтан 257,293, асаргааны халамжийн ажилтан 1,754 486, сэтгэцийн халамжийн ажилтан 93,544, нийт 2,105,323 ажилтан ажиллаж байгаа³⁵ ба энэ нь хүн амын 1.7% -ийг эзэлж байна. Нөгөөтэйгүүр, Монгол Улсад 1,547 нийгмийн ажилтан ажилладаг ба хүн амын 0.05% -ийг эзэлж байна. Хэрэгжүүлж буй нийгмийн халамжийн хөтөлбөрүүд харилцан адилгүй тул ерөнхий харьцуулалт хийх боломжгүй ч МУ-ын нийгмийн ажилтанд ногдох үйлчилгээ хүртэгчдийн тоо Японтой харьцуулахад олон, нийгмийн ажилтны тоо нь Японтой харьцуулахад цөөн байгааг харж болно.

3-2-5 Нийгмийн халамжийн системийн хүндрэл бэрхшээл

① Нийгмийн халамжийн хамрах хүрээ

Монгол Улсын нийгмийн халамжийн тогтолцоонд тулгамдаж буй гол асуудал бол халамжийн хамрах хүрээ хэт өргөн, ядуу зорилтот бүлэгт чиглээгүй байна. “Нийгмийн халамж хүртэгч иргэд”-ийн талаар 3-2-2-т тусгаснаар 2019 онд нийт хүн амын 58% нь нэг ба түүнээс дээш тооны нийгмийн халамжийн хөтөлбөрт хамрагджээ. Хүнсний эрхийн бичиг хөтөлбөр, ХЭБ авагчдын эрүүл мэндийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх хөтөлбөр нь ядуу иргэдэд чиглэсэн бол нийгмийн халамжийн тэтгэвэр, халамжийн тэтгэмж авагчид, ХБИ-дэд олгох тусламж, хөнгөлөлтөд хамрагдсан хүний ихэнх нь амьжиргааны түвшин доогуур иргэд байна. Жишээлбэл, ХЭБ хөтөлбөрийн зардал 100% ООТА-аар тодорхойлсон өрхийн амьжиргааны түвшин хамгийн доогуур 40 хувьд зарцуулагдаж байгаа ба нийгмийн халамжийн тэтгэвэр, нийгмийн халамжийн тэтгэмж болон ХБИ-нд олгох тэтгэмжийн 50 ба түүнээс дээш хувь нь хамгийн ядуу 40 хувьд олгогддог. Бусад нийгмийн халамжийн хөтөлбөрүүд нь ахмад настан, эхчүүд, алдар цолтон ахмад настан, хүүхдүүд зэрэг хүн амын тодорхой бүлгийг хамруулдаг. Гэвч АХБ-ны дэмжлэгтэйгээр 2019 онд хийсэн судалгаагаар, 2018 онд нийгмийн халамжийн нийт зарлагын 55% нь хүн амын хамгийн ядуу 40 хувьд зарцуулагдсан бол нийт зарлагын 26% нь хүн амын хамгийн чинээлэг давхаргын 40 % хувьд зарцуулагдсан байна³⁶.

② Нийгмийн халамжийн үйлчилгээний төвөгтэй байдал

Нийгмийн халамжийн хөтөлбөр нь олон төрлийн урамшуулал, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээнээс бүрддэг.

³⁴ ЭМНХХЯ, Халамжийн хэлтсийн ажилтны тоо

https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/hukushi_kaigo/seikatsuhogo/fukusijimusyo/index.html (мэдээлэл авсан огноо: 2021-06-12)

³⁵ Нийтийн ашгийн төлөөх байгууллага-Нийгмийн халамжийн хөгжил/үнэлгээний төв, Бүртгэлтэй иргэдийн нөхцөл байдал <http://www.sssc.or.jp/touroku/tourokusya.html>: (мэдээлэл авсан огноо 2021-06-12)

³⁶ Erdem Partners, Ulaanbaatar, 2019 “Mongolia's Social Welfare System: Study on Expenditure Allocation and Beneficiary Profile”.

Нийгмийн халамжийн хөтөлбөрүүд нь олон төрлийн тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээнээс бүрддэг. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмадуудад нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмж, онцгой тохиолдлын тэтгэмж, оршуулгын тэтгэмж, орон сууцны хэрэглээний зардал, түлш, протез, ортопед, тусгай хэрэгсэл, нийтийн тээвэр, амралт, рашаан сувилал, харилцаа холбоо, шуудангийн зардлын хөнгөлөлт, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ зэрэг олон нэр төрлийн хөнгөлөлт, үйлчилгээг янз бүрийн давтамжтай, хэмжээтэйгээр олгож байна. Эдгээр олон төрлийн тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийг авахын тулд халамж хүртэгч нь тухай бүр (ихэвчлэн жил бүр) өргөдөл хүсэлт гаргаж, баримт материал бүрдүүлэх ёстой болдог. Энэ нь халамж хүртэгчдэд чирэгдэлтэйгээс гадна хүсэлтийг шийдвэрлэх, хянахтай холбоотой халамжийн байгууллагын захиргааны үйл ажиллагаа нэмэгддэг. Түүнчлэн 1000 хүнээс цөөн хүнийг хамардаг тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээний төрлүүд байна.

Жишээлбэл ХХҮЕГ-ын статистикийг харвал, 2019 онд ганц бие ахмад настныг асран хамгаалж байгаа иргэнд олгодог тэтгэмж авсан хүн 157, дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй орон гэргүй өрх толгойлсон эх/эцгийн амьжиргааг дэмжих тэтгэмж авдаг иргэн 37, гэрээр асаргааны үйлчилгээ авдаг 252 иргэн байна. Бас цэцэрлэгийн хоолны зардлын хөнгөлөлт эдэлсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 30, хүүхдийн зуслангийн төлбөрийн 50 хувийн хөнгөлөлт эдэлсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 175, холбоо харилцааны үйлчилгээний зардлын хөнгөлөлт эдэлсэн харааны бэрхшээлтэй 8 иргэн байсан байна. Эдгээрийн адил хамрах хүрээ багатай үйлчилгээ олон байгаа ба үйлчилгээ хүртэгчдийн хэрэгцээг хангаж, бусад үйлчилгээтэй нэгтгэх шаардлага байгаа эсэх дээр үнэлгээ хийж үзэх шаардлагатай.

③ Нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх арга хэлбэр

Нийгмийн халамжийн нийт зарлагын 99% мөнгөн тэтгэвэр, тэтгэмжид зарцуулагдаж байгаа ба нийгмийн халамжийн үйлчилгээнд зөвхөн 1 хүрэхгүй хувийг зарцуулдаг.³⁷ХБИ, ганц бие эх/эцэг, байгалийн гамшиг болон эдийн засгийн хямралын нөлөөнд автсан хүмүүс зэрэг нийгмийн халамжийн зорилтот бүлгийн иргэдийн хувьд хөдөлмөр эрхлэх боломж нь хязгаарлагдмал байдаг тул ядууралд өртөмхий байна.Монголд бага орлоготой, хөдөлмөр эрхлэх боломж нь хязгаарлагдмал эдгээр ядуу, эмзэг бүлгийн иргэдэд бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ дутагдаж байна. Халамж хүртэгч иргэдийг ядуурлаас гаргахад зөвхөн мөнгөн тэтгэмж олгох нь хангалтгүй ба энэ нь халамжид найдаж амьдрах нөхцөл байдлыг дэвэргэж, ажил хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхолыг бууруулах магадлалтай. Жишээлбэл 2010 онд хүүхдийн мөнгөн тэтгэмжээс бусад нийгмийн халамж хүртэгч нь нийт хүн амын 18 хувийг эзэлж байсан бол 2019 онд 28 % болж өсөн, ажилгүйдлийн түвшин мөн үед 7.7% байснаас 10% болж нэмэгдсэн байна.

Нийгмийн халамжийн хөтөлбөр дээр тулгардаг хүндрэл бэрхшээл ба түүний шалтгаанд хийсэн дүн шинжилгээг хүснэгт 3-5-д тусгав.

³⁷ ХХҮЕГ-аас гаргасан 2019 оны “Нийгмийн халамжийн сангийн зарлагын тайлан”-д үндэслэн, судалгааны баг тооцож гаргав.

Хүснэгт 3-5: Нийгмийн халамжийн хөтөлбөр дээр тулгардаг хүндрэл бэрхшээл ба түүний шалтгаанд хийсэн дүн шинжилгээ

№.	Хөтөлбөрийн ангилал	Хүндрэл бэрхшээл ба шалтгааны дүн шинжилгээ
1	Нийгмийн халамжийн тэтгэвэр	ХХҮЕГ-ын тооцооллоор, 2019 онд нийгмийн халамжийн тэтгэвэр авдаг 62,640 хүнээс 42,541 (ойролцоогоор 70%) нь ХБИ байсан. Эдгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 68.5% (29,150 хүн) нь хөдөлмөрийн чадвараа 50-69% алдсан, зохистой анхаарал хандуулбал ажил эрхлэх чадвартай хүмүүс байна. ХХҮЕГ-ын тооцооллоор, Нийгмийн халамжийн тэтгэвэр хүртэгч иргэдийн 49% (20,845) нь ядуурлын шугамаас доогуур түвшинд амьдарч байна. 2021 оны байдлаар нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 188,000 төгрөг бөгөөд ҮСХ-ноос тогтоосон амьжиргааны доод түвшингээс доогуур байна³⁸. Тиймээс нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлж, ХБИ-ий хөдөлмөр эрхлэлт, орлогыг дэмжих бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байна.
2	Нийгмийн халамжийн тэтгэмж	2019 онд 65,000 хүн асаргааны тэтгэмж авсан байна. Эдийн засгийн байдал хүндрэхийн хэрээр асаргааны тэтгэмж авах хүсэлтэй иргэд нэмэгдэх хандлагатай байна. Асаргаа үзүүлэгчийн урамшуулалтай холбоотой бэрхшээл асуудлыг доор үзүүлэв. • 2018 он хүртэл, байнгын асаргаа шаардлагатай иргэнийг тодорхойлох зохистой шалгуур, тогтсон онош байдаггүй байсан. Шинээр нэвтрүүлсэн шалгуурыг тогтмол шинэчилж, сайжруулж байх шаардлагатай. • Сум, дүүргийн мэргэжлийн эмч нарын хяналтын комисс нь өвчтөнд байнгын асаргаа шаардлагатай эсэх тухай шийдвэр гаргадаг. Гэвч онош алдаатай гарсан тохиолдолд бараг хариуцлага хүлээдэггүй. • Сар бүр асаргааны тэтгэмж авч байгаа иргэн, байнгын асаргаа шаардлагатай иргэнийг тогтмол асарч хамгаалж байгааг хянах нийгмийн халамжийн байгууллагын хяналтын тогтолцоо сул. • Байнгын асаргаа шаардлагатай хүнийг асарч байгаа хүнд сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, сургалт явуулах зэрэг нэмэлт үйлчилгээ байхгүй. 2019 онд 61,352 иргэн онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмж авсан байна. Эдгээрийн дотроос байнгын асаргаа шаардлагатай 40,402 иргэнд улирал тутамд 84,500 төгрөгийн тэтгэмж олгосон. Асаргаа үзүүлж байгаа хүнд сар бүр тэтгэмж олгодог боловч байнгын асаргаанд байгаа иргэнд улирал тутамд тэтгэмж олгодог. Иймд хүнд өвчтэй хүний эм тариа, асаргаа сувилгааны материалын зардал их байдаг учраас тэтгэмжийн хэмжээ нь хүрэлцдэггүй. Иймээс хүнд өвчтэй иргэдийн эмчилгээний зардал, асаргааны зардал өндөр учраас тэдэнд олгож байгаа тэтгэмжийн хэмжээ хангалтгүй байна.
	Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох урамшуулал ("Алдарт эхийн одон" хөтөлбөр)	1957 онд алдарт эхийн урамшуулал (алдарт эхийн одон 1, 2) бий болсон. 2019 онд 223,250 эх энэ урамшуулалд хамрагдсан ба 29.3 тэрбум төгрөг улсаас зарцуулсан байна. Энэ хөтөлбөрөөр эхийн амьжиргааны түвшин, хүүхдийн наснаас үл хамааран, 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдэд жил бүр мөнгөн урамшуулал олгодог. Нас хамаарахгүй 4 ба түүнээс дээш хүүхэдтэй эхчүүд хамрагддаг тул урамшуулал хүртэгчдийн 70% нь 50 ба түүнээс дээш настай эхчүүд байна. Ингэснээр бага насны олон хүүхэдтэй эхчүүдийг дэмжих нийгмийн халамжийн бодлогын үүрэг алдагдаж байна.
4	Хүүхдийн мөнгөний хөтөлбөр	Хүүхдийн мөнгөний хөтөлбөр нь хамгийн их мөнгөн дүнтэй хөтөлбөр бөгөөд, 2019 онд 1,000,557 хүүхэд энэ хөтөлбөрт хамрагдаж, нийт 229.5 тэрбум төгрөг зарцуулсан. • Бүх хүүхдэд ижил хэмжээтэй олгогддог ба хүүхдийн нас, тусгай хэрэгцээ, мөн амьдралын түвшин хамаарахгүй. • Сар бүр олгодог 20,000 төгрөг нь ядуу өрхийн хүүхдүүдийн хөгжил, боловсролд хангалттай дэмжлэг болж чадахгүй ба нөгөө талаар чинээлэг өрхийн хувьд тийм ч хэрэгцээтэй биш юм.

³⁸ 2021 онд, нэг хүнд ногдох амьжиргааны доод түвшин нийслэлд 238,700 төгрөг, бусад орон нутагт 207,400-213,800 байна. <https://www.1212.mn/default.aspx> (мэдээлэл авсан огноо: 2021-06-14)

5	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөр	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөр нь 2010 онд туршилтаар хэрэгжсэн бөгөөд 2010 оноос улсын төсвийн санхүүжилттэй нийгмийн халамжийн хөтөлбөр болон хэрэгжиж эхэлсэн. 2019 онд энэ хөтөлбөрт 265,511 иргэн хамрагдсан байна. Энэ хөтөлбөртэй холбоотой асуудлуудыг доор тусгав. • Ядуу бүлэгт багтдаг ч хөдөлмөрийн насны, ямар нэгэн хөгжлийн бэрхшээлгүй иргэнд ч нэмэлт шалгуур тавьдаггүй. • Бусад нийгмийн хамгааллын болон хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөртэй уялдаа муутай. • ХХҮЕГ-ын халамжийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэнтэй ярилцлага хийх үед, хөтөлбөрт хамрагдах хугацаанд хязгаар байдаггүй учраас 2013 оноос энэ хөтөлбөрт хамрагдсаар байгаа өрх байгаа гэж онцолж ярьж байсан.³⁹ • ООТА-ыг хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамруулах эсэхийг тогтооход ашиглаж байгаа. 2016 оноос хойш энэ аргачлалыг шинэчилж сайжруулаагүй бөгөөд, хамрагдагчийг сонгоход алдаа заадаг талаар мэдээлэл ирж байсан байна.
6	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	2019 онд ойролцоогоор 15,294 иргэн ОНОТХҮ-нд хамрагдсан ба нийт зарлага нь 1.7 тэрбум төгрөг бөгөөд энэ нь нийт нийгмийн халамжийн зарлагын 0.3 орчим хувийг эзэлж байна. ОНОТХҮ нь дараах асуудалтай тулгарч байна. • ТББ, ААН, холбогдох хүмүүсийн ОНОТХҮ-ний талаарх мэдлэг хангалтгүй. • Ялангуяа орон нутагт, ТББ, ААН-үүд нь гэрээнд тусгагдсан шаардлагыг хангадаггүй. • Үйлчилгээний стандарт, загвар хөгжөөгүй. • Гол үзүүлж байгаа үйлчилгээ нь сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээгээр хязгаарлагддаг. • М&Е буюу мониторинг, үнэлгээний систем хөгжөөгүй.
7	Мэргэжлийн байгууллагын асрамжийн үйлчилгээ	Нийгмийн халамжийн сангаас санхүүждэг асрамжийн газрын үйл ажиллагаа, үйлчилгээнд тулгарч байгаа асуудлын талаар 5-р бүлэгт тусгав.
8	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдсан иргэдэд эрүүл мэндийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	МУ бүх нийтээр эрүүл мэндийн даатгалд албан журмаар хамрагдах тогтолцоог бий болгосон. 18 нас хүрээгүй хүүхэд, ахмад настан болон 3 нас хүрээгүй хүүхдээ асарч, ажил эрхлэхгүй байгаа эхчүүдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцдаг. Бас хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлөхөд 83.1 тэрбум төгрөг зарцуулжээ. Гэвч энэ хөтөлбөр нь доор дурдсан асуудалтай тулгарч байна. • Энэ хөтөлбөр нь эрүүл мэндийн үйлчилгээнд гарах нэмэлт зардлаас иргэн халааснаасаа төлөх зардлыг хариуцдаггүй. • Хувийн байгууллагын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, түүнтэй холбоотой олгогдох жор бүхий эм нь хамаарахгүй зэрэг эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний хамрах хүрээ нь хязгаарлагдмал. Иймээс олон ядуу иргэд хувийн байгууллагын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртэх боломжгүй байна. • Төрөөс ядуу өрхийн эрүүл мэндийн даатгалд их хэмжээний хөрөнгө зарцуулж байгаа хэдий ч, ядуу өрхийн иргэдийн эрүүл мэндийн тусламжийн хүртээмж хэрхэн сайжирч байгаа талаар үнэлгээ хийгдээгүй.
9	0-3 хүртэлх насны хүүхдээ асарсны тэтгэмж ("Цалинтай ээж" хөтөлбөр)	Энэ хөтөлбөр нь 2018 онд хэрэгжиж эхэлсэн ба халамжийн томоохон хөтөлбөрүүдийн нэг юм. 2019 онд хөтөлбөрт 204,493 эхийг хамруулж, 92.3 тэрбум төгрөг зарцуулжээ. Энэ хөтөлбөрийн асуудалтай талыг доор тусгав. • Хөтөлбөрийн хамрах хүрээг тогтоохдоо эхийн орлогыг харгалздаггүй. • Олгож байгаа тэтгэмжийн хэмжээ, өргөн хүрээг хамруулсан байдал нь хэрэгцээ шаардлага, эдийн засгийн үр өгөөж талаасаа асуудалтай. • Эрүүл саруул эхчүүдийн хувьд, бага хэмжээний мөнгөн тэтгэмжээс илүү хүүхэд асрах үйлчилгээний үр дүнтэй байдлыг дээшлүүлж, бага насны хүүхэдтэй эхчүүдийн ажиллах цагийг уян хатан байлгах зэрэг хүүхэд өсгөхөд ашигтай нөхцөл бүрдүүлсэн бодлого хэрэгжүүлэхийг хүсэн хүлээж буй хандлага ажиглагдаж байна.

³⁹ ХХҮЕГ-ын харьяа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс дээр 2021 оны 4 сарын 29-нд хийсэн ярилцлагаас.

10	Ахмад настанд олгох тэтгэмж, хөнгөлөлт	2019 онд 438,321 хүнд 42.2 тэрбум төгрөг зарцуулсан. Энэ хөтөлбөрт доор дурьдсан асуудал байна. • Олон төрлийн тэтгэмж, хөнгөлөлт байдаг бөгөөд ихэвчлэн жилд 1 удаа олгогддог. • Ахмад настнууд эдгээр тэтгэмжийг авах бүрдээ хүсэлт гаргаж, холбогдох материал бүрдүүлж өгдөг. • Тэтгэмжинд ахмад настны амьдралын түвшин (мөн орлого)-гээр хязгаар тавьдаггүй. • Жишээлбэл, ахмадын өдөр, цагаан сарын үеэр ахмадуудад хүндэтгэл үзүүлэх зорилгоор хүн бүрт жил бүр 20,000 төгрөг зарцуулдаг. 2019 онд 128,052 ахмад настан энэ арга хэмжээнд оролцсон ба 1.7 тэрбум төгрөг зарцуулжээ. Энэ нь ОНОТХҮ-ний нийт зарлагатай тэнцэж байна.
11	Алдар цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдэл, тусламж	2019 онд 4,417 иргэн энэхүү хөтөлбөрт хамрагдсан ба 5.2 тэрбум төгрөг зарцуулжээ. Энэ хөтөлбөрт дараах асуудал тулгарч байна. • Хөтөлбөрт хамрагдагчийн тоо олон биш ч, нэг хүнд ногдох зардал нь өндөр. • 2018 онд хийсэн судалгаагаар, хөтөлбөрт хамрагдагч, алдар цолтон ахмад настны 83% нь хүн амын хамгийн чинээлэг 40 хувьд багтаж байгаа бөгөөд⁴⁰, энэ нь амьжиргааны наад захын баталгаа хангах зорилготой хөтөлбөр биш.
12	ХБИ-ий тусламж, хөнгөлөлт	2019 онд 63,133 ХБИ-д 11.5 тэрбум төгрөгийн тусламж, хөнгөлөлт олгосон⁴¹. Энэ хөтөлбөр нь дараах асуудалтай тулгарч байна. • 2018 онд тэтгэмж авч байгаа ХБИ-ний 89% нь хүн амын 20 хувийг эзлэх хамгийн ядуу давхаргад багтаж байсан. • Нийгмийн халамж хүртэж байгаа хэдий ч ихэнх ХБИ урьдын адил ядуу хэвээр байсаар байна. • Өргөн хүрээг хамруулж, жилд нэг удаа олгодог энэхүү тэтгэмж нь ХБИ-ийг бие даан амьдрах чадвартай болоход нь тус нэмэр болдог эсэх нь эргэлзээтэй байна. • ХБИ-ий хэрэгцээнээс хамааруулж, тэтгэмжийн хэмжээ, давтамж, хугацааг ялгаатай тогтоогоогүй. • ХБИ-ий бие даан амьдрах чадварт дэмжлэг үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ дутагдаж байна.

Эх сурвалж: Судалгааны багийн хийсэн ярилцлага (2021 оны 6 сар)

3-3 Халамжийн үйлчилгээний хэрэгжилт, хүртээмжийн байдал, шийдвэрлэх асуудал

3-3-1 Халамжийн үйлчилгээний хэрэгжилтийн байдал

Халамжийн тэтгэмж олгох процессыг 3-13 зурагт тусгав. Тэтгэмж олгох процесст хүсэлт гаргагчийн эрэлт хэрэгцээг тодорхойлохын тулд халамжийн ажилтан, хяналт шалгалт, үнэлгээний ажилтан холбогдох мэдээллийг шалгаж, баталгаажуулан дүгнэлт гаргах процесс хамаардаг. Уг процесст олон хүн мониторинг хийж оролцдог. Тэтгэмж олгох процесст бичиг хэргийн ажил их байдаг. Нийгмийн ажилтантай хийсэн онлайн ярилцлагын үеэр тэтгэмж олгох эсэхийг шийдвэрлэхдээ тухайн өрхийн нөхцөл байдлыг (жишээлбэл өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг эсэх, тухайн хүний нөхцөл байдал зэрэг) шалгаж, гэрээр нь очиж уулздаг дүүргүүд байгаа нь харагдсан.


⁴⁰ Erdem Partners, Ulaanbaatar, 2019 “Mongolia's Social Welfare System: Study on Expenditure Allocation and Beneficiary Profile”.

⁴¹ Эрдэм Партнерс, Улаанбаатар хот, 2019 он “Монгол Улсын нийгмийн халамжийн тогтолцоо: Зардлын хуваарилалт, тэтгэмж авагчийн танилцуулга”.


оноонд үндэслэн үнэлж, тогтоодог. 3 жил тутамд ӨАТТС-ний судалгааг⁴⁵ хийдэг. Харин дундах нь хугацаанд өрхийн хүсэлтэд үндэслэн мэдээллийг шинэчилдэг. Судалгаагаар цуглуулсан өрхийн мэдээллийг хянах, бусад мэдээллийн сантай тулгах зэргээр баталгаажуулсаны дараа компьютераар бодсон оноог хавсарган ӨМНС-д хадгалдаг. Мөн ХЭБ зэрэг тусгай хөтөлбөрт хамрагдах шалгуурыг хангах эсэх нь өрхийн амьжиргааны түвшний оноо болон орон нутгийн АДЗ-өөс гаргасан эцсийн шийдвэрт үндэслэдэг. 2016 оноос хойш, ООТА шинэчлэгдээгүй бөгөөд хамрагдагчийн сонгоход алдаа заадаг талаар мэдээлэл бүртгэгдсэн байгаа. НҮБ-ын Хүүхдийн сан нь 2019 онд ООТА нь субъектив, чанар муутай, сайн бэлтгэгдээгүй орон нутгийн иргэд богино хугацаанд явуулсан гэж тайландаа тусгасан байна. ООТА нь бараг ижил нөхцөлд байгаа өрхүүдийг үйлчилгээнд хамрагдах эрхтэй, эрхгүй гэж ялган, олон нийтийн дунд таагүй байдал бий болгосон. Мөн үр дүн нь үнэн зөв биш учраас ядуу өрхүүд хамрагдаж чадахгүй үлдэх алдаа гардаг ба 2017 онд ийм алдаа 20% гарсан гэж тусгажээ⁴⁶.

В) Халамжийн мэдээллийн хяналтын систем

ХМХ, ХЭБ -аас бусад халамжийн хөтөлбөрийг Халамжийн мэдээллийн хяналтын систем (цаашид “ХМХС” гэх) удирддаг. ХУМС мэдээллийн санд үйлчлүүлэгчийн бүртгэлийн дугаар, халамжийн хөтөлбөрийн код, авсан тэтгэмжийн дүнгийн талаарх мэдээлэл агуулагддаг. 2019 онд бүртгүүлэгчдийн тоо 687,976 байсан бол 2020 онд 669,030 болсон. Хүйсийн харьцааг харвал эмэгтэйчүүд 80 орчим хувийг эзэлж байна (зураг 3-14). Үүнд эмэгтэйчүүдэд зориулсан "Одонтой эхийн мөнгөн тэтгэмж (Mother's Glory Program)", "Цалинтай ээж (Mothers with Salary Program)" хөтөлбөр их нөлөөлсөн. Насаар нь авч үзвэл 16-аас дээш насны хөдөлмөрийн насны (55 хүртэлх насны эмэгтэйчүүд, 60 хүртэлх насны эрэгтэйчүүд) иргэд 60 орчим хувийг эзэлж байна (зураг 3-15).



Зураг 3-14: WAIS-д бүртгэлтэй иргэдийн тоо, хүйсээр
Эх сурвалж: ХНХЯ (2021) "Нийгмийн халамжийн сангийн зарлага"-аас харж, судалгааны баг гаргав.



Зураг 3-15: WAIS-д бүртгэлтэй иргэдийн тоо, насны бүлгээр
Эх сурвалж: ХХҮЕГ (2021) WAIS-ийн мэдээллээс ашиглаж, судалгааны баг гаргав.

⁴⁵ 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн ХХҮХ 2013, 2017 оны ӨАТҮ-ний судалгааг хариуцаж хэрэгжүүлсэн. On-Demand үнэлгээг хариуцдаг.

⁴⁶ UNICEF, 2019, Universal Child Benefit Case Studies: The Experience of Mongolia <https://www.unicef.org/media/70471/file/MNG-case-study-2020.pdf> (мэдээлэл авсан огноо: 2021-06-15)

С) Халамжийн нэгдсэн систем

Халамжийн үйлчилгээний нэгдсэн систем "e-halamj" нь e-Mongolia⁴⁷ дотор халамжийн асуудлаар дагнасан онлайн систем юм. Үйлчлүүлэгч цаасаар өргөдөл гаргалгүйгээр халамжийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой бүх төрлийн үйлчилгээ авах боломжтой болгохын тулд 2020 оны 8 сард нэвтрүүлсэн. ХНХЯ системийн үндсэн дизайныг гаргаж, Сангийн яамны Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвд програм хангамжийг боловсруулсан. Үйлчлүүлэгч уг цахим хуудаснаас⁴⁸ дараах 6 төрлийн халамжийн үйлчилгээний хүсэлт гаргах боломжтой.

1. Жирэмсэн эхийн тэтгэмж (Жирэмсний 5 сартайгаас хүүхэд төрүүлэх хүртэлх хугацаанд олгох тэтгэмж)
2. 0-3 хүртэлх насны хүүхэд асарсаны тэтгэмж
3. Ихэр хүүхдийн тэтгэмж
4. 3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/-т улирал бүр олгох тэтгэмж
5. 65-аас дээш насны ахмад настанд жилд 2 удаа олгох “насны хишиг”
6. 4 ба түүнээс дээш хүүхэдтэй эхчүүдэд жил бүр олгох “одонтой эхийн мөнгөн тэтгэмж”

Судалгаагаар уг онлайн систем нь дараах давуу талуудтай болох нь харагдсан.

【BOX】

- Үйлчлүүлэгч ehalamj.mn вэбсайт, төрийн үйлчилгээний цахим машин, ухаалаг гар утасны ebarimt.mn программ зэрэг онлайн систем ашиглан ХХҮХ-ээс үйлчилгээ авсанаараа цаг хэмнэх боломжтой.
- Цаасаар өргөдөл гаргах шаардлагагүй, хэмнэлттэй.
- Өмнө нь өргөдөл гаргах процесс дунджаар 15 хоног үргэлжилдэг байсан бол одоо үйлчилгээний төрлөөс хамааран 2-5 хоног болж багассан.
- Үйлчлүүлэгч өөрийн дансаар дамжуулан шууд мөнгөн тэтгэмж, тэтгэвэр авах боломжтой.
- Үйлчлүүлэгч өргөдөл гаргах процессыг хянах боломжтой.
- Сум, хороо бүрт хурууны хээ уншигч төхөөрөмж тавигдсан байдаг тул үйлчлүүлэгч төрийн мэдээлэл солилцооны “Хур” систем болон бусад цахим системнээс 39 төрлийн халамжийн үйлчилгээнд шаардлагатай баримт бичиг, гэрчилгээг шууд татаж авах боломжтой.
- Үйлчлүүлэгч цаасан баримт бичгийг e-halamj системээс файл хэлбэрээр авах боломжтой.
- Өмнө нь халамжийн тэтгэмж, тэтгэвэр олгохын тулд арилжааны банкны 465 данс хэрэглэгддэг байсан бол одоо төрийн сангийн 13 дансаар дамжуулан халамжийн тэтгэмж, тэтгэврийг шууд тэтгэмж авагчийн дансанд шилжүүлдэг болсон.

Нийгмийн ажилтнаас ярилцлага авч, уг системийн давуу тал, шийдвэрлэх асуудлыг хүснэгт 3-6-д тодорхойлов (3-6 хүснэгт).

Хүснэгт 3-6: E-halamj систем ашиглахын давуу тал ба хүндрэл

Ярилцлагад орсон ажилтан	E-halamj ашиглахын давуу тал ба хүндрэл
Хэнтий аймгийн нийгмийн ажилтан	- Мэргэжилтнүүд нь e-halamj системийн талаарх 2 удаагийн сургалтад хамрагдсан. - Хэрэглэгчид нь системийг ашиглаж дасаагүй. - Системийн хөгжүүлэлтийг илүү сайжруулж, ашиглахад илүү хялбар болгох шаардлагатай.

⁴⁷ e-Mongolia цахим хуудасны англи хэл дээрх сайт: <https://www1.e-mongolia.mn/home> (мэдээлэл авсан огноо: 2021-5-22)

⁴⁸ <https://ehalamj.mn/#firstPage> (мэдээлэл авсан огноо: 2021-3-20).

Чингэлтэй дүүргийн нийгмийн ажилтан	- Нийгмийн даатгалын хэлтэс болон хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээр үйлчлүүлэгчдийн авч байгаа үйлчилгээ нь ялгаатай (үйлчлүүлэгчийн зүгээр харахад ойлгоход амаргүй). - Мэдээлэл дутуугаас болж үйлчлүүлэгчид нь e-halamj-ийг бүрэн ашиглаж чаддаггүй. - Нийгмийн халамжийн үйлчилгээ авдаг үйлчлүүлэгчдийн ихэнх нь эмзэг бүлгийн иргэд бөгөөд e-halamj үйлчилгээг бүртгүүлэхэд шаардлагатай e-mail хаяггүйгээс гадна ухаалаг утас хэрэглэдэг хүн ч цөөн. - Туслах хүн байхгүй бол үйлчлүүлэгчид өөрсдөө ашиглаж чаддаггүй. Жишээ нь e-mail хаягаар бүртгүүлэх байтал facebook хаягаа өгөх хүн байдаг. - Хөгжлийн бэрхшээлтэй иргэд дотор оюуны хомсдолтой иргэд олон байдаг тул, тэдний хувьд ашиглахад хүндрэлтэй. - Халамжийн бүх үйлчилгээ цахим болсон хэрэг биш. - Ажил дээр компьютер байдаг боловч халамж хүссэн иргэд ашиглах боломжгүй. - -E-Mongolia-г хэрхэн ашиглах талаар богино танилцуулга видео бэлтгэх хэрэгтэй. Жишээлбэл, жолооны үнэмлэх авах хүсэлт гаргах дэс дараалал, нийгмийн даатгалын шимтгэл төлөх арга гэх мэт - Ухаалаг утасны аппликэйшн ашиглаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн лавлагаа гаргуулж авдаг болвол зүгээр байна (Одоогоор энэ аппликэйшн нь компьютер болон таблетэнд зориулагдсан бөгөөд, эдгээр төхөөрөмжгүй хүмүүст хүндрэлтэй). - Хэрэглэгчдээс e-halamj үйлчилгээтэй холбоотой санал хүсэлтийг нь сонсож, дээд байгууллагын холбогдох ажилтанд дамжуулж ажилладаг.
-------------------------------------	--

Эх сурвалж: Судалгааны багийн судалсанаар (2021 оны 3 сар)

3-3-3 Халамжийн үйлчилгээн дэх хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, албан бус нөөцийн байдал

Халамжийн үйлчилгээ нь дээр дурдсан 12 хөтөлбөрт хуваагддаг. Эдгээрээс хувийн хэвшилтэй хамтран ажиллах хөтөлбөр нь "Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ" (цаашид "ОНОТХҮ" гэх) юм.

ХХҮЕГ-ын даргын 2020 оны А/58 тоот тушаалын дагуу "Орон нутгийн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал", ХНХЯ-ны сайдын А/374 тоот тушаалын дагуу 2019 оны 12 сарын сүүлчээр батлагдсан "Орон нутагт түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний сургалт, үйлчилгээний чанарын стандарт"-ыг үндэслэн жил бүр батлагдсан ОНОТХҮ-ний төсөв батлагддаг. Уг батлагдсан төсвийг хүн амын тоонд нийцүүлэн аймаг, дүүрэгт хуваарилдаг. Үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн байгууллагыг тендерээр сонгон шалгаруулдаг.

Хувийн байгууллагын магадлан итгэмжлэлийг орон тооны бус гишүүдээс бүрдсэн ХХҮЕГ-ын дэргэдэх Магадлан итгэмжлэлийн зөвлөл хариуцаж ажилладаг. Мөн Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Сайдын 2019 оны 2 сарын 14-ний өдрийн "А / 65" тушаалаар батлагдсан "Орон нутагт халамжийн үйлчилгээ үзүүлдэг иргэд, аж ахуйн нэгж болон ТББ-ыг магадлан итгэмжлэх журам"-ын дагуу магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан байгууллага нь дараах шаардлагыг хангасан байх шаардлагатай.

- Нийгмийн халамжийн үйлчилгээний чиглэлээр нэгээс дээш жил ажилласан байх

- Сэргээн засах үйлчилгээ үзүүлдэг байгууллага нь уламжлалт болон сэргээн засах эмчилгээний чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авсан байх
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний стандартыг хангасан ажлын байртай байх
- Тусгай зөвшөөрөл болон магадлан итгэмжлэлд заасан үйлчилгээ үзүүлэх тусгай ажилтнуудтай байх
- Татварын болон нийгмийн даатгалын байгууллагад өр төлбөргүй байх
- ТББ-аар магадлан итгэмжлэгдсэн байх
- Жилийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг байх
- Гаргаж өгсөн бичиг баримтууд нь баттай баримтанд үндэслэсэн, бодитой байх
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарын стандарт, журам, шалгуурыг хангасан байх
- Тусгай зөвшөөрөлд тусгасан үйл ажиллагааг бодитой хэрэгжүүлсэн туршлагатай байх
- Сүүлийн хоёр жилийн хугацаанд шүүх болон холбогдох эрх бүхий байгууллагаас ноцтой зөрчил гаргасан, гэрээний үүргээ биелүүлээгүй, мэргэжлийн хүрээнд хууль бус үйлдэл хийсэн гэдэг нь тогтоогдсон бол өргөдлийг хүлээн авахгүй.

Аймаг, дүүргийн ХХҮГ, хэлтэс нь тендерийн үнийн дүнгээр сонгогдсон байгууллагатай гэрээ байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана. Сонгогдсон ТББ-ын жагсаалтыг бүх аймаг, дүүргүүд болон олон нийтэд нээлттэй байлгана. Үйлчлүүлэгч уг жагсаалтыг харж үйлчилгээгээ сонгох боломжтой. Нэг иргэн олон үйлчилгээ авах тохиолдолд ихдээ дөрвөн үйлчилгээ авч болно (хувийн хэвшлийн жагсаалтыг хавсралт 2, зорилтот үйлчлүүлэгчийн тухай 3-3 хүснэгтээс харна уу).

Хувийн хэвшилтэй хамтран ажиллахад хэд хэдэн асуудал тулгардаг. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд хувийн хэвшилтэй хамтран үйлчилгээ үзүүлж буй ч дийлэнх үйлчилгээний цар хүрээ хязгаарлагдмал байна. Дээр дурьдсан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэхээр хүсэлт гаргагч байгууллагад тавигдах шаардлагад "Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний стандартыг хангасан байртай байх" гэж заасан байдаг. Иймд тухайн орон нутагт үйлчилгээ үзүүлэх ажлын байр шаардлагатай болдог⁴⁹.

Японд "коммьюнити" буюу "олон нийт" гэсэн нэр томъёо нь хөрш зэргэлдээ оршин суух иргэд нэг нэгэндээ харилцан туслалцах замаар бий болсон иргэдийн холбоог илэрхийлдэг. Оршин суугаа газартаа хөршийн холбоо маягаар нэгдэж, идэвхитэй хамтарч ажилладаг. Энэ нь Японы коммьюнитигийн онцлог юм. Харин Монголд цусан төрлийн гэр бүлийн холбоо хүчтэй байдаг хэдий ч харилцан туслалцаж дэмжих, орон нутгийн хэлхээ холбоонд түшиглэсэн зохион байгуулалт хөгжөөгүй. Орон нутагт түшиглэсэн үйл ажиллагааг ТББ-аар гүйцэтгүүлэх тохиолдол байдаг бөгөөд олон нийтийн үйл ажиллагааг ТББ-д хамааруулж үзэх хандлага давамгайл

⁴⁹ ОНОТНХҮ ба түүний хүндрэл бэрхшээлийн талаар хүснэгт 3-5-д тусгасан "Нийгмийн халамжийн хөтөлбөрийн хүндрэл бэрхшээлтэй тал ба шалтгаанд хийсэн дүн шинжилгээ"-г харна уу.

байдаг. Төр ба иргэдийг холбох үүрэгтэй хэсгийн ахлагч нь дүүргээс цалинжиж, гэрээ байгуулан ажилладаг бөгөөд, нийгмийн ажилтныг дэмжиж ажиллах, Японд байдгийн адил иргэдийг төлөөлсөн сайн дурын гишүүн байдаггүй, сайн дураараа үйл ажиллагаанд оролцох явдал нийтлэг биш, сайн дурын ажилд оролцох сэтгэлгээ, ойлголт сайн төлөвшөөгүй байна.

Албан бус нөөцийн нөхцөл байдлын талаар хийсэн ярилцлагын агуулгыг 3-7 хүснэгтэд тусгав.

Хүснэгт 3-7: Албан бус нөөцийн нөхцөл байдал⁵⁰

Ярилцлаганд оролцсон ажилтан	Албан бус нөөцтэй холбоотой мэдээлэл
<u>Сонгинохайрхан дүүргийн 9-р хорооны засаг дарга</u>	ТББ-ын үйл ажиллагааны талаар - Улаан загалмайн нийгэмлэгийн зарим ажилтнууд сэргээн заслын үйлчилгээ үзүүлэх зэрэг сайн дурын хааяа үйл ажиллагаа явуулдаг. - Өнчин хүүхдүүдийг асрах байгууллагыг ТББ ажиллуулдаг. - "Дэлхийн зөн" байгууллага 2010 оноос 10 жилийн турш орон нутгийг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж байна. Оршин суугчдын бүлэг, холбооны тухай - Оршин суугчдаас бүрдсэн, эмэгтэйчүүдийн эсвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүлэг байдаггүй ч ахмадын холбоо байдаг. Худалдаа эрхлэгчдийн холбоо байдаг ба амьдралын боломжгүй иргэд болон гамшгийн хохирол амссан зэрэг иргэдэд хоол хүнсний тусламж үзүүлэх зэргээр дэмжлэг үзүүлдэг. - Сургуульд эцэг эхийн зөвлөл (ЭЭЗ) ажилладаг. - Дэд бүтцийг бий болгох үүднээс айлуудыг блок болгон хувааж байна.
<u>Сонгинохайрхан дүүргийн 9-р хорооны нийгмийн ажилтан</u>	Хэсгийн ахлагчийн тухай - 9-р хороог газар зүйн байрлал, хүн амын тоогоор нь 7 хэсэг болгон хуваадаг ба 7 хэсгийн ахлагч ажилладаг. - Нэг хэсэгт 280-300 орчим өрх байдаг. - Хэсгийн ахлагч нь дүүргийн захиргаатай гэрээ байгуулан ажилладаг ба төрийн албан хаагч биш хэдий ч дүүргээс цалинждаг⁵¹. - Иргэдэд мэдээлэл хүргэж, төр ба иргэдийг холбох үүрэгтэй ажилладаг. - Тухайн нутаг дэвсгэртээ удаан амьдарсан хүн зэргээр оршин суугчиддаа танигдсан хүн сонгогдох ба иргэд, оршин суугчдад тулгарч байгаа асуудлыг сайн ойлгож мэдэрдэг хүн байдаг. - Хэсгийн ахлагчаар ажиллуулах хүнийг хорооны засаг дарга болон нийгмийн ажилтан нь сонгож, дүүрэгт санал оруулдаг. Дүүрэг зөвшөөрвөл, хэсгийн ахлагч нь дүүрэгтэй гэрээ байгуулж ажилладаг. - Хэсгийн ахлагч нь иргэдтэй утсаар ярих болон facebook-аар холбогдох, мессеж бичих зэргээр холбогдож ажилладаг. Сайн дурын үйл ажиллагааны тухайд - Дархлаажуулалт зэрэг дээр сайн дураар ирж ажиллах хүмүүс байдаг. - Жилд 10 орчим удаа оршин суугчид бүх нийтийн цэвэрлэгээ хийдэг (ялангуяа хавар цас хайлах үеэр цэвэрлэгээ их хийдэг). - Жилд нэг удаа мод тарих арга хэмжээ явагддаг. Иргэдэд 250 ш мод тарааж суулгуулсан. - Саяхан өндөр настнууд маск хандивласан. - Тогтмол биш ч гэсэн залуучууд нэгдэж, сайн дурын тусламжийн үйл ажиллагаа явуулах тохиолдол ч бий. - Гамшгаас сэргийлэх сургуулилтыг жил бүрийн 4-р сард явуулдаг. Сургуулилт болох өдрийг хэсгийн ахлагч нь урьдчилан иргэдэд мэдэгддэг. - Хорооны оршин суугчдын төв, соёлын төв байдаггүй ч хорооны байрны иргэдийн танхимыг ямар нэгэн арга хэмжээний үеэр ашиглах үе байдаг.

Эх сурвалж: Судалгааны багийн хийсэн ярилцлага (2021 оны 4 сар)

⁵⁰ Сонгинохайрхан дүүргийн 9-р хорооны засаг дарга болон нийгмийн ажилтантай хийсэн ярилцлага

⁵¹ Хан-Уул дүүргийн Хөдөлмөр, халамжийн хэлтэс дээр хийсэн ярилцлагаар, хэсгийн ахлагчийн сарын цалин 600,000 төгрөг гэж танилцуулсан.

3-4 Нийгмийн халамжийн давуу тал ба хүндрэл бэрхшээлийг нэгтгэж үзсэн нь

Энэ хугацаанд судалгааны баг ХНХЯ болон ХХҮЕГ, аймаг дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, сум, хорооны нийгмийн ажилтантай ярилцлага хийж, мэдээлэл авсан бөгөөд МУ-ын нийгмийн халамжийн давуу тал, хүндрэл бэрхшээлтэй асуудлыг хүснэгт 3-8-д нэгтгэн оруулав.

Хүснэгт 3-8: Нийгмийн халамжийн давуу тал ба хүндрэл бэрхшээлтэй тал

Давуу тал	Хүндрэл бэрхшээл
<u>Хууль эрх зүйн тогтолцоо</u> 2012 онд нийгмийн халамжийн тухай хуулийг шинэчлэн найруулсан ба 2021 оны сүүлээр мөн шинэчлэн найруулахаар төлөвлөж байна. 2021 оны шинэчилсэн найруулгаар халамж ба хөдөлмөр эрхлэлтийн уялдаа, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах агуулгыг багтаахаар төлөвлөж байна. - Төрийн бодлогод нийгмийн халамжийг сайжруулах талаар тусгагдсан. <u>Эрмэлзэл, сонирхол</u> - ХНХЯ-ны ажилтнуудын дотор зөвлөгөө өгөх үйлчилгээ зэрэг нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах шаардлагатай гэж үздэг хүн олон. - Японд хэрэгжүүлдэг эмзэг бүлгийн иргэд бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх тогтолцоог ихээр сонирхож байна. <u>Орчин, тогтолцоо</u> - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс дээр нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт хариуцсан ажилтан тусдаа байдаг бол хороо, суманд нийгмийн ажилтан нь давхар хариуцдаг (халамж, хөдөлмөр эрхлэлтийн уялдааг сайжруулах орчин байна). - Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох үйл явц дээр олон мэргэжилтэн мониторинг хийх тогтолцоо бүрдсэн байна. - Халамжийн үйлчилгээнд хамруулах эсэхийг шийдэхийн тулд биечлэн уулзах, гэрт нь очиж нөхцөл байдалтай танилцах тохиолдол ч байна. - Төрийн үйлчилгээ ба ард иргэдийг холбох үүрэгтэй хэсгийн ахлагч ажилладаг. - Төрийн байгууллага, иргэдийн төлөөллөөс бүрдсэн АДЗ ажилладаг. <u>Систем</u> - e-halamj зэрэг цахим орчин хөгжиж байгаа ба ажлын бүтээмж сайжирч байна. - Өрхийн мэдээллийн нэгдсэн сан ба халамжийн мэдээллийн нэгдсэн сан зэрэг халамж хүртэгчдийн мэдээллийг хянадаг мэдээллийн сан, систем байдаг ба хороо, сумын түвшинд ч хэн ямар үйлчилгээ авдаг талаарх мэдээллийг харах боломжтой.	<u>Нийгмийн халамжийн үйлчилгээ⁵²</u> - Хамрах хүрээ өргөн, ядуу, эмзэг бүлгээс бусад бүлгийн иргэдийг ч хамруулдаг. - Нийгмийн халамжийн 60 гаруй төрлийн үйлчилгээ байдаг ба үйлчилгээ үзүүлэх процесс нь төвөгтэй. - Бэлэн мөнгө олгох (99 хувийг эзэлдэг) нь нийгмийн халамжийн гол үйлчилгээ болж байна. - Цөөхөн хамрагдагчтай (1000 хүрэхгүй) халамжийн тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ байна <u>Санхүүгийн эх үүсвэр</u> - Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хасаж тооцсон ч нийгмийн халамжийн зарлага жилээс жилд өсөж байна. - Нийгмийн халамжийн санхүүгийн эх үүсвэрийг улс хариуцдаг ба орон нутаг хувь хариуцдаггүй (орон нутаг шийдвэр гаргах эрх, санаачилга дутмаг) <u>Халамж ба хөдөлмөр эрхлэлтийн уялдаа</u> - Халамжид найдаж амьдардаг, ажилгүй залуучууд олон. - Халамж ба хөдөлмөр эрхлэлтийг холбосон арга хэмжээ байдаггүй. - Бэлэн мөнгө олгохоос бусад эмзэг бүлгийн иргэдийн нөхцөл байдал, хэрэгцээнд нийцсэн халамж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ байдаггүй/хязгаарлагдмал <u>ООГА</u> - Ядуу давхаргын иргэдийг тодорхойлж чаддаггүй (орхигдуулалтын алдаа). - Судалгааг үнэн зөв явуулах аргачлалаа сайжруулаагүй. <u>Нийгмийн ажилтан</u> - Нийгмийн ажилтны гол ажил нь үйлчилгээ авах хүсэлт, материал хянах ажил байдаг. - Нийгмийн ажилтны үйлчилдэг үйлчлүүлэгчийн тоо олон, ажлын ачаалал их ч дүүрэг аймгаас хамаарч энэ тоо нь харилцан адилгүй. - Халамж хүртэгчийг тасралтгүй дэмжих тогтолцоо сул. - Нийгмийн ажлыг мэргэжлээ болгох хүн ховор. - Нийгмийн халамжийн хүний нөөцийг бэлтгэх сургах боломж ховор. - Нийгмийн ажилтны эрх олгох тогтолцоо байдаггүй (аль байгууллага зохион байгуулах ёстой, ямар шалгуур тавих зэрэг асуудлууд тодорхой болоогүй) <u>Хувийн хэвшил, олон нийтийн хамтын ажиллагаа</u> - Олон нийтийн оролцоонд түшиглэсэн арга хэмжээ нь цар хүрээ багатай, сэргээн засах үйлчилгээ үзүүлдэг зэрэг гэрээс гадуурх үйлчилгээ голлодог ба энэ нь олон нийтийн оролцоог хөгжүүлэх хэмжээнд очоогүй. - Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа хязгаарлагдмал. - Хувийн хэвшлийн үйлчилгээнд мониторинг, үнэлгээ хийх тогтолцоо сул. - Олон нийтийн хүний нөөц, нөөц баялагийг ашиглаж, харилцан туслаж дэмжих механизм хангалтгүй.

⁵² Дэлгэрэнгүй мэдээллийг 3-2-1 “Нийгмийн халамжийн үйлчилгээний хүндрэл бэрхшээл”

Дөрөвдүгээр бүлэг. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоо, үйлчилгээний өнөөгийн байдал ба шийдвэрлэх асуудал

2-3 Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн стратеги, төлөвлөгөө

МУ-ын нийгмийн хамгааллын тогтолцоо 2015 оноос хойших эдийн засгийн уналтаас үл хамааран⁵³, ядуурлыг бууруулах, нийгмийн хамгааллыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Ядуурлын түвшин 28.4% (2018 он) хүрэх⁵⁴ үед 2016-2018 онд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо 16.2%-иар өссөн. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардал 29%-иар өсч, 619 тэрбум 800 сая төгрөгт хүрсэн⁵⁵. Нөгөө талаар нийгмийн даатгалын сангийн⁵⁶ алдагдал даамжирч, улсын төсвийн татаасаар алдагдлыг нөхсөн байдалтай байна⁵⁷. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (цаашид “ОУХБ” гэх) “иргэдийг орлогын баталгаагаар хангах, нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй болгохын тулд МУ-ын Засгийн газар хамгийн багадаа нийгмийн хамгааллын зардалд 2020 он хүртэл ДНБ-ий 4.72%-ыг зарцуулах шаардлагатай” гэж дүгнэсэн⁵⁸. Тус улсын ядуурлын шугамаас дөнгөж дээгүүр амьдарч байгаа хүмүүс туйлын ядууралд өртөх магадлалтай тул нийгмийн хамгааллын арга хэмжээг бэхжүүлэх шаардлагатай⁵⁹.

Иймд “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын 3.1-д “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлэх” зорилт дэвшүүлээд байна. 2020 оноос 2030 он хүртэлх 10 жилийг “Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэх 1 дүгээр үе шат” гэж тодорхойлон, “нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх”, “нийгмийн халамжийн үйлчилгээнд хүн амын эмзэг бүлгүүдийг хамруулах”, “зорилтот, эмзэг бүлгийн өрх, иргэний амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээний нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийг үзүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн⁶⁰.

Ядуу иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд олон бэрхшээл тулгардаг. Нэгдүгээрт, үйлчилгээ хүргэх үйл ажиллагаа нь олон шат дамжлагатай, чирэгдэл ихтэй, уялдаа холбоо муутай байдаг. 60 гаруй төрлийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, ХНХЯ-аар магадлан итгэмжлэгдсэн 120 гаруй үйлчилгээ үзүүлэх байгууллага бий. Үйлчилгээ хэрэгжүүлэх тогтолцоо нь оновчтой бус, хоорондоо уялдаа муутай тул нэг иргэн олон үйлчилгээ авахаар давхар хүсэлт гаргах, ядуу бус

⁵³ Хятадын эдийн засгийн өсөлт саарч, дэлхийн зах зээлд уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурсантай уялдан МУ-ын эдийн засгийн өсөлт 2016 онд 1.2% болж буурсан. МУ-ын Засгийн газар 2017 оны 2 сард Олон улсын валютын сан (ОУВС)-тай өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр (EFF)-т хамрагдах гэрээ байгуулах зэргээр төсөв, санхүүгийн бодлогоо шинэчилсэн. 2019 онд эдийн засгийн өсөлт 5.2% болов. ЯГХБ (2020) “МУ-ын нөхцөл байдал” (2020 оны 8 сар) https://www.jetro.go.jp/ext_images/world/asia/mn/data/mn_202008.pdf (мэдээлэл авсан огноо: 2021-5-26).

⁵⁴ World Bank (March 2020), Publication: Mongolia Poverty Update, p.18, PDF

⁵⁵ ADB (December 2019), Technical Assistance Report, Mongolia: Building Capacity for an Effective Social Welfare System, p.1.

⁵⁶ Монголд хэрэгждэг өндөр настны тэтгэврийн сан, тэтгэмжийн даатгалын сан, эрүүл мэндийн даатгалын сан, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан, ажилгүйдлийн даатгалын сангаас бүрдэх нийгмийн даатгалын санхүүгийн эх үүсвэр.

⁵⁷ Mongolian Statistical Yearbook (2018)-ийн мэдээллээс тодруулав. Мөн ЖАЙКА (2015) “МУ-ын тэтгэврийн тогтолцооны мэдээлэл цуглуулах суурь судалгааны эцсийн тайлан”-гийн 4-6 хуудсанд “Өндөр настны тэтгэврийн сан их хэмжээний алдагдалтай байгаа тул 1) тэтгэврийн даатгалын шимтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх, 2) тэтгэмжийн хэмжээг бууруулах, 3) тэтгэврийн насыг бууруулах зэргээр тогтолцоог шинэчлэх арга хэмжээ шаардлагатай байгаа хэдий ч улс төрийн шалтгаанаар хойшлогдсоор ирсэн” гэж дүгнэсэн байв.

⁵⁸ ILO (2015), Social protection assessment based national dialogue: Definition and cost of a social protection floor in Mongolia, <https://www.social-protection.org/gimi/RessourcePDF.action?id=51678> (мэдээлэл авсан огноо: 2021-5-26).

⁵⁹ World Bank (March 2020), Publication: Mongolia Poverty Update, p.18-19, PDF

⁶⁰ ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар, материал “Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого: Алсын хараа 2050” (Эхний төсөл) p.160

иргэнийг хамруулах зэргээр нийгмийн халамжийн хомс байгаа нөөцийг үр дүнтэй, өгөөжтэй ашиглаж чаддаггүй.

Давхардсан үйлчилгээг цэгцэлж нэгтгэх, үйлчилгээ авах зорилтот бүлгийн иргэдийг зохистой тодорхойлох асуудлыг олон удаа хэлэлцэж ирсэн хэдий ч Засгийн газраас хэрэгжүүлж буй нийгмийн халамжийн арга хэмжээ, хөтөлбөрийн үр дүнг хянаж, үнэлэх тогтолцоо хангалтгүй байна гэсэн шүүмжлэлд өртөж байна⁶¹.

МУ-ын Засгийн газар халамжийн үйлчилгээ болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг уялдуулж, халамжаас хамааралтай амьдарч буй хүмүүсийг хөдөлмөрийн зах зээл рүү шилжүүлэх арга хэмжээ авч буй ч иргэдийг ажилтай болгох хангалттай үр дүн гаргаж чадахгүй байна (Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжсэн ч иргэдийн ажил эрхлэлттэй холбоотой асуудлын талаар 4-р бүлгийн 4-2 “Ажилгүй иргэдийн орлогыг хамгаалах тогтолцоо, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоо/үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой өнөөгийн байдал, тулгарч буй бэрхшээл”-ийг харна уу).

Халамж авдаг хүмүүс олширсон нь халамжийн санд ачаалал үүсгэдэг. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг шинэчлэх шаардлагатай байна.

МУ-ын Засгийн газар амьжиргааг дэмжих нийгмийн халамжийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг уялдуулж, халамжийн үйлчилгээнд хамрагддаг хүмүүсийг хөдөлмөрийн зах зээл рүү шилжүүлэх арга хэмжээ авч байгаа ч олон хүн тогтвортой хөдөлмөр эрхэлж чадахгүй байна. Нийгмийн халамжид хамрагдах хүмүүсийн тоо нэмэгдэж байгаа нь халамжийн сангийн ачааллыг нэмэгдүүлж байгаа тул төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг шинэчлэх шаардлагатай байна.

Мөн эмзэг бүлгийн нийгмийн хамгааллын үүднээс авч үзвэл хүн амын насжилтын бодлого нь Засгийн газрын дунд, урт хугацаанд шийдвэрлэх шаардлагатай асуудал юм. 1970-аад онд 7.5 байсан төрөлтийн коэффициент жилээс жилд буурсаар 2020 онд төрөлтийн коэффициент 2.83 болоод байна. Дундаж наслалт нэмэгдэж, 65-аас дээш насны хүн амын тоо 2045 онд нийт хүн амын 9 хувьд хүрнэ гэж Үндэсний статистикийн хороо тооцоолоод байна. Ирээдүйн хүн амын насжилттай уялдуулан МУ-ын Засгийн газар “Ахмад настны асрамж үйлчилгээний стратеги төлөвлөгөө” боловсруулж эхлээд байна. Дээр дурдсан “Алсын хараа-2050”-д “Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн цогц тогтолцоог бүрдүүлэх” зорилго дэвшүүлсэн. Гэхдээ одоогоор тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж эхлээгүй байна. Одоо байгаа өндөр настны халамжийн газар нь хөрөнгө, хүний нөөц хомс зэргээс шалтгаалж ахмад настны эрүүл мэнд, амьдралын баталгааг хангах асрамжийн зохих тусламж үйлчилгээг үзүүлж чадахгүй байна.

Эдгээр асуудлаас гадна 2020 онд Ковид-19 цар тахал дэлхийн хэмжээнд тархсан нь эмзэг бүлгийн иргэдийн амьдралд хүндээр туссан. Монголд Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд аймаг болон нийслэл хооронд зорчих иргэдийн хөдөлгөөнийг эртнээс хязгаарлаж, худалдаа, үйлчилгээний газруудын ажиллах цагийн хуваарьт хязгаар тогтоох зэргээр эдийн засгийн үйл ажиллагааг хязгаарлах арга хэмжээ авсан. Цар тахлаас урьдчилан сэргийлэх

⁶¹ ADB (December 2019), Technical Assistance Report Mongolia: Building Capacity for an Effective Social Welfare System, p.2-3, PDF.

зорилгоор хатуу хөл хорионы арга хэмжээ авсан нь хот доторх Ковид-19 цар тахлын тархалтыг хумихад нөлөөлсөн. Нөгөө талаар эдгээр арга хэмжээний дүнд олон хүн ажилгүй, орлогогүй болж, амьжиргаа нь доройтсон. Цар тахлын үед эмзэг бүлгийн иргэдэд дэмжлэг үзүүлэх олон арга хэмжээг нийгмийн халамжийн тогтолцооны хүрээнд хэрэгжүүлж байгаа хэдий ч эдийн засаг хямарч, хангалттай санхүүгийн эх үүсвэргүй байгаа үед зардал их хэмжээгээр өссөн. Цаашид цар тахал намжсаны дараах нийгмийн хамгаалал, халамжийн зохистой тогтолцооны талаар судлах шаардлагатай.

4-1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын тойм

4-1-1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлоготой холбоотой хууль тогтоомж болон бодлогын тойм

① Хөдөлмөрийн насны хүн ам


Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор 15-аас дээш насны хүн амын эзлэх хувь 2.17 саяд⁶² хүрсэн нь 2020 оны нийт хүн амын 65.8%-ийг эзэлж байна. Үүнээс 15-аас дээш насны хүн ам (эсвэл хөдөлмөрийн насны хүн ам)-ын 59.7% (нийт хүн амын 39.3%) нь ажиллах хүчний ангилалд багтсан бөгөөд 2010 оны тооллогын үзүүлэлтээс 3.3 пунктээр өссөн байна⁶³. (хүснэгт 4-1).

Хүснэгт 4-1: 2010 он ба 2020 оны хүн амын тооллогын дүнг харьцуулсан байдал

No.	Үзүүлэлт	Пункт
1	Хөдөлмөрийн насны хүн ам	3.3-аар өссөн
2	Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	3.3-аар буурсан
3	Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин	4.5-аар өссөн
4	Хөдөлмөрийн насны хүн ам дахь ажил эрхэлдэг хүн ам	6.0 -аар өссөн

Эх сурвалж: 2010 оны хүн амын тооллогын дүн

2020 онд ажиллах хүчний 90.1% нь ажил эрхэлж, 9.9% (128,900 орчим иргэн) нь ажилгүй байна. 2010 оны хүн ам, орон сууцны тооллогын статистиктай харьцуулахад “ажиллах хүчнээс гадуурх хүн ам” (40.3%) 3.3 пунктээр буурчээ. Ерөнхийдөө ажиллах хүчний оролцоо өссөн бөгөөд ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд 2010 оны тооллоготой харьцуулахад 4.5 пунктээр өсчээ. Хөдөлмөрийн насны нийт хүн амд ажиллагчдын эзлэх хувь 2010 оны тооллоготой харьцуулахад 6.0 пунктээр өссөн байна. Хөдөлмөрийн насны хүн ам өсөх хандлагатай болж байгаа ба эрэгтэйчүүдийн ажиллах хүчний



⁶² L.Tseveenjav et al, NSO (2020), Education and Employment survey

⁶³ NSO of Mongolia (2020), Population and Housing Census of Mongolia.

оролцооны түвшин эмэгтэйчүүдийнхээс илүү өндөр байна.

2019 оны эцсийн байдлаар 1,146,000 хүн ажил эрхэлж байгаагийн 774,968 (67,6%) нь хот суурин газарт, 371,192 (32,4%) нь хөдөө орон нутагт амьдарч байна. Хүйсээр нь үзвэл, хот суурь Эмэгтэй 405,984 эрэгтэй (52.4%), 368,984 эмэгтэй (47.6%), хөдөө орон нутагт 200,830 эрэгтэй эрэгтэ 170,362 эмэгтэй (45.9%) байна (Зураг 4-1).

Хөдөө орон нутгаас хот суурин газар руу хөдөө лжилт хө Хөдөө л нэмэгдсэнтэй холбоотойгоор ажилгүйдлийн түвшин хот суурин газарт өндөр, хөдөө орон нутагт бага байна. Ажилгүйдлийн түвшин 30-44 насныхны дунд хамгийн өндөр байгаа бөгөөд энэ насны бүлгийн 63,000 ажилгүй иргэд нийт ажилгүй иргэдийн 49%-ийг эзэлж байна. Улсын хэмжээнд 2020 онд 873,800 иргэн “ажиллах хүчнээс гадуурх хүн ам”-д тооцогдож байгаа бөгөөд 15-24 насны хүн амын 12,2% нь ажилгүй, эсвэл ямар нэгэн сургуульд хамрагдаагүй байдалтай байна. Ялангуяа, ажилгүй, сургуульд хамрагдаагүй 15-24 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь улсын дунджаас 0.3 пунктээр өндөр байна. Ерөнхийдөө ажилгүйдлийн түвшин нь хөдөө орон нутгаас хот суурин газарт өндөр, мөн эрэгтэйчүүдээс эмэгтэйчүүдийнх өндөр байна.

Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин эмэгтэйчүүдийнхээс өндөр хэвээр байгаа бөгөөд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин хот суурин газраас илүү хөдөө орон нутагт өндөр байна. Ялангуяа, хөдөө орон нутагт эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин⁶⁴ 69.1% байгаа нь хотынхоос 5.8 пунктээр өндөр, хөдөө орон нутгийн эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин⁶⁵ хот суурингийнхаас 11.8 пунктээр өндөр байна. Түүнчлэн 15-аас дээш насны хүн амын 53.8 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд энэхүү үзүүлэлт хөдөө орон нутагт 60.6 хувь байна. Үүнийг хөдөө орон нутгийн эрэгтэйчүүдийн дийлэнх нь мал аж ахуй эрхэлж байгаатай холбон тайлбарлаж болно.

Монголд үйлчилгээ, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл нь хөдөлмөр эрхлэлтийн хамгийн том салбар байдаг. Үйлчилгээний салбарт 680,700 хүн (53.1%), хөдөө аж ахуйн салбарт 290,200 хүн (25.3%), боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 247,300 хүн (21.6%) ажиллаж байна⁶⁶.

МУ-ын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2020 оны 1 сарын байдлаар 420,000 төгрөг болгон шинэчлэн тогтоосон бөгөөд⁶⁷ энэ нь 2019 оныхоос 100,000 төгрөгөөр илүү юм. Нийт хөдөлмөр эрхлэгчдийн 8 орчим хувь нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжиж байна.

Тус улсын хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлагыг харахад ажиллах хүчний оролцооны түвшин харьцангуй өндөр хэдий ч ажилгүйдлийн түвшин ч мөн өндөр, албан бусаар хөдөлмөр эрхэлдэг иргэд олон байна. Энэ нь МУ-ын хүн ам таруу байрладаг, цаг агаар эрс тэс уур амьсгалтай байдгаас аж үйлдвэрийн олон салбар улирлын чанартай ажилладаг нь ажил эрхлэлтэд нөлөөлдөгтэй холбоотой. Үүний улмаас олон хүн албан бус хөдөлмөр, бүтээмж багатай ажил эрхэлж байна (2016 оны ажиллах хүчний судалгаанаас харахад хөдөө аж ахуйн бус салбарын албан

⁶⁴ Хөдөлмөрийн насны хүн ам (15-64 насныхан)-д эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажил эрхлэгсэд + ажилгүйчүүд)-ын эзлэх хувь

⁶⁵ 15-аас дээш насны хүн амд эзлэх "ажил эрхлэгсэд" (ажиллагсад + чөлөө авагсад) -ийн эзлэх хувь.

⁶⁶ NSO of Mongolia (2020), Core Report on Employment Force, 2019.

⁶⁷ Baljmaa (2020), Montsame. National minimum wage rises to MNT 420 thousand. <https://www.montsame.mn/en/read/211422> (Мэдээлэл авсан огноо: 2021-5-25)

бус ажил олгогчид 2006 онд 12.7% байсан бол 2016 онд 26.3% болж өсчээ)⁶⁸. Үүнээс гадна техник технологийн хангалтгүй байдал, эмэгтэйчүүдийн цалин хөлсний ялгаа, хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг ч мөн дурдаж болно.

Мөн Монголд мэргэжлийн ур чадварын дадлага сургалтад хамрагдсан иргэд ажил эрхэлдэггүй асуудал байна. Жишээлбэл, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн (МСҮТ) талаар баримтлах бодлогод хийсэн дүгнэлтээс (2019) харахад МСҮТ-д мэргэжлийн дадлагад суралцаад төгссөн төгсөгчдийн дөнгөж гуравны нэг хүрэхгүй хувь нь эзэмшсэн ур чадвараараа ажилд орсон нь тодорхой болсон байна⁶⁹. Үүнд дараах шалтгаан байгааг онцолж байна.

-Ажлын цалин бага, ажлын нөхцөл тохиромжгүй (төгсөөд ажилд орж байгаа хүнд нийгмийн талаарх ойлголт бага, ажлын нөхцөл хүнд, ажлаар тогтмол хангадаггүй).

-Ажлын туршлага дутагдах, хийж байгаа зүйл нь сурч мэдсэнээс өөр

-Ажилгүй иргэд болон орлого багатай өрхөд чиглэсэн харьцангуй боломжийн халамжийн үйлчилгээ байдаг (ажил хийх хүсэл сонирхолыг бууруулдаг).

Харьцангуй боломжийн хэмжээнд нийгмийн халамжийн үйлчилгээ авдаг учраас хөдөлмөрийн насны хүн амын ажил хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхолыг бууруулж байна. Энэ нь энэ орны онцлог гэж үзэж болохуйц асуудал бөгөөд ХНХЯ нь цаашид нийгмийн халамжийн арга хэмжээг үргэлжлүүлэхээс гадна халамжаас хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг сайжруулах хэрэгцээ шаардлагыг бий болгож байна⁷⁰.

② Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын талаарх хууль

Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой Хөдөлмөрийн тухай хууль (1999), Ажиллах хүч, гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль (2001), Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль (2002), Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008), Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль (2008), Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2011) зэрэг хуулиуд байдаг⁷¹. Эдгээрээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх талаар тусгасан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль", "Хөдөлмөрийн тухай хууль", "Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль"-ийн талаар авч үзье.

2011 онд хэрэгжиж эхэлсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль нь төрөөс хэрэгжүүлж буй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцооны чиг үүргийн төрөл, хэлбэр, хамрах хүрээ, санхүүжилтийн талаар тусгасан. 2021 оны 5 сарын байдлаар боловсруулсан хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ОУХБ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай 181-р конвенц болон Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай 88-р конвенцийн асуудлыг тусгасан бөгөөд “халамжаас ажил эрхлэлт рүү” шилжихийг зорьж байна. Энэ нь гадаадын иргэн ажиллуулдаг ААН-ээс авсан ажлын байрны төлбөрөөс л хамааралтай байдаг "хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан"-гийн санхүүгийн эх үүсвэрийг ажилгүйдлийн

⁶⁸ Celine Ferre (2021) Labor Market Programs and Services in Mongolia.

⁶⁹ TVET-UNESCO (2019), TVET Policy Review Mongolia, p.105.

⁷⁰ ХНХЯ-ны газрын даргатай 2021 оны 3 сарын 19-нд хийсэн ярилцлага. Одоо ХНХЯ нь нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа бөгөөд, ядуу, орлого багатай иргэдэд нийгмийн халамжийг үргэлжлүүлэн олгох бус, ажил эрхэлж амьжиргаагаа дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх бодлого барьж ажиллах тухай танилцуулсан.

⁷¹ Монгол улсын хууль, Хууль зүй дотоод хэргийн яам, МУ-ынэрх зүйн мэдээлэл (<https://mojha.gov.mn/newmojha/>) (Мэдээлэл авсан огноо: 2021-5-25) (Эх: МУ-ынХууль зүй дотоод хэргийн яам. "ЭРХ ЗҮЙН АКТ".)

даатгалын сан болон Засгийн газрын төсвөөс санхүүжилт авахаар эх үүсвэрийг өргөжүүлэх зорилготой. Хуулийн шинэчилсэн найруулгад хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлтийн талаарх хөдөлмөрийн зах зээлийн богино, дунд, урт хугацааны судалгаанд үндэслэн ажил мэргэжлийн сонголтыг дэмжих асуудлыг хэлэлцэж байна⁷².

Хөдөлмөрийн тухай хууль 1999 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд түүнээс хойш 24 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ⁷³. Тус хуулийн дагуу ААН-ийн хөдөлмөрийн гэрээ, түүний менежмент болон ажил олгогч, ажиллагчдын хоорондын хөдөлмөрийн харилцааг зохицуулах стандарт батлагдсан. Хуулийн 2015 оны нэмэлт, өөрчлөлтөөр туршилтын хугацаа (туршилтын хугацаа уртдаа 3 сар), хөдөлмөрийн хөлсний талаарх заалт, цагийн ажлын тухай заалт, торгуулийн дүнг дахин авч үзэх зэрэг асуудал хэлэлцэгджээ⁷⁴. Гэхдээ цагийн ажил эрхлэхтэй холбоотой заалтад "Цагийн ажлын хөлсийг ажил дууссаны дараа олгоно" гэж тусгасан байдаг. Иймээс урт хугацааны гэрээ бүхий цагийн ажлын хувьд цалин хөлсний төлбөрийг хоцроох боломж олгож буй нь асуудалтай юм⁷⁵. Хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлттэй уялдан хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай болсон бөгөөд 2018 оны 3 сарын 26-ны өдөр Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн барьсан ба 2021 оны 5 сарын байдлаар тус хуулийн төсөл нь УИХ-ын хэлэлцүүлгийн шатанд явж байна.

Түүнчлэн 2002 оноос хэрэгжиж эхэлсэн Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн техникийн боловсрол, сургалт, дадлагыг хэрэгжүүлэх боломжийг олгосон хууль эрх зүйн тогтолцоо юм. Уг хууль нь сургалтын байгууллагын сургалтын агуулга болон сургалт явуулах аргачлалыг сайжруулах, суралцагчийн эзэмших ур чадварыг дээшлүүлэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, төр, хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилготой. Шинэчлэгдсэн хууль 2009 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд дараа нь 2012, 2015, 2016 онуудад жижиг нэмэлт, өөрчлөлтүүд хийгджээ. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, төрөөс магадлан итгэмжлэх тогтолцооны хүрээг тогтоох, мэргэжлийн сургалт явуулах сургалтын байгууллагын мэргэшсэн байдлыг сайжруулах, санхүүгийн эх үүсвэрийг нь төрөлжүүлж, санхүүгийн бие даасан тогтолцоотой болгохыг зорьжээ. Мэргэжлийн сургалт явуулах сургалтын байгууллагын багш, суралцагчдын чадварыг дээшлүүлэх, ажлын байраар хангах, ажиллах нөхцлийг сайжруулах, цалин хөлсийг нэмэгдүүлэх, цалин хөлсөөр үл хязгаарлагдах урамшууллын хөшүүрэг бий болгохыг зорьж байна.

③ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг 4-2 хүснэгтэд харуулав. 2016 оноос "Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого" хэрэгжиж эхэлсэн. Энэ нь 2026 он хүртэлх 10 жилийн бодлогын хүрээнд хэрэгжиж байна. Урт хугацааны зорилт нь хөдөлмөрийн ур чадварыг хөгжүүлэх, ажил эрхлэх тогтвортой боломж, орчинг бүрдүүлэх, улмаар ядуурлыг бууруулах явдал юм. Үүнээс

⁷² ILO (2020), Country Profile. "Comments adopted by the CEACR in 2020: Mongolia".

https://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=1000:13203:0::NO:13203:P13203_COUNTRY_ID:103142. (Мэдээлэл авсан огноо: 2021-5-25)

⁷³ Хамгийн сүүлд 2015 онд нэмэлт өөрчлөлт орсон.

⁷⁴ Hogan Lovells Publication. 2017. Mongolia Amends its Labor Law. <https://www.hoganlovells.com/en/publications/mongolia-amends-its-labour-law>. (Мэдээлэл авсан огноо: 2021-5-21)

⁷⁵ Дээр дурдсан материал.

гадна "2020-2024 он хүртэлх Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө", "Нийгэм, эдийн засгийн дунд хугацааны хөгжлийн хүрээ (2020-2025 он)", "Алсын хараа 2050" нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтоор эхэлж байгаа бөгөөд үүнд бага орлоготой өрхийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийн даатгалын тогтолцоог эргэн харах, албан бус салбарыг албан ёсны болгох, цахимжуулах зэрэг зорилтууд тусгагджээ.

Хүснэгт 4-2: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой бодлого

Хуулийн нэр	Хэрэгжиж эхэлсэн он	Товч агуулга
Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого (2016-2026)	2016	Урт хугацааны бодлогын зорилго нь ажиллах хүчний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх замаар ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэн, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг сайжруулж, хөдөлмөр эрхлэх боломж, орчныг бий болгосноор ядуурлыг бууруулах явдал юм.
2020-2024 онд хэрэгжих Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	2020	Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зорилтод дараах бодлогууд тусгагдсан. 2.5.9 Орлого багатай өрхийн ажил эрхэлдэггүй насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. 2.5.10 Томоохон бүтээн байгуулалт, үндэсний болон орон нутгийн хөгжлийн зорилт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээтэй уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтыг төрөлжүүлнэ. 2.5.1 Мэргэжлийн боловсрол, сургалтын шинэ хотхон, дадлагын бааз байгуулж, санхүүгийн бие даасан байдлыг хангана. 2.5.14 Бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн үр дүнд болон хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар 150 мянган ажлын байр шинээр бий болгоно. 2.5.15 Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа монгол иргэдийг дэмжих, эх орондоо эргэн ирж ажиллаж хөдөлмөрлөхөд дэмжлэг үзүүлэх хөдөлмөрийн бирж бий болгоно.
Нийгэм эдийн засгийн дунд хугацааны хөгжлийн хүрээ (2020-2025)	2020	Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой дараах зорилтуудыг тавьж ажиллана. 2.6 Хэрэгцээнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангана. 2.6.2 Ажилгүйдлийн даатгалын тогтолцоо боловсронгуй болж, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлэн ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”		Урт хугацааны хөгжлийн бодлого дотор ажил хөдөлмөртэй холбоотой дараах 3 үе шаттай бодлого тусгагдсан байна. ➤ Үе шат I. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэртэй байдлыг хангаж, эрэлтэд суурилсан цалин хөлс, урамшуулал олгох тогтолцоог бэхжүүлэх үе (2021-2030) 1. Мөнгө, санхүүгийн бодлогоор ажлын байрыг нэмэгдүүлж, ажлын байрны статистик мэдээллийг аймаг, сум, дүүргээр гаргадаг болно. 2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт ба ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, мөн түүний эрэлт, хэрэгцээнд нийцсэн тэгш, хүртээмжтэй орчныг бүрдүүлнэ 3. Хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. 4. Цахим, зайн ажлыг байрыг нэмэгдүүлсэнээр, оюуны хөдөлмөрийн тогтолцоог нь дэмжиж хөгжүүлнэ. 5. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээлэл сайжирсан байна. 6. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, дэд бүтцийн томоохон төслүүдийн хөдөлмөрийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн ажилчдыг бэлтгэж, төгсөгчид ажлын байрыг өөрөө бий болгоход чиглэсэн мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг хөгжүүлнэ. 7. Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдал нэмэгдэж, ажилгүйдлийн түвшин буурч, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн байна Үе шат II. Бүтээмжид суурилсан, хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлэх үе. (2031-2040) 1. Эдийн засгийн тэргүүлэх чиглэл, ажлын байрны шингээлт ихтэй аж үйлдвэр, хөнгөн үйлдвэрлэл, бүтээмжтэй үйлчилгээний салбарууд, орчин үеийн цахим салбар, эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн үнэлгээ, цалин хөлсний оновчтой хэлбэрийг бүрдүүлнэ. 2. Олон улсад оюуны бүтээл, мэдээллийн технологийн болон зөвлөх үйлчилгээг дэмжих зуучлагч компани, төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлнэ. Үе шат III. Мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, хүн бүр ажилтай, орлоготой болох орчин, нөхцөлийг бүрдүүлэх үе. (2041-2050) 1. Цахим эринд шаардагдах ур чадварыг эзэмшүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгох төр, хувийн хэвшлийн түншлэлийн оновчтой тогтолцоог бүрдүүлнэ
---	--	---

4-1-2 Төсөв (зардал, санхүүгийн эх үүсвэр)

Засгийн газар нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой төсвийг "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан"-гаас гаргадаг. Санхүүгийн эх үүсвэр болон бодит зардлыг дор харуулав.

① Санхүүгийн эх үүсвэр

Хүснэгт 4-3-т хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого ба санхүүгийн эх үүсвэрийг тусгав.

Хүснэгт 4-3: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого (сая төгрөг)

Санхүүгийн эх үүсвэр	2015	2016	2017	2018	2019	2020
Засгийн газрын төсвийн хуваарилалт	-	588.9	-	3,850.0	9,100.0	20,330.2
Орон нутгийн төсвийн	-	499.7	304.0	100.0	-	-
Донор орнуудаас авсан зээл, буцалтгүй тусламж	-	-	-	3,137.8	11,137.8	7,415.0
Гадаад ажиллах хүч ажиллуулдаг ААН-ийн татвар	36,402.0	18,739.6	29,717.1	38,616.0	54,348.7	26,267.9
Жижиг зээлийн эргэн төлөлт	13,000.0	99.7	17,000.0	4,350.0	25,350.0	-
Жижиг зээлийн хүү/торгууль		0.2	187.3	156.6	67.2	256.9
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүй ААН-	351.0	349.5	1,003.6	1,126.8	3,682.6	8,325.1
Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт	-	1,238.9	3,678.5	7,276.4	12,434.5	10,946.8
Бусад	-	2,901.1	13.9	172.2	-	13.8
Өмнөх оны үлдэгдэл хөрөнгө	20,815.1	28,378.7	40,883.6	39,244.0	44,113.3	96,626.3
Нийт орлого	70,568.1	52,796.4	92,788.0	98,029.8	160,234.2	170,195.2

Эх сурвалж: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайлан, ХХҮЕГ-аас авсан мэдээлэл⁷⁶

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн эх үүсвэрийг гадаадын иргэн ажиллуулдаг ААН-үүдийн төлөх ажлын байрны төлбөр, Засгийн газрын хуваарилсан төсөв, татаасны эргэн төлөлтөөс голчлон бүрдүүлдэг. Монголд гадаадын иргэн ажиллуулдаг ААН-үүдэд ажиллуулж буй гадаадын иргэнийн тоогоор төлбөр (татвар) төлдөг бөгөөд энэ нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын гол эх үүсвэр болдог. Гадаадын иргэдийг ажиллуулдаг гол ААН-үүд нь уул уурхай, барилгын салбарынх бөгөөд БНХАУ-аас олон ажилчдыг улирлын чанартайгаар авч ажиллуулдаг. 3 сараас ажилчдыг улирлын чанартайгаар ажиллуулж эхэлсний дараа гол төлбөрүүд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлөгддөг. Төсвийн тухай хуульд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн зарцуулалтыг дараах байдлаар тусгасан байдаг⁷⁷. ХНХЯ нь ХЭДС-гийн дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 8 сарын 15-ны дотор Сангийн яаманд хүргүүлнэ. Сангийн яам нь бодит зардал болон хөтөлбөр юунд чиглэхийг магадлаад, төсвийн төслийг 10 сард багтаан боловсруулж, УИХ-д өргөн барьдаг. Үүний дараа УИХ дараагийн санхүүгийн жилийн төсвийг 11 сарын 15-ны дотор баталж, төсөв хуваарилдаг. Жил бүрийн 1 сард, он гарснаас хойш гадаад ажилчин ажиллуулсан ААН-ээс төлбөр орж ирэх тул хөтөлбөрийн бодит санхүүжилт жил бүрийн 3 сараас хойш орж ирдэг байна. Тийм учраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодит хугацаа 4 сараас 9 сар хүртэлх хагас жилээр хязгаарлагддаг байдал нь хүндрэл болдог. Бас санхүүгийн эх үүсвэр нь гадаадын ажиллах хүчийг улирлын чанартай авч ажиллуулдаг ААН-ийн төлөх ажлын байрны төлбөрөөс бүрддэг. Коронавирусын халдвар зэрэг шалтгаанаар гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэлт багасах зэрэг хүчин зүйл бий болоход орлого огцом буурах тул санхүүгийн эх үүсвэр тогтвортой байх боломжгүй.

⁷⁶ 2019 он хүртэлх мэдээллийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн жилийн тайлангаас ашиглав. 2020 оны мэдээлэл нь санхүүгийн сарын тайлангаас ашигласан болно.

⁷⁷ Ferre Celine (2021), Labor Market Programs and Services in Mongolia

2020 оны санхүүгийн эх үүсвэрийг авч үзэхэд Засгийн газраас хуваарилсан төсөв, өмнөх оны үлдэгдэл төсөв 69%-ийг бүрдүүлж байна.

② Зарлагын гүйцэтгэл

ХЭДС-ийн зарлагыг 4-4 хүснэгтэд харуулав. 2020 онд шинэ төрлийн коронавирусын халдвар тархсаны улмаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн төсөв, ажилд зуучлах үйлчилгээний төсөв, зээлийн төсөв ихээхэн буурчээ. 2020 оны зарлагын хэмжээ өмнөх жилийн 47 орчим хувьтай тэнцэж байв. 2020 онд коронавируст халдварын улмаас санхүүгийн хүндрэлд орсон МСҮТ-ийн оюутнуудад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас тэтгэмж олгосон тул зарлага нь өмнөх жилийнхээс 2.7 дахин их байна. Ажил хайгчдад шууд ашиг тусаа өгдөг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний төсөв хумигдсан тул үйлчилгээнд хамрагдах хүмүүсийн тоо ч эрс буурчээ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний талаар 4-2-1 “Төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөр, үйлчилгээ”-нд дэлгэрэнгүй тайлбарлах болно.

Хүснэгт 4-4: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарлагын гүйцэтгэл (сая төгрөг)

Зарлагын үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019	2020
Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	2,023.7	1,389.4	1,137.7	1,012.5	886.6	200.0
Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	7,820.0	8,341.9	11,615.9	11,206.5	13,741.8	9,759.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	2,150.3	2,397.7	3,227.8	3,647.1	3,542.9	3,376.9
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	4,995.4	4,292.5	4,518.8	5,802.7	5,505.8	2,274.2
Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	687.6	979.9	1,715.7	2,652.7	5,193.5	1,158.8
Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	264.0	372.1	1,319.5	1,163.6	1,283.9	989.6
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр (нийт)	18,397.0	18,741.7	24,344.5	26,490.4	31,489.9	18,514.2
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зуучлах үйлчилгээ	456.0	968.2	809.1	1,005.3	1,335.4	673.0
Жижиг зээл	-	-	-	-	-	82.0
Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд зарцуулсан		10,149.3	2,271.0	-	-	-
МСҮТ-ийн оюутны сар бүрийн тэтгэлэг	-	-	-	-	18,588.3	45,700.9
Бусад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ	13,162.3	7,677.8	6,920.0	8,362.5	5,549.1	2,361.9
Жижиг зээл	11,000.0	-	20,000.0	15,900.0	8,000	2,224.4
Зээлийн хүү	-	11.6	9.3	13.2	10.1	-
Хөдөлмөрийн зах зээлийн туршилтын төсөл	-	-	-	-	-	469.4
Сангийн яамнаас буцаан олгосон өмнөх оны үлдэгдэл хөрөнгө	-	-	-	-	-	100,924.4
Нийт зарлага	42,559.3	36,580.4	53,544.8	50,766.1	63,637.4	170,195.2

Эх сурвалж: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайлан, ХХҮЕГ-аас авсан мэдээлэл⁷⁸

⁷⁸ 2019 он хүртэлх мэдээллийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн жилийн тайлангаас ашиглав. 2020 оны мэдээлэл нь санхүүгийн сарын тайлангаас ашигласан болно.

4-1-3 Төрийн байгууллагын тогтолцоо (ХНХЯ-ны үүрэг, холбогдох алба хэлтэс, нэгжийн үүрэг)

ХНХЯ, Үйлдвэрчний эвлэл, Ажил олгогч эздийн холбоодоос бүрдсэн гурван талт зөвлөл болох Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл (цаашид “ХЭҮЗ” гэх) хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэлэлцэж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг баталдаг. ХНХЯ нь хөдөлмөрийн талаарх бодлогын шийдвэрийг гаргадаг бөгөөд бодлогын хэрэгжилтийг ХНХЯ-ны хэрэгжүүлэгч агентлаг болох Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар хариуцан ажилладаг.

ХХҮЕГ нь улсын хэмжээнд нийгмийн халамжийн албуудыг нэгтгэн удирдахаас гадна ажил хайгчдад зөвлөгөө өгөх, ажилд зуучлах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ үзүүлдэг. ХХҮЕГ нь 7 газар хэлтэстэй (тамгын газар, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газар, нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийн газар, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний газар, санхүү төлөвлөлтийн газар, хяналт мониторингийн газар, мэдээллийн технологийн төв), тэдгээрийн дор бодит үйлчилгээ үзүүлдэг 32 хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс алба нийслэл, аймгийн засаг захиргааны нэгжид ажилладаг. ХХҮЕГ-ын нийт ажиллагсдын тоо 67 бөгөөд үүнээс тав нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газрын ажилтнууд байна.

Ажилтнуудын задаргааг харуулбал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хариуцсан 2, ажил мэргэжлийн зөвлөгөө, танилцуулга хариуцсан 1, хөдөлмөр зуучлалын агентлаг хариуцсан 1, статистик мэдээлэл, иргэдийн хөдөлгөөний асуудал хариуцсан 1 ажилтан ажиллаж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газар нь дүүрэг, аймгийн ХХҮХ, газар мөн тэдгээрийн удирдлагад байх хороо, сумын нийгмийн халамжийн мэргэжилтнийг удирдан, хяналт тавьж ажилладаг. Дүүрэг, аймгийн ХХҮХ, газар нь хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийг нэгтгэн, ХХҮЕГ-т тогтмол гаргаж өгөх үүрэгтэй.

ХХҮХ, газар нь хөдөлмөр эрхлэлтийн болон нийгмийн халамжийн албатай. Хөдөлмөр эрхлэлтийн албаны нийгмийн ажилтан нь ажил хайгчдын мэргэжлийн сургалтын бүртгэл хийх, ажилд орох талаар зөвлөгөө өгөх, тохирсон ажлын байрыг нь олж өгөх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт бүртгэх зэрэг үйлчилгээ үзүүлдэг. 4-5 хүснэгтэд дүүрэг, аймгийн хөдөлмөр эрхлэлтийн албаны нийт ажилтнуудын тоог харуулав. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан нийт 194 ажилтан улсын хэмжээнд ажиллаж байна.

Хүснэгт 4-5: Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн хөдөлмөр эрхлэлтийг албаны ажилтны тоо (2020 он)

Албан тушаал	Аймаг	Дүүрэг
Хөдөлмөр эрхлэлтийн алба, хэлтсийн дарга	21	9
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл хариуцагч	35	15
Ажлын танилцуулга, зөвлөгөө, ажил олгогчтой холбох үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн*	22	9
Ажил мэргэжлийн чиг баримжаа, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн**	5	1
Гадаад ажилчидтай холбоотой хөдөлмөрийн зах зээл/ажил мэргэжлийн зөвлөгөө/хөдөлмөрийн харилцаа/хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн***	22	9
Хөдөлмөрийн харилцаа/хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	12	6
Хөдөлмөр эрхлэлтийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн	21	7
Нийт	138	56

*Зарим алба хэлтэст, ажлын танилцуулга/зөвлөгөө өгөх болон ажил олгогчтой холбох/маччинг хийх үйл ажиллагааг тус тусын мэргэжилтэн хариуцдаг.

**Хөдөлмөрийн харилцаа/хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хариуцсан мэргэжилтэн ажилладаг боловч, орон тоо хязгаартай газарт тухайн мэргэжилтэн байдаггүй.

***Гадаад ажиллах хүч хариуцсан мэргэжилтэн нь заавал ажил мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллана гэсэн үг биш бөгөөд орон тоо хязгаарлагдмал газарт хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хариуцаж ажилладаг.

Эх сурвалж: Байгууллагын хүний нөөцийн мэдээлэл, ХХҮЕГ, 2020 (хүн)

Улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудал эрхэлсэн 261 албан хаагч ажиллаж байна. Халамжийн салбарыг оруулаад 1,700 төрийн албан хаагч 2.4 сая нийгмийн халамжийн үйлчилгээ авагч, ажил хайгч иргэдэд үйлчилж байна. Ялангуяа суманд хөдөлмөр, халамжийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн ажилладаг бөгөөд тус ажилтан нь нийгмийн халамжийн ажил болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлыг хоёуланг нь хариуцаж хэт их ачаалалтай ажилладаг нь шийдвэрлэх асуудлын нэг юм. Хүний нөөцийн хомсдлыг шийдэх зорилгоор өмнө өгүүлсэнээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн эх үүсвэрийг гаргаж, хувийн хэвшлийн хөдөлмөр зуучлалын байгууллагаар хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах чиг үүргийн ажлыг даатган хийлгэж байгаа ч, хувийн хэвшлийн байгууллага нь хоёрхон үндсэн ажилтантай, бусад нь үндсэн бус ажилтан тул хүн хүчний дутагдалтай хэвээр байна. Үүний улмаас үйлчлүүлэгчдээ хүрсэн зөвлөгөө үйлчилгээ, тасралтгүй дэмжлэг үзүүлж чадахгүй байна.

Ажилтан авах компани болон ажил хайгчийн мэдээлэл хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн систем (цаашид "ХЗЗМС" гэх)-д бүртгэгдэх ба төрийн байгууллага болон хувийн байгууллагуудын хооронд тус мэдээллийг хуваалцана. Байгууллага бүрт нэвтрэх хаяг олгох ба хувийн хөдөлмөр зуучийн байгууллагаас ажил хайгчийн мэдээлэл оруулахад улсын бүртгэлийн мэдээллийн сантай холбогдож, тухайн иргэний хувийн мэдээлэл, авч байгаа үйлчилгээ зэргийн мэдээлэл гарч ирнэ. Тэр үед ажил хайгч нь хөдөлмөр зуучийн ямар үйлчилгээ авсан тухай мэдээлэл нь мөн хадгалагдана. ХХҮХ-ийн хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн нь системд тусгагдсан мэдээлэл болон ажилд зуучилсан байдлыг нь харж, хувийн хөдөлмөр зуучийн байгууллагад олгох зуучлалын төлбөрийг тооцож, мөн ажил хайгч иргэнд ажилтан хайж байгаа ААН-ийн мэдээллийг өгнө. Гэвч энэ үйлчилгээний хүрээнд цугларсан мэдээлэл нь статистик

мэдээ болон хадгалагдахаас хэтэрдэггүй. Хөдөлмөр зуучлагч нь ажил хайгчид намтраа хэрхэн бичих талаарх мэдээлэл, ярилцлаган дээр байнга гардаг асуулт, яавал ажилд орох боломжтой байдаг талаарх мэдээлэл өгдөггүй. ХЗЗМС-д 2021 оны 1 сараас 6 сар хүртэлх хугацаанд ажил хайгч 11,509 иргэн, ажилтан хайж байгаа 1,005 ААН-ийн 16,115 ажлын байрны мэдээлэл бүртгэгдэж, 8,096 хүн ажилд орсон байна. Хөдөлмөрийн зах зээлийн талаарх өгөгдөл, мэдээллийг ХНХЯ-ны харьяа судалгааны байгууллага болох Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт (цаашид "ХНХСИ" гэх) болон ҮСХ цуглуулдаг. ХНХСИ нь 2016 оноос хойш хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн зах зээлийн цаашдын төлөв, төлөвлөгөөний чиглэлээр суурь судалгааг явуулж байна.

Дээр өгүүлсэн төрийн байгууллагын үйл ажиллагаанаас гадна хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хувийн хэвшлийн үйлчилгээ ч бас байна. Хувийн хэвшлийн үзүүлж байгаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний талаар 4-2-3-т тусгасан болно. Түүнээс гадна Сангийн яам, Боловсролын яам, Барилга, хот байгуулалтын яам, Зам тээвэр, хөгжлийн яам хооронд хөдөлмөр эрхлэлтийн бодлогын зохицуулалт хийгдэж байна.

4-2 Ажилгүй иргэдийг орлоготой болгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоо, үйлчилгээний өнөөгийн байдал ба шийдвэрлэх асуудал

4-2-1 Төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөр, үйлчилгээ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн үйлчилгээ нь үндсэндээ гурван төрөл байдаг. (1) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, (2) Нийгмийн халамжийн байгууллагаас үзүүлэх ажилд зуучлах зөвлөх үйлчилгээ, (3) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох жижиг зээлийн үйлчилгээ юм.

2019 оны мэдээллээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт зарцуулж буй зардал нь нийт төсвийн 49%-ийг эзэлж байгаа бол ажилд зуучлах зөвлөх үйлчилгээний төсөв нийт төсвийн дөнгөж 2%-ийг эзэлж байна.

Үйлчилгээ тус бүрийн агуулгын талаар тоймлон авч үзье.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд ажилд орж чадахгүй байгаа иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор үйлчлүүлэгч бүрт зориулсан хөтөлбөр боловсруулж, сургалт явуулж, мөн санхүүжилт олгодог. Тус хөтөлбөрийг ХЭДС-ийн төсвөөс санхүүжүүлдэг. 2020 оны гүйцэтгэлийг харахад зургаан хөтөлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл (цаашид “ХЭҮЗ” гэх)-өөс баталж хэрэгжүүлжээ. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэх ур чадварын хөтөлбөр, ажлын байрыг дэмжих хөтөлбөр, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, ахмад мэргэжилтнүүдийн зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрүүд батлагдсан байна. 4-6 хүснэгтэд хөтөлбөр тус бүрт хамрагдсан иргэдийн тоог харуулав. Харин зургаан хөтөлбөрийн товч танилцуулгыг 4-7 хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4-6: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо (хүн)

	Хөтөлбөрийн нэр	2016	2017	2018	2019	2020
1	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	5,684	9,631	7,677	7,353	2,587
2	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	11,690	36,466	38,464	45,728	18,277
3	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	12,113	4,281	4,869	8,177	2,637
4	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	4,032	4,886	6,617	6,265	1,598
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	4,849	5,782	5,617	5,622	2,844
6	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	2,587	2,278	1,527	1,342	844
Нийт		40,955	63,324	64,771	74,487	28,787

Эх сурвалж: Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн систем, ХХҮЕГ-аас авав.

Хүснэгт 4-7: Хөтөлбөр тус бүрийн товч танилцуулга

Хөтөлбөрийн нэр	Зорилго	Хамрагдагч	Ажилд орсон хувь (2020 он)
Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулж, ажлын орчинд дасгаж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	16-40 насны ажил эрхлэх сонирхолтой нийгмийх халамжийн үйлчилгээнл хамрагддаг иргэн (ажилгүй, эмзэг бүлгийн), сургууль завсардсан оюутан, орон гэргүй хүн, хорих ангиас суллагдсан иргэн, хүүхдийн асрамжийн газраас гарсан иргэн	10%
Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Хувиараа хөдөлмөр эрхлэгчийг дэмжих, ажлын байр шинээр бий болгосон ажил олгогчид урамшуулах олгох зэргээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. Ажил хайж байгаа оюутанд богино хугацааны ажил зуучилна.	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч, ажил хайж буй оюутан	81%
Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	Залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамруулах, залуучуудын шинэлэг санаанд тулгуурлан, гарааны дэмжлэг олгох, бизнесээ тогтмол эрхлэхэд нь туслах зорилготой.	15-34 насны залуучууд	8%
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Малтай болон малгүй малчдыг малтай болгох, малыг нь өсгөх зорилгоор ажлын байр бий болгож, орлоготой болгох зорилготой.	Малгүй өрх, мөн бог малд шилжүүлсэнээр 200-аас цөөн толгой малтай өрх	100%
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох сургалтад хамруулж, санхүүнийг дэмжлэг үзүүлсэнээр урт хугацаанд ажлын байраар хангана.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн	38%

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	Ахмад настны мэдлэг, ур чадварыг ашиглаж, залуучуудад хөдөлмөрийн дадал олгох чиглэлээр ажиллуулж, тэдний орлогыг нэмэгдүүлнэ.	Өндөр насны тэтгэвэрт гарсан ур чадвар бүхий ахмад настан	102%
---	--	---	------

Эх сурвалж: ХХҮЕГ-тай хийсэн ярилцлага

Зургаан хөтөлбөр дотроос хүнд байдалд байгаа иргэдийг дэмжих хөтөлбөр нь хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэх ур чадварын хөтөлбөр, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр юм. “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-өөр хүнд байдалд байгаа иргэдийг ажилд ороход нь бэлтгэх сургалт явуулж, тэднийг ажилд авсан компанийг дэмждэг. Зорилтот бүлэгт ажил хийх арга барил (харилцааны ур чадвар, сэтгэлзүйн зөвлөгөө өгч), ажилд ороход шаардлагатай бичиг баримт хэрхэн бүрдүүлэх талаар зааж, туслалцаа дэмжлэг үзүүлдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихээс гадна ажил олгогчид ч дэмжлэг үзүүлдэг. Ажилд авсан компанид 5-20 сая төгрөгийг буцалтгүйгээр олгодог. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авсан ажил олгогчид санхүүгийн дэмжлэг олгох талаар мөн хөтөлбөрт заасан байдаг. Тухайлбал, ажилд авсан хөгжлийн бэрхшээлтэй нэг иргэний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний санхүүгийн дэмжлэгийг ажил олгогчид нь үзүүлэхээр заасан байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаанд байдаг хүүхдээ асарч буй эцэг, эхийн боловсруулсан ажлын байр бий болгох төслийг шалгаруулж, барьцаагүй, хүүгүй, 50 хувийг нь эргэн төлөх нөхцөлтэй, 3.0-5.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 36 сарын хугацаатай олгодог.


Хөгжлийн бэрхшээлтэй иргэн гарааны бизнес эхлүүлсэн бол хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажиллах орчныг бүрдүүлэхэд 5-20 сая төгрөгийн зээл олгодог.

Ахмад настныг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан ахмадуудад тохирох ажил олж өгдөг. Ахмад настнууд өөрсдийн туршлага, ур чадвараа ашиглан зөвлөх үйлчилгээ үзүүлнэ. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлж буй ахмадад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан зардлын жишиг хэмжээгээр ажилласан цагийн урамшууллыг тооцож олгодог. Түүнчлэн Ахмад настан аж ахуй, өрхийн үйлдвэрлэл эрхлэх зорилгоор төсөл боловсруулж, 24 сарын хугацаанд эргэн төлөх нөхцөлтэйгээр 3.0 сая хүртэл төгрөгийн санхүүгийн дэмжлэг авдаг.

① —2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн зардлын гүйцэтгэл

4-3 зурагт харуулсанчлан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийт хөтөлбөрийн зардлын хэмжээ коронавируст халдварын нөлөөгөөр төсөв нь хумигдсан 2020 оныг эс тооцвол ерөнхийдөө өсөх хандлагатай байна. Ажлын байрыг дэмжих хөтөлбөр нь нийт төсвийн 40 гаруй хувийг эзэлж байна. Хүнд байдалд байгаа иргэдийг дэмжих хөтөлбөрүүдээс хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр нь 2016 оноос жил ирэх тутам буурч байгаа бол залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих

хөтөлбөр 2016 оноос хойш өсөх хандлагатай байна. Энэ нь Засгийн газар тэтгэмж авч ажиллахгүй байгаа хөдөлмөрийн насны залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлыг эн тэргүүний зорилт болгон ажиллаж буйтай холбоотой юм.



Зураг 4-3: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн зарлагын гүйцэтгэл
(Эх сурвалж: ХЭДС-ийн санхүүгийн тайлан⁷⁹, ХХҮЕГ)

2021 онд 2020 он шиг Ковид-19-ийн нөлөөнөөс болж төсөв хумигдсан хэдий ч 27,000 хүнд 20.5 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөжээ. 2021 оны төсөвт Засгийн газраас төсөв хуваарилаагүй, зөвхөн 2020 оны төсвийн үлдэгдлээс санхүүжилт хийгдэнэ. ХНХЯ хуваарилагдсан төсвийг 100% зарцуулахаар төлөвлөж байгаа ч 2022 оны төсвийн хувьд Засгийн газраас төсөв хуваарилахгүй бол өмнөх жилийн төсвийн үлдэгдэл байхгүй тул хөтөлбөр хэрэгжүүлэхэд төсөв хүрэлцэхгүй болох магадлалтай байна.

2021 онд ХЭҮЗ-өөс "Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр", "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр", "Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр", дээр нь "Коронавируст халдварын үед бизнесийн үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр"-ийг шинээр гаргаж, нийт 5 хөтөлбөр баталжээ.

2021 оны хөтөлбөр нь нийгмийн халамжаас ажил эрхлэлтийг дэмжих чиглэл рүү шилжиж буйгаараа, мөн коронавируст халдварын эсрэг авч буй арга хэмжээгээрээ онцлог юм. "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд нийгмийн халамжийн үйлчилгээ авч байгаа, хөдөлмөр эрхлэх боломжтой залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. "Коронавируст халдварын үед бизнесийн үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр" нь коронавируст халдвараас болж бизнес нь хүнд байдалд орсон бизнес эрхлэгчдэд бизнесээ хөгжүүлэхэд нь, малчдад малаа өсгөхөд нь нэмэр болгох зорилгоор хүүгүй зээл олгоно. 35-аас дээш насны ажил эрхлэх хүсэлтэй иргэд, гадаадаас буцаж ирсэн ажил хайгч иргэд болон компанид зориулж 36

⁷⁹ 2019 он хүртэлх өгөгдлийг ХЭДС-ийн жилийн санхүүгийн тайлангаас авав. 2020 оны өгөгдлийг сарын санхүүгийн тайлангаас авав.

сарын хугацаанд буцаан төлөх нөхцөл бүхий барьцаа, хүүгүй зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Малчдын хувьд 16-18 насны залуучуудад 150 малтайд нь 5 сая, 150-250 толгой малтайд нь 4 сая төгрөг хүртэлх зээлийг барьцаагүй, хүүгүй, 36 сарын эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгох зээлийн хөтөлбөр хэрэгжүүлж байна. Түүнээс гадна ажил олгогчийг дэмжих үүднээс коронавируст халдварын улмаас хөдөлмөр зуучлалын биржээр зуучлуулсан хэдий ч хагас жилээс дээш хугацаагаар ажилд орж чадаагүй иргэнийг нэгээс дээш жил ажиллуулсан компанид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний тэтгэмж олгож дэмжих бодлого боловсруулаад байна.

① —3 Тулгарч байгаа асуудал

2019 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо 74,482, төрийн болон хувийн хэвшлийн ажил зуучлал, зөвлөх үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 169,308, нийтдээ 243,790⁸⁰ байв. 2019 онд бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 127,736, боломжит ажиллах хүчин 58,800, нийтдээ 186,536⁸¹ байв. Энэ үзүүлэлтээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, ажил зуучлал, зөвлөх үйлчилгээнд хамрагдагчдыг давхардуулж тооцлоо ч бүртгэлтэй ажилгүй иргэдэд ерөнхийдөө хүрч ажиллаж байна гэж үзэж болно.

Гэвч хүснэгт 4-4-д тусгасан төсвийн хуваарилалтыг харахад ажилгүй иргэдийн 91%-д хүрч ажилладаг ажил зуучлал, зөвлөх үйлчилгээ өгөх үйлчилгээний төсөв ердөө 3% байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсвийн бараг тэн хагас хуваарилагддаг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдагсад нийт үйлчилгээнд хамрагдагсадын дөнгөж 31% байна. Зарцуулсан зардал мөнгөтэйгөө харьцуулахад үр дүн нь тааруу байна. Зөвхөн үйлчилгээнд хамрагдагсад төдийгүй үйлчилгээ өгч дууссаны дараах ажил эрхлэлтийн түвшинг харахад хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр болон залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр 10%-тай байна. Ялангуяа, 15-24 насныхны ажилгүйдлийн түвшин улсын дунджаас 2.5 дахин их байгаа бөгөөд⁸² залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь чухал асуудал болоод байна. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн төсөв, тус хөтөлбөрт хамрагдагсадын тоо жилээс жилд өсч буй ч ажил эрхлэлтийн түвшин ердөө 10 орчим хувьтай байгаа нь үр дүн тааруу байгааг харуулж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин доогуур байгааг төр, хувийн хэвслүүд халамжаас хамааралтай байдал, цалин бага, ажиллах хүсэл бага зэрэг хүчин зүйлүүдтэй холбон тайлбарлажээ. Гол хүчин зүйлийн нэг нь төрөөс олгож буй тэтгэмж халамжаас хамааралтай хүмүүс олширсонтой холбоотой. ХЭБ авахаар бүртгүүлсэн 100,000 ажилгүй иргэдийн ердөө 20,000 нь ажил хайж байна. Үлдсэн 80,000 нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд бүртгэгдээгүй, ажиллах хүсэлтэй эсэх нь тодорхойгүй, халамж тэтгэмжээс хараат байдалтай байна. Хөдөлмөрлөх хүсэлд “халамж авах бэлэнчлэх сэтгэлгээ”, мөн “гэр бүлийн гишүүд бие биенээ халамжилж тэжээх ёстой” гэсэн

⁸⁰ Дэлгэрэнгүй мэдээллийг 4-2-3-аас харна уу.

⁸¹ МУ-ын Үндэсний Статистикийн Хорооны өгөгдлийн сан, 2019 оны бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоон мэдээлэл. <https://www.en.nso.mn/> (Мэдээлэл авсан огноо: 2021-5-25)

⁸² ILO (2019), Accelerating the 2030 Sustainable Development Goals through decent work- SDG Monitoring and Country Profile for Mongolia. https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_673936.pdf.

уламжлалт хандлага сөргөөр нөлөөлдөг тул ажил хөдөлмөр хийх талаарх ойлголтыг өөрчлөх амаргүй.

Цалингийн тухайд авч үзвэл, сарын дундаж цалин 1.3 сая төгрөг. Нийт ажиллагсадын 40% нь ХАА-н салбарт ажилладаг ба ХАА-н салбарын цалин бага. Мөн цалин хөлс төлөхгүй байх асуудал ч гардаг тул хуулиар тогтоосон 3 сарын туршилтын хугацаа дууссаны дараа тогтвортой ажиллах хүн тун цөөхөн байдаг. Барилгын салбарын хувьд барилгын ажил дууссаны дараа цалин олгох тохиолдол их байдаг тул тус салбарт ажиллахаар хандах хүн цөөхөн байдаг. Хөдөлмөрийн тухай хуулийн 2003 оны нэмэлт өөрчлөлтөөр туршилтын хугацаанд цалинг заавал төлөх ёстой гэж заасан боловч⁸³, туршилтын хугацаанд цалин өгөхгүй байх явдал гарсаар байна.

Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн бүтэц зохион байгуулалтын тал дээр, ялангуяа төсвийг бүрдүүлэхэд томоохон бэрхшээл гарч байна. ХЭДС-ийн орлогоос хамааран 3 сар гарч байж тус хөтөлбөрийн төсөв хуваарилагддаг. Үүний улмаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн үйл ажиллагаа хэрэгжих бодит хугацаа нь 4-9 сар хүртэлх 6 сар байдаг. Өөрөөр хэлбэл, ердөө 6-хан сарын богино хугацаанд тус хөтөлбөр хэрэгжиж байна. Тиймээс үйл ажиллагаа гольдролдоо ортол цаг хугацаа шаардагддаг гарааны бизнесийн салбарт үр дүн гартал хугацаа шаардана. Мөн хөтөлбөрийн зээлийн эргэн төлөх мөнгөн дүн жил бүр харилцан адилгүй байгаа нь үйлчлүүлэгчид ойлгомжгүй байна.

ХХҮГ болон ХХҮЕГ нь хөтөлбөрт хамрагдсан хүмүүсээс судалгаа авдаггүй. Хөтөлбөрийн үр дүнг ажилд орсон эсэх, ажил хайгч, компани хоёрыг холбож чадсан эсэх гэсэн өнцгөөс дүгнэдэг тул ажилд орсон иргэн үндсэн, эсвэл үндсэн бус ажилтнаар ажиллаж буй эсэх, тогтвор суурьшилтай ажиллаж буй эсэх, мөн тогтвортой ажиллахгүй байгаагийн шалтгааны талаар хангалттай дүн шинжилгээ хийгдэхгүй байна. Хувийн хэвшлийн байгууллагаас хөдөлмөр зуучлалын үйлчилгээ аваад 3 сарын дараа тогтвор суурьшилтай ажиллаж буй иргэд ердөө 13% байна. Энэ үзүүлэлтээс хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрт хамрагдсан ч тогтвор суурьшилтай ажиллаж буй иргэд цөөн байгааг харж болно. Мөн ажилд орох хүмүүсийн тоо цөөн байгаа тул тогтвортой хөдөлмөр эрхлэгчдийн тоонд дорвитой нөлөөлж чадахгүй байна. Үүний үр дүнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн өөрийнх нь ажилд оролтын хувь буурч, үр дүн нь буурч байна. Засгийн газар энэ асуудлыг шийдвэрлэж, халамжаас хөдөлмөр эрхлэлт рүү шилжих явдлыг дэмжихийн тулд халамж авагчдыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамруулахыг чухалчилж байгаа бөгөөд Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар судалж байна. Хуулийн нэмэлт өөрчлөлтөөр ажилд орсон хүмүүсийн халамжийн үйлчилгээг хязгаарлах, тэтгэмж авах бол заавал хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдах болзолтой болгох талаар судалж байна.

Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн дизайныг төлөвлөх, ялангуяа төсвөөр хангах тал дээр хүндрэлтэй асуудал тулгардаг. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан дээр хөтөлбөрийн төсөв бүрдэх хугацаа нь 3 сараас хойш байдаг ба энэ нь хөдөлмөр эрхлэлтийн сангийн орлогоос шалтгаалж байгаа хэрэг юм. Тиймээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжих бодит хугацаа нь 4-р сараас 9-р сар хүртэл бөгөөд хөтөлбөрийг хагас жилийн богино хугацаанд

⁸³ ILO (1999), Law of Mongolia. Labor Code. <https://www.ilo.org/dyn/natlex/docs/SERIAL/57592/49012/F1417624175/MNG57592.pdf> (Мэдээлэл авсан огноо: 2021-5-21).

хэрэгжүүлэх шаардлагатай болдог. Гольдролдоо ороход цаг хугацаа ордог гарааны бизнесийн хувьд үр дүнгээ үзэхэд хугацаа шаардлагатай. Хөтөлбөрийн хүрээнд олгож байгаа зээл зэрэг дээр ч эргэн төлөх хувь хэмжээ нь жил жилд өөрчлөгддөг зэрэг үйлчлүүлэгчийн хувьд ойлгомжгүй асуудлууд гардаг.

② Хөдөлмөрийн зуучлал, зөвлөгөө өгөх үйлчилгээ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих алба нь бүртгэгдсэн ажлын байрны мэдээллийг ажил хайгчдад танилцуулж, ажилчин хайж буй компани болон ажил хайж буй иргэнийг холбодог. Ажилд авах компани нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс дээр очиж, ажлын байрны бүртгэлээ хийнэ. Ажлын байрны мэдээлэл бүртгэгдсэний дараа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээр үйлчлүүлэхээр ирсэн ажил хайгчид компанийн мэдээлэл танилцуулагдана. Ажилтан авах компани болон ажил хайгч иргэний мэдээлэл хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системд (цаашид “ХЗЗМС” гэх) бүртгэгдэж, төрийн байгууллага болон хувийн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцдог.

Ажил хайгч иргэнд ХЗЗМС-д бүртгэгдсэн тухайн иргэний хувийн мэдээлэл болон ажилтан хайж байгаа компанийн мэдээллийг танилцуулан, тохирох ажлыг санал болгохоос гадна ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх, мөн шаардагдах ажил мэргэжлийн сургалтын мэдээллийг олгоно. Мэдээллийг дүүрэг болон аймгийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан хороо, сумдад түгээж, хорооны нийгмийн ажилтан орон нутгийн удирдлагад хүргэдэг.

Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн хөдөлмөр эрхлэлтийн албанд хандаж зөвлөгөө авч буй иргэдийн дундаж тоо өдөрт 20 орчим байгаа боловч тэдний 3 орчим нь ажилд ордог. Ажил хайгч ажилд орж чадаагүй бол тухайн компани руу ажил хайгчтай хамт явж, яагаад ажилд орж чадаагүй талаар асууж лавлан, ажилд орох нөхцлийг хангахад ажил хайгчид тусалдаг.

2021 оны 1 сараас хойш Ковид-19-ийн нөлөөгөөр салбарууд дээр биечлэн уулзаж хийгддэг байсан бүх ажил онлайнаар хийгдэж байна. 2021 оны 4 сард МУ-ын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газрын хамтын ажиллагааны буцалтгүй тусламжийн хүрээнд хөдөлмөр зуучийн үйлчилгээний “E-job” цахим хуудас хөгжүүлж гаргасан тухай мэдээллэсэн. Төрийн байгууллагын хөдөлмөр эрхлэлт хариуцсан нэгж болон хувийн хөдөлмөр зуучийн байгууллага E-job цахим хуудсаар дамжуулан, ажил хайгчийн хөдөлмөр эрхлэх чадварыг үнэлэх, ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх, ажилд орох төлөвлөгөө гаргах зэрэг үйлчилгээг үнэгүй хүргэнэ⁸⁴.

ХЗЗМС-ийн үүрэг нь статистик мэдээг төвлөрүүлэх, ажил зуучлагч нь мэдээллээ хянахад ашиглахаас хэтрэхгүй байгаа бөгөөд, ажил хайгч иргэн болон ажилтан хайж байгаа ААН нь шууд хандалт хийж ашиглах боломжгүй бөгөөд, ажил хайгч иргэний хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ, ажилтан хайж байгаа ААН-ийн хэрэгцээнд уялдуулж ажил хайгчийг холбож, танилцуулах үйлчилгээ үзүүлдэггүй. Тиймээс бодит байдал дээр, хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн нь ХЗЗМС-ийг ажлын байр зарласан байгууллагын мэдээлэл төвлөрүүлэх систем болгож ашиглахаас өөр хэрэглээ байхгүй байгаа ба төвлөрсөн мэдээллийг эксэл программын хүснэгтэнд буулгаж,

⁸⁴ T. Saran (2021) IKON.MN. As of March, 25,105 people were looking for work and 6,413 vacancies were registered at the labor exchange, <https://ikon.mn/n/26ny>. (мэдээлэл авсан огноо:2021-5-25)

аймаг, дүүргийн нийгмийн ажилтнуудад явуулдаг ба үндсэн мэдээлэл төвлөрүүлэх түвшинд л ашиглагдаж байна. Доод шатны байгууллагууд нь эхсэл программын хүснэгтэн дээр хийсэн гарын авлага ашиглаж, хөдөлмөр зуучийн үйлчилгээ явуулж байна. Мөн төрийн болон хувийн байгууллагын хөдөлмөр эрхлэлт хариуцсан ажилтнууд нь сар бүрийн 26-ны өдөрт багтаж ХХҮЕГ-ын ХЗЗМС-д мэдээллээ өгөх шаардлагатай байдаг бөгөөд тухайн өдөр системд олноор хандалт хийдэг тул сервер байнга доголдохоос гадна, нэгэнт оруулсан мэдээллийг засах боломжгүй байдаг тул статистикийн бүртгэлийн алдаа гардаг байна.

Үүнтэй харьцуулахад “E-job” нь ажил хайгч иргэн ба ажилтан хайж байгаа ААН-үүд шууд хандалт хийх боломжтой, эдгээр үйлчлүүлэгчдийг хооронд нь холбох систем болж өгч байна. Гэвч “E-job” ч 2021 оны 3 сард туршилтаар ажиллуулж, 4 сараас ашиглаж эхэлсэн систем бөгөөд системийн саатал үүсч, түүнийг сайжруулах ажил ойр ойрхон хийгдэж байна⁸⁵. Жишээлбэл ажил хайгч иргэн өөрийн хүссэн хөдөлмөр зуучлалын байгууллагаа сонгосон ч, тухайн байгууллага руу мэдээлэл шууд автоматоор очдоггүй тул, хөдөлмөр зуучлалын байгууллагууд систем руу нэвтэрч тухайн байгууллагыг сонгосон ажил хайгч байгаа эсэхийг шалгах шаардлагатай болдог тул ажил хайгч иргэнд хариу арга хэмжээ авахад цаг хугацаа шаардагдаж байна.

Мөн 4-2-3-д өгүүлсэн хувийн ААН, ТББ-ууд ч ажил хайгч иргэд ижил төрлийн үйлчилгээ үзүүлж байна.

4-8 хүснэгтэд үзүүлсэнчлэн ажилд зуучлах үйлчилгээний үр шимийг хүртэгсэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан хүмүүсээс хамаагүй их байна.

Хүснэгт 4-8: Төрөөс үзүүлж буй ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдагчид (хүн)

Үйлчилгээний нэр	2016	2017	2018	2019	2020
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	52,056	103,862	89,961	118,584	41,970
Ажилд зуучлах үйлчилгээ	35,846	45,683	43,105	44,059	28,495
Нийт	87,902	149,545	133,066	162,643	70,465

Эх сурвалж: Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем, ХХҮЕГ-аас ирүүлсэнээр

③ Жижиг зээлийн үйлчилгээ

ХНХЯ нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөс гадна ажилгүй иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон бусад бүлгүүдэд жижиг зээл олгох үйлчилгээг үзүүлж байна. Зээлийн төсвийг ХЭДС-аас санхүүжүүлж, Хаан болон Төрийн банкаар дамжуулан үйлчлүүлэгчдэд олгодог. 2019 оны санхүүгийн эх үүсвэр 8 орчим тэрбум төгрөг байсан бол 2020 онд 7.4 тэрбум орчим төгрөг байв. 2021 оны 3 сарын байдлаар 1,313 аж ахуйн нэгж, иргэнд 9.9 тэрбум төгрөгийн зээл олгосон байна⁸⁶. Компанийн ажилтныг оролцуулан жижиг зээлийн үйлчилгээ авагчдын тоо 2020 он гэхэд 98,901 байв. Жижиг зээлийн үйлчилгээ авснаар 52,954 ажлын байр шинээр бий болжээ. 4-9 хүснэгтэд жижиг зээлийн үйлчилгээнд хамрагдсан аж ахуйн нэгж, иргэдийн тоог харуулав.

⁸⁵ МУ-ынхүний нөөцийн менежментийн холбоотой хийсэн ярилцлага(судалгааны баг, 2021 оны 6 сарын 13)

⁸⁶ ХХҮЕГ-тай хийсэн ярилцлага судалгаанаас олж авсан мэдээлэл

Хүснэгт 4-9: Жижиг зээлд хамрагдсан хүний тоо (ААН ба хувь хүн)

Үйлчилгээний нэр	2016	2017	2018	2019	2020	2021 (3 сар)
Жижиг зээл	1,014	1,112	1,775	644	694	1,313

Эх сурвалж: Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем, ХХҮЕГ-аас ирүүлсэнээр
(нэгж: байгууллагын тоо ба хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тоо)

Үүний зэрэгцээ нийгмийн ажилтнууд хэт ачаалалтай ажилладаг нь жижиг зээлийн төлөлт саатахад хүргэж байна. Жижиг зээлийн хүү болон үндсэн төлбөрийг хурааж авах ажлыг хороо, сумын нийгмийн ажилтан хариуцан ажилладаг ч энэхүү төлбөр тооцоо нь банкаар дамжин хийгддэггүй, нийгмийн ажилтан зээлдэгчийн гэрээр очин хурааж авдаг байна. Хувь хүн төлбөрийн чадваргүйн улмаас зээл төлөлт хоцрох тохиолдол гарахаас гадна нийгмийн ажилтан хэт ачаалалтай ажилладаг тул зээл төлөлтийн графикт хугацааг болон зээл төлөлт хугацаанаасаа хоцорч буйг нягталж чадахгүй байх явдал гарч байна. Ийм тохиолдолд зээл төлөлтийг шүүхээр шийдвэрлүүлэх тул буцаан төлөгдөлт тодорхой хугацаа ордог. Төлбөр хоцролт нь ХЭДС-ийн санхүүгийн эх үүсвэр бүрдэлтэд мөн нөлөөлж байна. Үүнийг шийдэхийн тулд Засгийн газар цаашид банкаар дамжуулан төлбөрийн системийг шийдэх талаар судалж байна.

4-2-2 Сургалтын хэрэгжилтийн байдал

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтыг ажил олгогч, ажил хайгч, хөдөлмөр эрхлэлтийг зохицуулдаг захиргааны ажилтнуудад зориулж 3 чиглэлээр явуулдаг. 4-10 хүснэгтэд хөдөлмөр эрхлэлтийг дэмждэг холбогдох байгууллагуудын сургалтын агуулгыг нэгтгэн харуулав. Ажил хайгчдад зориулсан сургалт нь зөвхөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд явагддаг бөгөөд мэргэжлийн ур чадварт сургаж мэргэшүүлэх сургалтыг явуулдаг. Хувийн хэвшлийн явуулдаг сургалт нь ихэвчлэн ажлын ярилцлагад бэлдэх харилцааны чиглэлийн сургалт байдаг бөгөөд ажилд ороход чухал ур чадвар болох техник ур чадвар эзэмшүүлэх сургалт явагддаггүй. Хөдөлмөр эрхлэлтийн тасгийн ажилтан болон хувийн хэвшлийн ажил зуучлах биржийн ажилтнуудад мэргэжил дээшлүүлэх сургалтыг явуулдаг. Гэхдээ 2020 онд коронавируст халдварын улмаас нийгмийн ажилтнуудыг нийслэлд авчирч явуулдаг улсын нэгдсэн сургалт хэрэгжээгүй байна.

Хүснэгт 4-10: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр холбогдох байгууллагуудаас зохион байгуулсан сургалт

Сургалт зохион байгуулагч	Сургалтад хамрагдагч	Сургалтын агуулга
ХХҮЕГ/ХХҮХ	Ажил хайгч	Ажил мэргэжлийн ур чадварын сургалт (хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр)
ХХҮЕГ	ХХҮХ-ийн хөдөлмөр эрхлэлт хариуцсан ажилтан	Зөвлөгөө өгөх аргад суралцах сургалт
Хувийн хөдөлмөр зуучлалын байгууллага	Ажил хайгч	Хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх сургалт (харилцаа, ярилцлагад бэлтгэх, өөрийгөө илэрхийлэх чадварыг дээшлүүлэх)
Хувийн хөдөлмөр зуучлалын байгууллага	Зөвлөгөө хариуцсан мэргэжилтэн	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээ үзүүлэх зөвлөх бэлтгэх, зөвлөгөө өгөх сургалт
Хүний хөгжлийн менежментийн холбоо	Ажилд зуучлах байгууллага	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээ үзүүлэх зөвлөх бэлтгэх, хөдөлмөр зуучийн мэргэжилтэнд эрх олгох, мэргэшсэн харилцааны зөвлөх бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн шинэлэг үйлчилгээний зөвлөхөд зориулсан сургалт
Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо	Ажил олгогч	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт
GIZ	Ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх мэргэжилтэн	Ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх аргад суралцах сургалт

4-2-3 Хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлж буй байдал

① Хувийн хэвшлийн байгууллага болон ТББ-уудаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ үзүүлж буй байдал

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн үзүүлдэг ажил зуучлалын үйлчилгээнээс гадна хөдөлмөр зуучлалын хувийн компаниуд болон ТББ-ууд хөдөлмөр зуучлалын үйлчилгээ болон сургалтын үйл ажиллагаа явуулдаг. Одоогийн байдлаар ХНХЯ-аар магадлан итгэмжлэгдсэн, хөдөлмөр зуучлалын чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг 42 хувийн байгууллага байна (Хавсралт 2-ыг харах). Үүнээс 24 нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, 18 нь ТББ байна. 2020 оны бүртгэлээр 85 орчим байгууллага магадлан итгэмжлэгдэж, бүртгэгдсэн байгаа боловч гүйцэтгэл муутай байгууллагуудын магадлан итгэмжлэл нь цуцлагдаж, энэ тоо хоёр дахин буурах төлөвтэй байна⁸⁷. ХНХЯ-аар магадлан итгэмжлэгдсэн 42 хувийн хэвшлийн байгууллагаас 30 орчим нь л үйл ажиллагаа явуулж байна. Бүртгэлтэй 85 байгууллагад ажил зуучлал хариуцсан 170, зөвлөх үйлчилгээний 170, судалгаа, шинжилгээний ажил хариуцсан 85, нийт 425 хүн ажиллаж байна.

⁸⁷ Ferre Celine (2021), Labor Market Programs and Services in Mongolia.

Ажилд зуучлах байгууллага нь ажилтан хайж буй компани болон ажил хайгчийг бүртгэж, бүртгэлтэй ажилтан хайж буй компанийг ажил хайгчид танилцуулж, тохирох ажлыг нь олж өгдөг. Ажилтан хайж буй компани болон ажил хайгчийг бүртгэх, зуучлахад ямар нэгэн хураамж авахгүй бөгөөд бүх үйлчилгээ үнэ төлбөргүй хийгддэг. 2020 онд хувийн хэвшлийн 42 байгууллагад бүртгэлтэй ажил хайгч иргэдийн тоо 6,665 байсан бөгөөд үүнээс 3,504 иргэнд ажил зуучлах үйлчилгээ үзүүлсэн байна. Ажил зуучлах үйлчилгээ авсан 3,504 ажил хайгчаас 1,642 нь үндсэн ажилтнаар ажилд оржээ⁸⁸.

Ажилд зуучлах үйлчилгээ үзүүлдэг компани болох LA&C-аас ярилцлага авахад тус компанийн хувьд сард зөвлөгөө өгөх тоо коронавируст халдвар тархахаас өмнө 80-100 байсан бол коронавируст халдвар тархсаны дараа 70-80 болжээ. Ажил зуучлалын үйлчилгээ авсан 3,504 иргэдийн 70 орчим хувь нь ажилгүй иргэд, 20% нь цагаар ажиллах хүсэлтэй иргэд, 10% нь ажлын байраа солихыг хүссэн иргэд байна. Тохирох ажилд нь зуучласны дүнд үндсэн ажилтнаар ажилд орсон нь нийт үйлчлүүлэгчдийн 30 орчим хувь байгаа бол 25% нь цагийн ажилтнаар ажилд оржээ. 2021 оны 1 сараас хойш Ковид-19-ийн нөлөөгөөр дээр дурдсан төрөөс үзүүлдэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээтэй адилхан зөвлөгөө өгөх, ажилд зуучлах гэх мэт биечлэн уулзаж хийгддэг ажлууд бүгд "E-job" вэб сайтаар онлайн хэлбэрээр хийгдэх болжээ.

Төрийн үйлчилгээнээс ялгаатай нь хөгжлийн бэрхшээлтэй, эсвэл ядуу иргэдийг⁸⁹ хувийн хэвшлийн хөдөлмөр зуучлалын үйлчилгээгээр дамжуулан ажилд авсан компаниудад ажиллах хүчний зардлыг нөхөн олгодоггүй⁹⁰. Мөн хувийн хэвшлийн хөдөлмөр зуучлалын байгууллагад Засгийн газрын төсвөөс хуваарилах эргэлтийн хөрөнгийн хэмжээ нь улсын үйлчилгээнийхээс бага байдаг. Хувийн хэвшлийн хөдөлмөр зуучлалын байгууллагууд үйлчлүүлэгчдээс төлбөр хураамж авдаггүй тул үйл ажиллагаа явуулах хөрөнгө нь хөдөлмөр зуучлалын үйлчилгээнд улсаас олгох олговор, сургалтын үйл ажиллагаанаас олох орлогоос бүрддэг. Олговрыг ажилд зуучилсан гүйцэтгэлд үндэслэн ХЭДС-аас олгоно. Гүйцэтгэлийг 4-11 хүснэгтэд харуулав.

Мөн үүнээс гадна хөдөлмөр зуучлалын компаниар дамжуулан ажилд орсон ажил хайгч 3 сар, 6 сар, эсвэл 1 жилээс дээш хугацаагаар тогтвортой ажилласан тохиолдолд ажилласан хугацаанаас нь хамааруулан төрөөс хөдөлмөр зуучлалын компанид гүйцэтгэлийн урамшуулал төлөгддөг. Иймээс ажилд зуучилсан компани нь ажил олгогч компанид тухайн ажил хайгч тогтвортой ажиллаж буй эсэх дээр судалгаа хийдэг. Ажил хайгч ажилд орсоны дараа тогтвортой ажиллаж буй эсэхийг судалсан хувийн зуучлалын компанийн судалгааны дүнгээс харахад 2020 оны 6 сар хүртэлх мэдээгээр ажилд орсон 2,255 хүнээс 3 сар ажилласан хүн 304, 6 сар ажилласан хүн 248, нэг жил ажилласан хүн 217-оор тус бүр буурчээ. Тиймээс урамшууллын хөлс хуваарилагдах магадлал бага байна.

2020 оны гүйцэтгэлийг харахад хамгийн их төсөв хуваарилагдсан компани 21 сая төгрөг, хамгийн багатай нь 12,500 төгрөг байна. Дундаж олговрын хэмжээ 4.6 сая орчим төгрөг бөгөөд

⁸⁸ ХХҮЕГ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газар (2021)-тай хийсэн ярилцлага

⁸⁹ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдах эрхтэй хорих ангиас суллагдсан иргэн, хүүхдийн асрамжийн газраас гарсан иргэн, орон гэргүй иргэн зэрэг ажил олоход хүндрэлтэй иргэд багтана.

⁹⁰ Төрийн үйлчилгээ ашиглан хөгжлийн бэрхшээлтэй, эсвэл санхүүгийн хувьд хүнд байдалд байгаа иргэдийг ажилд авбал ажилд авсан компанид нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөн төлбөр олгоно.

нийт 42 байгууллагад олгосон нийт олговрын дүн 188.52 сая төгрөг байна. Энэ нь 2020 оны ХЭДС-ийн зарцуулсан нийт 170,195 тэрбум төгрөгийн ердөө 1% юм.

Хүснэгт 4-11: Хөдөлмөр зуучлалын үйлчилгээ үзүүлсэн хөдөлмөр зуучлалын байгууллагад санхүүжилт олгох тариф

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг үйлчилгээ	Нэгжид оногдох зардал (ХХДХ-ээр дүйцүүлэн 1 цаг=2500 төгрөг)	Төгрөг
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө өгөх /биечлэн болон цахимаар/	5 цагийн хөдөлмөрийн хөлс	12,500
Хөдөлмөр эрхлэх чадварыг үнэлэх (профайлинг, матчинг) /биечлэн болон цахимаар/	10 цагийн хөдөлмөрийн хөлс	25,000
Ажил хайгчийн хувийн төлөвлөгөө боловсруулах / биечлэн болон цахимаар/	8 цагийн хөдөлмөрийн хөлс	20,000
Модульт сургалт зохион байгуулах /биечлэн болон цахимаар/	1 сарын хөдөлмөрийн хөлсний 40 хувиар	168,000
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн зөвлөгөө өгөх /танхимаар/	1 сарын хөдөлмөрийн хөлсний 40 хувиар	168,000
Ажилд зуучлах		
Байнгын	5 цагийн хөдөлмөрийн хөлс	12,500
Цагийн	3 цагийн хөдөлмөрийн хөлс	7,500

Эх сурвалж: ХХҮЕГ-ын журам, МУ-ынхүний нөөцийн менежментийн холбооноос авсан мэдээлэл

Үүнээс гадна ХНХЯ-тай хамтран гурван талт ХЭҮЗ-ийг бүрдүүлдэг хувийн байгууллага болох Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэл бий. Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо (цаашид “МАОЭНХ” гэх) нь Японы Эдийн засгийн байгууллагуудын холбоотой (Кэйданрэн) дүйцэхүйц ажил олгогчдын төв байгууллага бөгөөд 8,100 ажил олгогчоос гишүүнчлэл нь бүрддэг. МАОЭХ нь бизнес эрхлэгч болон хувийн хэвшлийг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг⁹¹. Харьяа байгууллагын хувьд 21 бүс нутгийн аж ахуйн нэгжүүд, 41 мэргэжлийн байгууллага, 12 салбарын холбоо байдаг бөгөөд 60 сум, аймгаас боловсруулах үйлдвэрлэл, тээвэр, барилга, даатгал, үйлчилгээний салбарын 8,100 компани гишүүнээр элссэн байдаг.

Тус холбоо нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр мэдээлэл солилцох, зөвлөгөө өгөх, гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан сургалт, гишүүн компаниудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлийг голчилсон хүний нөөцийг хөгжүүлэх сургалтыг явуулдаг. Мөн донор байгууллагуудтай хамтран ажиллах замаар ЕХ болон ОУХБ-ын хамтарсан төсөл⁹²-ийн хүрээнд ЕХ руу экспорт хийхээр төлөвлөж байгаа ЖДҮ эрхлэгчдэд экспортын стандартын чиглэлээр сургалт явуулах, ЖДҮ-ийн экспортыг дэмжих, гадаад валют олох зорилготой ажилладаг.

МҮЭХ нь ажилчдыг төлөөлж, Засгийн газартай шууд хэлэлцээр хийх үүрэгтэй. Энэ байгууллага нь Японы Үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн холбоо (Рэнго)-той ижил төстэй үүрэг гүйцэтгэдэг. 2018 оны 11 сарын байдлаар МҮЭХ 36 гишүүн байгууллага, 2,245 үйлдвэрчний эвлэл, 237,500 ажилтан

⁹¹ ILO (2019), The ILO in Mongolia., https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_706539.pdf.

⁹² ОУХБ-ын хэрэгжүүлж буй Ready2Export төсөл.

эгнээндээ нэгтгэсэн байдаг. Ажилчдын эрхийг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хэлэлцэхэд оролцдог⁹³. Ялангуяа, коронавируст халдварын нөхцөлд өсөн нэмэгдэж буй ажилгүй иргэд болон үйл ажиллагаагаа түр зогсоосон жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих үүднээс гурван талын оролцоотой Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр дамжуулан санал дэвшүүлэн ажиллаж байна.

4-2-4 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоо, үйлчилгээний өнөөгийн байдал ба шийдвэрлэх асуудал

Хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх тогтолцооны давуу тал ба хүндрэл бэрхшээлийг ерөнхийд нь нэгтгэн, хүснэгт 4-12-д тусгав.

Хүснэгт 4-12: Давуу тал ба хүндрэл бэрхшээл

Давуу тал	Хүндрэл бэрхшээл
• Хөдөлмөр зуучийн цахим платформ хөгжүүлж гаргаснаар үйлчилгээг үр өгөөжтэй үзүүлж эхлэх • Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, жижиг зээл, хөдөлмөр зуучлалын үйлчилгээ гэсэн чиглэлээр өөр өөр давхаргын иргэдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр арга хэмжээ авах • Хувийн ААН-үүдийн оролцоо бий болсоноор хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөртэй харьцуулахад олон хүнийг хамруулах боломжтой хөдөлмөр зуучийн үйлчилгээ бий болох • Туршилтын хугацааны талаар хуулинд тодорхойлж тусгасан.	• Өмнө нь ашиглаж байсан мэдээлэл төвлөрүүлэх системийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажиллагаа дутагдалтай. • Үйлчлүүлэгчийн ажил эрхлэх хувь бага, ажилд орсон иргэдийн мөрөөр судалгаа хийдэггүй. • Хувийн хөдөлмөр зуучийн байгууллагад олгож байгаа үйлчилгээний тариф бага ба үүнээс шалтгаалан үйл ажиллагаа зогсонги байдалд орсон байгууллага олон. • Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдах иргэн цөөн. • Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан ба хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн эх үүсвэр тэнцвэргүй. • Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөв бүрдэх хугацаанаас хамаарч хөтөлбөр хэрэгжих хугацаа хязгаарлагддаг. • Цалин бага, туршилтын хугацааг тогтоосон хуулийн зүйл заалтыг мэддэггүй, цалингийн асуудал хөдөлмөрийн хуулиндаа цоорхойтой. • Хөдөлмөр эрхлэлт хариуцсан боловсон хүчин дутагдалтай ба хэт их ачаалалтай ажилладаг.

⁹³ Олон улсын хөдөлмөрийн сан (2020 он), Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо.
https://www.jilaf.or.jp/nc_view/masters/view/62 (Мэдээлэл авсан огноо: 2021-5-25)

Тавдугаар бүлэг. Насжилтыг дэмжих тогтолцоо, ахмад настанд үзүүлэх үйлчилгээний өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудал

5-1 Монгол дахь насжилтын байдал

5-1-1 Ахмад настай хүн амын тоо

Үндэсний статистикийн хорооны хүн ам зүйн мэдээллээр Монгол Улсын хүн ам 2020 оны эцсээр 3,357,542 байсан бөгөөд үүнээс 60 ба түүнээс дээш насны хүн ам 249,840 (101,444 эрэгтэй, 148,396 эмэгтэй) хүн амын 7.4% -ийг эзэлж байна. Мөн 65-аас дээш насны эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тоог харахад 2016 онд 46,000 орчим эрэгтэй, 71,000 эмэгтэй байсан бол дөрвөн жилийн дараа буюу 2020 онд эрэгтэй 56,000 орчим, эмэгтэй 88,000 орчим болжээ. Ердөө дөрөвхөн жилийн хугацаанд 65-аас дээш насны хүн ам хүйсийн ялгаагүй 1.2 дахин нэмэгдсэн байна (хүснэгт 5-1).

Хүснэгт 5-1: 2016 оноос 2020 он хүртэлх 65 ба түүнээс дээш насны хүн амын өсөлт, хүйсээр

Он Насны бүлэг	2016		2017		2018		2019		2020	
	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
65 ба түүнээс дээш насны хүн ам	46,262	71,032	48,377	74,340	50,160	77,781	52,984	82,612	55,964	87,732

Эх сурвалж: www.1212.mn YCSX, 2021

5-1-2 Ахмад настны ерөнхий байдал

① Гэрлэлтийн байдал

Ахмад настнуудын гэрлэлтийн байдлын хувьд гэрлэлт цуцлуулсан хувийг 2010 болон 2020 оноор харьцуулж үзэхэд 55-64 насныхан, 65-аас дээш насныхны хувьд тус бүр өссөн үзүүлэлттэй байна. Хань ижлээ алдсан хүмүүсийн эзлэх хувийг 2010, 2020 оноор харьцуулахад гэрлэлт цуцлуулсантай эсрэг үзүүлэлттэй байгаа бөгөөд хоёр хүйсийн аль альных нь хувьд буурах хандлагатай байна. Гэхдээ 65-аас дээш насны бэлэвсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь маш өндөр, 2010, 2020 онуудад тус бүр 58.6%, 55.0%-тай, аль аль нь 50%-ыг давсан байна.

Хүснэгт 5-2: 2010 он ба 2020 оны ахмад настны гэр бүлийн байдал, хүйсээр (%)

Насны бүлэг	Эрэгтэй				Нийт	Эмэгтэй				Нийт
	Ганц бие	Гэр бүлтэй	Салсан	Бэлэвсэн		Ганц бие	Гэр бүлтэй	Салсан	Бэлэвсэн	
2010										
55-64	2.8	85.9	3.5	7.8	100%	3.3	62.8	3.5	30.4	100%
65+	2.5	71.9	1.6	24.0	100%	2.9	37.2	1.2	58.6	100%
2020										
55-64	4.3	86.3	4.1	5.3	100%	4.3	67.0	5.0	23.7	100%
65+	2.1	78.1	1.9	17.9	100%	2.7	40.7	1.6	55.0	100%

Эх сурвалж: Хүн ам орон сууцны тооллого 2020 тайлан, YCSX

② Боловсролын түвшин

Ахмад настны боловсролын түвшинг харахад боловсрол эзэмшээгүй хүмүүсийн эзлэх хувь 2010, 2020 оноор харьцуулахад багасч буй бөгөөд ялангуяа 65-аас дээш насны хүн амын хувьд 2010 онд 11.7% хувь байсан бол 2020 онд 2.9% болж буурчээ. 2010, 2020 оноор харьцуулахад дээд боловсролтой хүмүүсийн эзлэх хувь нэмэгдэж байгаа бөгөөд бүрэн дунд боловсролоос дээш түвшний боловсрол эзэмшсэн ахмад настны эзлэх хувь өндөр байна.

Хүснэгт 5-3: 2010 он ба 2020 оны ахмад настны боловсролын түвшин(нэгж:%)

Насны бүлэг	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техник мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дээд боловсрол	Нийт
2010								
55-59	3.7	16.8	17.2	23.8	4.1	15.1	19.4	100%
60+	11.7	30.6	11.5	15.7	2.2	11.0	17.2	100%
2020								
55-59	1.8	6.5	17.8	32.0	6.8	11.8	23.3	100%
60+	2.9	18.0	16.2	22.5	4.7	12.7	23.0	100%

Эх сурвалж: Хүн ам орон сууцны тооллого 2020 тайлан, YCX

③ Ажил эрхлэлтийн байдал

2020 оны насны бүлэг, хүйсээр гаргасан хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувийг харахад 30-аас дээш насны эрэгтэйчүүд, 40-өөс дээш насны эмэгтэйчүүд хамгийн өндөр хувийг эзэлж буй бол нас нэмэгдэхийн хэрээр хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь буурч байна. Ялангуяа, эмэгтэйчүүд 55 насандаа тэтгэвэрт гарахад 70%-ийг эзэлж байсан хөдөлмөрийн насны хүн ам 40% хүртэл буурч, 60-аас дээш насанд 10% хүртэл буурч байна.

Хүснэгт 5-4: 2020 оны ажиллах хүч/ажиллах хүчнээс гадуурх хүн ам, насны бүлэг, хүйсээр (%)

Насны бүлэг	Ажиллах хүчний харьцаа		Ажиллах хүчнээс гадуурх хүн ам		Нийт
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	
15-19	11.0	4.2	89.0	95.8	100%
20-24	51.0	37.7	49.0	62.3	100%
25-29	78.3	67.9	21.7	32.1	100%
30-34	84.9	75.9	15.1	24.1	100%
35-39	84.6	77.2	15.4	22.8	100%
40-44	83.7	79.8	16.3	20.2	100%
45-49	81.5	80.1	18.5	19.9	100%
50-54	77.5	71.9	22.5	28.1	100%
55-59	67.8	41.3	32.2	58.7	100%
60+	25.0	10.9	75.0	89.1	100%

Эх сурвалж: Хүн ам орон сууцны тооллого 2020 тайлан, YCX

④ Гар утасны хэрэглээ

2010, 2020 оны ахмад настнуудын гар утасны хэрэглээний байдлыг хүйсээр нь харьцуулан харахад 55-аас дээш насны хүмүүсийн хэрэглээ аль ч хүйсийн хувьд насны бүлэг үл харгалзан ихээхэн нэмэгджээ. Гар утас хэрэглэгчдийн хувь хэмжээ 2020 оны байдлаар 55-69 настнуудын хувьд насны бүлэг тус бүрээр аль ч хүйсийн хувьд 90%-ийг давж байгаа бол 70-аас дээш настнуудын хувьд 80%-иас илүү байна.

Хүснэгт 5-5: Ахмад настны 2010 он, 2020 оны гар утасны хэрэглээг харьцуулсан байдал, насны бүлэг, хүйсээр (%)

Насны бүлэг	2010		2020	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
55-59	73.8	77.0	94.4	96.9
60-64	73.3	73.7	93.9	96.3
65-69	66.4	64.6	92.7	95.0
70+	50.7	42.8	83.0	81.1

Эх сурвалж: Хүн ам орон сууцны тооллого 2020 тайлан, ҮСХ

5-1-3 Эмзэг бүлгийн ахмад настны байдал

① Эмзэг бүлгийн ахмад настны тоо, төрөл

Тэтгэвэрт гарах нас эмэгтэйчүүдийн хувьд 55, эрэгтэйчүүдийн хувьд 60 байдаг тул Монголын Ахмадын Холбооноос үүнээс дээш насныхныг “ахмад настан” гэж үздэг. Статистик мэдээллээс харахад ахмад настан эмэгтэйчүүдийн эзлэх хувь 70 орчим хувьтай байгаа нь ахмад настан эрэгтэйчүүдийнхээс нэлээн өндөр байна. Ахмад настны тоо 2019 онд 275,523 байсан бол 2021 оны эхээр 325,915 болж, 18 орчим хувиар өсчээ. Ахмад настнуудын 20 орчим хувь нь эмзэг бүлэгт хамаарагдаж байна. 2021 оны эхний байдлаар эмзэг бүлгийн ахмад настнуудыг авч үзвэл "ядууралд өртсөн өндөр настан" хамгийн их байгаа бөгөөд үүний дараа "бусдын асаргаанд буй өндөр настан", "хөгжлийн бэрхшээлтэй өндөр настан", "гэр бүлгүй өндөр настан" орж байна.

Хүснэгт 5-6: Монголын ахмадын холбооноос гаргасан ахмад настны тоо баримт (хүн)

Ангилал	Ангилал	2019 он	2020 он	2021 оны эхээр
Насны бүлэг	Эмэгтэй 55 наснаас, эрэгтэй 60 наснаас 70 нас хүртэл	201,878	221,101	237,978
	71-80	55,055	63,519	64,497
	81-90	16,522	19,640	20,418
	91-100	2,004	2,602	2,883
	100 ба түүнээс дээш нас	64	134	139
	Нийт	275,523	306,996	325,915
	Үүнээс эмэгтэйчүүдийн тоо ба хувь	202,753 (73.6%)	207,587 (67.6%)	217,688 (66.8%)
Эмзэг бүлгийн ахмад	Ядуу ахмад настан	26,701	24,477	20,044
	Гэр бүлгүй ганц бие ахмад настан	9,288	6,569	5,822

настан	Бусдын асаргаанд байдаг ахмад настан	16,813	17,097	19,130
	Хөгжлийн бэрхшээлтэй ахмад настан	7,889	7,518	7,551
	Эмзэг бүлгийн ахмад настны тоо ба харьцаа	60,691 (22.0%)	55,661 (18.1%)	52,547 (16.1%)

Эх сурвалж: Монголын ахмадын холбооноос авсан мэдээлэлд үндэслэн судалгааны баг гаргав.

② Эрүүл мэндийн байдал тааруу ахмад настны байдал

Геронтологийн үндэсний төв 2020 онд ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн нарийн бичгийн дарга нарын газар⁹⁴-тай хамтран эрүүл мэндийн байдлын ангилалаар⁹⁵ IV (эрүүл бус) болон V (Маш эрүүл бус) гэсэн ангилалд хамаарах Улаанбаатарт амьдардаг 6,895 ахмадуудаас 100 хүнийг санамсаргүй байдлаар сонгон, эрүүл мэндийн хэрэгцээг үнэлэх судалгааг⁹⁶ утсаар хийжээ. Энэхүү судалгааны зорилго нь 60-аас дээш насны хүн амын биеийн эрүүл мэнд, асаргааны байдал, нийгмийн статусыг харьцуулах юм. Судалгаанд хамрагдагчдын дундаж нас 74.5 байсан бөгөөд 58% нь эмэгтэйчүүд, 42% нь эрэгтэйчүүд байв. Орлогын эх үүсвэрээ 97% буюу ихэнх нь тэтгэвэр гэж хариулжээ. Эрүүл мэндийн байдлаа өөрөө үнэлсэн байдлыг нь авч үзэхэд судалгаанд оролцогчдын 41% нь хэвийн, 25% нь тааруу, 22% нь сайн, 11% нь маш муу гэж хариулжээ. Эрүүл мэндийн байдлаа тааруу, маш муу гэж хариулсан хүн нийтдээ 36% байв. Мөн сүүлийн 12 сарын хугацаанд асаргаа авсан хүн 42% байв.

③ Өндөр настныг асрах шалтгаанаар ажил хайхгүй байгаа иргэдийн эзлэх хувь

Дэлхийн банкнаас 2018 онд гаргасан тайлан⁹⁷-г харахад МУ-ын хувьд ажил хайхгүй байгаа шалтгаанд өндөр настан асрах шаардлагатай, ажил хийх цаг зав байхгүй гэсэн шалтгаан дурдсан хүн аль ч хүйс дээр цөөн байна (ажил эрхлээгүй эмэгтэйчүүдийн 1.0%, эрэгтэйчүүдийн 1.1%). Гэхдээ Монголд насжилт эрчимтэй явагдаж эхэлж байгаа бөгөөд энэ талаар авах ямар нэгэн бодлого, систем нэвтрээгүй байна. Насжилтаас үүдэн гарах асуудлыг шийдвэрлэх бодлого, тогтолцоо бараг байхгүй байна. Ойрын ирээдүйд өндөр настан асран ажил хийх боломжгүй хүмүүсийн хувь хэмжээ хурдацтай өсч мэднэ." хэмээн тус тайланд дурджээ.

⁹⁴ WPRO нь ДЭМБ-ын бүс нутгийн нарийн бичгийн дарга нарын газруудын нэг бөгөөд Номхон далайн баруун бүсийн нарийн бичгийн дарга нарын газар юм.

⁹⁵ МУ-ынэмч нар хариуцсан иргэдээ үнэлэхэд ашиглах үнэлгээний хуудас бөгөөд “өрхийн эмнэлгийн маягт” гэж нэрлэдэг. Эрүүл мэндийн байдлаар нь дараах 5 бүлэгт хуваана.1. “маш эрүүл”, 2. “эрүүл:төрөлхийн өөрчлөлт болон өвчний анхны шинж тэмдэг илэрч байгаа ч хөдөлмөрийн чадварыг хязгаарлахгүй, эмчилгээ шаардлагагүй”,3. “зөвшөөрөгдөх хэмжээнд эрүүл бус:эмчлэх боломжтой архаг өвчинтэй”,4. “эрүүл бус:зарим хэсгийг нь эмчлэх боломжтой архаг өвчинтэй”, 5. “огт эрүүл биш:эмчлэх боломжгүй архаг өвчний хурц үе дээрээ байгаа”.

⁹⁶ 2021 оны 2 сард Геронтологийн үндэсний төв дээр очиж хийсэн судалгааны үеэр, нийтэд танилцуулаагүй мэдээллийг авсан.

⁹⁷ World Bank (2018) Perceptions of precariousness: A qualitative study of constraints underlying gender disparities in Mongolian’s labor market, p35. (Энэ тоон үзүүлэлт нь 2016 онд хийсэн судалгааны мэдээлэл болно)

5-2 Насжилтын талаар авч хэрэгжүүлэх бодлого

5-2-1 Үндсэн хууль ба Алсын хараа 2050

Үндсэн хуулинд ахмад настан болон бүх насны хүмүүсийн тэгш байдлыг хангах, өндөр насан дээрээ хөгжлийн бэрхшээлтэй болох, хүүхэд төрүүлэх гэх мэт тохиолдолд санхүүгийн туслалцаа авах эрхтэй гэж заасан байдаг.

2021 оноос эхлэх 30 жилийн хөгжлийн төлөвлөгөөг тусгасан бодлогын баримт бичиг болох “Алсын хараа 2050”-ийн анхны төсөлд өндөр настантай холбоотой дараах агуулга тусгагджээ. Хүний хөгжлийн хувьд “Эрүүл мэндийн байдлын хувьд амьдралынхаа сүүлийн шатанд байгаа өвчтөн, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон өндөр настай иргэн асрамжийн газар удаан хугацаанд эмчлүүлэх, асруулах тохиолдолд зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ”, “Ахмад настнуудад үзүүлэх эрүүл мэндийн урт хугацааны үйлчилгээний цогц системийг бий болгоно” гэж тусгажээ.

Мөн амьдралын чанар ба дунд орлоготой иргэдийн талаар “Өндөр настнуудад урт хугацааны дэмжлэг үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулна”, аюулгүй, амар амгалан нийгмийн тухайд “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах түр байр, гэр бүлийн хүчирхийллийн талаар зөвлөгөө өгөх төв байгуулна” гэжээ.

Улаанбаатар хот болон дагуул хотуудын хувьд “Насан туршийн боловсролын хүртээмжийг сайжруулж, насанд хүрэгчид болон өндөр настнуудад зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж, нийгмийн түншлэлийг бэхжүүлнэ” гэж тусгажээ.

Алсын хараа 2050-ийг хэрэгжүүлэхэд гарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэхийн тулд “Хүний нөөцийг дээд зэргээр ашиглах чиглэлээр: Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн тогтолцоог бэхжүүлж, цэргийн албан хаагчид, их сургуулийн оюутнууд, ажилгүй ахмад настан, их сургууль төгсөөгүй ахмад настнуудад зориулсан богино хугацааны болон эрчимжүүлсэн мэргэжлийн сургалтын байгууллага, сургууль байгуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ” гэсэн бол цаашид өсөн нэмэгдэх ахмад настнуудын хувьд асаргааны зардлыг олгох, хүний нөөцийг ашиглах, хамгаалах, зөвлөгөө өгөх байгууллага байгуулна гэх мэтээр тодорхой төлөвлөн тусгажээ.

Алсын хараа 2050 нь 10 жилийн хугацаагаар 3 үе шаттай хэрэгжинэ. Үе шатууд нь 2021-2030 он хүртэлх “Нийгмийн хамгааллын салбарыг шинэчлэх эхний үе шат”, 2031-2040 он хүртэлх “Эрсдэлээс урьдчилан сэргийлэх нийгмийн хамгааллыг сайжруулах II үе шат”, 2041-2050 он хүртэлх “Амьдралын чанарыг сайжруулах нийгмийн хамгааллын цогц үйлчилгээг үзүүлэх III үе шат” юм.

5-2-2 Өндөр настны нийгмийн халамжийн талаарх хууль, холбогдох үйлчилгээ

МУ-ын нийгмийн халамжийн үйлчилгээний талаар зургаан хуульд заасан байдаг. Өндөр настантай холбоотой гурван хууль байдаг бөгөөд энэ нь 2012 оны Нийгмийн халамжийн тухай хууль, 2017 оны Ахмад настны тухай хууль, 2017 оны Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл хөнгөлөлт олгох тухай хууль юм. Эдгээрээс ахмад настан энгийн иргэдтэй хамгийн

холбоотой нь Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хууль юм. Энэ хоёр хуулийн талаар авч үзье.

① Нийгмийн халамжийн тухай хууль ба түүний үйлчилгээ

Нийгмийн халамжийн тухай хуулийн зорилтыг "нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний төрөл, хамрах хүрээг тодорхойлох, нийгмийн халамжийн сан бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг зарцуулах, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж тодорхойлжээ. Нийгмийн халамжийн тухай хуульд заасан ахмад настны орлогын баталгаат байдлыг хангах арга хэмжээ, үйлчилгээний талаар 5-7 хүснэгтэд харуулав.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ нь тухайн олон нийтийн бодит эрэлт хэрэгцээнд тулгуурлан үйлчилгээ үзүүлэх зорилгоор ХНХЯ-ны зүгээс 2005 онд нэвтрүүлсэн нийгмийн халамжийн хөтөлбөр юм. Энэхүү хөтөлбөр нь нийгмийн халамжийн үйлчилгээг хөгжүүлэх үндсэн үүрэг хариуцлагыг олон нийтийн оролцоонд даатгадаг бөгөөд үйлчилгээг хувийн хэвшлийн байгууллага болон ТББ хэрэгжүүлдэг⁹⁸.

2020 онд улсын хэмжээнд 106 төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж ХХҮЕГ-аас ОНОТХҮ үзүүлэх хоёр жилийн хугацаатай магадлан иргэмжлэлийн эрх авчээ. Зорилтот бүлэг нь ахмад настууд төдийгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүнд нөхцөлд байгаа хүүхдүүд, хүчирхийлэлд өртсөн, шоронгоос суллагдсан, донтолттой, эдгэршгүй өвчтэй, орон гэргүй, нийгмийн дэмжлэг шаардлагатай шилжин ирэгсэд, өрх толгойлсон эцэг эх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй иргэд, 3-аас дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхийн хүүхэд байна. Үйлчилгээ нь "нөхөн сэргээх" болон "өдөр тутмын үйлчилгээ", "зөвлөгөө өгөх", "сургалт", "гэрээр асаргааны үйлчилгээ үзүүлэх", "түр байраар хангах", "орон гэргүй хүмүүс болон тэдний гэр бүлийг бичиг баримтжуулах" зэрэг агуулгаар хэрэгждэг.

Хүснэгт 5-7: Нийгмийн халамжийн тухай хуульд заасан ахмад настны орлогын баталгаат байдлыг хангах арга хэмжээ ба төрийн үйлчилгээ⁹⁹

Үйлчилгээний төрөл	Хамрагдагч ба үйлчилгээний агуулга	Мөнгөн дүн ба олгох давтамж	Олгох хэлбэр
Нийгмийн халамжийн тэтгэвэр	• 60 ба түүнээс дээш насны эрэгтэй, 55 ба түүнээс дээш насны эмэгтэй (нийгмийн даатгалын хуулиар тэтгэвэр авах эрх эрхгүй иргэн)	188,000 төгрөг/сар (бүгд ижил дүнгээр)	Банкны дансаар бэлнээр олгоно.
Нийгмийн халамжийн тэтгэмж	Асаргааны тэтгэмж • Ганц бие ахмад настан ба хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэн • Байнгын асаргаа шаардлагатай, эмнэлгийн хяналтанд байдаг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асран хамгаалж	84,500 төгрөг/сар	Банкны дансаар олгоно.

⁹⁸ ADB 2015. Social Protection Brief: Mongolia's community-based welfare service program, ADB Briefs No.33 February 2015

⁹⁹ <https://www.legalinfo.mn/law/details/393> and <http://ub.hudulmur-halamj.gov.mn/menu/61/post/815-г> ашиглаж гаргав.

	байгаа иргэн		
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ	Гэрээ байгуулсан ТББ-ын үзүүлж буй үйлчилгээ • Ахмад настан, бусад	Үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагад үйлчилгээний төлбөр шилжинэ.	
Мэргэжлийн байгууллагын асрамжийн үйлчилгээ	Дараах иргэдэд зориулсан асрамжийн байгууллага • Ганц бие өндөр настан, бусад	Үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагад үйлчилгээний төлбөр шилжинэ.	

Эх сурвалж: Судалгааны багийн судалсанаар (2021 оны 3 сар)

② Ахмад настны тухай хууль ба түүний үйлчилгээ

2017 онд батлагдсан Ахмад настны тухай хуулийн зорилт нь “Ахмад настны эрхийг хангах, тэдний амьжиргаа, хөгжил, оролцоог дэмжих, нийгмийн үйлчилгээ авах боломжийг нь нэмэгдүүлэх, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үүргийг тодорхойлж, тэдгээрийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршино.” Ахмад настны тухай хуулинд зааснаар ахмад настан нь дараах 9 төрлийн үйлчилгээ авдаг. а. лавлагаа, мэдээллийн үйлчилгээ; б. зөвлөгөө өгөх үйлчилгээ; в. явуулын үйлчилгээ; г. өдрийн үйлчилгээ; д. сайн дурын үйлчилгээ; е. өдрөөр эмчлэх, асран сувилах үйлчилгээ; ё. асрамжийн үйлчилгээ; ж. хүнсний дэмжлэг үзүүлэх үйлчилгээ; з. гэр бүлийн хүчирхийллээс хамгаалагдах үйлчилгээ¹⁰⁰.

Энэ хуулинд түлш худалдан авах болон халаалт тогны төлбөрийн мөнгөн тэтгэмж, нийгмийн даатгалд хамрагдаагүй ахмад настны оршуулгын зардал, жилд хоёр удаа олгодог мөнгөн тэтгэмж, хөл, гарны протез, ортопедийн хэрэгсэл зэргийн төлбөрөөс чөлөөлөх зэрэг зарим тэтгэмж, үйлчилгээг ахмад настан (55-аас дээш насны эмэгтэй, 60-аас дээш насны эрэгтэй)-д үзүүлэхээр заажээ. Ахмад настны тухай хуульд заасан ахмад настны орлогын баталгаат байдлыг хангах арга хэмжээ, төрийн үйлчилгээг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 5-8: Ахмад настны тухай хуульд тусгагдсан орлогын баталгаат байдлыг хангах арга хэмжээ, төрийн үйлчилгээ¹⁰¹

Үйлчилгээний агуулга	Олгох мөнгөн дүн ба давтамж	Олгох арга
Нийгмийн даатгалын хуулиар оршуулгын зардал авах эрхгүй ахмад настны оршуулгын зардалд нэг удаагийн мөнгөн тусламж үзүүлэх	1,000,000 төгрөг/1 удаа	Дансаар олгоно.
Ахмад настан үр хүүхэдгүй бол түлш худалдан авах, эсвэл орон сууцны төлбөр төлөхөд зориулж жил нэг удаа тусламж үзүүлэх	140,000 төгрөг/жил	Дансаар олгоно.
Эрүүл мэндийн байгууллага зөвлөснөөр ахмад настан рашаан сувилалд эмчлүүлэх тохиолдолд эмчилгээний зардлын 50%, нэг талын замын зардлыг буцаан олгох	Тогтоосон хэмжээгээр, жилд 1 удаа	

¹⁰⁰ ADB (2020) Country Diagnostic Study on Long-Term Care in Mongolia, p.26-27

¹⁰¹ Энэ хүснэгтэд алдар цолтон ахмад настанд зориулсан ахмад настны орлогын баталгааг хангах арга хэмжээ, үйлчилгээг тусгаагүй болно.

Ахмад настан амралт, сувилаалаар үйлчлүүлсэн тохиолдолд төлбөрийг хөнгөлөх	20,000 төгрөг/өдөр (1 жилд 10 хоног хүртэл)	
Хиймэл хөл, гар, хиймэл шүдний зардлыг хөнгөлөх	Төрөөс тогтоосон дундаж зардал (3 ба 5 жилд 1 удаа)	
Сонсгол, хараа дэмжих хэрэгсэлийн зардлыг хөнгөлөх	Төрөөс тогтоосон дундаж зардал (5 жилд 1 удаа)	
Нийслэлээс 1000 км ба түүнээс хол бүс нутагт амьдардаг өндөр настан Нийслэлд ирэх тохиолдолд нэг талын замын зардалд дэмжлэг үзүүлэх	Тогтоосон хэмжээгээр, жилд 1 удаа	Дансаар олгоно.
Ажиллаж байсан байгууллага нь татан буугдсан болон бусад шалтгаанаар харьяалах байгууллага байхгүй болсон ахмад настанд бэлэн мөнгө олгох	2 жилд 1 удаа 10,000 төгрөг	Дансаар олгоно.
65 ба түүнээс дээш насны ахмад настанд бэлэн мөнгөн тэтгэмж олгох (Насны хишиг хөтөлбөр)	Жилд 2 удаа 50,000-250,000 төгрөг Мөнгөн дүн нь наснаас шалтгаалан өөр байна.	Дансаар олгоно.

Эх сурвалж: Судалгааны багийн судалгаа (2021 оны 3 сар)

Ахмад настны орлогын баталгааг хангах арга хэмжээ, төрийн үйлчилгээг авч буй иргэдийн тоо болон зарлагын нийт дүнгийн 2017-2020 онуудад гарсан өөрчлөлтийг авч үзвэл (хүснэгт 5-9), нийгмийн халамжийн тэтгэвэр, байнгын асрамж, эмнэлгийн хяналтанд байх шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн асарч буй хүмүүсийн нийгмийн халамжийн тэтгэвэр авагчдын тоо болон нийт зарлага 2017-2020 онд өссөн байна. Ялангуяа, 2020 онд нийгмийн халамжийн тэтгэврийн нийт зарлага 2017 оныхоос гурав дахин их гарчээ.

Хүснэгт 5-9: Ахмад настны орлогын баталгааг хангах арга хэмжээ, үйлчилгээнд хамрагдагсдын тоо ба зарлагад¹⁰² гарсан өөрчлөлт (сая)

	2017		2018		2019		2020	
	Хамраг-дагч	Зарлага	Хамраг-дагч	Зарлага	Хамраг-дагч	Зарлага	Хамраг-дагч	Зарлага
Нийгмийн халамжийн тэтгэвэр: 60 ба түүнээс дээш насны эрэгтэй, 55 ба түүнээс дээш насны эмэгтэй	2,443	3,109,455	2,538	4,528,285	3,595	5,646,940	3,810	9,571,184
Нийгмийн халамжийн тэтгэмж: Ганц бие ахмад настан ба хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэн	1,343	755,792	174	119,838	157	120,982	158	128,476
Нийгмийн халамжийн тэтгэмж: Байнгын асаргаа шаардлагатай, эмнэлгийн хяналтанд байдаг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаа иргэн	28,635	17,043,513	30,647	19,478,525	33,118	22,899,888	34,557	28,547,169
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ (ахмад настанаас бусад иргэд)	15,495	2,378,319	19,258	3,584,105	15,294	1,696,633	6,995	1,409,461

¹⁰² Нийт зарлагын нэгж :сая төгрөг

Оршуулгын тэтгэмж авах эрхгүй ахмад настанд олгох оршуулгын зардал	63	58,750	217	215,161	177	170,000	— ¹⁰³	—
Үр хүүхэдгүй ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, эсвэл түлш худалдан авахад зориулж 1 удаа бэлэн мөнгө олгох	7,559	1,041,109	6,764	1,103,218	58,875	8,634,305	—	—
Ахмад настан нь эрүүл мэндийн байгууллагын зөвлөснөөр магадлан итгэмжлэгдсэн рашаан сувилалд эмчлүүлэх тохиолдолд эмчилгээний зардлын 50%, нэг талын замын зардлыг буцаан олгох	29,650	3,981,260	30,867	4,293,610	35,820	7,023,073	—	—
Ахмад настны амралт, сувилалын төлбөрийг хөнгөлөх	45,546	8,710,251	50,123	10,423,712	53,875	8,634,305	—	—
Хиймэл хөл, гар, шүдний зардлаас чөлөөлөх	36,650	6,223,461	40,578	7,674,437	48,213	8,454,567	—	—
Сонсгол, харааны төхөөрөмжийн зардлаас чөлөөлөх	9,309	2,235,881	16,282	3,224,961	16,026	2,370,843	—	—
Нийслэлээс 1000 км ба түүнээс хол орон нутагт оршин суудаг иргэний Нийслэлд ирэх нэг талын замын зардалд дэмжлэг үзүүлэх	3,549	421,141	3,649	502,849	3,759	587,374	—	—
Ажиллаж байсан байгууллага нь татан буугдсан болон бусад шалтгаанаар харьяалах байгууллага байхгүй болсон ахмад настанд бэлэн мөнгө олгох	101,923	1,435,448	108,248	1,574,369	128,052	1,713,761	—	—
Насны хишиг мөнгөн тэтгэмж	141,032	19,842,639	131,313	20,526,907	138,383	21,754,264	—	—

Эх сурвалж: ХХҮЕГ, 2021

5-2-3 Ахмад настанд эрүүл мэндийн болон асаргааны үйлчилгээ үзүүлэгчид

① Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч

Доорх 5-10 хүснэгтэд 2015 болон 2020 оны эрүүл мэндийн салбарын байгууллагуудын тоог харуулав. Улсын эрүүл мэндийн байгууллагуудын хувьд өрхийн эрүүл мэндийн төвүүд болон дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийн тоо цөөрч байгаа ч бусад эрүүл мэндийн байгууллагуудын хувьд онцын өөрчлөлт алга байна. Харин хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд болон

¹⁰³ Зарим орлогын баталгаат байдлыг хангах арга хэмжээ/төрийн үйлчилгээтэй холбоотой 2020 оны тоон мэдээллийг олж авч чадаагүй.

компаниудын тоо эрс өсч, энэ дундаас хувийн эмнэлэг, эм ханган нийлүүлэгч компани, хувийн эмийн сангуудын тоо тус бүр бараг 1.5 дахин өссөн байгааг харж болно.

Хүснэгт 5-10: Эрүүл мэндийн байгууллагын тоо, 2015 ба 2020 оны байдлаар

Эрүүл мэндийн байгууллага	2015 оны тоо	2020 оны тоо
Өрхийн эрүүл мэндийн төв	218	209
Сумын эрүүл мэндийн төв	291	332 ¹⁰⁴
Сум дундын эмнэлэг	39	
Дүүргийн эмнэлэг	12	4
Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	6	6
Аймгийн нэгдсэн эмнэлэг	16	16
Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	5	5
Төв/төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг	13	12
Төрөх эмнэлэг	3	3
Хувийн эмнэлэг	224	241
Хувийн клиник	1,006	1,491
Сувилал	105	102
Эм ханган нийлүүлэх компани	210	350
Эмийн компани	33	40
Хувийн эмийн сан	967	1,613
Бусад	96	39
Нийт	3,244	4,463

Эх сурвалж: 2015 оны үзүүлэлтийг АХБ (2020) Country diagnostic study on long-term care in Mongolia-д, 2020 оны үзүүлэлтийг Эрүүл мэндийн хөгжлийн төв-ийн протоколд үндэслэж судалгааны баг гаргав.

② Асаргааны үйлчилгээ үзүүлэгч

Өндөр настны асрамжийн үйлчилгээнд зарцуулдаг төсвийн зардлыг асаргааны үйлчилгээ үзүүлэгч гол байгууллагуудаар авч үзэхэд хамгийн их хувь буюу 60 орчим хувийг эмнэлгүүд эзэлж байна. Үүний дараа эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллага 20 гаруй хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, эмнэлэг, анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд дангаараа 80 гаруй хувийг эзэлдэг. Үүний дараагаар сувиллын газар, асрамжийн газар, албан бус асаргаа үзүүлэгчид ордог. Уг хүснэгтээс эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилагдах төсвийн зардлын эзлэх хувь асрамжийн газар, сувилал, албан бус асаргаа үзүүлэгчдийнхээс хамаагүй өндөр байгааг харж болно.

Хүснэгт 5-11: Гол асаргааны үйлчилгээ үзүүлэгчдэд 2015 онд төрөөс гаргасан хөрөнгө

Асаргаа үзүүлэгч	Төсөв (ам доллар)	%
Эмнэлэг	153,445,143	59.81%
Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлэгч байгууллага	59,147,959	23.05%
Сувилал	41,564,049	16.20%
Хөнгөвчлөх үйлчилгээний төв	1,605,558	0.63%
Асрамжийн төв	510,825	0.20%
Албан бус асаргааны үйлчилгээ үзүүлэгч	288,203	0.11%

Эх сурвалж: АХБ (2020) Country Diagnostic Study on Long-Term Care in Mongolia

¹⁰⁴ 2019 оноос хуулинд өөрчлөлт орсоноос сумын эмнэлэг, сум дундын эмнэлгийн тоог нэгтгэж тусгасан.

2015 оны нийгмийн хамгаалал, асаргаа, эрүүл мэндийн үйлчилгээний төсвийн зарцуулалтыг үйлчилгээ болон хөтөлбөр тус бүрээр авч үзэхэд хоёрдогч болон гуравдагч шатлалын эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тусламж үйлчилгээний зардал хамгийн өндөр байна. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ болон эдгээр хоёрдогч болон гуравдагч шатлалын эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлыг нийлүүлэх юм бол асаргааны үйлчилгээний хөтөлбөртэй холбоотой нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн үйлчилгээний хөтөлбөрийг нийлүүлсэний бараг 90%-тай тэнцэж байгааг харж болно.

Хүснэгт 5-12: 2015 онд нийгмийн хамгаалал/асаргаа, тусламжийн үйлчилгээнд төрөөс гаргасан зардал

Асаргааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн нийгмийн хамгааллын үйлчилгээ	Зарлага (ам доллар)	Тусламж үйлчилгээ/ хөтөлбөр	Зарлага (ам доллар)
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	7,535,189	Анхан шатны тусламж	59,147,959
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээ	795,735	Хоёрдугаар шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээ	81,663,663
Сэргээн заслын тусламж	10,091,947	Гурав дахь шатлалын төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ	81,929,766
Гэрийн асрамж, түр байрлуулан асрамжлах үйлчилгээ	1,581,689	Нийгмийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр	9,971,501
Нийт	20,004,560	Нийт	232,712,889

Эх сурвалж: АХБ (2020) Country Diagnostic Study on Long-Term Care in Mongolia

5-2-4 Өндөр насны тэтгэвэр

Тэтгэврийн даатгалын тогтолцоогоор хөдөлмөрийн гэрээ байгуулсан ажилтан өндөр насны тэтгэвэр, хөгжлийн бэрхшээлтэй иргэний болон тэжээгчээ алдсаны тэтгэмж авахын тулд шимтгэл төлөх үүрэгтэй. Энэхүү тогтолцоо нь 1994 онд бий болсон бөгөөд социализмын үеэс мөрдөж байсан цалинд суурилсан тэтгэврийн тогтолцоо болон тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тогтолцооноос бүрдэнэ. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь нь ажил олгогч, даатгуулагч нийлээд 17% бөгөөд малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон хөдөлмөрийн гэрээгээр ажилладаггүй бусад иргэд сайн дураараа 12%-ийн шимтгэл төлж хамрагдах боломжтой. Эдгээр шимтгэлийн хэмжээг 2017 онд батлагдсан хуулиар ажил олгогч, даатгуулагчид 17%, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид 12.5% -ийг төлдөг байхаар үе шаттайгаар аажмаар нэмэгдүүлсэн.

Өндөр насны тэтгэврийг эрэгтэй 60, эмэгтэй 55 наснаас авах боломжтой боловч тодорхой ажил мэргэжилтэй, тодорхой нөхцөл бүхий ажил хийдэг иргэд тэтгэврийн наснаас 10 жилийн өмнө тэтгэвэрт гарах боломжтой. 20 жил тасралтгүй ажиллаж, тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн иргэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75-аас доошгүй хувийн тэтгэвэр авах боломжтой. 10 жил ажилласан иргэн хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэвэр авах эрхтэй. Санхүүгийн дарамтыг бууруулах, шимтгэл, тэтгэмжийн хоорондын уялдааг сайжруулах зорилгоор 1999 онд Тэтгэврийн даатгалын нэрийн дансны тогтолцоо (цаашид "ТДНДТ" гэх)-г нэвтрүүлжээ. Энэхүү тогтолцоонд 1960 оноос

хойш төрсөн даатгуулагчдыг хамруулах байсан боловч 2015 оны тэтгэврийн шинэчлэлийн үндэсний бодлогоор 1979 оноос хойш төрсөн даатгуулагчид хамрагдахаар хугацааг нь сунгажээ. 1960-1978 оны хооронд төрсөн даатгуулагчид цалинд суурилсан тэтгэврийн тогтолцоо болон нэрийн дансны тэтгэвэр (НДТ)-ийн аль нэгэнд хамрагддаг болжээ. НДТ авах хугацааг 2015 оноос 2033 он хүртэл (эмэгтэйчүүд 55 насандаа тэтгэвэрт гарах жил) хойшлуулжээ¹⁰⁵.

Өндөр насны тэтгэврийн даатгалын сангаас олгох өндөр насны тэтгэвэр, тахир дутуугийн тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр гэсэн гурван төрлийн тэтгэвэр байдаг. Энэ дундаас өндөр насны тэтгэвэрт 55-аас дээш насны эмэгтэйчүүд, 60-аас дээш насны эрэгтэйчүүд 20-иос доошгүй жил шимтгэл төлж ирсэн бол хамрагдана. Өндөр насны тэтгэврийг даатгуулагчийн банкны дансанд шилжүүлдэг бөгөөд сард нэг удаа шилжүүлэг хийх даалгавар банкинд өгдөг. 2017-2020 оны өндөр насны тэтгэвэр авагчдын тоо болон нийт зарлагын өөрчлөлтийг 5-13 хүснэгтэд харуулав. 2020 онд тэтгэвэр авагчдын тоо 2017 онтой харьцуулахад 1.26 дахин, үүнтэй уялдан нийт зарлага 1.62 дахин өссөн байна.

Хүснэгт 5-13: Өндөр насны тэтгэвэр авагчдын тоо ба зарлагын өөрчлөлт (сая төгрөг)

Өндөр насны тэтгэвэр	2017		2018		2019		2020	
	Тэтгэвэр авагчдын тоо	Зарлагын хэмжээ	Тэтгэвэр авагчдын тоо	Зарлагын хэмжээ	Тэтгэвэр авагчдын тоо	Зарлагын хэмжээ	Тэтгэвэр авагчдын тоо	Зарлагын хэмжээ
	133,069	546,914	142,262	640,071	152,637	746,605	167,885	885,814

Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар (НДЕГ), 2021

5-2-5 Үндэсний стратеги, хөтөлбөрүүд

Засгийн газар 2002 оны “Насжилтын асуудлаарх Мадридын Үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн дараа “Хүн амын насжилтын асуудлаарх үндэсний стратеги (2009-2030 он)”-ийг 2009 онд баталсан.

Үндэсний стратегид дараах зүйл багтана.

- Хүн амыг насжилтад бэлтгэх стратеги
- Хөдөлмөрийн насны хүн амын нийгмийн хамгаалал
- Төрөлтийн түвшинг нэмэгдүүлэх арга хэмжээ
- Ахмад настны амьжиргааг дээшлүүлэх стратеги
- Ажил эрхлэлт
- Орлого
- Өндөр чанартай эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, ашиглах
- Дэд бүтцийг хөгжүүлэх
- Өндөр настанд ээлтэй орчин, нийгэм

¹⁰⁵ World Bank (2018) Policy Options for Pension Reform, World Bank Report No. 127165-MN.

① “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр

Засгийн газар "Хүн амын насжилтын асуудлаарх үндэсний стратеги (2009-2030 он)"-ийн хэрэгжилтийг хангах үүднээс “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр (2014-2020)-ийг 2013 онд 416 дугаар тогтоолоор баталсан. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь "идэвхтэй, эрүүл насжилтыг дэмжиж, ахмад настны эрүүл мэнд, сайн сайхан байдал, нийгмийн хамгаалал, нийгмийн оролцоог дээшлүүлэх замаар тэдний амьдралын чанарыг сайжруулах" явдал юм. Энэхүү хөтөлбөрийг Эрүүл мэндийн яам (цаашид “ЭМЯ” гэх) боловсруулж, Засгийн газар баталсан.

Хүснэгт 5-14: “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн тойм

“Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр	
Эх үүсвэр	• Улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилагдсан хөрөнгө • Олон улсын байгууллага, донор орнуудаас олгосон хандив • Дотоод, гадаадын төрийн байгууллага, төрийн бус байгууллага, ААН, ард иргэдийн хандив, санхүүгийн дэмжлэг • Эрүүл мэндийг дэмжих сангийн төсөв • Хуулиар зөвшөөрөгдсөн бусад хөрөнгийн эх үүсвэр
Хэрэгжүүлэгч байгууллага	Гол хэрэгжүүлэгч байгууллага: ЭМЯ, Геронтологийн үндэсний төв Хамтран хэрэгжүүлэгч: Аймаг, нийслэлийн засаг дарга, орон нутгийн засаг захиргаа, Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
Хөтөлбөрийн зорилго	• Зорилт 1: Хүн амын эрүүл насжилтыг дэмжих хууль эрх зүй, нийгэм, эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх; • Зорилт 2: Настны эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх; • Зорилт 3: Настны хөгжил, хамгаалал, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх • Зорилт 4: Эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг настны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өргөжүүлэх

Эх сурвалж: Геронтологийн үндэсний төвөөс авсан матеиалын төсөлд үндэслэн судалгааны баг боловсруулав.

Хөтөлбөрийг хоёр үе шаттайгаар хэрэгжүүлсэн бөгөөд I үе шат нь 2014-2017 он, II үе шат 2018-2020 он хүртэл байв. АХБ-ны тайланд¹⁰⁶ "2016 оны тус хөтөлбөрийн хэрэгжилтийг эрүүл насжилтыг дэмжих хууль эрх зүй, нийгэм, эдийн засгийн таатай орчинд шилжих гэдэг талаас нь үнэлбэл хөдөө орон нутагт уг хөтөлбөр бараг хэрэгжихгүй байна" гэж онцолжээ. Ахмад настны эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн үед хийгдэж байсан ихэнх ажил нь асран хамгаалагчдад зориулсан сургалт хэлбэрээр хэрэгжиж байв. Нийгмийн амьдрал дахь ахмад настны оролцоо, хөгжил, хамгааллыг сайжруулах ажил тухайн үед хөдөө орон нутагт ч, хот сууринд ч хязгаарлагдмал хүрээнд хийгдэж байв.

Ахмад настны хэрэгцээнд нийцсэн эмнэлгийн үйлчилгээг өргөжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлууд дунд зэргийн үр дүнтэй байна. Хөтөлбөрийн талаарх ойлголт болон мэдээлэл дутмаг, хөдөө орон нутагт дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй байсан, санхүүгийн хомсдол, Засгийн газрын салбар хоорондын хяналт, зохицуулалт, хамтын ажиллагаа хангалтгүй байсан зэрэг нь хэрэгжилтэд нөлөөлсөн гэж тайланд дурджээ.

¹⁰⁶ АХБ (2020) “Монгол дахь урт хугацааны тусламж үйлчилгээний судалгаа” хуудас 27-28.

2021 оны 5 сарын сүүлчийн байдлаар тус үндэсний хөтөлбөр нь үнэлгээний шатандаа явж байна. Одоогоор холбогдох тайлангийн төслийг бичиж боловсруулах ажил хийгдэж байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч агентлагуудын нэг бөгөөд үнэлгээний процесст оролцож буй Геронтологийн үндэсний төвийн зөвшөөрлөөр тус тайлангийн төслийг уншиж танилцахад "Асрамжийн үйлчилгээг хөгжүүлэхийн тулд асаргааны даатгалын тогтолцоонд шилжих шаардлагатай" гэж дурдсан байна. Эндээс Геронтологийн үндэсний төв нь асаргааны даатгалын тогтолцоог нэвтрүүлэх тал дээр нааштай хандлагатай байгааг харж болно.

② Ахмад настны хөгжил, хамгааллын хөтөлбөр

МУ-ын Засгийн газраас хэрэгжүүлж буй ахмад настны хөгжил, хамгааллын хөтөлбөр¹⁰⁷-т "2009 оны хүн амын насжилтын асуудлаарх үндэсний стратеги, 2013 оны үндэсний хөтөлбөрөөр эрүүл насжилт, ахмад настны эрүүл мэндийн талаар баталсан хэдий ч, хууль, бодлого, хөтөлбөр, холбогдох хэлтэс газруудын ажлын уялдаа холбоо, үйл ажиллагааны зохицуулалт, судалгаа, мэдээлэл, үр дүн хангалтгүй байв. Иймд ахмад настуудад тулгарч буй асуудлыг шийдвэрлэх хөтөлбөрийг боловсруулсан" гэж дурджээ. Хөтөлбөрийн зорилго нь "Ахмад настны халамжийг сайжруулах, ядуурлаас хамгаалах, эрүүл мэнд, наслалтыг дэмжих, нийгэмд идэвхтэй оролцох, амьдрах нөхцлийг сайжруулах чиглэлээр төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, хүчин чармайлтад анхаарлаа төвлөрүүлэн ажиллах явдал" юм. Хөтөлбөрийг 2020-2023 он хүртэл хэрэгжүүлэх бөгөөд улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, татаас, хандиваар санхүүжүүлнэ.

Хөтөлбөр нь ахмад настны амьдралын чанарыг сайжруулах, тэднийг ядуурлаас урьдчилан сэргийлж, нийгмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулахад чиглэгдсэн бөгөөд ахмад настны эрэлт хэрэгцээнд тулгуурлан төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх, ахмад настанд зориулсан үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг өргөжүүлэн хөгжүүлэх, олон нийтийн дэмжлэг тусалцааны сүлжээг өргөтгөх зэрэг агуулга тусгагджээ. Мөн тус хөтөлбөрөөр 2017, 2018 оны мэдээлэлд үндэслэн суурь судалгаа хийгдсэн бөгөөд хөтөлбөрийн сүүлийн жил болох 2023 онд хүрэх зорилтот түвшинг тодорхойлжээ. 5-15 хүснэгтэд ХНХЯ-аас тогтоосон 14 шалгуур үзүүлэлт, нэгж, суурь түвшний он болон үзүүлэлт, зорилтот түвшний он болон үзүүлэлт, тэдгээрийн эх үүсвэрийг харуулав.

Хүснэгт 5-15: Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт		Нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин		Мэдээллийн эх сурвалж
			Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт	
1	Дундаж наслалт	%	2018	70.19	2023	72.0	ҮСХ
2	60 наснаас дээш амьдрах дундаж хугацаа	Жил	2017	16.0	2023	16.3	ҮСХ-ы хүн амын статистик
3	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 55-59 нас	тоо	2018	45.9	2023	50.0	ҮСХ-ы ажиллах хүчний судалгаа

¹⁰⁷ Засгийн газрын 2019 оны 384 дүгээр тогтоолын хавсралт болох "Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр"-ийн монгол хувилбарыг судалгааны баг орчуулав.

4	Орон сууцанд амьдардаг ахмад настны тоо	%	2019	28	2023	33.0	ҮСХ
5	Суурь нийгмийн хамгааллын хөтөлбөрт хамрагдах, тэтгэвэрт гарсан ахмад настай хүн амын хувь	%	2017	97.5	2023	100.0	ҮСХ, тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтийн тоон мэдээлэл
6	Ахмад настан тэргүүлэгчтэй өрхийн орлого	1000 төгрөг	2017	753,690	2023	900,000	ҮСХ-ны ахмад настны нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлтийн судалгаа
7	60 наснаас дээш эрүүл амьдрах дундаж хугацаа	Он	2017	12.1	2023	12.4	ҮСХ-ны хүн амын статистик
8	Урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх асаргаа сувилгаа/өдөр өнжүүлэх цогцолбор төв	Тоо	2019	0	2023	3	ХХҮЕГ-ын тайлан мэдээ
9	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамрагдах ахмад настны тоо	Хүний тоо	2018	3.1 сая	2023	4 сая	ҮСХ, Ахмад настны нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлтийн судалгаа
10	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт хамрагдсан ахмад настны нийт ахмад настанд эзлэх хувь (Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ, санхүүгийн дэмжлэг)	%	2018	0.52	2023	1.5	ХХҮЕГ-ын тайлан мэдээ
11	55-59 насны ажилгүй иргэд	%	2018	5.5	2023	5.0	ҮСХ, Ажиллах хүчний судалгаа
12	Ахмадын хөгжлийн ордон, өргөө, танхим, төвөөр үйлчлүүлсэн ахмад настан	тоо	2018	201,000	2023	300,000	Ахмадын холбооны тайлан
13	ГБХЗХГ-ын харьяа Хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн ахмад настан	%	2018	45.4	2023	60.0	ГБХЗХГ-ын тайлан
14	Тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөрт хамрагдсан ахмад настны тоо	Хүний тоо	2018	0	2023	20,000	Ахмадын холбооны тайлан мэдээ

Эх сурвалж: 2019 онын Засгийн газрын 389 дугаар тогтоолын хавсралт “Ахмад настны хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр” -ийн монгол орчуулгаас

- ③ Ахмад настны асрамжийн тогтолцоог нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ХНХЯ болон ЭМЯ "Алсын хараа 2050"-ийн зорилтод хүрэхийн тулд "Ахмад настны асрамжийн тогтолцоог нэвтрүүлэх 2021-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулж байгаа бөгөөд сайд нарын хамтарсан тушаалаар батлахаар төлөвлөж байна. Тус үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл¹⁰⁸-өөс харахад шаардлагатай хөрөнгө мөнгийг улс, орон нутгийн төсөв,

¹⁰⁸ Төслийн агуулгыг тус судалгаанд ашиглах, дурдах зөвшөөрлийг ХНХЯ-аас авсан. Мөн одоо боловсруулж буй бичиг баримт нь төслийн шатанд байгаа ба цаашид өөрчлөгдөх магадлалтай (2021 оны 5 сарын сүүлийн байдлаар).

хандивлагчдын зээл болон татаасаас санжүүжүүлэх талаар холбогдох байгууллагуудад заавар чиглэл өгчээ.

Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөний алсын хараа нь "идэвхтэй, бүтээлч насжилтыг дэмжих найрсаг уур амьсгал орчныг бүрдүүлж, тусламж үйлчилгээ шаардлагатай өндөр настанд нээлттэй, тэгш хүртээмжтэй, цогц, нэгдсэн урт хугацааны тогтолцоо (цаашид “Асрамжийн тусламж үйлчилгээ” гэх)-г бүрдүүлсэнээр иргэдийн амьдралын чанарыг сайжруулах” явдал гэжээ. Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөнд алсын хараа болон 5 гол зорилт, мөн зорилт тус бүрээрх үйл ажиллагааны чиглэл, үйл ажиллагааны агуулга, үр дүн, стандарт, хэрэгжүүлэх болон хамтран хэрэгжүүлэх байгууллага, хэрэгжүүлэх хугацаа зэргийг тусгажээ.

Агуулга ихтэй тул 5 зорилт, үйл ажиллагааны салбаруудыг энд дурдаад бусад агуулгыг багтаасан ерөнхий төлөвлөгөө (төсөл)-г хавсралт 3-т дурдав. Гол хэрэгжүүлэх байгууллагаар ХНХЯ, ЭМЯ голлон ажиллах бөгөөд энэ хоёр яамны холбогдох байгууллагууд (ХХҮЕГ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн, Геронтологийн үндэсний төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Ахмад настны асрамжийн газар гэх мэт) болон их дээд сургууль, сургалтын төв гэх мэт газрууд үйл ажиллагааны агуулгаас хамаараад хамтарч хэрэгжүүлнэ гэжээ.

Уг төлөвлөгөөнд ахмад настны асрамжийн тогтолцоог нэвтрүүлэхэд шаардлагатай асуудлууд тусгагдсан тул тавьсан эдгээр зорилтдоо хүрч чадвал сайн систем бүрэлдэнэ гэж үзэж байна. 2021 оны 4 сард АХБ-ны өндөр настны асуудал хариуцсан мэргэжилтэнтэй уулзаж ярилцахад АХБ уг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад хамтарч ажилласан гэж хэлж байсан. Иймд МУ-ын Засгийн газар төрөл бүрийн байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллаж, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх дээрээ анхаарах шаардлагатай.

Хүснэгт 5-16: Ахмад настны тусламж үйлчилгээний системийг нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний (төсөл) товч агуулга 2021-2024 он

Алсын хараа	
Идэвхтэй, бүтээлч насжилтыг дэмжих найрсаг орчныг бүрдүүлж, асаргаа сувилгаа шаардлагатай өндөр настануудад нээлттэй, хүртээмжтэй, цогц, нэгдсэн урт хугацааны асаргаа тусламжийн системийг бий болгосноор ард иргэдийн амьдралын чанарыг сайжруулах	
Зорилго 1: Ахмад настны хэрэгцээнд тулгуурлан төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэхийн тулд урт хугацааны тусламж үйлчилгээний системийг бий болгож, хөгжүүлэх.	
1.1	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн анхан шатны тусламж үйлчилгээний сүлжээг байгуулж, хөгжүүлэх
1.2	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн асаргаа үйлчилгээний төвийг сум, баг, хорооны түвшинд байгуулж, ажилуулах
1.3	Ахмад настны асрамжийн төвийн чадавхийг сайжруулах
1.4	Асаргаа хийх иргэдэд дэмжлэг үзүүлэх системийг бий болгох
1.5	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг өргөжүүлэх
1.6	Асаргааны үйлчилгээний менежментийн системийг бий болгох
1.7	Асаргаа үйлчилгээний стандарт, дэс дарааллыг багтаасан үнэлгээний системийг бий болгож, хэрэгжүүлэх

Зорилго2: Хүнд нөхцөлд байгаа иргэд ашиглах боломжтой нийтлэг, тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бий болгох	
2.1	Асаргаа үйлчилгээний системд санхүүгийн дүн шинжилгээ хийх чадавхийг бэхжүүлэх
2.2	Урт хугацааны тусламж үйлчилгээ (татвар, даатгал, өөрийн хөрөнгө) -ний санхүүжилтийн систем, санхүүгийн хуваарилалтын боломжит хувилбаруудыг тодорхойлох.
2.3	Хувийн ААН, ТББ-ын оролцуулсан санхүүгийн урамшууллын системийг хөгжүүлэх
2.4	Асаргаа үйлчилгээний шинэ санаа, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх сан байгуулах
Зорилго 3: Чадвартай, асаргаа үйлчилгээг идэвхитэй гүйцэтгэж чадах боловсон хүчнийг дэмжих	
3.1	Урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээ, ур чадварыг тооцоолоход чиглэсэн хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах
3.2	Асаргааны ажилтны тоо, ур чадварыг нэмэгдүүлэх
3.3	Хүний нөөцөөр хангаж, тогтвортой ажиллуулах
Зорилго 4: Ил тод, хүн төвтэй чанарын удирдлагын системийг бүрдүүлэх	
4.1	Чанарын удирдлагын механизмыг бий болгох, хөгжүүлэх
4.2	Тусламж үйлчилгээний чанарын хяналтын системийг нэвтрүүлэх
4.3	Тусламж үйлчилгээний тогтолцоон дээр чанартай соёлын дадлыг бий болгох
Зорилго : Урт хугацааны тусламж үйлчилгээг өргөжүүлж, улс хоорондын хамтын ажиллагаа, үр дүнтэй засаглалыг бий болгож, хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжих	
5.1	Асаргаа үзүүлэх үр дүнтэй хамтын ажиллагааг дэмжиж, урамшуулах
5.2	Ахмад настнуудад зориулсан цогц, бүтээмжтэй нийгмийг бий болгоход ахмадуудын оролцоог нэмэгдүүлэх

Эх сурвалж: ХНХЯ-аас авсан баримт бичгийн төсөл дээр үндэслэн судалгааны баг гаргав.

5-3 Насжилтыг дэмжих тогтолцоо, үйлчилгээний өнөөгийн байдал ба шийдвэрлэх асуудал

5-3-1 Ахмад настныг дэмжих хууль эрх зүйн тогтолцоо, үйлчилгээний танигдсан байдал

Ахмад настныг дэмжих хууль эрх зүйн тогтолцоо, дэмжлэг үзүүлэх үйлчилгээ хэр танигдсаныг тодруулах зорилгоор "Ахмад настан болон түүний гэр бүл Засгийн газраас хэрэгжүүлж буй хууль эрх зүйн тогтолцоо, ахмад настныг дэмжих үйлчилгээний талаар хэр мэддэг вэ?" гэдэг асуултыг ахмад настныг дэмжиж ажилладаг төрийн болон төрийн бус 7 байгууллагаас 2021 оны 4 сарын 21-нээс 5 сарын 4-ний хооронд утсаар асуув.

Үр дүнг нь харахад ХНХЯ болон түүний харьяа байгууллагууд хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон интернет, брошюр, утас гэх мэт төрөл бүрийн мэдээллийн хэрэгслийг ашиглан ахмад настан, түүний гэр бүлийнхэнд хууль эрх зүйн тогтолцоо, үйлчилгээний талаар мэдээлэл хүргэдэг болох нь харагдаж байна. Үүний зэрэгцээ амьдрах орчин, боловсрол, өвчин, бэртэл гэмтэл гэх мэт шалтгаанаар тэдгээр шаардлагатай мэдээллийг олж авахад хэцүү орчин нөхцөлд байгаа хүмүүс ч байгаа нь тогтоогдов. Хүнээсээ хамаарч мэдлэг мэдээлэл ихээхэн ялгаатай байх магадлалтай тул мэдээлэл олж авах боломж бололцоо муутай хүмүүст анхаарал хандуулж ажиллах нь чухал.

Хүснэгт 5-17: Ахмад настан ба тэдний гэр бүлийн ахмад настанд дэмжлэг үзүүлэх хууль, эрхзүйн тогтолцоо, үйлчилгээний талаарх ойлголт

Хамрагдсан байгууллага	Ярилцсан хүн ба албан тушаал	Хариулт
ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн газар (population development policy and coordination)	Хүн амын хөгжлийн бодлого зохицуулалт хариуцсан ахлах шинжээч Ц. Мягмарсүрэн	Ахмад настан, тэдний гэр бүлийнхэн тэр бүр мэддэггүй байж болох ч төрийн захиргааны түвшинд хүүхэд, ХБИ, ахмад настны асуудал хариуцсан нэгжтэй, нийгмийн ажилтан ажилладаг. Нийгмийн ажилтнууд хариуцсан нутаг дэвсгэрийнхээ зорилтот бүлгийн иргэдэд үйлчлэхийн төлөө нягт хамтран ажилладаг. Хууль эрх зүйн мэдээлэл өгөх зорилгоор материал эмхэтгэл тараах тохиолдол ч байна. Хэвлэл мэдээлэл, интернет зэрэг нь зурагтын адил мэдээлэл түгээх өөр төрлийн арга юм.
Монголын ахмадын холбоо (Mongolian Association of Elderly People)	Ахмад мэргэжилтэн Цэцэгсүрэн Балдан	2020 онд ахмад настануудыг хамруулж, тэтгэвэрт бэлтгэх чиглэлээр мөн тэтгэвэрт гарсны дараа ажиллах боломж, хууль эрх зүйн мэдээлэл, нийгмийн халамжийн тэтгэмж зэрэг гурван чиглэлээр онлайн сургалтыг зохион байгууллаа. Мөн энэ жил, улирал тутамд фэйсбүүк-ээр шууд мэдээлэл дамжуулахаар төлөвлөж байна. 2021 оны 3-р сарын 22-нд үр дүнтэй төлөвлөлтийн талаар Facebook-ээр шууд мэдээлэл цацаж, 2000 гаруй ахмадууд оролцсон. Дүүрэг, аймгийн нийгмийн ажилтнууд тэдэнд хууль эрх зүйн мэдээллийг ойлгуулахад туслах томоохон үүрэг гүйцэтгэдэг.
Ахмад настны үндэсний төв (National Center for Elderly)	Хүний нөөц хариуцсан хуулийн мэргэжилтэн Г.Хүлэгчимэг	Ахмад настануудын боловсролын түвшин, сэтгэцийн байдлаас хамаарна. Миний туршлагаас харахад боловсролтой, эрүүл мэндийн асуудалгүй хүмүүс хууль эрх зүйн талаар сайн мэдээлэлтэй байх магадлалтай. Тэд төвд ирэхээсээ өмнө өөрсдийн бичиг баримтаа бэлддэг. Ахмад настануудын 15% нь хууль эрх зүйн мэдлэгтэй гэж би боддог. Эргэлзээтэй тохиолдолд хаанаас зөвлөгөө авахаа мэддэг.
Геронтологийн үндэсний төв (National Gerontology Center)	Чанар, хяналт үнэлгээ, дотоод аудитын албаны дарга Т.Дулмаа, Эрдэм шинжилгээ, сургалтын албаны дарга Ч. Тунгалаг	Монголд ахмад настануудад хууль эрх зүйн мэдээлэл авах олон арга байдаг. Сүүлийн үед онлайн уулзалт, семинар нь ахмад настануудын хууль эрх зүйн мэдээллийг олж авах эх сурвалж болж байна. Гэхдээ оффист ажиллаж байсан зэрэг, мэдээлэл ашиглаж чаддаг хүмүүс нь хязгаартай. Манайд тэтгэвэрт гарсан иргэдэд зориулсан Facebook групп байдаг. Телевиз, радио зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь ахмад настануудад хууль эрх зүйн мэдээлэл авахад нь тусалдаг. Мөн ахмад настанууд утсаар мэдээллээ хуваалцах тохиолдол ч байна.
Дорноговь аймгийн Ахмадын төрөлжсөн асрамжийн газар (Gobi region's nursing home in Dornogobi)	Төвийн дарга Д.Цэндмаа	Ахмад настанууд өөрсдийнхөө эрхийг хамгаалах халамжийн хуулийн талаар мэддэг боловч зарим хүмүүс бодит үйл ажиллагааны талаар мэдээлэл багатай байдаг. Тиймээс төрөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагааг таниулж мэдээлэх арга хэмжээг хорооны хэмжээнд зохион байгуулж байна. Ахмад настануудын авах боломжтой үйлчилгээний талаар сар бүр мэдээлэл өгдөг тул ахмад настануудын 90 орчим хувь нь мэдээлэлтэй байгаа гэж үзэж байна. 2016 оны 11-р сараас хойш бид сар бүр “222” арга хэмжээ зохион байгуулж байна. Энэ нь сар бүрийн хоёр дахь долоо хоногийн мягмар гарагийн 14:00 цагт иргэдийг цуглуулж, засгийн газраас үзүүлж буй халамжийн тухай хууль, үйлчилгээний талаар мэдээлэл өгдөг. Эдгээр арга хэмжээнүүдээс гадна сум болон багийн түвшинд самбарт мэдээлэл хадаж, мөн цаасаар мэдээлэл хүргэж байна.
“Бат-Гэрэлт ирээдүй” Дотоодын ТББ	Захирал Г.Роза	Сэтгэцийн өвчтэй, тархины цус харвалтай, биеийн байдал муу, хэвтрийн гэх мэт өндөр настай хүмүүс мэдээлэл олж авахад амаргүй ч бид тэдний төлөө ажиллаж байгаадаа урам авдаг. Тэд өөрсний асуудлаа хэрхэхээ мэдэхгүй, хууль эрхзүйн мэдлэг

		хязгаарлагдмал байдаг тул, ихэнхдээ хороо, дүүргийн нийгмийн ажилтнаас заавар зөвлөгөө авдаг.
“Тереза эх” Гадаадын ТББ	Менежер Б.Урантуул	Одоогийн байдлаар бичиг баримтгүй хоёр ахмад настан байна. Тэдний нэг нь хөдөөнөөс ирсэн бөгөөд өмнө нь саальчин байсан. Тэрээр хөлөө хугалж, гэр бүлийнхэн нь хотод ажилладаг байсан боловч очих газаргүй, гэмтлийн эмнэлэгт хэвтсэний дараа манай төвд ирсэн юм. Тэр таних хүн байхгүй. Бичиг баримтаа хэрхэн зохицуулахаа мэдэхгүй, иргэний үнэмлэхгүй. Үүний адил бичиг баримтгүй хүмүүсийг бид хүлээн авч байна. Тэд бичиг баримтаа хэрхэн яаж авахаа мэдэхгүй байгаа ч бид тэдэнд тусалж байна.

Эх сурвалж: Судалгааны багийн судалсанаар (2021 оны 5 сар)

5-3-2 Ахмад настны асрамжийн газрын байдал

2015 болон 2020 онуудын ахмад настны асрамжийн газрын орон тоо, асруулагчдын тоо, ажиллагсдын тоо, санхүүгийн эх үүсвэрийг дараах 5-18 хүснэгтэд харуулав. 2020 оны өгөгдөл нь 11 сарын 13-ны өдрийн тоон үзүүлэлт юм. Улаанбаатар хотын ойролцоо байрлах Төв аймгийн Ахмад настны үндэсний төв болон ТББ, хувийн хэвшлийн асрамжийн газруудын орон тоо, ажиллагчид, асруулагчдын тоо аль аль нь нэмэгдсэн тул 2015 оныг 2020 оныхтой харьцуулахад нийт тоо өссөн байна. Харин аймгийн асрамжийн газруудын хувьд орон тоо, асруулагчдын тоо, ажиллагчдын тоо буурсан болон бараг өөрчлөлтгүй, мөн бага зэрэг өссөн үзүүлэлттэй гарсан газрууд байв. Санхүүгийн эх үүсвэрээр нь харахад улсын болон аймгийн асрамжийн газрууд нь улсын эсвэл орон нутгийн төсвөөс санхүүжиж байна. ТББ-ын эрхэлдэг хоёр газар хэсэгчилсэн байдлаар улсын төсвөөс санхүүжилт авч байна. Нөгөөтэйгүүр христийн шашны үйл ажиллагаа явуулдаг олон улсын ТББ-д улсын болон орон нутгийн төсөв хуваарилагдаагүй байв.

Хүснэгт 5-18: Ахмад настны асрамжийн газрын орон тоо, үйлчлүүлэгчдийн тоо, ажилтын тоо ба санхүүгийн эх үүсвэр

Байгууллагын нэр		Хамаарах хүрээ	Орон тоо		Үйлчлүүлэгчийн тоо		Ажилтны тоо		Санхүүгийн эх үүсвэр
			2015	2020	2015	2020	2015	2020	
1	Ахмад настны үндэсний төв	Улсын асрамжийн байгууллага	130	200	116	157	48	113	Улсын төсөв
2	Ховд аймгийн асрамжийн газар	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны сэргээн заслын төв	30	22	30	22	15	13	Орон нутгийн төсөв
3	Баянхонгор аймгийн асрамжийн газар	Төвийн бүсийн ахмад настны асрамжийн газар	20	13	12	10	7	6	Орон нутгийн төсөв
4	Дорнод аймгийн асрамжийн төв	Зүүн бүсийн ахмад настны асрамжийн газар	20	24	20	22	7	8	Улсын төсөв
5	Баян-Өлгий аймгийн асрамжийн төв	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны сэргээн заслын төв	20	20	11	13	7	9	Орон нутгийн төсөв
6	Дорноговь аймгийн төрөлжсөн асрамжийн газар	Төвийн бүсийн ахмад настны асрамжийн газар	30	22	21	16	15	11	Улсын төсөв
7	Хөвсгөл аймгийн асрамжийн төв	Хангайн бүсийн ахмад настны асрамжийн газар	50	50	52	35	28	25	Орон нутгийн төсөв
8	Увс аймгийн асрамжийн төв	Баруун бүсийн ахмад настны асаргааны газар	25	25	20	14	11	13	Улсын төсөв
9	“Бат-Гэрэлт Ирээдүй” ТББ Улаанбаатар	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны хувийн асрамжийн газар	40	60	40	60	8	16	Нэг хэсэг нь улсын төсөв
10	“Ачлалт хүүхдүүд” ТББ Улаанбаатар	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны хувийн асрамжийн газар	20	38	26	49	6	12	Нэг хэсэг нь улсын төсөв
11	”Тереза эх” ахмадын асрамжийн төв, Яармаг, Улаанбаатар	Эрэгтэй ахмад настны асрамжийн газар	10	30	9	27	10	10	Олон улсын байгууллага
12	”Тереза эх” ахмадын асрамжийн төв, Дарь-Эх, Улаанбаатар	Эмэгтэй ахмад настны асрамжийн газар	10	30	4	20	8	8	Олон улсын байгууллага
Нийт			385	546	335	439	164	241	

Эх сурвалж: 2015 оны тоо баримтыг АХБ-с авав. (2020) Country diagnostic study on long-term care in Mongolia, 2020 оны тоо баримтыг ХНХЯ-ны протоколоос авав.

5-3-3 Ахмад настанд асрамжийн тусламж үйлчилгээ үзүүлдэг ТББ, хувийн хэвшлийн компаниудын байдал

Улаанбаатар хотод ахмад настанд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын 5 ТББ, хувийн хэвшлийн компаниудын дунд явуулсан судалгаагаар "Энгийн иргэд асрамжийн үйлчилгээний талаар мэдлэг, ойлголт дутмаг", "зөнөгрөх өвчин тусах ахмад настны тоо нэмэгдэж буйтай уялдан тусламж үйлчилгээний ачаалал нэмэгдэж байгаа", "тогтвор суурьшилтай ажиллах ажилтан олоход хэцүү", "барилга байгууламж, хөрөнгө мөнгөний боломж бололцоо хязгаарлагдмал", "шашны бүлгүүдийн талаар ойлголтгүй засаг дарга нар байдаг, "асрамжийн сургалт хийхэд асуудалтай байдаг" зэрэг асуудлууд байдаг нь тогтоогдов¹⁰⁹. Мөн коронагийн нөлөөнөөс үйл ажиллагаа нь зогссон, татан буугдсан байгууллага байна. 5-19 хүснэгтэд ахмад настныг дэмжих үйлчилгээ үзүүлдэг ТББ, хувийн компаниудыг нэгтгэн харуулав.

Хүснэгт 5-19: Ахмад настныг дэмжих үйлчилгээ үзүүлэх ТББ ба хувийн ААН-ийн товч танилцуулга

Хувийн байгууллагын нэр	Үндэслэл, үйл ажиллагаа, бэрхшээл
Ачлал Номуун ХХК (хувийн компани)	Үндэслэл: Байгууллагын эзэн нь ахмад настны асаргаа үйлчилгээ сонирхдог байсан ба Японд асаргааны чиглэлээр суралцаж, нэгдүгээр зэргийн асрагчаар бэлтгэгдсэн. Үйл ажиллагаа: Хувийн хэвшлийн компани бөгөөд гэрээр асаргааны үйлчилгээ (амин үзүүлэлт үзэх, хооллох, усанд орох, амны хөндий арчлах, живх солих гэх мэт) үзүүлдэг. Асаргааны 10 ажилтан ажилладаг. 4 цагийн үйлчилгээ 40,000 төгрөг, 8 цагийн үйлчилгээ 64,000 төгрөг. (Бэрхшээл) Олон нийтийн дунд асаргааны үйлчилгээний талаархи мэдлэг, ойлголт дутагдалтай байдаг. Төр, нийгмийн даатгалаас санхүүгийн дэмжлэг, байхгүй тул хөнгөлөлттэй зээл олгодог эсвэл санхүүгийн дэмжлэг үзүүлдэг бол сайн байна.
Инами Медикал Монгол (хувийн компани)	Үндэслэл: МУ-ын хувийн эмнэлэг, Японы компаний оролцоотой хамтарсан компани Үйл ажиллагаа: Японы асаргаа үйлчилгээний аргыг нэвтрүүлж, Япон сувилагч ажиллаж байна. Өдрийн үйлчилгээг 10:00-20:00 цагийн хооронд үзүүлдэг (2021 оны 3-р сарын 15-ны байдлаар COVID-19-ийн нөлөөгөөр түр хугацаагаар хаагдсан). Сарын төлбөр нь хоолны зардлыг оруулаад 200,000 төгрөг. Асаргааны ажилтан нь 1 менежер, бусад 8 ажилтан, нийт 9 хүн ажилладаг. Бэрхшээл: Сүүлийн үед Альцгеймер өвчтэй өндөр настнуудын тоо нэмэгдэж байгаа тул асаргааны ачаалал их байна. Хүмүүсийн сэтгэлзүйн асуудал байна, учир нь монголчууд ахмад настнуудаа өөрсдөө асарч халамжилдаг уламжлалтай боловч, орчин үеийн нийгэмд хөдөлмөрлөж мөнгө олох шаардлагатай болдог тул энэ хоёр зөрчилдөж байна.
“Ачлалт хүүхдүүд” асрамжийн газар (Дотоодын ТББ)	Үндэслэл: Нэг гэр бүлийн эхнэр нөхрийн ажиллуулдаг хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчдэд зориулсан асрамжийн газар бөгөөд эхнэр нь эмч, нөхөр нь захирлын ажилтай. Үйл ажиллагаа: 47 үйлчлүүлэгтэй бөгөөд (хөгжлийн бэрхшээлтэй, хэвтэрт байгаа өндөр настай хүмүүс, тэдний 70% нь оюун, сэтгэцийн бэрхшээлтэй. Хамгийн залуу нь 19 настай, хамгийн ахмад нь 93 настай, гадаадад үр хүүхэд нь амьдардаг ахмад настан 4 байна) 12 ажилтантай.

¹⁰⁹ Монгол зөвлөхөөр хийлгэсэн цахим мэдээ мэдээллийн судалгаа болон утсаар хийсэн ярилцлагын үр дүн. Утасны судалгааг 2021 оны 3 сарын 15, 16-ны өдрүүдэд хийсэн. Мөн судалгааны ажлын хүрээнд 2021 оны 4 сарын 1-ний өдөр орон нутгийн зөвлөх “Ачлалт Хүүхдүүд” ТББ-аар очиж ярилцлага хийж, барилга байгууламжтай нь танилцсан.

	Бэрхшээл: COVID-19-ийн нөлөөнөөс болж мэс заслын дараах тусламж үйлчилгээ авах боломжгүй болж байна. Ажилтнуудыг тогтвортой ажиллуулахад хүндрэлтэй.
“Тереза эх” ахмад настны асрамжийн газар (Дотоодын ТББ) (1) Дарь-Эх төв (2) Яармаг төв	Үндэслэл: 11 жилийн өмнө христийн номлогчдын байгуулсан ахмадын асрамжийн газар. Үйл ажиллагаа: Улсын болон аймгуудын ахмад настны асрамжийн газрууд хүлээн авах боломжгүй ахмад настнуудыг хүлээн авдаг. Тэтгэврийн зээлтэй, бичиг баримтгүй, орон гэргүй зэрэг ядуу хүн, үр хүүхэдтэй ч тэд нь байнгын ажилтай зэрэг. Энэрэл эмнэлэгтэй нягт холбоотой ажилладаг. Дарь-Эх дахь төвд зөвхөн эмэгтэйчүүдэд байрладаг, 24 үйлчлүүлэгчтэй. Яармаг дахь төвд зөвхөн эрэгтэйчүүд байрлана, 49 үйлчлүүлэгчтэй. Энэ хоёр төв дээр 1 эмч, 2 нийгмийн ажилтан, найман асрагч гээд нийт 32 хүнтэй. Бэрхшээл: Засаг дарга нь шашны байгууллагуудын талаар ойлголтгүй. Асрамжийн дадлага сургуулилт асуудалтай.
“Бат-Гэрэлт ирээдүй” (Дотоодын ТББ)	Үндэслэл: 2009 онд байгуулагдсан. Эзэн нь Христийн шашин шүтэгч бөгөөд хувийн бизнес эрхэлдэг. Бусдад буян үйлдэх зорилгоор ахмад настны асрамжийн төвийг ажиллуулж байгаа. Үйл ажиллагаа: Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийлсэн 58 үйлчлүүлэгчтэй (43 эрэгтэй, 15 эмэгтэй). Зарим үйлчлүүлэгчид сэтгэцийн асуудалтай, цус харвасан, хараа, сонсголын бэрхшээлтэй, гэмтлийн улмаас яс, үе мөчний асуудалтай хүмүүс байдаг. 25 ажилтантай (1 захирал, 1 менежер, 1 нийгмийн ажилтан, 1 дадлагажуулагч, 2 гэрээт эмч, 3 гэрээт сувилагч, 1 гэрээт нягтлан, 1 нягтлан бодогчийн туслах, 1 хуульч, 9 асрамжийн ажилтан), тогооч 1 хүн, жолооч 1 хүн, бичиг хэргийн ажилтан 1 хүн) Хандив, төвийн эзний бизнесийн орлогын нэг хэсгээр санхүүгийн эх үүсвэрээ бүрдүүлдэг боловч хоол хүнсний зардлын 50%, хувцасны төсөв дээр ХНХЯ-ээс дэмжлэг үзүүлдэг. (Бэрхшээл) Байр, санхүүгийн бэрхшээл

Эх сурвалж: Судалгааны багийн судалсанаар (2021 оны 4 сар)

5-3-4 Насжилтыг дэмжих үйл ажиллагаа явуулдаг байгууллага, мэргэжилтнүүдийн дунд явуулсан судалгааны үр дүн

① Геронтологийн үндэсний төв

Геронтологийн үндэсний төвд хийсэн судалгаагаар тодорхойлсон үндсэн хэрэгцээг 5-20 хүснэгтэд нэгтгэн харуулав. Мөн тус төвийн хариуцсан мэргэжилтэн насжилтын бодлогын талаар "хууль эрх зүйн орчин бүрдсэн боловч улам сайжруулах шаардлагатай", "ХНХЯ, ЭМЯ аль аль нь өндөр настны асрамжийн газар, эмнэлэг, эрүүл мэндийн төв гэх мэт байгууллагуудтай. Аль нэг яам дагнаж хариуцсан нь дээр" гэж санал бодлоо хэлж байв¹¹⁰. Ахмад настны асрамж нь хоёр яаманд хамаарсан асуудал тул яамд газрын бодлого чиглэл өөр тохиолдолд зохицуулах, шийдэх тал дээр цаг хугацаа орж мэдэх тул зохицуулалтын ажлыг саадгүй хийхэд анхаарах нь цаашдын шийдвэрлэх гол асуудлын нэг юм.

¹¹⁰ 2021 оны 2 сарын 8-нд очиж уулзаж ярилцлага авсан. Төвийн захирал болон дэд захирал, стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга, сургалтын төвийн захирал гэсэн 4 хүнээс ярилцлага авав.

Хүснэгт 5-20: Геронтологийн үндэсний төвд хийсэн судалгаагаар тодорхой болсон хэрэгцээ шаардлага

Гол хэрэгцээ	Одоо тулгарч буй бэрхшээл ба хэрэгцээний жишээ
Зохистой асаргаа сувилгааны тогтолцоо, мэргэжлийн хүний нөөц болон сургалтын тогтолцооны хэрэгцээ шаардлага	- Ахмад настанд тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн эмч байхгүй. - Ахмад настны асаргаа сувилгааны талаар төрөөс сургалт явуулдаггүй. - Стандартын бус асаргаа сувилгаатай газрууд байдаг. - Эмч сувилагч нарт зориулсан ахмад настны асаргааны сургалтын хөтөлбөр байдаггүй. - Ахмад настанд зориулсан асаргааны нэгдсэн тогтолцоо, модуль, сургалт, удирдамж, сурах бичиг, гарын авлага байдаггүй.
Ахмад настантай холбоотой судалгаа, судалгааны ажлын хэрэгцээ шаардлага	- Эмийн зохистой хэрэглээний аргыг боловсруулж гаргах ажил хангалтгүй. - Асаргаа болон сэтгэцийн байдлын суурь судалгаа (суурь мэдээлэл цуглуулах) хангалтгүй.
Асрамжийн газар дутагдалтай	- Монгол улсын 4 бүсэд ахмад настны асрамжийн төв байгуулах шаардлагатай. - Яармагт баригдаж байгаа Геронтологийн төвийн барилгыг барьж дуусгах шаардлагатай.

② Монголын ахмадын холбоо

Монголын ахмадын холбоо нь Засгийн газрын дэргэдэх ахмад настны эрхийг хамгаалдаг 90 орчим жилийн хөгжлийн түүхтэй байгууллага юм. 2016 онд МУ-ын Засгийн газар ахмад настны эрхийг хамгаалах бие даасан байгууллагатай болох шийдвэр гаргасан. Одоогийн байдлаар МУ-ын ахмадын холбоо нь ХНХЯ-тай гэрээ байгуулан ажиллаж байна. 2017 онд Ахмад настны тухай хууль батлагдсан бөгөөд Монголын ахмадын холбооноос уг хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Төсвийг ХНХЯ-аас хуваарилдаг бөгөөд жилийн төсөв нь 148 сая төгрөг байдаг. Уулзалт ярилцлагаар тодорхойлсон үндсэн хэрэгцээг 5-21 хүснэгтэд харуулав¹¹¹.

Хүснэгт 5-21: Монголын ахмадын холбоонд хийсэн судалгаагаар тодорхой болсон үндсэн хэрэгцээ

Үндсэн хэрэгцээ	Тулгарч буй асуудал ба хэрэгцээ шаардлагын жишээ
Өдрийн үйлчилгээний тоог нэмэгдүүлж, чанарыг сайжруулах	- Хэд хэдэн төв байгуулагдсан хэдий ч үйл ажиллагаа, хяналтын стандарт хангалтгүй. - Мэргэжлийн асаргаа сувилгааны ажилтан ажиллуулах шаардлагатай. - Ахмад настууд хүчирхийлэлд өртөж байгаа нь асуудал болж байна.
Хүчирхийллийн талаар судалгаа хийж, арга хэмжээ авах шаардлагатай	- Өндөр настанд үзүүлж буй хүчирхийлэл нь нуугдмал байдаг ба бодит байдлыг ил болгох шаардлагатай. - Хүчирхийллээс урьдчилан сэргийлж, хүчирхийлэл үйлдэгчээс тусгаарлах шаардлага

¹¹¹ 2021 оны 2 сарын 9-ний өдөр Улаанбаатар дахь МУ-ын Ахмадын Холбоотой танилцаж, ахлах мэргэжилтэнтэй ярилцсан.

Мөн уг судалгааны багийн 2021 оны 4 сард Монголын ахмадын холбооноос олж авсан мэдээллээр 2020 оны эцсийн байдлаар ахмадын холбооны харьяа 456 ахмадын байгууллага, ахмад настны хөгжлийн төвтэй 6 аймаг байна. Дараах хүснэгтэд аймаг бүрт хэчнээн ахмадын байгууллага, ямар барилга байгууламжид байрладгийг харуулав. Ахмад настны хөгжлийн төвтэй аймгийг дугуйгаар тэмдэглэв.

Хүснэгт 5-22: Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ахмад настны байгууллагын тоо ба байрны нөхцөл байдал

Аймаг	Ахмад настны хөгжлийн төв	Ахмад настны байгууллага байрладаг байрны төрөл зохион байгуулалт						Нийт
		Заал, өрөө	Төв	Заал	Өрөө	2-3 өрөө	Нэгдсэн төв	
1	Архангай	○	14			5	1	20
2	Баян-Өлгий	○			1	7	1	10
3	Баянхонгор		2		1	13	1	17
4	Булган		7		10	3		20
5	Говь-Алтай		8		6		3	18
6	Говь-Сүмбэр		1			4		5
7	Дархан-Уул		1			24	1	26
8	Дорноговь		7		9		1	17
9	Дорнод		10	3	8		1	22
10	Дундговь		4		3	2		9
11	Завхан		2		1	11	1	15
12	Орхон		2			9	1	12
13	Өвөрхангай		9	2	4	1	2	19
14	Өмнөговь		15	1	1	1	1	19
15	Сүхбаатар		11				1	12
16	Сэлэнгэ		11			11		22
17	Төв		5		22		1	28
18	Увс		2				14	17
19	Ховд		5	1	9	1	1	17
20	Хөвсгөл			24			1	25
21	Хэнтий		9	8	1		2	21
22	Баянгол дүүрэг	○					1	1
23	Сүхбаатар дүүрэг	○					1	1
24	Багануур дүүрэг	○					1	1
25	Багахангай дүүрэг	○					1	1
26	Нийслэл		18	4	1	20	38	81
	Нийт		143	43	77	112	61	456

Эх сурвалж: Ахмадын холбооноос авсан мэдээлэлд үндэслэж, судалгааны баг гаргав.

- ③ Ахмад настанд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ үзүүлдэг нийгмийн ажилтан, халамжийн асуудал хариуцсан ажилтны ажилд тулгарч буй асуудал

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст ажилладаг нийгмийн ажилтан, халамж хариуцсан ажилтны ахмад настанд дэмжлэг үзүүлэх ажлын талаар тоймлон авч үзье. Хөдөлмөр халамжийн

үйлчилгээний хэлтэс нь ахмад настанд зөвлөгөө өгөх тохиолдолд, гэр бүл, үр хүүхэд байхгүй тохиолдолд, ахмад настан өөрөө эсвэл, хамаатан садан нь ирэх тохиолдол байна. Ахмад настныг хүчирхийлсэн асуудал гарсан бол, нөхцөл байдлаас шалтгаалан хариуцах газар нь өөр байна. Насанд хүрсэн иргэдийн хувьд (ахмад настан, эмэгтэйчүүд) цагдаагийн газар болон гэр бүл залуучуудын хөгжлийн газарт мэдэгддэг. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс дээр хүчирхийлэлд өртсөн хүн шууд ирвэл холбогдох газар хэлтэс рүү явуулдаг байна¹¹².

Ахмад настны хүчирхийллийн хэргийн хувьд хамт амьдардаг үр хүүхэд нь архинд донтож, эцэг эх, ахмад настныг хүчирхийлэх тохиолдол гардаг. Судалгааны багт ярилцлага өгсөн нийгмийн ажилтны яриагаар "Асрамжийн газарт оруулах талаар судалдаг ч асрамжийн газарт орохыг хүсч буй өндөр настан хүүхэдтэй бол асрамжийн газарт орохыг хуулиар хориглосон байдаг. Ганцаараа амьдардаг өндөр настан орох боломжтой ч хүүхдүүдтэйгээ хамт амьдардаг бол ороход хэцүү болдог. Улсын өндөр настны асрамжийн газар хотын зайдуу нэг байдаг. Ахмад настны нөхцөл байдлыг судалж үзээд асрамжид хамрагдах шаардлагатай бол авдаг байна¹¹³.

Үүнээс гадна ахмад настныг яаралтай хамгаалалтад авахад тулгамдаж буй асуудал бий. Тухайлбал, хүчирхийлэлд өртсөн өндөр настныг хамгаалалтанд авдаг ч 2, 3 хоногийн дараа гэртээ харих ёстой болдог. Удаан хугацаагаар хамгаалалтанд байж чаддаггүй тул хүчирхийллийг үндсээр нь шийдвэрлэж чадахгүй байна¹¹⁴.

Нийгмийн халамжийн тухай хуульд зааснаар хамаатан садангүй ганцаараа амьдардаг, хүүхэдтэй хэдий ч хүүхэд нь мөн өндөр настай, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй, хүүхэдтэй хэдий ч хүүхэддээ хүчирхийлүүлж буй өндөр настан тус асрамжийн газарт орох боломжтой. Сүүлийн жилүүдэд Монголд өндөр настныг хүчирхийлсэн хэргүүд их гарч байна. Түр хамгаалалтын байранд байрласны дараа асрамжийн газар руу шилжих үед бичиг баримт бүрдүүлэх нь амаргүй, асрамжийн газрын багтаамж хүрэлцээгүй зэрэг хүндрэлтэй асуудал байдаг.

Хүснэгт 5-23: Нийгмийн ажилтан, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаар тодорхойлж гаргасан хэрэгцээ

Гол хэрэгцээ	Одоо тулгарч буй асуудал ба хэрэгцээний жишээ
Архинд донтох өвчин ба хүчирхийлэлтэй холбоотой судалгаа	• Архинд донтсоны улмаас ахмад настанд хүчирхийлэл үзүүлэх асуудал байдаг учраас бодит байдлыг судлах шаардлагатай.
Асрамжийн газарт ороход бүрдүүлэх материалыг хялбар болгох	• Гэр бүлийн гишүүдээс ирдэг хүчирхийлэл, дарамтаас хамгаалахын тулд, түр хамгаалах газар төдийгүй, тавигдах шаардлага нь хялбар, удаан хугацаанд байрлаж амьдрах боломжтой газар шаардлагатай.

¹¹² Чингэлтэй дүүргийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст ажилладаг халамж хариуцсан ажилтантай хийсэн онлайн ярилцлага (2021 оны 3 сарын 9-ний өдөр явуулсан).

¹¹³ Сонгинохайрхан дүүргийн хороонд ажилладаг нийгмийн ажилтантай хийсэн онлайн ярилцлага (2021 оны 3 сарын 11).

¹¹⁴ Хамгаалах байрнаас асрамжийн газар руу шилжихэд цаг хугацаа ордог. Тухайлбал, эрүүл мэндийн үзлэгт хамрагдах, хорооноос зөвшөөрөл авах, зөвшөөрөл авсны дараа дээд шатны байгууллагын зөвшөөрөл мөн авах шаардлагатай. Түүнчлэн нийслэл хотын ойролцоо улсын нэг асрамжийн газар байдаг боловч, тийшээ дагуулж очлоо ч хүн олон гээд хүлээж авахгүй байх тохиолдол бий.

④ МУ-ын Ахмад настны үндэсний төв

Тус судалгаагаар Монгол дахь цорын ганц улсын ахмадын асрамжийн газар болох "Ахмад настны үндэсний төв" (National Center for the Elderly)-ийн талаар мэдээлэл цуглууллаа¹¹⁵. Уг асрамжийн газарт "ЖАЙКА-гийн Коосэн загварын боловсролын талаарх мэдээлэл цуглуулах, баталгаажуулах судалгаа"-ны баг 2016 оны 12 сарын 12-нд (энэ айлчлалаас 4 жил 3 сарын өмнө) очиж танилцан, тус төвийн удирдлагуудтай ярилцжээ.

2016 оны судалгаагаар харьцуулах боломжтой зүйл хязгаарлагдмал байгаа ч нөхцөл байдлын харьцуулалтыг 5-24 хүснэгтэд харуулав. Орны тоонд өөрчлөлт ороогүй ч, асрамжийн газар амьдардаг ахмадуудын тоо 126-аас 154 болж, 28-аар өсчээ (Үүнээс байнгын асрамж шаардлагатай хүмүүсийн тоо 35-аас 63 болж, 28-аар нэмэгджээ). Ажиллагчдын тоо 103-аас 119 болж 16-аар нэмэгдсэн байв. Эрүүл мэнд, халамжийн чиглэлийн мэргэжилтэй ажилтны тоо 8-аас 14 болж, 6-аар нэмэгджээ. Гадаад хамтын ажиллагааны хувьд 2014 он хүртэл БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг (цаашид "КОЙКА" гэх)-ын сайн дурын ажилтнуудыг хүлээж авдаг байв. 2016 оноос хойш техникийн хамтын ажиллагааны гэрээтэй ажиллаж байгаа Хоккайдо мужийн Китами хотод байрладаг М-Линк Холдингс ХК-тай холбоотой ажиллаж байна.

Хүснэгт 5-24: Ахмад настны үндэсний төвийн 2016 ны 12 сар ба
2021 оны 3 сарын байдлыг харьцуулсан нь

	2016 оны 12 сарын 12-ны өдөр	2021 оны 3 сарын 10-ны өдөр
Орны тоо	200 ор	200 ор
Ажилтны тоо	103 хүн	119 хүн
Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ/халамжийн мэргэжлийн боловсон хүчний тоо	Эмч:2 Бага эмч:2 Сувилагч:2 Сэтгэлзүйч:1 Нийгмийн ажилтан:1	Эмч:5 (үүнээс гэрээт ажилтан 1) Сувилагч:4 (үүнээс гэрээт ажилтан 1) Сэтгэлзүйч:1 Нийгмийн ажилтан:1 Эрүүл мэндийн нийгмийн ажилтан:1 Соёлын ажилтан:1 Эм зүйч:1
Үйлчлүүлэгчдийн тоо (хүйсээр) Байнгын асаргаатай хүний тоо	126 (Эмэгтэй 52, эрэгтэй 74) Асаргаа шаардлагатай хүний тоо:35	154 (Эмэгтэй 62, Эрэгтэй 92) Асаргаа шаардлагатай хүний тоо: 63
Гадаад харилцаа	2004 оноос 2014 он хүртэл КОИСА-ийн сайн дурын ажилтныг ажиллуулж байсан. 2016 оноос М линк Холдингс ХК-тай техникийн хамтын ажиллагаа эхлүүлсэн.	2016 оноос өнөөг хүртэл М Линк Холдингс ХК-тай техникийн хамтын ажиллагаатай ажиллаж байна.

Эх сурвалж: 2016 оны мэдээлэл нь JICA (2017) Монгол улсын Коосэн загварын инженер, технологийн дээд боловсролын тухай судалгаа/судалгааны тайлангаас ашиглав. 2021 оны мэдээлэл нь судалгааны баг судалсанаар (2021 оны 3 сар)

Тус төв болон ЖАЙКА-гийн хамтын ажиллагааг авч үзвэл М-Линк Холдингс ХК-ны Works fair ашгийн бус байгууллага ЖАЙКА-гийн өвсний үндэс техникийн хамтын ажиллагааны хүрээнд

¹¹⁵ Санал асуулгын хуудсыг бэлтгэсний дараа тус улсын зөвлөхтэй урьдчилан тохирч, 2021 оны 3 сарын 14-ний өдөр очиж судалгаа хийсэн.

"Сувилахуйн хүний нөөцийг хөгжүүлэх төсөл"-ийг 2017 оны 7 сараас 2019 оны 5 сар хүртэл нэг жил 10 сарын хугацаанд хэрэгжүүлсэн. Түүний дараа М-Линк Холдингс ХК нь ЖАЙКА болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааны суурь судалгаагаар "Япон маягийн олон нийтийн оролцоонд түшиглэсэн асрамжийн тусламж үйлчилгээний цогц системийг нэвтрүүлэхэд чиглэсэн суурь судалгаа"-г хэрэгжүүлж байна. Уг компанийн зүгээс тус төвд тараасан "Сувилахуйн тусламжийн гарын авлага (2019 оны 3 сар)"-ыг энэхүү судалгаагаар олж авсан. Уг гарын авлагад асаргааны ажилтнуудын хандлага, ёс зүй, насжилт болон зөнөгрөх өвчний талаарх үндсэн мэдлэг, асаргааны үндсэн техник чадвар, яаралтай тусламжийн үед авах арга хэмжээ гэх мэт асрагч хүний наад захын мэдвэл зохих зүйлсийн талаар тусгасан байлаа. Агуулгыг хүснэгт 5-25-д тусгав.

Хүснэгт 5-25: Асаргааны гарын авлагын агуулга

I	Асаргааны суурь мэдлэг		1	Хооллох
	1	Асаргааны цөм	2	Бие засуулах
	2	Хүний эрхийг хамгаалахын тулд	3	Холголтоос сэргийлэх
	3	Эрх тэгш байдлыг хангах	VI	Зөнөгрөл
	4	Бие дааж амьдрахад үзүүлэх дэмжлэг	1	Зөнөгрөл гэж юу вэ?
	5	Тэгш хуваарилалт	2	Төрөл, урьтал шинж, шинж тэмдэг
	6	Хүсэл шаардлагыг шийдвэрлэх ба шийдвэр гаргах	3	Хөгшрөлтийн шалтгаантай ой санамж алдагдалт болон зөнөгрөлийн ялгаа
II	Амьдралын орчин		4	Оношлох арга
	1	Амьдрах орчинг бэлтгэх	5	Зөнөгрөлтэй хүнтэй харьцах арга
	2	Хувийн орон зайгаар хангах	VII	Яаралтай үед авах арга хэмжээ
III	Хөгшрөлтийг ойлгох		1	Ухаан алдах/ амьсгал зогсох үед авах арга хэмжээ
	1	Бие махбодийн өөрчлөлт	2	CPR
	2	Физиологийн өөрчлөлт	3	Цээж шахалт
	3	Сэтгэл санааны өөрчлөлт	VIII	Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ
	4	Мэдрэхүйн өөрчлөлт	1	Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ гэж юу вэ?
IV	Хөгжлийн бэрхшээлийн талаар ойлгох		2	Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ үзүүлэх дараалал ба нөхцөл
	1	Хөдөлгөөний бэрхшээл	3	Судалж үзэх шаардлагатай зүйлс
	2	Оюун, сэтгэцийн бэрхшээл	4	Дүгнэлт
	3	Сэтгэлзүйн бэрхшээл	IX	Бусад зүйлс
V	Асаргааны ур чадвар		1	Тэмдэглэл хөтлөхийн ач холбогдол
	1	Усанд оруулах	2	Дасгалын ач холбогдол

Эх сурвалж: Ахмад настны үндэсний төвөөс авсан материалд үндэслэж судалгааны баг гаргав.

⑤ Асаргааны гарын авлага тараагдсан байдал

2017 оны 7 сараас 2019 оны 5 сар хүртэл Японы ашгийн бус байгууллага "Works fair" ТББ-аас хэрэгжүүлсэн ЖАЙКА-гийн өвсний үндэс техникийн хамтын ажиллагааны "МУ-ын сувилахуйн хүний нөөцийг хөгжүүлэх төсөл"-өөр Ахмад настны үндэсний төвд асаргааны сургалт зохион байгуулж, асаргааны гарын авлага мөн тараажээ. Ахмад настны үндэсний төвд тус гарын авлагыг хаана тараасан нь тодорхойгүй байгаа ч асрамжийн газрын ажилтнуудад зориулж хадгалан,

шаардлагатай үед тус гарын авлагаас үзэж судалдаг байна¹¹⁶. Тиймээс асаргааны гарын авлага тараагдсан байдлыг тогтоохын тулд ахмад настанд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг 6 байгууллагаас "асаргааны гарын авлага хэрхэн олж авсан" талаар тодрууллаа¹¹⁷.

Үр дүнг танилцуулахад Ахмад настны үндэсний төвийг оролцуулаад 3 газар (үүнээс нэг газар нь бусад хоёрт байгаатай ижил гарын авлагатай эсэх нь тодорхойгүй) Японы дэмжлэг оролцоо бүхий асаргааны гарын авлага авсан байв. Геронтологийн үндэсний төв сургалтандаа өөрсдийн орчуулсан удирдамжийг ашигладаг бол Дорноговь аймгийн асрамжийн газар КОЙКА-аас 2017 онд гаргасан ахмад настнуудад зориулсан номтой байв. Монголыг ахмадын холбоо хаанаас ч асаргааны гарын авлага авч байгаагүй гэж байлаа. Улсаас асаргааны гарын авлага боловсруулж батлан улсын болон бусад асрамжийн газар, хувийн компани, ТББ-д тарааж, ашиглуулах шаардлагатай.

Хүснэгт 5-26: Ахмад настны асрамжийн газруудад гарын авлага тараагдсан байдал

Байгууллагын нэр	Ярилцсан албан тушаалтан	Хариулт
Ахмад настны үндэсний төв (National Center for Elderly)	Хүлэгчимэг Хүний нөөц хариуцсан хуулийн мэргэжилтэн	- М Линк Холдингс-аас гаргасан асаргааны гарын авлага байгаа ба ЛСА болон ХНХЯ-аас хүлээн авсан. - Ихэнх асаргааны ажилтнууд өдөр тутамд гарын авлагыг уншиж судлангаа асаргаа хийдэг байсан. Эхэндээ байнга хэрэглэдэг байсан бол одоо ашигладаггүй.
Монголын ахмадын холбоо (Mongolian Association of Elderly)	Цэцэгсүрэн, Балдан ахлах мэргэжилтэн	- Гарын авлага ашиглахгүй байгаа ч Геронтологийн үндэсний төвтэй хамтарч, асаргааны чиглэлийн сургалтан дээр хамтарч ажилладаг. 2018, 2019 онд ДЭМБ-аас зохион байгуулсан урт хугацааны асаргааны сургалтад хамрагдаж байсан. Өөр сургалтад оролцоогүй, гарын авлага олж аваагүй.
Геронтологийн үндэсний төв (National Gerontology Center)	Дулмаа, Тунгалаг Сургалт, эрдэм шинжилгээ хариуцсан, настан судлалын эмч	- ДЭМБ-ын "Ахмад настны асаргаа үйлчилгээний нэгдсэн удирдамж" (ICORE) -ийг орчуулж, 900 хувь хэвлүүлж, 21 аймаг, 9 дүүргийн эрүүл мэндийн байгууллагад 2021 оны 1-р сард хуваарилж өгсөн. - Мөн Япон, Өмнөд Солонгосын ном байгаа бөгөөд ахмад настны асаргаа үйлчилгээтэй холбоотой эмч сувилагчдад зориулсан сургалт, лекцэнд ашиглаж байна. Тус төв нь эмч, сувилагч, сайн дурын ажилтан, өндөр настнуудад анхаарал халамж тавьдаг гэр бүл зэрэг бусад хүмүүсийг сургадаг. Төв нь эмч, сувилагч, сайн дурын ажилтан, ахмад настнаа асардаг гэр бүл болон бусад хүмүүст зориулж дадлага сургалт явуулж байна.
Дорноговь аймаг дахь Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газар	Захирал Цэндмаа	- Өмнө нь КОЙКА-ийн хамтын ажиллагааны хүрээнд асрамжийн газрын хүний нөөцийг бэлтгэх сургууль, боловсролын байгууллагуудад сургалтын материал болгон тарааж байсан. Тэр бол хэвлэмэл ном байсан (энэ номонд тоглоомууд, янз бүрийн будах зураг, юм нэхэх арга, хөзөр тоглох арга, гар урлал хийх арга зэрэг багтсан бөгөөд 2017 онд КОЙКА хэвлүүлж байсан). - Ахмад настны үндэсний төвөөс бидэнд асаргааны гарын авлага

¹¹⁶ Тухайн үед тараагдсан асаргааны тусламж үйлчилгээний гарын авлага Ахмадын үндэсний төвөөс өөр газар хэр өргөн тараагдаж хэрэглэгдэж буй талаар монгол зөвлөх утсаар лавлагаа авсан.

¹¹⁷ Тус улсын зөвлөх 4 сарын 21-нээс 5 сарын 4-ний хооронд утсаар судалгаа авсан.

(Gobi region's nursing home in Dornogobi)		зэрэг материал хүлээж аваагүй.
“Бат-Гэрэлт Ирээдүй” Дотоодын ТББ	Төвийн захирал Роза	• Өмнө нь асрамжийн чиглэлээр сургалтанд хамрагдах үедээ Mlink Holdings-ийн гаргасан гарын авлагыг хүлээж авсан.
“Тереза эх” Гадаадын ТББ	Урантуул Менежер	• 2019 оны орчимд Япон мэргэжилтэн асаргааны чиглэлээр сургалт явуулж, асаргааны гарын авлага тарааж байсан. Сургалтанд асрамжийн газраас хүмүүс оролцсон. Асрамжийн газрын ажилтан, төрийн байгууллагын ажилтнууд нийлээд 50 гаруй хүн оролцсон. Би тэр үед авсан гарын авлагыг үе үе ашигладаг.

Эх сурвалж: Судалгааны баг судалсанаар (2021 оны 5 сар)

Ахмад настны үндэсний төвд хийсэн судалгаагаар тодорхойлсон гол хэрэгцээг дараах 5-27 хүснэгтэд нэгтгэж харуулав.

Хүснэгт 5-27: Ахмад настны үндэсний төвд хийсэн судалгаагаар тодорхой болсон хэрэгцээ шаардлага

Үндсэн хэрэгцээ	Одоо тулгарч буй асуудал ба хэрэгцээ шаардлагын жишээ
Үйлчлүүлэгчид цаг агаараас шалтгаалахгүй дасгал хөдөлгөөн хийх орчныг бүрдүүлэх	• Үйлчлүүлэгчид 10 сараас 5 сар хүртэл цаг агаар таагүй улиралд гадаа гарч чадахгүй, биеэ ч хангалттай хөдөлгөж чаддаггүй. • Дасгал хийх өрөө байдаг ч спорт танхимын адил жишиг тоног төхөөрөмжтэй байх шаардлагатай байна. • Ажилтнууд дотор ахуй засалч, хөдөлгөөн засалч байдаггүй.
Төвд байрлах шаардлагатай ахмад настуудад арга хэмжээ авах	• Тэтгэврийн зээлтэй иргэдийг хүлээн авах боломжгүй. • Бичиг баримт нь бүрдээгүй иргэнийг хүлээн авах боломжгүй. • Гэр бүл нь байгаа ахмад настанг хүлээн авах боломжгүй.
ЭМЯ-тай хамтарч ажиллах	• Төвд хэвтрийн болон хөнгөн, дунд зэргийн сэтгэцийн өвчтэй, эрүүл мэндийн байдал сайнгүй ахмадууд олон байдаг. Гэсэн хэдий ч ЭМЯ-тай бараг хамтарч ажилладаггүй.
Шинээр ажилд орж байгаа ажилтанд зориулсан асаргааны сургалт, сургалтын хөтөлбөртэй болох	• Төвд ахлах сургууль төгссөн хүнийг авч ажиллуулдаг бөгөөд асаргааны талаар албан ёсны сургалт явагддаггүй, сургалтын хөтөлбөр байдаггүй.
Асаргааны мэргэжлийн сургуулийн боловсрол болон магадлан итгэмжлэх тогтолцоо шаардлагатай	• Монголд асаргааны ажилтан бэлтгэх албан ёсны дээд сургуулийн анги болон сургалтын төв байдаггүй.

⑥ ХНХЯ-ны ахмад настны асуудал хариуцсан мэргэжилтэн

ХНХЯ-ны нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахмад настанд зориулсан үйлчилгээ хариуцсан мэргэжилтэний яриагаар тус яам нь "ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих", "нийгмийн оролцоог өргөжүүлэх", "асаргааны даатгал" дээр илүү анхааран ажиллаж байна. ХНХЯ нь 2019 оны 11 сараас АХБ-ны нэмэлт төсвийг ашиглан асрамжийн газрын чадавхийг бэхжүүлэхийн тулд хүний нөөцийн сургалт зохион байгуулж байна. Сургалтын

материалд 7 модулийг 41 цаг 30 минут зарцуулан заахаар тусгасан хэдий ч бодит сургалт нь багшийн зав зайгаас шалтгаалан хугацаа нь богиносож, нийт 16 цагийн 2 өдрийн сургалт явагджээ. Сургалтын тоймыг 5-28 хүснэгтэд харуулав¹¹⁸.

Хүснэгт 5-28: 2019 оны 11 сард зохион байгуулагдсан асрамжийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх сургалтын товч танилцуулга

Ивээн тэтгэгч	Азийн хөгжлийн банк сургалтын модулийг боловсруулж, Дэлхийн банк сургалтын зардлыг хариуцаж зохион байгуулсан.
Сургалтад хамрагдагсад	60 гаруй хүн оролцсон (Дараах байгууллагуудаас 2-3 хүн оролцсон) - Ахмад настны үндэсний төв болон Увс, Ховд, Баян-Өлгий, Баянхонгор, Хөвсгөл, Дорнод, Дорноговь аймгийн асрамжийн газар - ТББ болох “Бат-Гэрэлт ирээдүй”, “Ачлалт хүүхдүүд”, “Тереза эх” асрамжийн газрын ажилтнууд - Нийгмийн үйлчилгээ үзүүлдэг дүүргүүдийн холбогдох албан тушаалтан - ХНХЯ, ХХҮЕГ-ын ажилтнууд
Сургалтын цаг	2 өдрийн нийт 16 цагийн (Эхний өдөр 8 цагийн онолын лекц, 2 дахь өдөр Ахмад настны үндэсний төв дээрх 8 цагийн дадлага) сургалт
Сургалтын агуулга	Модуль 1 : Нийгмийн халамжийн бодлогын шинэчлэлт ба хууль эрх зүй Модуль 2 : Нийгмийн ажлын онол ба мэргэжлийн ёсзүй Модуль 3 : Нийгмийн халамжийн үйлчилгээн дээр үйлчлүүлэгчтэй хамтарч ажиллах арга Модуль 4 : Мэргэжлийн асрамжийн газар дээр хэрэгжих нийгмийн ажил үйлчилгээ ба стресс менежмент Модуль 5: Амьжиргааг дэмжих төслийн гишүүдийг чадавхижуулах тухай Модуль 6 : Мониторинг ба үнэлгээ хийх арга Модуль 7 : Зорилтот бүлгийн өрхтэй хэрхэн ажиллах тухай (Сургалтын материалд нийт 42 цаг 30 минутын агуулга багтсан)

Эх сурвалж: ХНХЯ-аас авсан мэдээлэлд үндэслэн судалгааны баг гаргав.

⑦ Эрүүл мэндийн яам (ЭМЯ)

МУ-ын ЭМЯ-наас 2013-2020 онд "Эрүүл насжилт, настны эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж буй бөгөөд одоогийн байдлаар тус хөтөлбөрийн үр дүнгийн үнэлгээ хийгдэж байна. Цаашид энэхүү үнэлгээний дүнд тулгуурлан хөтөлбөрийг цаашид хэрэгжүүлэх чиглэл, аргачлалыг тодорхойлох, улмаар 2019-2027 он хүртэлх мастер төлөвлөгөөний агуулгыг боловсруулахаар төлөвлөж байна. Гэхдээ энэхүү мастер төлөвлөгөө коронавируст халдварын нөлөөгөөр удаашралтай байна. Мөн өндөр настан асрах хүний нөөцийн тухайд сүүлийн жилүүдэд бэлтгэж эхэлсэн ахуй засалч, физик эмчилгээний эмч, хэл засалчид 2019 оноос анхны төгсөлтөө хийж эхлээд байна¹¹⁹.

¹¹⁸ 2021 оны 3 сарын 23-ны өдөр ХНХЯ-ны Нийгмийн хамгаалал бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын нийгмийн хамгааллын ахмад настны үйлчилгээ хариуцсан шинжээч Б. Майчимэг, Хүн амын хөгжлийн газрын ахмад настны хөгжлийн бодлогын зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Д. Бат-Эрдэнэтэй хийсэн ярилцлага.

¹¹⁹ 2021 оны 4 сарын 15-ны өдөр ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн бодлого хэрэгжилтийг зохицуулах газрын Лавлагаа шатлалын тусламжийн хэлтсийн дарга, тус хэлтсийн лавлагаа шатлалын тусламжийн өндөр настны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, лавлагаа шатлалын тусламжийн хүний нөөц хариуцсан мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын судалгааны үеэр олж авсан мэдээлэл.

⑧ Дорноговь аймгийн ахмад настны асрамжийн төв

Дорноговь аймгийн ахмад настны асрамжийн төв нь говийн бүсийн 4 аймаг (Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр)-ийн ахмад настнуудыг асардаг асрамжийн газар бөгөөд 1990 онд байгуулагдсан. Барилга нь 1942 онд баригдсан цэргийн эмнэлгийнх бөгөөд нэлээд хуучирчээ. 30-50 орчим хүн хүлээн авах хүчин чадалтай боловч барилга нь хуучирсан тул одоогоор 20 хүн хүлээн авч байна. Нийт 14 ажилтантайгаас 4 нь ЕБС төгссөн. Хөгжлийн бэрхшээлтэй ахмад настныг асрах хүсэлтэй, удаан хугацаанд ажиллах хүмүүсийг ажилд авдаг. Ажиллагчдын дундаж нас 45-55 нас. Ахмад настны үндэсний төвд хүн шилжүүлж байснаас өөр харилцаагүй. Мөн бусад аймгийн асрамжийн төвүүдтэй хамтарч ажилладаггүй. Энэ асрамжийн төв нь эмчтэй тул эмнэлэгтэй холбоотой ажилладаггүй байна¹²⁰.

⑨ Олон нийтийн оролцоонд түшиглэсэн шинэ хэв маягийн асрамжийн тогтолцоо, үйлчилгээ хөгжүүлэх төсөл

АХБ-ны "Олон нийтийн оролцоонд түшиглэсэн шинэ хэв маягийн асрамжийн тогтолцоо, үйлчилгээ хөгжүүлэх төсөл" (цаашид "Урт хугацааны асрамжийн үйлчилгээний төсөл" гэх)-ийн талаар авч үзье.

АХБ 2017 оноос ахмад настны асрамжийн болон урт хугацааны асрамжийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн техникийн хамтын ажиллагааг хэрэгжүүлсэн. Тухайн үед ХНХЯ-ны Нийгмийн хамгааллын газрыг түнш байгууллагаар ажиллуулж, судалгаа хийж дүгнэлт гарган, чадавхийг дээшлүүлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулжээ. Судалгааны дүнг нэгтгэж, дараа нь 2017 онд батлагдсан "Ахмад настны тухай хууль"-ийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөнд АХБ-ны төслийн үр дүнг тусгах ажил дээр жил орчмын хугацаанд хамтарч ажиллажээ.

Тус урт хугацааны асрамжийн үйлчилгээний төслөөр техникийн тусламжийн хүрээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн урт хугацааны тусламж үйлчилгээг хөгжүүлэхэд хэрэгтэй зүйлсийг нэгтгэн дүгнэж, урт хугацааны асрамжийн үйлчилгээний төслийн концепц бодит байдал дээр тухайн орчинд хэрхэн ажиллахыг судлах юм. Уг төсөл 2019 оны сүүлчээр батлагдсан боловч цар тахлын улмаас эхлэх нь хойшлогдоод байгаа юм. 4 оронд хэрэгжиж байгаа бөгөөд Индонез улсад саадгүй хэрэгжиж байна. Харин Монголд идэвхтэй насжилтын төв гэсэн анхан шатны дизайн хийгдэж байна. Идэвхтэй насжилтын төв нь нийгмийн халамжийн үйлчилгээний зохицуулагч байгууллагын хувьд эрүүл мэндийн болон нийгмийн үйлчилгээг хамтад нь хэрэгжүүлнэ. Энэ төвийг "идэвхтэй насжилтын төв" гэдэг нэрээр Дархан-Уул аймгийн Ахмад настны хөгжлийн төв, сумын түвшинд Сэлэнгэ аймгийн Мандал сумын эмнэлэг, нийслэлд ахмад настны асрамжийн газар ажиллуулдаг ТББ "Ачлалт хүүхдүүд" дээр байгуулахаар тооцоолж байна¹²¹.

¹²⁰ 2021 оны 4 сарын 21-нд говийн бүсийн 4 аймгийн ахмад настнуудад үйлчилгээ үзүүлдэг Дорноговь аймгийн Ахмадын асрамжийн төвөөс ярилцлага авсан ба тус төвийн захирал Д. Цэндмаа, говийн бүсийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн Астонгара нар ярилцлага өгсөн.

¹²¹ 2021 оны 4 сарын 26-нд АХБ-ны Нийгмийн хөгжлийн судалгааны багийн ахлах Уэнди Уолкер, АХБ-ны Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн (ахмад настан, асрамжийн салбар) Мерит Вайсс нартай ярилцлага хийсэн.

5-3-5 Тулгарч буй болон шийдвэрлэх шаардлагатай асуудлын тойм

① Давуу тал ба тулгарч буй асуудал

Холбогдох яам агентлаг, байгууллагууд, Дорноговь аймгийн Ахмадын асрамжийн төв, мөн АХБ-ны урт хугацааны асрамжийн үйлчилгээний төсөл, орон нутгийн халамжийн газар, эрүүл мэндийн төвүүдэд тус судалгааны багаас хийсэн ярилцлагын дүнд тодорхойлсон ахмад настанд үзүүлэх асаргааны тусламж үйлчилгээг хөгжүүлэх давуу тал болон хүндрэлтэй байж болзошгүй гэж үзсэн зүйлээ 5-29 хүснэгтэд тусгав.

Хүснэгт 5-29: Давуу тал ба хүндрэл бэрхшээл

Давуу тал	Тулгарч буй асуудал
• ХНХЯ-ны ажилтнууд олон жилийн туршлагатай, хийж байгаа зүйлдээ итгэл үнэмшилтэй ажилладаг. • Ахмад настны тухай хууль 2017 онд батлагдсан • Стратеги төлөвлөгөө боловсруулж байгаа. • Хорооны өрхийн эмнэлгийн ажилтнууд нь халамжийн ажилтнуудтай хамт, айл өрхөөр тойрч ажиллах зэргээр анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон халамжийн үйл ажиллагаа уялдаатай байгаа нь ажиглагддаг. • Хотын хөгжлийн өрнөл дунд ахмад настныг дэмжсэн (олон нийтийн оролцоог хөгжүүлэх/оролцоог дэмжих) арга хэмжээ авдаг нь харагдаж байна. • ХНХЯ болон ЭМЯ-ны ажилтнуудын дотор, асаргааны хүний нөөцийг бэлтгэх шаардлагатай гэж үздэг хүн олон бий. •	• Улс орны хэмжээнд урт хугацааны асаргаа үйлчилгээний бодлого дутагдалтай байна. • Ахмад настны асрамжийн газрын тоо ба ажилтны орон тоо нь ахмад настай хүн амтай харьцуулахад маш цөөн. • Улсын асрамжийн газрын ахмад настанг хүлээн авах шалгуур нь хатуу, гэр бүлийн хүчирхийлэл, дарамтанд байдаг болон бичиг баримтгүй ахмадууд зэрэг асрамжийн газарт орох шаардлагатай ахмад настанууд ороход хялбар биш. • Хувийн компаниуд болон ТББ-уудад үзүүлэх урамшуулал сул (ахмад настны асрамжийн газар ажиллуулдаг ТББ-ын зарим нь төрөөс татаас авдаг, зарим нь авдаггүй), бас үнэлгээний систем нь хангалтгүй, одоо ажиллаж байгаа асаргааны ажилтнуудад сургалт хангалттай явагддаггүй. • Асаргааны мэргэжлийн ажилтан бэлтгэгддэггүй. • Өдрийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаа, хяналтын стандарт хангалтгүй. • Ахмад настны тусламж үйлчилгээ, асаргаатай холбоотой албан ёсны сургалт, сургалтын хөтөлбөр байдаггүй. • Өргөн уудам газар нутагт хүн ам тархмал амьдардаг, шаардлагатай хүний нөөц, нөөц бололцоо дутагдалтай нөхцөлд үйлчилгээ нь хялбар биш. • Ахмад үеийнхэн хуучинсаг үзэл бодолтой. Тэдгээрээс бусад насныхан асаргаан дээр ач холбогдол өгөх нь бага • Анхан шатны байгууллагад төсөв мөнгө хүрэлцээгүй. • Ахмад настны асрамжийн газрын барилга байшин хуучирсан, тоног төхөөрөмж хангалтгүй.

② Шаардлагатай арга хэмжээ

Дээр дурдсан асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай гэж үзсэн ажлуудыг дор жагсаав.

- Засгийн газар насжилтын талаар хэрэгжүүлэх бодлогын хүрээнд асрамжийн тусламж үйлчилгээний тогтолцооны алсын хараа, зорилго чиглэлийг тодорхойлоход манлайлан оролцоно. Тухайлбал, гэр бүлийн асаргааг цаашид үргэлжлүүлэн санал болгох эсэх, асрамжийн үйлчилгээг ТББ болон хувийн компаниудад аль хүртэл даатгах, тэднийг хэрхэн дэмжиж, удирдан зохион байгуулж ажиллах гэх мэт.
- Мэргэшсэн хүний нөөцөөр хангахад хууль эрхзүйн орчин бүрдүүлэх, сургалтын хөтөлбөр бэлтгэх, мэргэшлийн зэрэг олгох тогтолцоо бүрдүүлэх зэрэг олон бэлтгэл ажил шаардлагатай. Иймд асрамжийн тусламж үйлчилгээний алсын хараа, чиглэл тодорхойлогдсоны дараа асаргааны салбарын боловсон хүчний төрөл, сургаж бэлтгэх арга замыг тодорхойлох шаардлагатай.
- ХНХЯ, ЭМЯ, Геронтологийн үндэсний төв, Ахмад настны үндэсний төв, Монголын ахмадын холбоо зэрэг холбогдох байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллах, байгууллага тус бүрээр үзүүлэх үйлчилгээг эрэмбэлэх, зорилго чиглэлтэйгээ уялдуулж, илүү нягт хамтын ажиллагааг хөгжүүлэх.
- Улаанбаатар болон түүний ойр орчмын бүсээс бусад бүс нутагт хүн хүчний болон барилга байгууламжийн хүрэлцээ хомс нөхцөлд хэрхэн үйлчилгээ үзүүлэх талаар судлах.

Зургаадугаар бүлэг. Шинэ төрлийн коронавирусын эсрэг авах яаралтай арга хэмжээний дэмжлэг тусламжийн талаар судалсан нь

6-1 Монгол дахь шинэ төрлийн коронавирусын эсрэг авах яаралтай арга хэмжээний үед үзүүлж буй тусламжийн хэрэгжилтийн байдал

2021 оны 4 сард ч Ковид-19-ийн нөхцөл байдал хэвээр үргэлжилж, халдвар авагчдын тоо нэмэгдсэн. 4 сарын 30-ны өдрийн байдлаар халдвар авсан хүмүүсийн тоо 1,128 хүрсэн. Нас барсан хүний тоо 140-д хүрчээ. 4 сарын 24-ний байдлаар Энэтхэг улсын дэмжлэг болон шинэ төрлийн коронавирусын вакциныг хэд хэдэн улс оронтой хамтран худалдаж авах олон улсын хөтөлбөр (цаашид “КОВАКС” гэх)-ийг ашиглан АстраЗенека вакцин 214,800 тун, Хятадаас Синофарм фирмийн вакцин 1,500,000 тун, Оросын “Спутник V” болон КОВАКС-аар дамжуулан Пфайзер компанийн вакцин татаж авсан¹²². НҮБ-ын Монгол дахь төлөөлөгчийн газраас явуулсан онлайн судалгаанаас харахад судалгаанд оролцогсдын 65.7% нь өнгөрсөн сарынхаас өрхийн орлого нь буурсан, 71.8% нь коронавируст халдвар гарахын өмнөх үетэй харьцуулахад орлого буурсан, 48.1% нь ойрын хэдэн долоо хоногт орлого улам буурна хэмээн хариулжээ. Түүнчлэн судалгаанд оролцогсдын 65.8% нь ажилгүй болсон байлаа¹²³.

Засгийн газраас хэрэгжүүлсэн Ковид-19 цар тахлын эсрэг авах арга хэмжээ, тухайлбал татвар, нийгмийн даатгалын шимтгэл, халамжийн чиглэлээр голчлон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг 6-1 хүснэгтэнд тусгав. Засгийн газар ерөнхийдөө жилийн өмнөөс буюу 2020 оны 4 сараас эхлэн орлогыг хамгаалах, бизнесийн үйл ажиллагаа, хүнсний хангамжийг тогтворжуулах, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлж ирсэн. Нийгмийн даатгалын шимтгэлээс хэсэгчлэн чөлөөлөх, импортын барааны тариф, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлснөөр төсөв буурах төлөвтэй байгаа ч, эдийн засгаа сэргээх зорилгоор бизнес эрхлэгчдэд зээл олгоход анхаарч ажиллаж байна. Сангийн яам 2021 оны эхээр "Эрүүл мэндийг хамгаалах, эдийн засгийг сэргээхэд чиглэсэн 10 их наяд төгрөгийн цогц төлөвлөгөө" гаргасан бөгөөд 2021 оны 4 сарын 16-ны өдрийн байдлаар 7,936 бизнес эрхлэгч энэхүү цогц төлөвлөгөөний хүрээнд бага хүүтэй зээл авчээ. Түүнчлэн Монголбанкнаас олгосон репо санхүүжилтээр нийслэлд 1,013, хөдөө орон нутагт 584, нийт 1,587 иргэнд зээл олгожээ¹²⁴.

¹²² Another 300,000 doses of Sinopharm COVID-19 vaccine arrive in Mongolia”, <https://www.montsame.mn/en/read/261618> (Мэдээлэл авсан огноо: 2021/4/30)

¹²³ Impact on People Monitoring of the COVID-19 impact on people through the online and other household survey, <https://www.covidmongolia.mn/22-0-92-0-0.aspx> (Мэдээлэл авсан огноо: 2021/5/6)

¹²⁴ “Ажлын байрыг дэмжих зээлд тэрбум төгрөгийг зээлдэгчид олгожээ”, <https://news.mn/r/2423481/> (Мэдээлэл авсан огноо: 2021/4/30)

**Хүснэгт 6-1: КОВИД-19 цар тахлын үеэр татвар, нийгмийн даатгал,
халамжийн салбарт авсан арга хэмжээ**

Орлого хамгаалах чиглэлээр	
1	2020 оны 4-р сарын 1-ээс 2020 оны 10-р сарын 1 хүртэл зургаан сарын хугацаанд хувийн хэвшилд ажиллаж буй иргэдийн цалинг хувь хүний орлогын албан татвараас чөлөөлсөн. Энэхүү арга хэмжээний үр дүнд 889.356 татвар төлөгчийн 198.9 тэрбум төгрөгийг татвараас чөлөөлсөн.
2	2020 оны 4-р сарын 1-ээс 2021 оны 7-р сарын 1-ний хооронд хүүхдүүдийн мөнгийг нэг жил гурван сарын хугацаанд 100,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн. Энэхүү арга хэмжээний үр дүнд 2020 онд 1.2 сая хүүхдэд нийт 1 их наяд 604 сая төгрөг олгожээ.
3	2020 оны 4-р сарын 1-ээс 2020 оны 10-р сарын 1 хүртэл 6 сарын хугацаанд хувийн хэвшлийн компаниуд, хувийн хэвшилд ажилладаг иргэд, сайн дурын даатгуулагчдын төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн чөлөөлсөн. 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарыг дуустал 3 сарын хугацаанд шимтгэлийн хувь хэмжээг 5 хувь болгон хөнгөлж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 6 сарын хугацаанд шимтгэлийн хувь хэмжээг 8.5 хувь болгон хөнгөлнө. Энэхүү арга хэмжээний үр дүнд 2020 онд 38602 аж ахуйн нэгж, 572,007 даатгуулагчийн төлөх 715,5 тэрбум төгрөгийг шимтгэлээс хөнгөлж чөлөөлсөн байна.
4	2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 4 сарын хугацаанд хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн хүүхдэд олгох хүнсний талоны үнийг 16,000 төгрөгт хүргэж 2 дахин нэмэгдүүлсэн. Энэхүү арга хэмжээний үр дүнд 118,474 хүүхдэд 1,060.4 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлэв.
5	2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оныг дуустал 8 сарын хугацаанд хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн насанд хүрэгчдэд олгох хүнсний талоны үнийг 32,000 төгрөгт хүргэж 2 дахин нэмэгдүүлсэн. Энэхүү арга хэмжээний үр дүнд 123,514 иргэнд 31.5 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлэв.
6	2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 он дуустал хугацаанд нийгмийн халамжийн тэтгэврийг 100,000 төгрөгөөр нэмэгдүүлж 288,000 төгрөгт хүргэсэн. Энэхүү арга хэмжээний үр дүнд 2020 онд 60,000 иргэнд 122.9 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлэв.
7	2020 оны 11 дүгээр сард ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай хөтөлбөрт зориулан нөөцөлсөн хүнсний бүтээгдэхүүнийг зорилтод бүлгийн өрхүүдэд тараасан. Энэхүү арга хэмжээний үр дүнд нийт 44 мянган хүүхдэд 3.7 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
ААН-ийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр	
1	2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оныг дуустал хүртэл 9 сарын хугацаанд жилийн 1.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны орлогыг албан татвараас чөлөөлсөн. Энэхүү арга хэмжээний үр дүнд 2020 онд 104,400 аж ахуйн нэгжийг 78.9 тэрбум төгрөгийн татвараас чөлөөлсөн.
2	2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл түрээсийн төлбөрөө бууруулсан аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт үзүүлээ. Улмаар энэ чөлөөлөлтийг 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл сунгахаар хуулийн төсөл өргөн мэдүүлсэн. Энэхүү арга хэмжээний үр дүнд 2020 онд 3,400 түрээслэгчийн 30.0 гаруй тэрбум төгрөгийн түрээсийн төлбөр буурсан.
3	2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл ногдуулж тайлагнасан боловч хуулийн хугацаанд төлөөгүй татварын алданги, торгуулийг чөлөөллөө. Улмаар энэ чөлөөлөлтийг 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл сунгахаар хуулийн төсөл өргөн мэдүүлсэн. Энэхүү арга хэмжээний үр дүнд 356,233 татвар төлөгчийг 2020 онд 48.2 орчим тэрбум төгрөгийн татварын алданги, торгуулиас чөлөөлөгдөнө.
4	2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл ногдуулж тайлагнасан боловч хуулийн хугацаанд төлөөгүй нийгмийн даатгалын шимтгэлийн алданги, торгуулийг чөлөөлсөн. Улмаар энэ чөлөөлөлтийг 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл сунгахаар хуулийн төсөл өргөн мэдүүлсэн. Энэхүү арга хэмжээний үр дүнд 6,100 аж ахуйн нэгжийг 14.4 тэрбум төгрөгийн алданги, торгуулиас чөлөөлнө.

5	2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 3 сарын хугацаанд үйл ажиллагаа нь зогссон болон борлуулалтын орлого 50-аас дээш хувиар буурсан аж ахуйн нэгжүүдийн ажилтан бүрийн тоогоор сар бүр 200,000 төгрөг олгосон. Энэхүү арга хэмжээний үр дүнд 7,284 аж ахуйн нэгжийн 220,852 даатгуулагчдад давхардсан тоогоор 44.2 тэрбум төгрөгийн дэмжлэг олгосон.
6	2020 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж байгаа оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг гаалийн албан татвараас чөлөөлнө. Энэхүү арга хэмжээний үр дүнд дотоодод борлуулж байгаа нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлж, борлуулалтын үнийг тогтворжуулсан. 2020 оны эцсийн байдлаар 220 аж ахуйн нэгж, 99 иргэний импортолсон эм, эмнэлгийн хэрэгслийг 15.0 тэрбум төгрөгийн татвараас чөлөөлсөн.
7	2020 оны 12 сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд 870 гаруй мянган айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төрөөс хариуцан төлнө. Үүнд цахилгаан, дулааны эрчим хүчний төлбөрт 477.2 тэрбум төгрөг, усны төлбөрт 108.2 тэрбум төгрөг, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлбөрт 26.6 тэрбум төгрөг зарцуулахаар Засгийн газраас шийдвэрлээд байна.
Хүнсний хангамжийг тогтвортой байлгах чиглэлээр	
1	2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл 15.0 мянган тонн элит үрийн улаан буудай, дотоодын гурилын үйлдвэрлэлд шаардагдах 160.0 мянган тонн хүнсний улаан буудай, бүх төрлийн хүнсний будаа, элсэн чихэр, ургамлын тосыг 24.3 тэрбум төгрөгийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн. Энэхүү арга хэмжээний үр дүнд хүнсний бүтээгдэхүүний хомсдолоос сэргийлж, дотоодод борлуулалтын үнийг тогтворжуулсан.
2	Гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний үнийг цаашид тогтворжуулах зорилгоор бүх төрлийн хүнсний будаа, ургамлын тос болон өвс, мал, амьтны тэжээл, тэжээлийн үр, хүнсний улаанбуудай, улаанбуудайн үр, тослог ургамал, ургамлын түүхий тосыг 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө.
Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр	
1	Коронавируст халдварын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж байгаа оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оныг дуустал хугацаанд гаалийн болон НӨАТ-аас чөлөөлж байна. Үүнд 2020 оны эцсийн байдлаар 15 орчим тэрбум төгрөгийн татвараас чөлөөлсөн.

Эх сурвалж: Сангийн яамны тайлан мэдээ, Судалгааны баг судалснаар (2021 оны 4 сар)

6-2 Шинэ төрлийн коронавирусын эсрэг авах яаралтай арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх дэмжлэг тусламжийн үр дүн, шийдвэрлэх асуудал

Засгийн газар ерөнхийдөө 2020 оны 4 сараас эхлэн орлогыг хамгаалах, бизнесийн үйл ажиллагаа, хүнсний хангамжийг тогтворжуулах, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр арга хэмжээ идэвхтэй авч хэрэгжүүлж байна. Өнөөг хүртэл хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, ядуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааны тогтвортой байдал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар дор тоймлон авч үзье.

① Ядуу иргэдийн ажил эрхлэлтийг дэмжих, амьжиргааны тогтвортой байдлыг сэргээх

Онлайн судалгаанд хамрагдагчдын 65.7% нь 2021 оны 1 сараас орлого нь буурсан, 71.8% нь Ковид-19 гарахын өмнөх үетэй харьцуулахад орлого буурсан гэж хариулжээ. Түүнчлэн судалгаанд оролцогчдын 48.1% нь ойрын хэдэн долоо хоногт орлого улам буурна хэмээн хариулжээ¹²⁵. Мөн албан бус секторт ажиллах 385 иргэнээс авсан судалгаагаар хөл хорионы үеэр орлого нь 97%-иар буурсан байв. Судалгаанд оролцогчдын 62% нь зээлтэй бөгөөд үүнээс 56% нь зээлээ хугацаандаа төлж чадаагүй байна¹²⁶.

2019 онд 5.2% болж өссөн МУ-ын эдийн засаг 2020 онд 6% орчмоор буурч¹²⁷, 2020 оны 4 дүгээр улиралд ажилтай иргэдийн тоо 70,000-аар буурсан гэж Засгийн газар тооцоолжээ. ДБ-ны тайлангаас харвал эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтийг эрчимжүүлэх арга хэмжээ авахгүй бол ядуурлын түвшин 2018 оны 28.4 хувиас 2020 онд 33.6% болж өсөх магадлалтай байна¹²⁸.

Засгийн газрын шийдвэрлэх ёстой чухал асуудал бол эдийн засгийг сэргээж, ажил эрхлэлтийг дэмжиж, иргэдийн амьжиргааг тогтворжуулах явдал юм. ЖДҮ эрхлэгчдэд жилийн 3%-ийн хүүтэй 2 их наяд төгрөгийн зээл олгох, залуучуудад зориулж тэтгэлэг өгөх, ХАА-н үйлдвэрлэл, малчдын орлого болон амьжиргааг дэмжих зорилгоор 500 тэрбум төгрөгийн санхүүжилт хийхээр төлөвлөсөн. Мөн Засгийн газраас дунд давхаргыг орон сууцаар хангахад анхаарч ажиллахаа мэдэгдсэн бөгөөд Улаанбаатар хотод орон сууцны шинэ хорооллуудыг барих, дэд бүтэц хөгжүүлэх, ипотекийн хөнгөлөлттэй зээл олгох зэргээр орон сууцжуулах ажилд гурван их наяд төгрөгийн иж бүрэн дэмжлэг үзүүлэхээр төлөвлөжээ¹²⁹.

ҮСХ 2021 оны 2 сарын 16-нд ОУХБ-ын үндэсний зохицуулагчтай уулзаж ярилцахдаа 2021-2025 он хүртэл хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар судалгаа хийж, албан бус хөдөлмөр эрхлэлтийг үнэлэхэд анхаарлаа хандуулж ажиллахаа мэдэгдэж байв¹³⁰. Онцгой байдлын үед сургуулиудыг удаа дараа хаасны улмаас ялангуяа ядуу иргэдийн боловсрол орхигдож болзошгүй байгааг ДБ онцлон дурдсан байдаг¹³¹. Эдийн засгийг дэмжих бодлого хэрэгжүүлэхтэй зэрэгцэн төрөөс эмзэг бүлгийн ядуу иргэдэд чиглэсэн тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

② Доноруудын үзүүлж буй арга хэмжээ, цаашид шийдвэрлэх шаардлагатай асуудалд хийсэн дүн шинжилгээ

НҮБ-ын Монгол дахь төлөөлөгчийн газраас 2020 оны 7 сард Ковид-19 цар тахлын нөлөөнөөс болж эмзэг бүлгийн иргэдэд тулгарч буй асуудлыг тодорхойлж, Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээний чиглэлийг тодорхойлох зорилгоор “Ковид-19 цар тахлын нөхцөл дэх нийгэм, эдийн засгийн талаар авах арга хэмжээний төлөвлөгөө”¹³²-г боловсруулжээ. Тус материалд НҮБ-

¹²⁵ UN Mongolia, 2021.02.12 updated (<https://www.covidmongolia.mn/22-0-92-0-0.aspx>).

¹²⁶ SICA Survey (2021) Impact of COVID-19 curfew on informal employment, PPT slide 18.

¹²⁷ 2021 оны 2-р сарын 17-ны өдрийн (Монгол Улсын ДНБ 2020 онд 5.3 хувиар буурсан) нийтлэлд ҮСХ-ны мэдээлэлд үндэслэн, 2019 онтой харьцуулахад 1.0 их наяд (5.3%) буурсан гэж тэмдэглэсэн байна. <https://montsame.mn/en/read/253910> (мэдээ ашигласан огноо: 2021-2-17)

¹²⁸ World Bank, Mongolia (February 2021), Mongolia Economic Update from Relief to Recovery. PPT Resource slide 19.

¹²⁹ 2021 оны 2-р сарын 15-ны өдрийн нийтлэл (Working teams set up to implement Government's complex plan of MNT 10 trillion), <https://www.montsame.mn/en/read/25359> (Мэдээлэл авсан огноо: 2021-2-15)

¹³⁰ 2021 оны 2 сарын 16-ны өдрийн нийтлэл (Online meeting held with ILO National Coordinator), <https://www.montsame.mn/en/read/253728> (Мэдээлэл авсан огноо: 2021-2-16)

¹³¹ World Bank, Mongolia (February. 2021), Mongolia Economic Update from Relief to Recovery. PPT Resource slide 14

¹³² UN Mongolia (July 2020), Socio-Economic Response Plan for COVID-19, PDF source.

ын агентлагуудын боловсруулсан 11 үнэлгээний тайлан, МУ-ын ҮСХ-ны мэдээллийг ашиглан "эмнэлгийн тусламж үйлчилгээг нэн тэргүүнд анхаарах", "иргэдийг хамгаалах", "эдийн засгийг сэргээх", "макро эдийн засаг болон олон талт хамтын ажиллагаа", "нийгмийн эв нэгдэл, асуудлыг даван туулах олон нийтийн чадвар" гэсэн таван үзүүлэлтээр Ковид-19-ийн эсрэг авах хариу арга хэмжээ болон шийдвэрлэх асуудлуудыг дүгнэжээ. 6-2 хүснэгтэд гол асуудлуудыг нэгтгэв.

Хүснэгт 6-2: Ковид-19-ийн эсрэг авах хариу арга хэмжээнд хийсэн үнэлгээний дүнд гаргаж ирсэн гол асуудлууд

No.	Үзүүлэлт	Үнэлгээний үндсэн үр дүн (Төрөөс арга хэмжээ авах шаардлагатай асуудал)
1	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэн түрүүнд анхаарах	- Хамгаалах хэрэгсэл, амьсгалын аппарат, үндсэн багаж хэрэгсэлээр хангах, шинжилгээ хийх тогтолцоог сайжруулах - Нийслэлд амьдарч байгаа бүртгэлгүй иргэд эмнэлгийн тусламж авах боломжийг сайжруулах - Эмнэлгийн хаягдал болон хорт хаягдлыг зохистой боловсруулах арга хэмжээ авах
2	Иргэдийг хамгаалах	- Эмзэг бүлгийн хүмүүсийг хамгаалах, зорилтот бүлэгт хамруулах механизм, бодлогын үнэлгээний системийг бэхжүүлэх - Архидалтаас сэргийлэх/жендерт суурилсан гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх арга хэмжээ - Нийгмийн хамгаалал, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд цогц арга хэмжээ авах - Иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээ, боловсролын хүртээмжийг хангах үндэсний болон орон нутгийн засаг захиргааны чадавхийг бэхжүүлэх
3	Эдийн засгийг сэргээх	- Албан бус салбарт ажиллагсадын мэдээллийн сан хөгжүүлэх - Цахим орчин бүхий бизнесийн хуулийн орчинг сайжруулах - Нэмүү өртгийн сүлжээг эрчимжүүлж, ЖДҮ, нүүдэлчдийн үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх стратегийг боловсруулах - Амьжиргаанд нэн шаардлагатай хүнсний бүтээгдэхүүнийг тодорхойлох, импортыг орлох урт хугацааны бодлого тогтоох
4	Макро эдийн засаг ба олон талт хамтын ажиллагаа	- Татварын дахин хуваарилалт, татварын менежментийг сайжруулж, орлогыг нэмэгдүүлэхэд төрд дэмжлэг үзүүлэх - Тогтвортой хөгжлийн зорилтуудын төсөвлөлт, төсвөө алсын хараатай гаргаж, бодлоготой уялдуулах - Тээвэрлэлттэй холбоотой асуудалд арга хэмжээ авах зэрэг хил дамнасан зохицуулалтын чадавхийг сайжруулах - Бизнесийн зохицуулалтыг сайжруулах, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахад төрд дэмжлэг үзүүлэх
5	Нийгмийн эв нэгдэл ба олон нийтийн асуудлыг даван туулах чадвар	- Улс, орон нутгийн төрийн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох системийг боловсронгуй болгох - Тэгш бус байдлын шалтгаан болдог, дижитал нийгмээс үүдэлтэй хуваагдмал байдалд арга хэмжээ авах - COVID-19 цар тахлаас шалтгаантай иргэдийг үзэн явах, ялгаварлан гадуурхах, гадаад иргэдийг гадуурхах явдалд хариу арга хэмжээ авах

Эх сурвалж:Тайлангийн агуулгад үндэслэж судалгааны баг эмхэтгэв.

АХБ, ДБ, ОУХБ зэрэг хандивлагчдын Ковид-19 цар тахалтай тэмцэхэд үзүүлж буй дэмжлэг тусалцааны талаар 6-3 хүснэгтэнд тусгав¹³³. АХБ одоо хэрэгжиж буй Second Shock-Responsive

¹³³ ADB (2021) Sector Assessment, <https://www.adb.org/projects/documents/mon-54214-002-rrp> (Мэдээлэл авсан огноо: 2020-5-26)

Social Protection Project буюу "Цочролд хариу үзүүлэх нийгмийн хамгаалал төсөл"-ийн хоёрдугаар үе шатыг 2021 оны 4 сард хэрэгжүүлэхээр баталсан. Уг төслийн хүрээнд хүүхдийн мөнгөний хөтөлбөрийг үргэлжлүүлэн санхүүжүүлэх юм.

Хүснэгт 6-3: Ковид-19 цар тахлын үеэр донор байгууллагуудаас үзүүлсэн тусламж дэмжлэг (сая ам. доллар)

хандивлагч түнш	төслийн нэр	Үргэлжлэх хугацаа	Төсөв
АХБ	Shock-Responsive Social Protection Project	2020-2021	26.4
АХБ	Second Shock-Responsive Social Protection Project	2021-2023	73.0
ОУХБ	Second Shock-Responsive Social Protection Project	2020-2021	2.0
НҮБ-ын ХХ	Supporting an Inclusive and Multi-Sectoral Response to COVID-19 and Addressing its Socio-Economic Impact	2020-2021	1.1
ДБ	Mongolia Emergency Relief and Employment Support Project	2020-2023	20.0
ЕСБХБ*	Building Resilient SMEs Post COVID-19 Crisis	2020-2025	12.5
ЕСБХБ*	Stepping Up for Women	2020-2030	4.6
ЕХ	Employment Intensive Programmes	2020-2024	2.6
ЕХ	Budget Support Operations in Mongolia	2020-2024	18.2

* ЕСБХБ = Европын Сэргээн босголт хөгжлийн банк

③ Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх, иргэдийн дэмжлэг оролцоо

Засгийн газар халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг өнөөг хүртэл авсаар ирсэн. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх, иргэдийн дэмжлэг оролцоог сайжруулах шаардлагатай байна. ЭМЯ-ны мэдээлснээр 2021 оны 4 сарын эхний байдлаар 323,690 хүн шинэ төрлийн коронавирусын вакцинд хамрагдаад байна. Үүнээс 14,408 нь хөдөөгийн иргэд байна. 320,000 гаруй иргэн вакцинд хамрагдсан нь нийт зорилтот бүлгийн 16,6%-ийг эзэлж байна. Энэ нь зорилтот бүлгийн зургаан хүн тутмын нэг нь вакцинд хамрагдсан гэсэн үг юм. Тус яам вакцинжуулалтын ажлыг хөдөө орон нутагт идэвхжүүлэх төлөвлөгөөтэй байгаа ба Улаанбаатар хотын вакцинжуулалтын цэгүүдийн тоог нэмэгдүүлж, хоёр дахь тунд хамруулах бэлтгэл ажлыг хангаад байна¹³⁴. Түүнчлэн БШУЯ нь АШУҮИС-ийн Эмнэл зүйн молекул оношилгооны төвийг санхүүжүүлж, шүлснээс корона вирус илрүүлэх шинэ оношлуур бүтээж, хэрэглээнд нэвтрүүлжээ. Уг оношлуурыг ЭМЯ-наас өгсөн албан ёсны зөвшөөрлийн дараа хэрэглээнд нэвтрүүлээд байна¹³⁵. Мөн ЭМЯ хүний нөөцийн хомсдлыг нөхөх зорилгоор 733 резидент эмчийг Ковид-19-ийн халдварын эсрэг ажиллахад дайчлан ажиллаж байна¹³⁶.

¹³⁴ 2021 оны 4 сарын 2-ны өдрийн нийтлэл (One in six people in the target group has been vaccinated against coronavirus) <https://ikon.mn/n/26ea> (Мэдээлэл авсан огноо: 2021/4/2)

¹³⁵ 2021 оны 4 сарын 1-ний өдрийн нийтлэл (COVID-19 test kit developed by Mongolian scientists put into practice) <https://montsame.mn/en/read/259052> (Мэдээлэл авсан огноо: 2021/4/1)

¹³⁶ Тандалт шуурхай хариу арга хэмжээний багт 20, вакцинжуулалтын багт 141, гэрийн тусгаарлалтад байгаа иргэдийн эрүүл мэндийн хяналтад 40, өрхийн эрүүл мэндийн төвд 40 гаруй резидент эмч ажиллаж байна. 2021 оны 3 сарын 23-ны өдрийн нийтлэл. (B.Dashkhumb: Psychological counseling will be provided by telephone and online to people living in isolation), <http://time.mn/pLY.html> (Мэдээлэл авсан огноо: 2021/3/23)

Мөн халдвар авч гэртээ тусгаарлагдаж буй хүмүүс сэтгэл санааны асуудлаас болж стресст өртөх, айж эмээх эрсдэл өндөр байгаа тул эдгээр хүмүүст утсаар болон онлайнгаар зөвлөгөө, мэдээлэл өгч байна. ЭМЯ коронавирусын халдвар авах хүмүүсийн тоо нэмэгдэхэд ор, хүн хүч, техник хэрэгсэл, эм тариаг тогтмол шийдэж байгаа ч хүнд өвчтний тоо нэмэгдсээр байна. Үүнтэй уялдан эмчилгээнд гарч буй хүний нөөцийн хомсдол томоохон асуудал болоод байгаа тул халдвараас урьдчилан сэргийлэхэд иргэдийн хүчин чармайлт нэн чухал байна¹³⁷.

6-3 Цаашдын нийгмийн хамгааллын тогтолцооны талаарх санал

Дээр дурдсанчлан Засгийн газар орлогыг хамгаалах, бизнесийн үйл ажиллагаа, хүнсний хангамжийг тогтворжуулах, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр коронавирусын эсрэг арга хэмжээ авсаар ирсэн. ДБ-ны 2021 онд гаргасан тайланд санхүүгийн тусламж үзүүлэх арга хэмжээний зардал ДНБ-ий 9%-иас давна гэж тооцоолжээ. Мөн Засгийн газрын шийдвэрлэсэн цалин нэмэх, халамжийг нэмэгдүүлэх, татвар хөнгөлөх, ипотекийн зээлийн төлөлтийн хугацааг хойшлуулах зэрэг арга хэмжээнээс үүдэн цар тахлын үр дагавар даамжрахын хэрээр төсвийн тэнцвэргүй байдал (орлого ба зарлагын зөрүү) улам бүр газар авсан гэж дүгнэжээ. Яаралтай арга хэмжээний хүрээнд авч хэрэгжүүлсэн санхүүгийн дэмжлэг нь зүй зохистой байсан хэдий ч Засгийн газар цаашид эдийн засгаа сэргээхийн тулд, дунд хугацааны эдийн засгийн төлөв байдал болон ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэхийн тулд санхүүгийн тогтвортой байдлыг хангахад анхаарах шаардлагатай байна. Ялангуяа, уул уурхай болон уул уурхайн бус салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг ашиглах замаар орлого олох боломжийг бий болгоход гол анхаарлаа хандуулж, дэд бүтцийн салбар зэрэгт улсаас хөрөнгө оруулалт хийхийн зэрэгцээ нийгмийн халамж, хамгааллын сүлжээгээр дамжуулан ядуу, эмзэг бүлгийн иргэдэд нэмэлт дэмжлэг үргэлжлүүлж үзүүлэх нь чухал байна гэжээ¹³⁸.

Коронавируст халдварын улмаас өссөн “Хүүхдийн мөнгө”, “Хүнсний эрхийн бичиг” хөтөлбөр зэрэг нийгмийн халамжийн тэтгэмж дэмжлэгүүдийн санхүүгийн эх үүсвэр нь байнга өсөхгүй тул корона намжсаны дараа дэмжлэг тусалцаа хэрэгтэй иргэдийг зөв тогтоох нь чухал юм. 2021 оны намар Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орохтой холбоотойгоор тэтгэвэр тэтгэмж авагчдын нөхцөл сайжрах төлөвтэй байгаа бөгөөд тус хуулийн хэрэгжилтийг хангахын зэрэгцээ тусламж дэмжлэгийн үр нөлөөг хэмжиж, үнэлэх нь чухал. Ядуу, эмзэг бүлгийн иргэдийн өмнө тулгарч буй амьжиргааны асуудлыг цогцоор нь шийдвэрлэхийн тулд холбогдох яам, агентлагууд хамтран хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангаж, үйлчилгээг сайжруулахад анхаарч ажиллах шаардлагатай.

Мөн 6-2 хүснэгтэд үзүүлсэнчлэн Ковид-19 цар тахлын улмаас Засгийн газар төрөл бүрийн асуудалтай тулгараад байна. Халдварын тархалт намжиж, нийгмийн амьдрал буцаж сэргэсэн үед хэрхэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаар бүрэн судлаагүй байна. Цаашид ядуу, эмзэг бүлгийн иргэдийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах шаардлагатай.

¹³⁷ 2021 оны 4-р сарын 2-ны өдрийн нийтлэл (B.Buyandelger: Human resources capacity is more needed as a hospital bed in an increased number of cases) <http://www.olloo.mn/n/77817.html> (Мэдээлэл авсан огноо: 2021/4/2)

¹³⁸ World Bank, Mongolia (February, 2021) Mongolia Economic Update from Relief to Recovery, page VIII-IX.

Долоодугаар бүлэг. Японы хэрэгжүүлж буй арга хэмжээ, шилдэг туршлага

7-1 Нийгмийн хамгааллын салбар дахь Япон Улсын хэрэгжүүлж буй арга хэмжээний жишээ

Тус судалгааны хугацаанд Япон улсын хэрэгжүүлж буй арга хэмжээний жишээг цуглуулж, нэгтгэв. 7-1 хүснэгтэд МУ-ын нөхцөлд ашиглаж болох, үр дүнтэй туршлагуудаас түүвэрлэн тусгав.

Хүснэгт 7-1: Японд хэрэгжүүлдэг арга хэмжээний жишээ

No.	Арга хэмжээний нэр	Муж/бүс нутаг	Хэрэгжүүлэх байгууллага зэрэг
Бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээний жишээ			
1	Хүүхдийн ирээдүйг дэмжих 3 тулгуур (Аспот үйл ажиллагаа)	Сайтама муж	Ашгийн бус байгууллага “Сай но күни”/залуучуудад дэмжлэг үзүүлэх сүлжээ
2	Амьжиргааны нэг цэгийн нэгдсэн зөвлөгөө өгөх арга хэмжээ (Осака хот, Шиавасэ сүлжээ)	Осака муж	Нийгмийн халамжийн хувийн байгууллага “Осака мужийн нийгмийн халамжийн зөвлөл”
3	Бие даан амьдрах зөвлөгөө өгөх, хөдөлмөр эрхлэхэд бэлтгэх ажлыг хослуулан зэрэг хэрэгжүүлэх (Хувийн дэмжлэг үзүүлэх төв)	Мияаги муж	Ашгийн бус байгууллага “Хувийн дэмжлэг үзүүлэх төв”
4	Орон нутгийн нөөц бололцоотой хамтарч ажиллах, хөдөлмөр эрхлэлтийг хөндлөнгөөс дэмжих (амьдрал)	Хоккайдо Күширо хот	Күширо хотын А мьжиргааны зөвлөгөө/дэмжлэг үзүүлэх төв “Амьдрал”
5	"Хотын эрүүл мэндийн танхим" дээр төвлөрсөн нэг цэгийн зөвлөгөө өгөх үйлчилгээ	Миэ мужийн Михари хот	Михари хотын нийгмийн халамжийн зөвлөл
6	Олон нийтийн оролцоотойгоор бүс нутгаа хөгжүүлэх “Зөөлөн хэлхээ”-г өргөжүүлэх (100,000 эмэгтэйчүүдийн холбоо “WeLab46”)	Фүкүока мужийн Курүмэ хот	Күрүмэ хотын 100,000 эмэгтэйчүүдийн холбоо
7	Амьдралын боломжгүй иргэдэд дэмжлэг үзүүлэх хүмүүсийг сургах "Үндэсний судалгааны хамтын ажиллагааны зөвлөлгөөн"/"Практик сургалт семинар"/ "Амьдралын боломжгүй иргэдэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр мэдээлэл солилцох сайт-Хүн бүрийг холбох сүлжээ"	Орон даяар	Ашгийн бус байгууллага “Эмзэг бүлгийн иргэдэд дэмжлэг үзүүлэх үндэсний сүлжээ”
Ахмад настанд дэмжлэг үзүүлэх бүс нутгийн халамжийн үйл ажиллагааны жишээ			
1	Нийслэлийн хэд хэдэн хороололд бүс нутгийн нөөц баялаг, сүлжээг дээд зэргээг ашиглах үйл ажиллагаа	Токио хотын Сэтагая дүүрэг	Сэтагая дүүргийн захиргаа
2	Бүс нутгийн мөнгөн тэмдэгт ашиглан сайн дурын арга хэмжээ зохион байгуулж, ахмад настанд зориулсан салон ажиллуулах	Окаяма мужийн Окаяма хот	Ашгийн бус байгууллага “Хотто Надасаки сайн дурын сүлжээ”
3	Халамжийн нэгдсэн зөвлөгөө тусламжийг нэг цэг дээр үзүүлэх тогтолцоог бий болгох	Шизуока мужийн Фужиномия хот	Фужиномия хотын захиргаа
4	Иргэдийн хамтын дэмжлэгтэйгээр асаргаанд орохоос урьдчилан сэргийлэх	Чиба мужийн Ураясү хот	Ураясү хотын захиргаа

5	Иргэдийн саначилга бүхий харилцан дэмжлэгтэйгээр орон нутгийг хөгжүүлэх	Кагошима мужийн Ямато тосгон	Ямато тосгоны захиргаа
6	Дементиа бүхий иргэдэд дэмжлэг үзүүлэгчийг бэлтгэх	Орон даяар	”Тэмээн жингийн анд” үндэсний зөвлөл
7	100 жилийн түүхтэй нийгмийн халамжийн үйл ажиллагааг сайн дураар гүйцэтгэх тогтолцоо	Орон даяар	ЭМНХХЯ/орон нутгийн засаг захиргаа
8	Энгийн! 30 минутанд хийх хоол	Миэ муж, Кихо хот	Кихо хотын захиргаа
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны жишээ			
1	Жендэрийн тэгш оролцооны төвийг түшиглэн эмэгтэйчүүдэд хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэгийг үзүүлэх	Канагава мужийн Ёкохама хот	Ёкохама хотын захиргаа (Жендэрийн тэгш оролцооны төв)
2	Шилдэг компанийг магадлан итгэмжлэх орон нутгийн засаг захиргааны бие даасан тогтолцоог бий болгох	Шиманэ муж	Муж/эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх төв зэрэг
3	Ажил хайгч, ажил олгогчийг холбох хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ	Сайтайма муж	Муж / Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв, Жендэрийн тэгш оролцооны төв зэрэг
4	Хувь хүний хэрэгцээнд нийцсэн өрх толгойлсон эх/эцгийн хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр бий болгох	Токио хотын Адачи дүүрэг	Адачи дүүргийн захиргаа, хөдөлмөрийн яармаг зэрэг

7-2 МУ-ын нийгмийн хамгаалал, халамжийн салбарт Японы туршлагыг ашиглах боломж

① Японы туршлагыг МУ-ын нөхцөлд ашиглах боломж

7-1 хүснэгтэд дурдсан Японы туршлагаас Монголд ашиглах боломжийн талаар 7-2 хүснэгтэд дурдав. Уг хүснэгтэнд Японы туршлагаас Монголд хэрэгжүүлэх боломж, гол анхаарах зүйлээс гадна эдгээр туршлагыг хэрэглэх магадлалтай ХНХЯ болон ЭМЯ зэрэг байгууллагуудын талаар дурдав. МУ-ын нөхцөлд ашиглаж болох олон туршлага бий. Гэхдээ Япон нь орон нутгийн иргэд, олон нийтийн нийгмийн нөөцийг идэвхтэй ашигладгаараа Монголоос ялгаатай. Мөн Японы хувьд халамжийн удирдлага менежментэд орон нутгийн засаг захиргаа (хот, тосгоны захиргаа) томоохон үүрэг гүйцэтгэдэг тул ялангуяа үйлчилгээ үзүүлэх тал дээр Японы туршлага, ололт амжилтыг тэр чигээр нь МУ-ын нөхцөлд ашиглаж болно гэж хэлж болохгүй юм. Үүнээс гадна МУ-ын халамжийн салбарт ажиллах боловсон хүчин тоо болон төрлийн хувьд хязгаарлагдмал тул нийгмийн халамжийн тогтолцоог олон талаас нь сайжруулах шаардлагатай. Япон Улсын олон нийтийн нөхцөл байдал болон иргэдийн хэрэгцээнд нийцүүлэн халамжийн үйлчилгээг сайжруулах, боловсронгуй болгох тал дээр уян хатан ажилладаг. Иймд Японы туршлагыг МУ-ын нөхцөлд тохируулан өөрчлөх замаар хамтран ажиллах боломжтой.

Хүснэг 7-2: Японы туршлагыг Монголд хэрэгжүүлэх боломж (жишээ)

#	Үйл ажиллагааны жишээ	Монголд хэрэгжүүлэх боломж, гол анхаарах зүйл	Хамтын ажиллагааны хүрээнд Японы туршлагыг ашиглах арга	Дугаар
Эмзэг бүлгийн иргэд бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны жишээ				
1	Хүүхдийн ирээдүйг дэмжих 3 төрлийн дэмжлэг	• Зөвлөгөө өгч, дэмжлэг туслалцаа үзүүлэх ажилтан эмзэг бүлгийн ядуу өрхүүдэд очиж уулзан, эцэг эх, хүүхэдтэй боловсролын (сургуулийн боловсрол, дараагийн шатны сургуульд дэвшиж суралцах гэх мэт) асуудлаар ярилцаж, суралцах хүсэл эрмэлзлийг төрүүлэх. • Сургууль завсардалтаас урьдчилан сэргийлэх, ирээдүйд суралцаж, ажиллаж хөдөлмөрлөхтэй холбоотой сонголтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Ахуй амьдралын асуудлаар зөвлөгөө өгч, нийгмийн гишүүнийг эртнээс бэлтгэнэ. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцооны талаар үлгэр жишээ болохуйц туршлагаас хуваалцаж, мэдээллээр хангах боломжтой.	• Ядуу иргэдийн нийгмийн оролцоог дэмжих, нийгмийн ажилтны ур чадварыг дээшлүүлэх, залуучуудыг дэмжих аргачлалыг санал болгох	1, 2, 6, 7
2	Ахуй амьдралын асуудлаар зөвлөгөө өгөх нэг цэгийн үйлчилгээ	• Сургалтанд хамрагдсан нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын ажилтан тухайн орон нутагт зөвлөгөө авах, дэмжлэг хүссэн хүмүүст үйлчилнэ. • 5-аас дээш жил ажилласан туршлагатай, сургалтанд хамрагдсан цэцэрлэгийн багш хүүхдийн өсөлт торнилт, гэр бүл, өвчин эмгэг, асаргаа сувилгааны талаар зөвлөгөө өгч, холбогдох халамжийн үйлчилгээтэй холбоно. • Олон нийтийн нөөцийг үр дүнтэй ашиглан, тусламж дэмжлэг үзүүлэх туршлагаас Монголд танилцуулж, нийгмийн ажилтны ачааллыг бууруулах арга замыг санал болгох боломжтой.	• “Нийгмийн халамжийн компанийн тогтолцоо”-г нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нийгмийн ажилтны ур чадварыг дээшлүүлэх, ажлын ачааллыг багасгах арга замыг эрэлхийлэх, цогц дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх, олон нийтийн оролцоог эрчимжүүлэх	1, 5, 7
3	“Бие даан амьдрахад зөвлөгөө өгөх”, “хөдөлмөр эрхлэхэд бэлтгэх” ажлыг хослуульж хэрэгжүүлэх	• Хөдөлмөр эрхлэхэд бэлтгэж, сургах, ажлын байран дээр дадлага хийлгэх зэрэг ажлыг улсын байгууллага, компани, орон нутаг хамтран хэрэгжүүлэх. • Тэтгэмж олгоод, хөдөлмөрийн дадлага олгоод орхих бус, тухайн хүний санал бодлыг анхаарч, ойр дотны хамтрагчийн байр сууринаас дэмжлэг туслалцаа үзүүлэх зэрэг Монголд шаардагдаж буй дэмжлэг туслалцааны арга хэлбэрийг тодорхойлох	• Засгийн газар, компани, орон нутаг хамтран, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих загвар санал болгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аргачлалыг сайжруулах	1, 3, 7
4	Орон нутгийн хүний нөөцтэй хамтран ажиллаж, өвчин эмгэгийн улмаас удаан хугацаанд хөдөлмөр эрхлээгүй, шууд ажилд ороход хүндрэлтэй хүмүүст анхаарал хандуулж, хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх	• Амьжиргааны тэтгэмж авдаг, санхүүгийн хүндрэлд орсон иргэдэд цогц дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зөвхөн халамжийн хэлтэст даатгах бус тухайн орон нутгийн бусад нөөцийг ашиглан дэмжлэг туслалцаа үзүүлэх. • Тухайн салбартаа мэдлэг, туршлагатай байгууллага, мэргэжилтнээс бүрдсэн “Тусламж дэмжлэгийн асуудал хэлэлцэх хороо” байгуулж, орон нутгийн хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлэх	• Засгийн газар болон орон нутгийн хамтын ажиллагааны аргачлал, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, дэмжлэгийн	1, 5, 7

			талаар судлах алба байгуулах аргачлал	
5	Хот дотор байдаг "Эрүүл мэндийн асуудлаар төрөл бүрийн зөвлөгөө өгөх өрөө (infirmary)"-нд түшиглэн нэг цэгийн зөвлөгөө өгөх үйлчилгээ нэвтрүүлэх	Нарийн ээдрээтэй, олон талын асуудал хамаарсан тохиолдлыг судалж, шийдвэрлэхдээ хамтын ажиллагаа хариуцсан ажилтанг (бүсийн ахлах) орон нутгийн цогц тусламж дэмжлэгийн төв, эмзэг бүлгийн иргэдийн амьжиргаа, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан алба, боловсролын хороо зэрэг олон хэлтэс тасагт томилж, бусад байгууллагуудтай хамтран ажиллах, орон нутгийн хамтын ажиллагааны сүлжээг бэхжүүлж, орон нутагт асуудлыг шийдвэрлэх чадварыг хөгжүүлэх.	"Цогц дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны аргачлал нэвтрүүлэх"-д дэмжлэг үзүүлэх, холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааны сүлжээ нэвтрүүлэх аргачлал санал болгох	1, 5, 6, 7
6	"Албан бус харилцаа"-г өргөжүүлэн орон нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх	- Японд орон нутаг дахь иргэдийн "албан бус харилцаа"-г өргөжүүлж, хамтран асуудал шийдвэрлэж, бие биедээ харилцан нөлөөлдөг комьюнити бүрдүүлэн, өргөн хүрээг хамаарсан асуудал (тухайлбал амьжиргааны түвшин доогуур эмзэг бүлгийн хүмүүст тулгарч буй асуудалд анхаарч) хэлэлцэж, шийдвэрлэх чадварыг хөгжүүлэхэд анхаарч ажилладаг. - Энэ үйл ажиллагаа нь Монголд орон нутагт түшиглэн нийгмийн халамжийг хэрэгжүүлэх, орон нутгийн байгууллагуудыг хөгжүүлэхэд туршлага болох боломжтой.	Олон нийтийн оролцоог дэмжих, амьжиргааны түвшин доогуур зорилтот бүлгийн хүмүүст дэмжлэг үзүүлэх аргачлал санал болгох	1, 5, 7
7	Амьжиргааны түвшин доогуур зорилтот бүлгийн хүмүүст дэмжлэг үзүүлэх ажилтанг сургаж бэлтгэх	- Японд хууль хэрэгжиж эхлэхээс хагас жилийн өмнөөс туршиж хэрэгжүүлсэн. - Эхлээд улсын байгууллага хүний нөөцийг сургаж бэлтгэн, аажмаар орон нутагт хэрэгжүүлж эхэлсэн. "Амьжиргааны түвшин доогуур зорилтот бүлгийн иргэд бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үндэсний хэмжээний сүлжээ", "Амьжиргааны түвшин доогуур зорилтот бүлгийн иргэд бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх мэдээлэл солилцох цахим сайт" зэрэг флатформ үүсгэж, хүний нөөцийг хөгжүүлэх, зорилтот бүлэгт дэмжлэг тусалцаа үзүүлэх тогтолцоог сайжруулахад анхаардаг.	Амьжиргааны түвшин доогуур зорилтот бүлгийн хүмүүс бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг нэвтрүүлэх (засаг захиргааны байгууллагын үйл ажиллагаанд өргөн хүрээнд хэрэгжүүлж хэвших)	1, 5, 7
Ахмад настанд дэмжлэг үзүүлэх орон нутгийн нийгмийн халамжийн үйл ажиллагааны жишээ				
1	Орон нутгийн хүний нөөц, сүлжээг үр дүнтэй ашиглах	- Ахмад настны нөхцөл байдлыг судалж тодорхойлох, "Асаргааны даатгалын үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний талаар иргэдийн санал хүсэлтийг сонсох, мэдээлэл цуглуулах. - Хот суурин газрын төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллага, компани, их дээд сургуулийн арвин баялаг нөөц, сүлжээг үр өгөөжтэй ашиглаж, ахмад настны нийгмийн оролцоог дэмжих боломжтой.	Орон нутгийн эрэлт хэрэгцээг тодорхойлох аргачлал, ахмад настны нийгмийн оролцоог дэмжих аргачлал санал болгох	1, 4, 7, 8
2	Орон нутгийн нөөцөд тулгуурласан сайн дурын ажилтны үйл ажиллагаа, "ахмад настны салон"	- Орон нутагт иргэд хамтран ажиллах, санал бодол солилцох орчин бүрдүүлэх. - Орон нутгийн нийгмийн халамжийн нөөц баялагийг үр дүнтэй ашиглах. - Сайн дурын ажилтнаар тогтвортой хангаж чадвал, нийгмийн халамжийн үйл ажиллагааг өргөжүүлж, сайн дурын ажилтны оролцоог нэмэгдүүлэн,	Ахмад настны нийгмийн оролцоог дэмжих аргачлал санал болгох	1, 4, 6, 7

		тогтвортой, үр өгөөжтэй дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжтой.		
3	Нийгмийн халамжийн нэг цэгийн цогц зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх	- Орон нутгийн нийгмийн халамжийн төвийн үйлчилгээг багцалж, гэр бүлд зөвлөгөө өгөх цэг ажиллуулдаг. - Иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг үзүүлэх боломжтой. Орон нутгийн байгууллага болон хүний нөөцийг холбож, үйлчилгээг өргөжүүлж, чанаржуулахад анхаарч ажилладаг.	Нийгмийн халамжийн үйлчилгээний аргачлалыг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн дэмжлэг туслалцаа үзүүлж, үйлчилгээг сайжруулах	1, 5, 7
4	Иргэдийн хамтын ажиллагаанд тулгуурлан асаргаа сувилгааны урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Асрамжийн үйлчилгээнд туслах сайн дурын ажилтанг сургаж бэлтгэн, иргэдийн сайн дурын үйл ажиллагааг дэмжих, иргэд хотын захиргаатай хамтран асаргаа сувилгааны урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой.	Олон нийтийн оролцоог дэмжих, хүний нөөцийг хөгжүүлэх аргачлалыг санал болгох	4, 5, 7, 10, 11, 13
5	Иргэдийн санал санаачлагад тулгуурлан орон нутагт харилцан туслалцах орчинг бүрдүүлэх	“Олон нийтийн газрын зураг” боловсруулах замаар иргэдийн хооронд холбоо харилцаа тогтоож, тухайн орон нутагт иргэд зохих үүрэг гүйцэтгэж, нийгэмд өөрийн байр суурь, амьдралын зорилготой болоход нь дэмжлэг үзүүлж, харилцан туслалцах орчин бүрдүүлэн, иргэдийн оролцоог дээшлүүлэх (өөрөө өөртөө тусалж чаддаг, харилцан бие биедээ тусалдаг болгож иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх) боломжтой.	Ахмад настны нийгмийн оролцоог дэмжих аргачлал санал болгох	1, 4, 6, 7
6	Зөнөгрөх өвчтэй хүмүүст тусламж дэмжлэг үзүүлэх ажилтан сургаж бэлтгэх	Зөнөгрөх өвчтэй хүмүүст тусламж дэмжлэг үзүүлэх төвийн үйл ажиллагааны талаар ДЭМБ-ын тайланд (2012) дурдсан байдаг. Англид Японы загвараар “dementia friend” гэсэн нэртэй зөнөгрөх өвчинтэй хүмүүст дэмжлэг үзүүлэх төвийн тогтолцоог нэвтрүүлсэн. Монголд сургууль, эмнэлэг, дэлгүүр, нийтийн тээврийн байгууллагад чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрэлт хэрэгцээ бий.	- Олон нийтийн оролцоог эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, - хүний нөөцийг хөгжүүлэх аргачлал, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны аргачлалыг санал болгох	4, 6, 7, 10, 11, 13
7	100 жилийн түүхтэй “Орон нутагт иргэдэд зөвлөгөө өгч, зохих тусламж дэмжлэг туслалцаа үзүүлэх, орон тооны бус халамжийн ажилтны тогтолцоо”	Орон нутгийн орон тооны бус нийгмийн халамжийн ажилтан нь засаг захиргааны байгууллага болон иргэдийн хооронд гүүр болж, халамжийн байгууллага, холбогдох улсын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлдэг. Иргэдийн эрэлт хэрэгцээг тодорхойлж, нийгмийн ажилтан зэрэг халамжийн мэргэжилтний ажилд дэмжлэг үзүүлэн, нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг сайжруулахад хувь нэмэр оруулдаг.	Олон нийтийн оролцоог эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх аргачлал санал болгох, үйлчилгээний чанарыг сайжруулах	1, 5, 6, 7
8	“30 минутанд хялбар хийж болох хоол”	Хоол тэжээлийн мэргэжилтэн, шүдний эрүүл ахуйч, public health nurse зэрэг олон мэргэжилтний мэдлэг, туршлагад тулгуурлан хоол тэжээл, амны хөндийн арчилгаатай холбоотой зөвлөгөө, үйлчилгээг хүргэж, ахмад настан асаргаа сувилгаа авах хүртэл дордохоос урьдчилан сэргийлнэ. Мөн “хоол хүнс”-ээр дамжуулан, сургалтанд оролцогчид хоорондоо харилцах орчин бүрдүүлдэг тул орон нутгийн хөгжил, хамтын ажиллагаанд хувь нэмэр оруулах	Төрөл бүрийн мэргэжлийн хүмүүс хамтран ажиллах тогтолцоо, аргачлалыг санал болгох, олон нийтийн оролцоог дэмжих, үйлчилгээний чанарыг	9, 11, 12, 13

		боломжтой.	сайжруулах	
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны жишээ				
1	Жендэрийн эрх тэгш ор олцоог хангах төвийн үйл ажиллагаанд түшиглэн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээг хэрэгжүүлэх	- Монголд эмэгтэйчүүд орлогын эх үүсвэртэй болох арга хэрэгсэл, мэдээллийн сүлжээнд холбогдох боломж хязгаарлагдмал байдгаас болж ихэвчлэн албан бус салбарт жижиг хэмжээний бизнес эрхэлдэг, эрэгтэйчүүдээс доогуур цалин хөлс авдаг нь анхаарал татсан асуудлын нэг юм. “Эмэгтэйчүүдэд тусгайлан зөвлөгөө өгөх цэг” ажиллуулж, хамтарч ажиллан, эмэгтэйчүүдэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг санал болгох	- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аргачлал - зөвлөгөө өгөх үйлчилгээний чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	2, 3, 7
2	Орон нутгийн шилдэг компанийг тодорхойлох тогтолцоог бүрдүүлэх	Монголд өндөр албан тушаалд ажиллаж буй эмэгтэйчүүд цөөн байдаг. Улсын болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын тендерт хүйсийн тэгш оролцоог хангасан компанид илүү үнэлгээ өгөх, хүйсийн тэгш байдлыг хангасан үлгэр жишээ компанийг сонгон шалгаруулах тогтолцоог нэвтрүүлж, компаний имижийг дээшлүүлэх замаар өндөр цалинтай удирдах ажилтны албан тушаалд ажиллах эмэгтэйчүүдийн тоог өсгөх.	Хувийн хэвшлийн компани хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах арга хэрэгслийг (gender mainstreaming) нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аргачлалыг санал болгох	2, 5, 7
3	Ажил хайж буй иргэн болон компанид чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг эрчимжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	- Ажил хайж буй иргэдэд үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний аргачлал, компаний ажилтан сонгон шалгаруулах тогтолцоог уян хатан, боловсронгуй болгох, энэ талаарх компаний ойлголт мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарах. - Ажлын байраар хангаж, хүний нөөцийг хөгжүүлэх арга хэмжээгээр хязгаарлалгүйгээр, илүү өргөн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг авах	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих загвар санал болгох, одоогийн аргачлалыг сайжруулах	3, 7
4	Тухайн хувь хүний эрэлт хэрэгцээнд нийцүүлэн өрх толгойлсон эх (эцэг) хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөр боловсруулах	Амьдралын нөхцөл байдал, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ болон бусад нийгмийн халамжийн үйлчилгээг уялдуулах, бие даан амьдрахад чиглэсэн цогц дэмжлэг туслалцаа үзүүлэх	Тусгайлан зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх аргачлал (тогтолцоо) нэвтрүүлэх	1, 3, 7

[Ашиглаж болох байгууллагуудын жишээ]

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (Бодлого төлөвлөлтийн газар),
2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (Гэр бүлийн бодлого зохицуулах газар),
3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (Хөдөлмөр эрхлэлтийн бодлого зохицуулах газар),
4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (Хүн амын бодлого зохицуулах газар),
5. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (Нийгмийн халамжийн бодлого зохицуулах газар),
6. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (ГБХЗХГ),
7. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ),
8. Нийгмийн даатгалын ерөнхий газар,
9. Эрүүл мэндийн яам (Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар),
10. Эрүүл мэндийн яам (Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар),
11. Геронтологийн үндэсний төв,
12. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв,
13. Аймаг, дүүргийн Эрүүл мэндийн газар

② Нийгмийн халамжийн тэтгэмж

Монгол, Японы халамжийн тэтгэмжийн ялгаатай болон адил талыг тоймлон авч үзье. Японы нийгмийн даатгалын тогтолцоонд бэлэн мөнгөөр тэтгэмж олгож, эрүүл мэндийн үйлчилгээ болон асаргааны зардлыг улсаас даадаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настанг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулж, нийгмийн даатгалаас бусад бэлэн мөнгөөр тэтгэмж төдийлөн олгодоггүй. Бэлэн мөнгөөр олгох тэтгэмж нь олгох болон авах аль аль талдаа чөлөөтэй хэрэглэх боломжтой арга хэрэгсэл боловч тэтгэмжээрээ хуримтлал үүсгэх, хөдөлмөр эрхлэх хүсэл эрмэлзэлгүй болгох эрсдэлтэй байдаг. Тэтгэмжүүдээс хүүхдийн мөнгийг бэлнээр олгодог. Харин МУ-ын нийгмийн халамжийн тэтгэмжийн тухайд 3-2-5 “Нийгмийн халамжийн үйлчилгээний асуудал”-д дурдсанчлан нийгмийн халамжийн дийлэнх хөтөлбөрт бэлэн мөнгөөр тэтгэмж олгодог. Үйлчилгээ хэлбэрээр олгох тэтгэмж тун цөөн байдаг. 7-3 хүснэгтэнд халамжийн тэтгэмжийн арга, онцлогийг Япон, МУ-ын тэтгэмжийн жишээн дээр харуулав.

Хүснэгт 7-3: Халамжийн тэтгэмж олгох арга, онцлог

	Мөнгөн тэтгэмж (бэлэн мөнгө)	Эрхийн бичиг (купон)	Холбогдох байгууллагад төлөх	Үйлчилгээ үзүүлж төлөх
Агуулга	- Хэрэгцээтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг авахад нь зардал олгох. - Зах зээлээс тусгай арга хэрэгслээр дамжуулан нийлүүлж болно. Эсвэл тэтгэмж хүртэгч өөрөө бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ авах боломжтой.	Тэтгэмж хүртэгч нь зах зээл дэх бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнээс тогтсон бүтээгдэхүүн, үйлчилгээг заасан хэмжээгээр авч ашиглах боломжтой.	Тэтгэмж хүртэгчид бэлнээр төлбөрийн мөнгө олгож болох хэдий ч засаг захиргааны байгууллага тухайн тэтгэмж авагчид үйлчилгээ үзүүлсэн аж ахуйн нэгжид шууд төлбөр төлнө.	Засаг захиргааны байгууллага бараа бүтээгдэхүүн үйлчилгээг үйлдвэрлэж, нийлүүлэх механизмыг бүрдүүлж эргэлтэнд оруулах
Японы жишээ	Хүүхдийн тэтгэмж, тэтгэвэр, амьжиргааны тэтгэмж (эмчилгээ, асаргаа хамаарахгүй)	Амьжиргааны тэтгэмж (эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхийн бичиг), купон, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ авах эрхийн бичиг, бүтээгдэхүүн авах гэрчилгээ	Эрүүл мэндийн даатгал, асаргаа сувилгааны даатгал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх цогц дэмжлэг	Цэцэрлэг, асаргаа халамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллага, хүүхдийн асрамжийн газар
МУ-ын жишээ	Нийгмийн халамжийн тэтгэвэр, нийгмийн халамжийн тэтгэмж, хүүхдийн мөнгө, эхчүүд (ганц бие эцэг эхэд) олгох тэтгэмж гэх мэт.	Хүнсний талон	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хөнгөлөлт, хүнсний эрхийн бичиг авдаг иргэдийг шимтгэлээс чөлөөлөх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд хэрэгжиж буй ажлыг байрыг дэмжих хөтөлбөр	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, мэргэжлийн байгууллагын тусламж үйлчилгээ

Давуу тал	• Үйлчилгээ авсан зэргээс үл хамааран тэгш эрхтэй • Чөлөөтэй зарцуулах боломжтой • Удирдлагын зардал (тэтгэмж олгох) бага • Тэтгэмжийн хэмжээг тохируулахад хялбар, уян хатан тогтолцоотой	• Хүртэх ашиг тодорхой • Тухайн хүн ямар зорилгоор хэрэглэхийг тодорхойлох боломжтой.	• Зардал, үр өгөөжийн харьцаа сайн (үйлчилгээтэй холбодог, үргүй зардал гарахгүй) • Орон нутгийн засаг захиргааны байгууллага ашиглаж, зохицуулахад хялбар • Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд тустай • Ажил хөдөлмөр эрхлэх хүсэл эрмэлзлийг төрүүлдэг (бэлэн мөнгөний эрэлт хэрэгцээ үүсгэдэг)
Сул тал	• Зарцуулалт тодорхой бус, зорилгодоо хүрч чадахгүй байх магадлалтай. • Мөнгөн хадгаламж болгож ашиглах магадлалтай. • Ажил хөдөлмөр эрхлэх урам зоргийг бууруулах магадлалтай (тухайлбал эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэнд саад болох)	• Хууль бусаар ашиглах магадлалтай. • Эрхийн бичиг, купон олгох зэрэгт их ажиллагаа шаарддаг. • Ямар нэгэн байгууллагын үйлчилгээг сурталчилсан болж харагдах магадлалтай. • Үйлчилгээ хангалтгүй тохиолдолд үйлчилгээ авч байгаа хүнд ашиггүй байдаг. • Үйлчилгээ авах байгууллагыг сонгох үед өрөөсгөл ойлголт (stigma) бий болгож болзошгүй.	• Тэтгэмж авч байгаа хүнд өөрт нь ашигтай байна гэсэн мэдрэмж сул байдаг. • Үйлчилгээ хангалтгүй тохиолдолд үйлчилгээ авч байгаа хүнд ашиггүй байдаг. • Чөлөөтэй сонголт хийх боломжгүй байдаг. • Удирдлагын зардал өндөр. • Эрэлт, нийлүүлэлтийг тохируулахад хүндрэлтэй. • Үйлчлүүлэх байгууллагыг сонгох үед өрөөсгөл ойлголт (stigma) бий болгож болзошгүй. (цэцэрлэг, яслийн ялгаа)

Эх сурвалж: Японы нийгмийн халамжийн тэтгэмжийн талаар 2021 оны 4 сарын 27 өдөр зохион байгуулсан онлайн семинарын үеэр Тойо их сургуулийн Ябунага профессорын танилцуулсан илтгэлийн материалд тулгуурлан судалгааны баг уг хүснэгтийг боловсруулав.

Японд бэлэн мөнгөөр олгох тэтгэмжийг зорилгоос нь хамаарч “ядуурлаас урьдчилан сэргийлэх тэтгэмж”, “ядуу иргэнд туслах тэтгэмж” гэж хувааж авч үздэг. Ядуурлаас урьдчилан сэргийлэх тэтгэмжийг хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настанд олгодог. Тусгай зардалтай холбоотой ачааллыг багасгах, тодорхой шалтгааны улмаас тэтгэвэрт хамрагдаж чадаагүй хүмүүст туслах зорилготой. Тухайн хүний орлогоос нь шалтгаалж тэтгэмжийг заагтай тогтоодог. Харин Монголд бэлэн мөнгөөр тэтгэмж олгохдоо орлогоос нь шалтгаалж тэтгэмжийг заагтай тогтоодоггүй тул “ядуурлаас урьдчилан сэргийлэх тэтгэмж”, “ядуу иргэнд туслах тэтгэмж” гэж нэг бүрчлэн ялгаж хэлэхэд хүндрэлтэй. Гэхдээ хөрөнгийг нь харгалзан олгодог хүнсний эрхийн бичиг болон хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдагчдад зориулсан эрүүл мэндийн үйлчилгээ, “онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж” нь “ядуу иргэн”-д туслах зорилготой¹³⁹. Үүнээс бусад тэтгэмж нь “ядуурлаас урьдчилан сэргийлэх” зорилготой. Улс орондоо хувь нэмэр оруулсан ахмад настанд олгох тэтгэмж, алдарт эхийн одонтой эхэд олгох тэтгэмж зэрэг “амьжиргааны наад захын хэрэгцээг хангах санхүүгийн дэмжлэг”-ээс ялгаатай тэтгэмжүүд¹⁴⁰ бий. 7-4 хүснэгтэнд шимтгэл төлөлгүй авдаг мөнгөн тэтгэмжийг тусгав.

¹³⁹ ӨАТТА нь өндөр нарийвчлалтай бус, алдаатай бодох магадлалтай тул ядуу иргэнд туслах (урьдчилан сэргийлэх) гэж тэмдэглэв.

¹⁴⁰ “Амьжиргааны наад захын хэрэгцээг хангах санхүүгийн дэмжлэг”-ээс ялгаатай тул (ядуурлаас урьдчилан сэргийлэх) гэж хаалтанд тэмдэглэв.

Хүснэгт 7-4: Япон болон Монголд бэлэн мөнгөөр олгож буй тэтгэмжийн хамрах хүрээ

	Япон			Монгол		
	Зорилго	Тэтгэмж	Орлогоос нь хамаарч ялгаатай тогтоох	Зорилго	Тэтгэмж	Орлогоос нь хамаарч ялгаатай тогтоох
Шимтгэл төлөлгүй авдаг тогтмол тэтгэмж	Ядуурлаас урьдчилан сэргийлэх тэтгэмж	Хүүхдийн тэтгэмж	Бий	Ядуурлаас урьдчилан сэргийлэх	Нийгмийн халамжийн тэтгэвэр	Байхгүй
		Хүүхэд асарч өсгөх тэтгэмж		Ядуурлаас урьдчилан сэргийлэх, ядуу иргэнд туслах	Нийгмийн халамжийн тэтгэмж	
		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч өсгөх тусгай тэтгэмж		(Ядуурлаас урьдчилан сэргийлэх)	Одонтой эхэд олгох тэтгэмж	
		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэтгэмж		Ядуурлаас урьдчилан сэргийлэх	Хүүхдийн тэтгэмж	
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусгай тэтгэмж			Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	
		Тэжээгчээ алдсаны тэтгэмж (эх, хүүхдийн халамж)			Мэргэжлийн байгууллагын асрамжийн үйлчилгээ	
		Биеийн болон оюуны бэрхшээлтэй иргэнд асарч туслах	Хөгжлийн бэрхшээлтэй хүний асран хамгаалагч сар бүр тогтмол төлөх шимтгэл (хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тэтгэвэрийн шимтгэл) ийг хөнгөлдөг	Ядуу иргэнд туслах (Ядуурлаас урьдчилан сэргийлэх)	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдагчдад зориулсан эрүүл мэндийн үйлчилгээ	
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэний суурь (халамжийн) тэтгэвэр	Бий	Ядуурлаас урьдчилан сэргийлэх	Эхчүүдэд олгох тэтгэмж	
		Тусгай хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэмж, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэмж		Ядуурлаас урьдчилан сэргийлэх	Ахмад настны тэтгэмж, хөнгөлөлт	
		Өндөр настны халамжийн тэтгэвэр		(Ядуурлаас урьдчилан сэргийлэх)	Улс орондоо хувь нэмэр оруулсан ахмад настанд олгох тэтгэмж	

		Тэтгэвэр авагчдад дэмжлэг үзүүлэх тэтгэмж		Ядуурлаас урьдчилан сэргийлэх	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст олгох тэтгэмж	
	Ядуу иргэнд туслах тэтгэмж	Амьжиргааны тэтгэмж	Орлого, өмчийн дүнгээс хамааран зааг тогтоодог	Ядуу иргэнд туслах (Ядуурлаас урьдчилан сэргийлэх)	Хүнсний эрхийн бичиг	Өмчийн дүнгээс хамааран зааг тогтоодог

Эх сурвалж: Японы нийгмийн халамжийн тэтгэмжийн талаар 2021 оны 4 сарын 27 өдөр зохион байгуулсан онлайн семинарын үеэр Тойо их сургуулийн Ябунага профессорын танилцуулсан илтгэлийн материалд тулгуурлан судалгааны баг уг хүснэгтийг боловсруулав.

Энэ мэтчилэн Японд халамжийн бүх тэтгэмжинд тухайн хүний орлогоос шалтгаалан нарийн зааг тогтоосон байдаг бол Монголд зөвхөн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээн дээр орлого, хэрэглээг нь үндэслэж хамруулах эсэхээ шийддэг. Төсвийн зарлага нэмэгдэж буйтай уялдаад цаашид Монголд тухайн хүний тэтгэмжийг орлогоос нь хамаарч ялгаатай тогтоох арга нэвтрүүлэх магадлал өндөр байна. Гэхдээ Монголд албан бус салбарт ажиллаж буй хүмүүсийн орлогыг тодорхойлоход хүндрэлтэй, орлогоос нь хамаарч ялгаатай тэтгэмж тогтооход амаргүй. Орлогыг нь үнэн зөв тодорхойлохоос өмнө орлогын шатлал тогтоовол шударга бус мэтээр ойлгогдож, албан бус салбар руу шилжих хүмүүсийг нэмэгдүүлж болзошгүй. Халамжийн тэтгэмжийн шинэчлэлийг татварын системтэй уялдуулах шаардлагатай.

③ Амьжиргааны тэтгэмжийн тогтолцоо

Японд амьжиргааны тэтгэмжийг бэлэн мөнгөөр олгодог. Тухайн хүний орлого, хөрөнгө болон бусад тэтгэмжийг хамруулаад тооцоход амьжиргааны доод түвшингээс доогуур байвал улсаас амьжиргааны доод түвшинг баталгаажуулах тэтгэмж олгодог. Амьжиргааны доод түвшнийг баталгаажуулах зардалд өдөр тутмын амьжиргааны зардал, байрны түрээс, хичээлийн хэрэгслийн зардал, эмчилгээний зардал (бодит гарсан зардал), асрамжийн зардал (бодит гарсан зардал), төрөх ээжид үзүүлдэг мөнгөн тэтгэмж, мэргэжлийн сургалтын зардал, оршуулгын зардал зэрэг найман төрлийн зардлыг оруулж тооцдог. Орон нутгаас хамааран бараа бүтээгдэхүүний үнэ ялгаатай байдаг тул тухайн хүний амьдардаг орон нутгаас хамааран амьжиргааны доод түвшний зардал ялгаатай байдаг.

Тухайн хүн ажил хийж орлоготой болвол тэр хэмжээгээр амьжиргааны тэтгэмжийн хэмжээ буурдаг. Иймд хөдөлмөр эрхлэх хүсэл эрмэлзэл буурч болзошгүй тул хөдөлмөр эрхлэлтийг



Зураг 7-1: Цалингийн орлогоос тодорхой хувиар хасч, үлдсэн дүн дээр нь тэтгэмж тооцох арга

Эх сурвалж: Японы нийгмийн халамжийн тэтгэмжийн талаар 2021 оны 4 сарын 27 өдөр зохион байгуулсан онлайн семинарын үеэр Тойо их сургуулийн Ябунага профессорын танилцуулсан илтгэлийн материал

дэмжих урамшуулал (татвар хөнгөлдөг) -ын тогтолцоог нэвтрүүлсэн байдаг. Тэтгэмж авдаг иргэдийн хөдөлмөр эрхлэх хүсэл эрмэлзлийг алдагдуулахгүйн тулд хөдөлмөрлөж олсон орлогод бүхэлд нь татвар ногдуулалгүйгээр тодорхой хувьд нь татвар тооцдог. Татварын суутгалын хэмжээ нь орлогын хэмжээнээс хамаарна. 7 зурагт татварын суутгалын бүтэц болон суутгалын хувь хэмжээг харуулав. Амьжиргааны тэтгэмжийн нэг зорилго нь бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх юм. Тэтгэмжээс хамааралгүй бие даан амьдардаг болгоход чиглэсэн дэмжлэг (үйлчилгээ) үзүүлдэг. Ийм зорилгоор хэрэгждэг эмзэг бүлгийн иргэд бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх тогтолцооны талаар дор тайлбарлав.

Тэтгэмж олгох арга, агуулга харилцан адилгүй байдаг тул ерөнхийд нь харьцуулалт хийх боломжгүй юм. Гэхдээ харьцуулж үзвэл, МУ-ын “хүнсний эрхийн бичиг” хөтөлбөр нь Японы амьжиргааг хамгаалах тэтгэмжтэй төстэй. Мөн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдагчдад зориулсан эрүүл мэндийн үйлчилгээ нь Японы эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээ (амьжиргааны доод түвшинд амьдарч буй хүмүүст эмнэлгийн үзлэг, эм эмийн бүтээгдэхүүний төлбөр, мэс заслын зардал, эмнэлэгт хэвтэх, сувилуулах зэрэгт олгох тэтгэмж)-тэй төстэй гэж хэлж болно. МУ-ын нийгмийн халамжийн “онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж” нь дор дурдах Японы эмзэг бүлгийн иргэд бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх “онцгой үеийн тусламж”-тэй төстэй байдаг.

Гэхдээ Монголд тэтгэмж олгохдоо тухайн иргэний орлого болон амьжиргааны хамгийн наад захын зардлыг нарийвчлан тооцдоггүй, бараа бүтээгдэхүүний үнээс хамааран орон нутагт тэтгэмжийг ялгаатай тогтоодоггүй, бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг хослуулж, татварын хөнгөлөлт зэрэг урамшууллын арга хэрэглэдэггүй зэрэг Японы амьжиргааны тэтгэмжээс ялгаатай зүйл олон бий.

Гуравдугаар бүлэгт дурдсанчлан Монголд ӨАТТА болон нийгмийн халамжийн тэтгэмжинд хамрагдах иргэнийг зөв тогтоож чаддаггүй нь шүүмжлэлд өртдөг тул шинэчлэл хийх шаардлагатай. Нарийн шалгууртай, шударга тогтолцоог бүрдүүлэхэд анхаарч ирсэн Японд хүртэл “тэтгэмжээс орхигдох¹⁴¹”, эсвэл “хууль бусаар тэтгэмж авах” тохиолдол гардаг тул “амьжиргааны тэтгэмжийг шүүмжлэх” явдал гардаг. Амьжиргааны тэтгэмж, хүнсний талон хөтөлбөр нь иргэд эрүүл, наад захын хэрэгцээгээ хангаж амьдрахад улсаас амьжиргааг нь баталгаажуулах хамгийн сүүлийн шатны арга хэмжээ юм. Иймд хүнсний эрхийн бичгийн тогтолцоо болон хамрагдах хүрээг шинэчлэн тогтоохдоо маш болгоомжтой хандах хэрэгтэй. Ард иргэдийн санаа бодол, орчин нөхцөлтэй уялдуулан хамгийн оновчтой байдлаар тодорхойлох нь зүйтэй. Юуг хэрэгжүүлэх боломжтой, ямар арга үр дүнтэй болох талаар нухацтай хэлэлцүүлэг, судалгаа хийх нь чухал юм.

④ Эмзэг бүлгийн иргэд бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх тогтолцоо

Монголд нийгмийн халамжийн санхүүгийн тогтолцоог эрүүлжүүлэх, ядуу, эмзэг бүлгийн иргэдэд дэмжлэг үзүүлэхэд Японы “Эмзэг бүлгийн иргэдийг бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх

¹⁴¹ Тусламж шаардлагатай иргэнд амьжиргааны тэтгэмж хүрэхгүй буюу “тэтгэмжээс орхигдох” тохиолдол гардаг. Амьжиргааны тэтгэмжийг авах нь “ичгүүртэй хэрэг” гэж үзэн, амьдрал нь хүнд байсан ч өөрөө хүсэлт гаргадаггүй хүмүүс байдаг нь “тэтгэмжээс орхигдох” шалтгаан болох тохиолдол ч бий.

тогтолцоо”¹⁴² туршлага болно. Японд “тусламж авах шаардлагатай хүн өөрөө хүсэлт гаргах”, эсвэл “хүсэлт гаргасан хүн бүрт нэгэн адил үйлчилгээ үзүүлэх” уламжлалт арга бус “тухайн хүнд нь нийцсэн үйлчилгээ” үзүүлэх арга барил руу шилжсэн¹⁴³. Амьжиргааны тэтгэмж авах, ядууралд өртөх эрсдэлтэй хүмүүс цаашид өсөхөөс урьдчилан сэргийлж, бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх зорилгоор уг тогтолцоог нэвтрүүлсэн. Хөдөлмөр эрхлэх чадвар, бие, сэтгэцийн эрүүл мэнд, тухайн орон нутгийн байдал болон бусад бусад нөхцөл байдлаас болж санхүүгийн хувьд хүнд байдалд орсон, хамгийн наад захын амьдралын хэрэгцээгээ хангах чадваргүй болсон хүмүүсийг уг тогтолцоонд хамруулдаг. 7-2 зурагт Японы бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх тогтолцооны тоймыг тусгав.



Японд ядуу эмзэг бүлгийн иргэдэд зөвхөн мөнгөн тэтгэмж өгөх бус, тухайн хүн бүрийн нөхцөл байдалд нь нийцүүлсэн, цогц, тогтвортой, хүндээ хүрсэн нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулсаны үр дүнд тэтгэмж авагчдын тоог бууруулж чадсан.

¹⁴² Японы нийгмийн хамгаалал нь нийгмийн даатгал болон даатгалын шимтгэлээс ихээхэн хамааралтай байдаг. Хөдөлмөрийн насны хүн ам харьцангуй цөөрч буйтай уялдан шимтгэл төлж чадахгүй иргэд олширч, төрөөс хариуцах зардал их хэмжээгээр нэмэгдсэн тул Засгийн газар бонд гаргаж нөхдөг. Иймд төрийн ачаалал нэмэгдэхээс сэргийлэхийн тулд дунд, урт хугацааны бодлого хэрэгжүүлэх шаардлагатай болсон бөгөөд уг бодлогын хүрээнд эмзэг бүлгийн иргэд бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх тогтолцоог нэвтрүүлсэн.

¹⁴³ Ритсумейкан их сургуулийн Бодлого судлалын нийгэмлэг (2019) Хироюки Мори "Эмзэг бүлгийн иргэд бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг төсөв санхүү талаас харж дүгнэх нь" https://ritsume.repo.nii.ac.jp/?action=pages_view_main&active_action=repository_view_main_item_detail&item_id=5270&item_no=1&page_id=13&block_id=21 (мэдээлэл авсан огноо: 2021-6-16)

Японы нийгмийн хамгааллын систем нь олон давхарга бүхий нийгмийн халамж, хамгааллын сүлжээтэй, орон нутгийн системтэй тогтолцоогоор дамжин хэрэгждэг. Ерөнхийдөө ашгийн бус хувийн байгууллагууд үйлчилгээ үзүүлдэг. Нийгмийн халамжийн корпорациуд болон ашгийн бус байгууллагуудын бүтээлч үйл ажиллагаа, ашгийн төлөө компаниудын оролцоо нь үйлчилгээний олон төрлийн эрэлт хэрэгцээг хангадаг.

Хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлдэг зөвлөх үйлчилгээ нь бие, сэтгэцийн эрүүл мэндийг сайжруулж хамгаалах, бие дааж амьдрах, нийгмийн харилцаанд оролцох, хөдөлмөр эрхэлж эдийн засгийн хувьд хараат бус болоход зайлшгүй чухал.

Гурав, дөрөвдүгээр бүлэгт дурьдсанчлан Монголд нийгмийн халамжийн үйлчилгээг хэрэгжүүлэхэд нийгмийн ажилтан акт үйлдэх, үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээг тодорхойлох ажлыг голлож хариуцдаг. Мөн судалгаа хийж, тэтгэмж авагчийн гэрт очиж уулздаг. ОНОТХҮ болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хувийн хэвшилтэй хамтран ажиллаж, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх шинэ санаачилга гаргаж ажилладаг тул Японы "ядуу амьдралтай иргэдийг дэмжих тогтолцоо"-ноос санаа аван МУ-ын бодит нөхцөлд тохирсон системийг бүрдүүлэх бүрэн боломжтой.

Японд хэрэгжүүлж буй эмзэг бүлгийн иргэдийг бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх тогтолцоог Монголд нэвтрүүлэхэд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Дор дурдсан үйл ажиллагаа нь наймдугаар бүлэгт дурдсан “Эмзэг бүлгийн иргэд бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээний тогтолцоог сайжруулах төсөл”-ийн агуулгад хамаарна.

- Эмзэг бүлгийн иргэд (голчлон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдах иргэд)-ийн бодит нөхцөл байдал, эрэлт хэрэгцээг судлах шаардлагатай. Судалгаагаар тэтгэмжинд хамрагдах иргэдийг зөв тодорхойлох асуудлыг шийдвэрлэнэ.
- Бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээний тухай хууль, төлөвлөгөө боловсруулна. Уг төлөвлөгөөнд тулгуурлан үйлчилгээний гарын авлага боловсруулна. Уг гарын авлагад үйлчилгээ үзүүлэх аргачлал, шат дараалал, үйлчилгээнд анхаарах зүйл, хувийн хэвшлийн болон бусад байгууллагын хамтын ажиллагаа, нийгмийн халамжийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нийгмийн ажилтны (community social worker) хариуцах ажил, зөвлөх үйлчилгээ, тэтгэмжийг оновчтой болгох аргачлал, тухайн хүний эрэлт хэрэгцээнд нийцүүлэн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах аргачлал, мониторинг, үнэлгээний арга, шилдэг туршлагын талаар тусгана.
- Бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээг хэрэгжүүлэх орон нутгийн алба (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар)-ын чиг үүрэг, хариуцах ажлыг шинээр тодорхойлно. Хариуцах ажилтны үүрэг болон бусад албан хаагчдын хамтын ажиллагааны тогтолцоог сайжруулна.
- Бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээг хэрэгжүүлэх нийгмийн халамжийн ажилтныг бэлтгэж хөгжүүлэх алсын харааг тодорхойлно.
- Эмзэг бүлгийн иргэдэд тулгардаг олон талт асуудлыг шийдвэрлэх, үйлчилгээний нэр төрөл, цар хүрээг тэлэхийн тулд хувийн хэвшлийн байгууллагын үйлчилгээг өргөжүүлэх шаардлагатай.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн эх үүсвэрийн бүтцийг шинэчилнэ. Одоогийн байдлаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн эх үүсвэрийг гадаад иргэд ажиллуулдаг аж ахуйн нэгжийн ажлын байрны төлбөрөөс голчлон бүрдүүлдэг. Иймд аж ахуйн нэгжид ажиллах гадаад иргэдийн тоо буурвал хөтөлбөрийн санхүүжилт хүндрэлтэй болох юм. Энэ мэтчилэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэхэд шийдвэрлэх шаардлагатай асуудлууд бий. Тухайлбал хөтөлбөрийн санхүүжилтийн 50-60 орчим хувийг төрийн сангаас бүрдүүлдэг болгож, хөтөлбөрийг тогтвортой хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөр олгож буй зээлийг буцаан төлүүлэх аргачлалыг сайжруулна. Буцаан төлөгдсөн зээлийн хөрөнгөөр дахин зээл олгож, зээлийн санг эргэлтэнд оруулах аргачлалыг тодорхойлно.
- Хүний нөөцийг хөгжүүлнэ. Тухайлбал, эмзэг бүлгийн хүмүүст дэмжлэг үзүүлэхдээ зөвлөгөө өгч, тухайн хүнд нийцүүлэн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө тусгайлан боловсруулах аргачлалд сургана.
- Бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хяналт шинжилгээ, үнэлгээний аргыг боловсруулна.

⑤ Хувийн хэвшлийн байгууллагын үйлчилгээг өргөжүүлэх боломж

Дөрөвдүгээр бүлэгт дурьдсанчлан улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудал хариуцсан 261 төрийн албан хаагч ажиллаж байна. Халамжийн салбарыг оруулаад 1700 төрийн албан хаагч 2.4 сая гаруй нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагддаг болон ажил хайж буй иргэдэд үйлчилдэг. Ялангуяа суманд ажилладаг ганц нийгмийн ажилтан нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлыг давхар хариуцдаг тул хэт их ажлын ачаалалтай байдаг. Үүнээс гадна ахмад настны асаргаа сувилгааг хариуцах хүний нөөц хомс байна. Илүү чанартай үйлчилгээ үзүүлэхийн тулд төрийн албан хаагч, холбогдох байгууллагын тоог нэмэх шаардлагатай юм. Гэхдээ төрийн албан хаагчийн тоог нэмэх асуудал дээр олон нийт шүүмжлэлтэй ханддаг тул Засгийн газрын хувьд төрийн албан хаагчийн тоог нэмэгдүүлэхэд амаргүй.

Японд нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх болон үйлчилгээг хэрэгжүүлэх явцад үе шаттайгаар хувийн хэвшлийн байгууллагыг оролцуулдаг. Үйлчилгээний үр өгөөжийг нэмэгдүүлэх, үйлчилгээг олон төрөлжүүлэхэд Монголд хэрэглэх боломжтой Японы туршлагыг дор дурдав.

● Нэг цэгийн үйлчилгээний үр өгөөж

Японд Хөдөлмөр зуучлалын төв болон орон нутгийн засаг захиргааны байгууллага хамтран нэг цэгийн үйлчилгээ үзүүлдэг. Нэг цэгийн үйлчилгээ гэдэг нь Хөдөлмөр зуучлалын төвийн ажлын байр зуучилж үнэгүй танилцуулах үйл ажиллагаа болон орон нутгийн улсын байгууллагын нийгмийн халамжийн үйлчилгээг нэг цэгт хэрэгжүүлэх, улсын болон орон нутгийн байгууллагын хамтарсан үйл ажиллагаа ¹⁴⁴ юм. Тухайлбал, Монголд Хөдөлмөр,

¹⁴⁴ ЭМНХХЯ-ны Хөдөлмөр зуучлалын үйл ажиллагаа болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын нэг цэгийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа <https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/0000054171.html> (мэдээ авсан огноо: 2021-06-16)

халамжийн үйлчилгээний газрын халамжийн хэлтэс болон хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс нэг байранд ажиллаж, нийгмийн халамж болон хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зөвлөгөөг нэг цэгт төвлөрч хэрэгжүүлэх боломжтой. Хүний нөөцийг бэлтгэж хөгжүүлэх, бүтэц зохион байгуулалт, үйлчилгээний аргачлалыг сайжруулах шаардлагатай. Японы туршлагаас Монголд нэвтрүүлэх боломжтой.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих: Хувийн зуучлагч компаниар дамжуулан үйлчилгээ хэрэгжүүлэх

Япон хувийн компани байгуулах, шинэ бизнесийг дэмжих тал дээр олон туршлага хуримтлуулсан. Хувийн хэвшлийн шилдэг бизнес шалгаруулах тэмцээн, бизнес эрхлэгчдэд зориулсан сургалт семинар зохион байгуулагдаж, олон жижиг дунд хувиараа бизнес эрхлэгчид төрж гардаг.

Мөн Японы төр, хувийн хэвшлийн хамтарсан байгууллага болон төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны туршлагаас Монголд нэвтрүүлж болно. Тухайлбал Японд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг бий болгох зорилгоор Жендэрийн тэгш эрхийн төв бусад ТББ-тай хамтран эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг дэмжих сургалт семинар зохион байгуулдаг. Түүнчлэн Сангийн яамны харьяанд байдаг хувийн хэвшлийн компани болох Японы Хөгжлийн Банк нь шинээр бизнес эрхлэгчдэд бага хэмжээний зээл олгож, сургалт семинар зохион байгуулах замаар шинэ бизнесийг дэмжиж ажилладаг. Монголд ажлын байр хомс байдаг нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд шийдвэрлэх шаардлагатай асуудал болдог. Ажлын байр шинээр бий болгох, нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн бизнес эрхлэгчдийг дэмжих тал дээр Японы туршлагаас нэвтрүүлэх боломжтой.

- Ахмад настанг асарч сувилах үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн байгууллагыг оролцуулах

Хувийн асрамжийн газар ажиллуулах, гэрээр үйлчилгээ үзүүлэх арга, тэргэнцэр, нөхөн сэргээх эмчилгээний хэрэгсэл, асаргаа, халамжийн хэрэгслийг хэрхэн сонгож, баталгаажуулах, эдгээр хэрэгслийг хэрхэн борлуулах зэрэг асаргааны үйлчилгээтэй холбоотой ноу хау Японд хуримтлагдсан байдаг. Энэ төрлийн үйлчилгээ үзүүлдэг Япон компаниуд МУ-ын хувийн хэвшлийн компани, ТББ-тай хамтран ажиллаж, ноу-хау дамжуулж, хамтран ахмад настанг асарч сувилах үйлчилгээг өргөжүүлэх боломжтой.

⑥ Насжилтын бодлого

Японд асаргааны даатгалын тогтолцоо 2000 оноос хэрэгжиж эхэлсэн. Өмнө нь хууль журмаар хаалттай байсан асрамжийн тусламж үйлчилгээний зах зээлийг хувийн хэвшлийнхэнд нээлттэй болгож, нийлүүлэлтийг нэмэгдүүлж, гэрээр очиж асрамжийн тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг эрчимжүүлсэн. 20 гаруй жилийн түүхтэй асаргааны даатгалын тогтолцооны туршлагаас Монголд санаа авах зүйл олон бий.

Мөн олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн цогц системд гэрээр очиж үйлчлэх үйлчилгээ, эсвэл үйлчлүүлэгч өөрөө асрамжийн газарт тогтмол очиж авах үйлчилгээ,

амьжиргааг дэмжих үйлчилгээ, асрамжийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ (care management) зэрэг төрөл бүрийн үйлчилгээ, орон нутгийн цогц дэмжлэг үйлчилгээний төв ажиллуулах, тусламж үйлчилгээний ажилтан (care manager), асаргаа халамжийн мэргэжилтэн, асаргааны мэргэжлийн ажилтан бэлтгэх туршлагатай тул энэ чиглэлээр хамтран ажиллах боломжтой.

Орон нутгийн зөвлөл, хөршийн холбоо, ахмадын клуб, орон нутгийн орон тооны бус нийгмийн халамжийн ажилтан, сайн дурын бүлгүүд, олон нийтийн сүлжээ үүсгэх, сайн дурын үйл ажиллагааг дэмжих төвүүдийн оролцоотойгоор асаргааны урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээг дэмжиж, сайн дурын үйл ажиллагааг хөгжүүлж ирсэн туршлагаас мөн ашиглах боломжтой.

Мөн цаашид ихсэх хандлагатай байгаа зөнөгрөх өвчин туссан ахмад настныг дэмжих бодлого боловсруулах, ийм ахмад настанд ээлтэй хот хөгжүүлэх, халамжийн төв болон гэрээр үзүүлэх эцсийн шатны халамжийн тогтолцоог бүрдүүлэх, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургах, олон нийтийг соён гэгээрүүлэх гэх мэт Японы туршлагыг ашиглах боломжтой.

7-3 Дунд болон урт хугацааны хамтын ажиллагааны төсөлд ашиглах боломжтой Японы нөөц

Цаашид Японы дунд болон урт хугацааны тусламж, хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд ашиглаж болох хүн болон байгууллагын нөөцийг 7-5 хүснэгтэд харуулав. Уг хүснэгтэд үзүүлсэн нөөц нь тус судалгааны багийн таамаглал дээр үндэслэн тооцсон нөөц тул хамтын ажиллагаа бодитоор хэрэгжих үед өөрчлөгдөж болох юм. Мөн хүснэгтэд тусгасан хүний нөөц, байгууллага нь ашиглах боломжтой нөөц эсэхийг энэ шатанд бүрэн тодорхойлох боломжгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

Хүснэгт 7-5: Ашиглах боломжтой Япон талын нөөц бололцоо (жишээ)


Хамтын ажиллагааны чиглэл, асуудал	Япон талын хүний/байгууллагын нөөц
Эмзэг бүлгийн иргэд бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээ	ЭМНХХЯ, нийгмийн халамжийн хувийн байгууллага, нийгмийн халамжийн үндэсний зөвлөл, АББ “эмзэг бүлгийн иргэд бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үндэсний сүлжээ”
	Тоёо их сургуулийн нийгмийн ухааны факультет/олон улс судлалын факультет, бусад боловсролын байгууллага
	Орон нутгийн засаг захиргаа (Сайтама муж, Осака муж, Мияги муж, Хоккайдо Күширо хот, Миэ муж Михари хот)
	Эмзэг бүлгийн иргэд бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх тогтолцооны хүний нөөцийг бэлтгэх сургалттай холбоо бүхий их сургууль/байгууллага
	Ашгийн бус байгууллага “Sai no kuni” Хүүхэд залуучуудыг дэмжих сүлжээ “Аспот үйл ажиллагаа”)
	Осака муж (Нийгмийн халамжийн хувийн байгууллага, Осака мужийн Нийгмийн халамжийн зөвлөл ”Shiawase network” үйл ажиллагаа)
	Мияги муж (Ашгийн бус байгууллага “Хувийн дэмжлэг үзүүлэх төв”, Бие даан амьдрах/ажил эрхлэх зөвлөгөө өгөх төвийн арга хэмжээ) Мияги муж
	Хоккайдо Күширо хот (Амьжиргааны зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх төв “Курашигото”)
	Миэ муж, Михари хот (Нийгмийн халамжийн зөвлөл “Nabari Kurashi Anshin Center”

	Мэйжи Гакуин их сургуулийн нийгмийн ухааны факультет, нийгмийн халамжийн тэнхим
	Нихон Фүкүши их сургуулийн нийгмийн халамжийн факультетийн нийгмийн халамжийн тэнхим
Эмзэг бүлгийн иргэд бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх тогтолцооны хүний нөөцийг бэлтгэх сургалттай их дээд сургууль/байгууллага	Дожиша их сургуулийн нийгмийн ухааны факультет, нийгмийн халамжийн тэнхим
	Мэйжи Гакуин их сургуулийн Социологийн факультет, нийгмийн халамжийн тэнхим
	Нихон Фүкүши их сургуулийн Нийгмийн халамжийн факультет, нийгмийн халамжийн тэнхим
	Нийгмийн халамжийн хувийн байгууллага “Тоёнака хотын нийгмийн халамжийн зөвлөл”
	Олон нийтийн төлөөх байгууллага “Окинава мужийн ажилчдын халамжийн сангийн нийгэмлэг”, Окинава мужийн “Хувийн дэмжлэг үзүүлэх төв”
	Чиба мужийн Ичикава хот, амьдралыг дэмжих төв “So-ra”
	Ашгийн бус байгууллага Нийгмийн хүртээмжийг дэмжих төв
	Осака бүсийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тасаг
	Ашгийн бус байгууллага “Kusa no ne Sasaei”
	Тусгай эрхтэй ашгийн бус байгууллага “Student support face”
Ахмад настныг дэмжих үйлчилгээг бэхжүүлэх (орон нутгийн халамж)	ЭМНХХЯ, нийслэл муж, хот тосгон, бүс нутгийн цогц дэмжлэгийн төвүүд, эмнэлэг, эрүүл мэндийн төв, эрүүл мэндийн газар, нийгмийн халамжийн зөвлөлүүд, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ/ халамжийн их дээд сургуулиуд, гэрээр асаргааны үйлчилгээ үзүүлэх төвүүд, гэрээр үйлчилгээ үзүүлэх байгууллага, ахмад настнуудын тусгай асрамжийн газрууд, төлбөртэй асрамжийн газар, ахмад настны клуб, ахмад настанд зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээ, богино хугацааны байрлах байр зэрэг.
Асаргааны хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх	ЭМНХХЯ, нийслэл муж, хот тосгон, бүс нутгийн цогц дэмжлэг үзүүлэх төвүүд, асаргааны халамжийн ажилтан зэрэг халамжийн хүний нөөцийг бэлтгэх их дээд сургууль, дадлагын газар (гэрээр асаргааны үйлчилгээ үзүүлэх төв, ахмад настны тусгай асрамжийн газар, хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүст зориулсан байгууламж гэх мэт) зэрэг.
Урт хугацааны тусламж үйлчилгээг бодитоор хэрэгжүүлэх/стратеги боловсруулахад дэмжлэг үзүүлэх	ЭМНХХЯ-ны Ахмад настны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, халамж хариуцсан газар, нийслэл муж, хот тосгоны тусламж үйлчилгээ/ асаргаа хариуцсан хэлтэс, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ/халамжийн их дээд сургууль зэрэг.

Наймдугаар бүлэг. Нэгдсэн дүн шинжилгээ, Японы дэмжлэг, хамтын ажиллагааны боломж

8-1 МУ-ын нийгмийн хамгаалал, халамжийн салбарт шийдвэрлэх шаардлагатай асуудлыг тодорхойлох нь

8-1 зурагт тус судалгааны дүнд тодорхойлсон МУ-ын нийгмийн хамгааллын салбарт тулгарч буй асуудлыг тусгав.



Зураг 8-1: МУ-ын нийгмийн хамгааллын салбар дахь хүндрэл бэрхшээлийг эмхэтгэсэн нь

Ядуурлын асуудал Монголд эртнээс яригдаж ирсэн асуудлын нэг юм. 2020 оноос хойш үргэлжилж буй Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийн нөлөөгөөр коронагийн дараа ч тэгш бус, нийгмийн эмзэг байдал улам газар авч болзошгүй байна.

8-1 хүснэгтэд харуулсанчлан ядуурлыг үүсгэж буй гол шалтгаануудыг дараах 5 өнцгөөс тоймлон тусгав.

- 1) Ядуу иргэд ажиллах боломжтой, бүтээлч ажлын байр хомс
- 2) Нийгмийн даатгалын тогтолцооны асуудал

- 3) Нийгмийн халамжийн тогтолцооны асуудал
- 4) Үйлчилгээний тогтолцооны асуудал
- 5) Хүртээмжгүй байдал гэсэн 5 өнцгөөс тоймлон гаргав.

Монголд ядуу давхаргын хүмүүс ажилд орлоо ч цалин бага, дагалдангийн хугацаанд цалингүй ажилладаг гэх мэт хууль эрх зүйн саад бэрхшээлүүд цөөнгүй бий. Иймд эрсдэл өндөртэй ч гадаадад гарч ажиллан, хуримтлал үүсгэх нь дээр гэж үзэх хүн олон бий. Тогтмол биш, өдрөөр цалинждаг ажил хийдэг хүмүүс нийгмийн даатгалд хамрагдаж, хамгаалуулж чаддаггүй. Ядуу, эмзэг бүлгийн иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн бүтээлч ажлын байр байхгүй байгаа нь тулгамдсан асуудал болоод байна. Хөдөлмөрийн хууль тогтоомж боловсруулах тал дээр ОУХБ, мэргэжлийн сургалтын хувьд ОУХБ, АХБ, ДБ, Өмнөд Солонгос гэх мэт ОУБ, улсууд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Мэргэжлийн сургалтын чиглэлээр хамтарч ажиллах тохиолдолд сургалтын байр, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл бэлтгэх, багш томилох зэрэг ажил нь зардал ихтэй, мөн ашиг хүртэгчид нь хязгаарлагдмал тул Японы талаас мэргэжлийн сургалтын чиглэлд түлхүү анхаарч хамтран ажиллах шаадрлагагүй гэж үзэж байна.

Нийгмийн даатгал, тэтгэвэр олголттой холбоотой асуудлын талаар 2015 онд явуулсан “МУ-ын тэтгэврийн салбарын мэдээлэл цуглуулах судалгаа”-ны тайланд (1) тэтгэврийн тогтолцоог төсөв, санхүүгийн хувьд дахин тооцоолох, (2) тэтгэврийн түвшинг оновчтой болгох (орлого орлуулах хувь хэмжээ зэргийг эргэн харах), (3) нийгмийн халамж зэрэг нийгмийн хамгааллын тогтолцоо болон тэтгэврийн системийн хоорондох тэтгэвэр тэтгэмж дээр зохицуулалт хийх, (4) нийгмийн даатгалд хамрагдах даатгуулагчийг хамгаалах тогтолцоог шинэчлэх, (5) тэтгэврийн санхүүжилтийг тогтворжуулахад чиглэсэн тэтгэврийн сангийн менежментийн оновчтой арга хэлбэрийг судлах, менежментийн аргыг боловсронгуй болгох шаардлагатай талаар дурдсан байв.

Япон нь 2016-2020 онд “Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж, тэтгэврийн менежментийг сайжруулахад хувь нэмэр оруулсан. Тэтгэвэр, халамжийн сангийн төсөв хүндрэлтэй, үйл ажиллагааг нь либералчлах, нийгмийн хамгааллын болон тэтгэврийн тогтолцоо хоорондын тэтгэвэр, тэтгэмж дээр зохицуулалт хийх шаардлагатай байгаа тул энэ асуудлаар хамтран ажиллах эрэлт хэрэгцээ ХНХЯ-нд бий. Гэхдээ одоогийн байдлаар нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчлэл хийгдэж буй ч, тэтгэврийн хууль тогтоомж, тогтолцоог хэрхэн шинэчлэх нь тодорхойгүй, тэтгэврийн сангийн ээдрээтэй санхүүгийн эх үүсвэрт дорвитой зохицуулалт хийх шаардлагатай, мөн өнөөг хүртэлх хугацаанд тэтгэврийн тогтолцооны чиглэлээр ДБ хамтарч ажиллаж ирсэн тул энэ чиглэлээр Япон Улс хамтарч ажиллах шаардлагагүй гэж үзэж байна.

Мөн гуравдугаар бүлэгт дурдсанчлан ядуу өрх амьжиргааны тэтгэмж, хүүхдийн мөнгө, хоол хүнс худалдан авах хүнсний эрхийн бичиг зэрэг олон тэтгэмж зэрэг авдаг тул ажил хийлгүй, амьдраад байх боломжтой болдог. Ийм байдал нь ядуу иргэдийн ажиллах хүсэл эрмэлзэлд сөргөөр нөлөөлөх тохиолдол байдаг.

Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаа нь тухайн өрхийн нөхцөл байдлыг тодорхойлох мэдээлэл авч болох асуулт хангалтгүй байдаг. Иймд тэтгэвэр, тэтгэмж авах хүмүүсийг зөв тодорхойлж чаддаггүй зэргээс болж дэмжлэг туслалцаа үнэхээр хэрэгтэй хүндээ хүрдэггүй. Ковид-19 цар тахлын эсрэг авч буй яаралтай арга хэмжээний улмаас халамжийн зардал 2 дахин

өсч, халамжийн үйлчилгээний ачаалал нэмэгдсэн. ХНХЯ халамжийн тэтгэмжийн хуваарилалтыг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах хэрэгтэй байна гэжээ. Гэвч дээр дурдсанчлан нийгмийн даатгалын тогтолцоо хоорондын тэтгэвэр тэтгэмж дээр зохицуулалт хийх шаардлагатай, тэтгэвэр тэтгэмжинд улс төрийн бодлого их нөлөөлдөг тул тодорхойгүй хүчин зүйл их бий. Иймд Японы зүгээс нийгмийн халамжийн тэтгэмжийн хуваарилалт болон менежментийн чиглэлээр хамтран ажиллах боломжгүй гэж үзэж байна. Энэ талаар дор дэлгэрэнгүй тайлбарлана. Уг судалгаагаар санал болгож буй “бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх төсөл”-ийн хүрээнд тэтгэмжийг зохистой болгохын тулд эмзэг бүлгийн иргэдийг (голчлон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдаж буй иргэд) хэрхэн сонгож хамруулах асуудлыг шийдвэрлэж, зөвлөгөө өгөх үйлчилгээ болон тухайн хүн бүрийн нөхцөл байдалд нийцүүлэн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөг боловсруулан, зорилтот бүлгийн хүмүүс бие даан амьдардаг болоход тус дөхөм болох хамгийн тохиромжтой тэтгэмжийг тодорхойлж, санал болгоно.

Нөгөө талаар нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээний хувьд хүний нөөцийг хөгжүүлэх, хөтөлбөрийг чанаржуулах, дэд бүтцийг боловсронгуй болгох, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, санхүүгийн эх үүсвэрийг баталгаатай болгох, зохистой хуваарилах зэрэг олон арга хэмжээг хэрэгжүүлж, нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулах шаардлагатай. Засгийн газрын "халамж хүртэгчийг хөдөлмөрийн зах зээл рүү шилжүүлэх" бодлогын хүрээнд ХНХЯ-аас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж буй ч ажил эрхлэлтийн түвшин доогуур, үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн ажилд зуучлах үйлчилгээ үзүүлж чаддаггүй, ажилд орсны дараах дэмжлэг хангалтгүй байдаг тул эдгээр үйл ажиллагааны аргачлалыг сайжруулах шаардлагатай байна.

Уг судалгаагаар Японд ядуу амьдралтай иргэдийг бие даахад үзүүлдэг дэмжлэг тусалцааны аргачлалыг Монголд ашиглах боломжийн талаар судлав. МУ-ын нөөцөд тулгуурлан, бодит нөхцөл байдалд нь тохирсон хөтөлбөр хэрэгжүүлж, ядуу, эмзэг бүлгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд тодорхой үр дүнтэй хамтарч ажиллах боломжтой. Монголд энэ чиглэлийн хэрэгцээ шаардлага өндөр байгаа тул Японы туршлагыг ашиглах боломжтой.


Японы хөгжлийн албан ёсны тусламж нь тухайн улсын нөхцөл байдалд нийцсэн арга барилаар хэрэгждэг, тодорхой технологи дамжуулахад голлож анхаардаг онцлогтой тул хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг боловсронгуй болгох, загварчлахад дорвитой хувь нэмэр оруулах боломжтой.

Мөн ахмад настныг дэмжих тал дээр өндөр настны орон болох Японд туршлага их бий. Асаргааны чиглэлийн хүний нөөц бэлтгэх, олон нийтийн оролцоонд түшиглэсэн цогц халамжийн тогтолцоог хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах боломжтой. Монголд асаргаа сувилгаанд хамрагдах шаардлагатай хүмүүст үйлчлэх асрамжийн газрын орны тоо 500 хүрэхгүй байдалтай байна. Ахмад настны асрамжийн газрыг хөгжүүлэх тал дээр Японтой хамтарч ажиллах өндөр хүлээлттэй байна. Монголд ахмад настны тоо нэмэгдсээр байгаа тул Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс урт хугацааны асрамжийн үйлчилгээний алсын харааг тодорхойлж эхлээд байна. Өнөөг хүртэл АХБ-ны зүгээс энэ чиглэлийн дэмжлэг үзүүлж ирсэн. Гэхдээ алсын харааг бодитой хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг хэрхэн хангах, ирээдүйд ямар өндөр настны нийгэм болон хүний нөөцтэй болохыг төлөвлөж буй талаар ерөнхий дүр зураг тодорхой гараагүй байна. Ийм

нөхцөлд техникийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэхээс илүүтэйгээр ахмад настанд чиглэсэн үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэхэд хамтран ажиллах нь зохистой юм.

8-2 Асуудал шийдвэрлэх замын зураглал

Дээр дурдсан шийдвэрлэх асуудал болон судалгааны үр дүнд тулгуурлан Японы нийгмийн хамгааллын салбарын дунд, урт хугацааны хамтын ажиллагааны зураглалыг 8-2 зурагт үзүүлэв.



Зураг 8-2: Нийгмийн хамгааллын салбар дахь ЖАЙКА-ийн дунд, урт хугацааны хамтын ажиллагаа (төсөл)

Японы Монголд хэрэгжүүлэх хөгжлийн хамтын ажиллагааны "Тэргүүлэх чиглэлд заасан (3) Нийгэмд хүртээмжтэй байх" зарчимд тулгуурлан иргэд эдийн засгийн хөгжлийн үр шимийг хүртэхүйц, нийгмийн нөхцөлд тохирсон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандартыг бүрдүүлэх, нийгмийн суурь үйлчилгээний чанарыг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоо, нийгмийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. ЖАЙКА нь хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл 3-3-т дурдсан нийгмийн хамгааллын салбарыг дэмжих зорилгоор "хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоо, нийгмийн хүртээмжийг дэмжих" чиглэлээр ажиллаж байна. МУ-ын эдийн засаг 2019 он хүртэл өсөлттэй гарсан ч, баян

хоосны ялгаа ихэсч, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоо хангалтгүй байна. Сургуулийн өмнөх насанд нь хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэхээс эхлээд боловсрол эзэмших боломж олгох, өдөр тутмын амьдралын хүртээмжтэй байдлыг хангах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүртэлх өргөн хүрээнд асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Бодлогыг шийдвэрлэхэд шаардлагатай статистик мэдээлэл хангалтгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн халамжийн тэтгэвэр авагчид болон сургуулийн насны хүүхдүүдийн авах мэдээлэл хязгаарлагдмал байгаа нь нэг том саад болж байна. Мөн 2020 онд дэлхий даяар тархаж буй Ковид-19 цар тахлын үед онлайн хичээлд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн мэдээллийн хүртээмжийг сайжруулах шаардлагатай байна. Өнөөг хүртэл хэрэгжүүлж ирсэн хамтын ажиллагааны дүнд тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ядуу, эмзэг бүлгийн иргэдэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг улам өргөжүүлэх шаардлагатай.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд үзүүлж ирсэн дэмжлэг, хамтын ажиллагаанд тулгуурлан хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэн, зорилтот бүлгийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, хүн бүр нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг хүртэх, бүх нийтийг хамарсан нийгмийн хамгаалал (USP: universal social protection)-ыг бүрдүүлэхийн тулд Монголд тулгараад буй ядуурлын асуудлыг илүү цогц байдлаар шийдвэрлэх шаардлагатай байна. Дунд, урт хугацааны хамтын ажиллагааны төлөвлөгөө (замын зураг)-г 8-2 зурагт харуулав. Хамтын ажиллагааг дараах 2 чиглэлээр тодорхойлов. 1) Нийгмийн эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн нийгмийн оролцоог дэмжих, 2) Ядуу, эмзэг бүлэгт дэмжлэг тусалцаа үзүүлэх аргачлалыг сайжруулахын тулд нийгмийн хамгааллын үйлчилгээний системийг бэхжүүлэх (суурийг бүрдүүлэх)

Тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээнд нийцсэн хөгжлийг дэмжих загвар боловсруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт оношилгоо, хөгжлийн дэмжлэг, тусгай хэрэгцээт боловсрол олгох чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр төсөл хэрэгжүүлэх механизм бүрдүүлэх, хүний нөөцийг бэлтгэж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьжиргаа болон нийгмийн оролцоог дэмжинэ.

Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай систем, механизмыг бий болгох, хүний нөөц бэлтгэх замаар нийгмийн хамгааллын үйлчилгээний тогтолцоог бүрдүүлж, бэхжүүлэхэд хамтарч ажиллана. Эмзэг, ядуу иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх зорилгоор ядуу амьдралтай иргэдийг бие даахад дэмжлэг үзүүлдэг Японы туршлагаас нэвтрүүлж, Монголд нийцсэн загварыг боловсруулах, төр хувийн хэвшлийн түншлэлийн тогтолцоог бий болгох замаар нийгмийн хамгааллын үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэхэд хамтарч ажиллана. Мөн ахмад настныг дэмжих үүднээс улсын асаргааны тусламж үйлчилгээний бодлогын чиглэлийг тодорхойлоход дэмжлэг үзүүлж, төрийн үйлчилгээ үзүүлэх чанарын болон тооны шаардлага хангасан хүний нөөцийг хөгжүүлэх системтэй тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар асрамжийн тогтвортой системийг санал болгоно.

8-3 Японы хамтын ажиллагааны чиглэл, хэрэгжүүлэх боломжтой төслийн санал

8-1 хүснэгтэнд уг судалгааны үр дүн болон ХНХЯ-ны хэрэгцээнд тулгуурлан хэрэгжүүлэх боломжтой төслийн чиглэлийг тусгав.

Хүснэгт 8-1: Тусламж дэмжлэг үзүүлэх боломж

Бодит дэмжлэг туслалцааны чиглэл	Анхаарах зүйл	Донор байгууллагын тусламж дэмжлэг	Дэмжлэг үзүүлэх боломж
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх (эмзэг бүлгийн иргэд бие даан амьдрахад үзүүлэх дэмжлэгийг нэвтрүүлэх)	Хэрэгцээ өндөр	Хэрэгжүүлж байсан туршлагатай. Гэхдээ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн загварыг сайжруулах ажил хийгдэж эхлээгүй байна	Байгаа
Хамрагдах хүрээ, халамжийн тэтгэмж олгох ажиллагааг зохистой болгоход дэмжлэг үзүүлэх	Хэрэгцээ өндөр. Япон туршлагатай ч хэрэгжүүлэхэд асуудалтай.	ООТА-ыг сайжруулах тал дээр дэмжлэг үзүүлж байгаа.	Дунд зэрэг
Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлэх	Хэрэгцээ өндөр	Дэмжлэг үзүүлж байгаа, гэхдээ удирдамж/үнэлгээ боловсруулах ажил хоцрогдолтой байгаа.	Байгаа
Мэдээлэл холбооны технологийн тусламжтайгаар үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Зардал өндөр, хийж буй ажил байгаа.	Байгаа	Бага
Нийгмийн халамжийн ажилтны чадавхийг дээшлүүлэх (магадлан итгэмжлэх тогтолцоо)	Ажил эрхэлж байгаа хүний нөөц нь тодорхой бус	Байгаа боловч хөрөнгө бага.	Бага (ирээдүйд)
Ахмад настанд дэмжлэг үзүүлэх үйлчилгээг сайжруулах (бүс нутгийн халамж)	"Олон нийт" гэдэг ойлголт сул	Байхгүй	Дунд зэрэг
Асаргааны хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх	Хэрэгцээ өндөр боловч, төрөөс асаргааны хүний нөөцийн талаар баримтлах чиглэл тодохой болоогүй.	Туршлагатай ч тогтвортой бус	Дунд зэрэг
Урт хугацааны тусламж үйлчилгээг практик хэрэглээ болгох, стратеги боловсруулахад дэмжлэг үзүүлэх	Энэ ажлыг нэн тэргүүнд хийх шаардлагатай.	Байгаа хэдий ч стратеги боловсруулах ажил дутуу.	Байгаа
Ахмад настанд дэмжлэг үзүүлэх байгууллага барьж байгуулах	Хэрэгцээ өндөр	Хэсэгчилсэн ажил хийгдсэн.	Байгаа
JOCV (нийгмийн халамжийн салбар)	Хэрхэн хослуулахаас шалтгаална.	————	Байгаа

Ядуу, эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн дэмжлэг туслалцааг сайжруулахын тулд Монголд хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн техникийн хамтын ажиллагааны саналыг ① ядуу, эмзэг

бүлгийн иргэдэд үзүүлэх дэмжлэг (бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээг нэвтрүүлэх)

② ахмад настныг дэмжих бодлогын талаас нэгтгэн оруулав.

① Ядуу, эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх дэмжлэг (бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээг нэвтрүүлэх)

Хоёрдугаар бүлэгт дурдсанчлан Монголд ядуурлын түвшин 2018 онд 28.4% болж 2016 оны 29.6%-аас ялимгүй буурсан. Гэвч "ядуурлын занга"-наас гарч чадахгүй байгаа иргэд олон хэвээр байна. МУ-ын Засгийн газар нийгмийн халамжийн тогтолцоог бүрдүүлж, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, "Хүүхдийн мөнгө", "Хүнсний эрхийн бичиг" хөтөлбөр зэрэг нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлж байна. Эдгээр тэтгэмж нь ихэвчлэн бэлэн мөнгөөр олгогддог бөгөөд ядуу амьдралтай иргэдийн нийгмийн оролцоо, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтвортой, үе шаттай ажлууд (зөвлөгөө өгөх, тухайн хүний нөхцөл байдалд нь нийцүүлэн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах, хөтөлбөрийн дараах дагалдах үйлчилгээ гэх мэт) хангалтгүй, тухайн хүнтэй тулж ажиллаж чадахгүй байна¹⁴⁵. Тухайлбал дөрөвдүгээр бүлэгт дурдсанчлан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хүн бүрийн ялгаатай орчин нөхцөлд нь нийцүүлэн үйлчилгээ үзүүлж чаддаггүй. Иймд тухайн хүний нөхцөлд тааруулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ганцаарчилсан зөвлөх үйлчилгээ үзүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдах иргэнд олгох тэтгэмжийг зохистой болгох шаардлагатай.

ХНХЯ "ажил эрхлэлт" ба "нийгмийн хамгаалал, нийгмийн халамж"-ийг хооронд нь холбож, ядуу амьдралтай иргэдийг бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх тогтолцоог сайжруулахаар төлөвлөж байна. Үүнд нийгмийн халамжийн үйлчилгээ авч буй хүмүүс бие даан амьдрахад туслах хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ хамаарна. Ялангуяа, ядуу амьдралтай эмзэг бүлгийн хүмүүстэй (хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдах иргэн хамаарна) тулж ажиллан, тэдэнд ойр дотно дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдах иргэн зээлэнд баригдахаас сэргийлж, тодорхой орлогын эх үүсвэртэй болгох богино хугацааны зорилго талаас хараад үзсэн ч, мөн улсын төсвийн зардал хэт ихэсхээс сэргийлэх урт, дунд хугацааны бодлого талаас аваад үзсэн ч чухал арга хэмжээ юм.

Япон нь нийгмийн халамж болон нийгмийн даатгал (хөдөлмөр эрхлэлт)-ын хооронд нийгмийн халамж, хамгааллын "Ядуу амьдралтай иргэдийг бие даахад дэмжлэг үзүүлэх тогтолцоо"-г бүрдүүлж, хүндээ хүрсэн, үе шаттай системийг хөгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн хувь хэмжээ, болон эмзэг бүлгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлж, үр дүнд хүрч чадсан. Монголын нөхцөлд тохируулан өөрчилж, 7-2 "Монголын нийгмийн хамгаалал, халамжийн салбарт Японы туршлагыг ашиглах боломж"-ийн ④ "Ядуу амьдралтай иргэдийг бие даахад дэмжлэг үзүүлэх тогтолцоо"-нд дурдсан шиг суурь хөрс нь бүрдсэн Монголын хувьд хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Халамжаас хөдөлмөр эрхлэлт рүү шилжүүлэх засгийн газрын бодлого, ХНХЯ-наас гаргаж буй хүсэлт, хэрэгжүүлэх боломж зэргийг цогцоор нь дүгнээд, ядуу, эмзэг бүлгийн иргэд бие даан амьдрахад

¹⁴⁵ Долоодугаар бүлэгт нийгмийн халамжийн тэтгэмжийн талаар дурдсанчлан Японы нийгмийн халамжийн тогтолцоо нь ихэвчлэн үйлчилгээ үзүүлэх хэлбэрээр хэрэгждэг. Нийгмийн даатгалаас бусад тэтгэмжийг бэлэн мөнгөөр тэр болгон өгдөггүй. Зөвхөн хүүхдийн тэтгэмж, амьжиргааны тэтгэмжийг бэлэн мөнгөөр олгодог. Амьжиргааны тэтгэмж олгохдоо бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээг зэрэг хэрэгжүүлдэг.

дэмжлэг үзүүлэх үйлчилгээ нэвтрүүлэх чиглэлээр дэмжлэг тусалцаа үзүүлэх нь үр дүнд хүрнэ гэж үзэж байна.

Алсдаа Японы тогтолцоо, туршлагаас танилцуулж, үндэсний хэмжээнд нийгмийн халамжийн чиглэлээ тодорхойлох урт хугацааны бодлого боловсруулах тал дээр дэмжлэг үзүүлэх нь зохистой юм. Ялангуяа бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээний тал дээр, дэмжлэг үзүүлэх ганцаарчилсан төлөвлөгөөг багтаасан эмзэг бүлгийн иргэдийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээний агуулга/үйлчилгээг хүргэх арга/хөтөлбөрүүдийг сайжруулж, хүний нөөцийг бэлтгэх зэргээр халамж ба хөдөлмөр эрхлэлтийг холбон уялдуулж, туршилтын төсөл зэргийг хэрэгжүүлсэнээр дунд, урт хугацаанд харж, үйлчилгээний системийг сайжруулахыг зорьж ажиллах шаардлагатай. Туршилтын төслийн хувьд дараах агуулгыг багтаахыг санал болгож байна.

- Ядуу, эмзэг бүлгийн иргэдийн бодит байдал, хэрэгцээг тодорхойлох судалгаанаас гадна нийгмийн ажилтан зэрэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж буй хүний нөөц/байгууллагад тулгарч буй хүндрэл бэрхшээлд дүн шинжилгээ хийнэ. Мөн уг судалгаагаар, ядуу, эмзэг бүлгийн иргэдийн авч байгаа үйлчилгээ, тэтгэмжид дүн шинжилгээ хийж, ядуу, эмзэг бүлгийн иргэд бие даан амьдрах зохистой тэтгэмжийн талаар судалж үзэх үйл ажиллагааг мөн багтаана. Бас хязгаарлагдмал төсвийг үр дүнтэй зарцуулахын тулд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүжилтийн бүтэц, ядуу, эмзэг бүлгийн иргэдэд олгож байгаа мөнгөн тусламжийн бодит байдалд дүн шинжилгээ хийх ажлыг багтаах нь чухал юм.
- Бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээ үзүүлэх удирдамж боловсруулж гаргана. Үйлчилгээ үзүүлэх удирдамж гэдэг нь үйлчилгээ үзүүлэх шат дараалал, анхаарах зүйлс, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, бусад байгууллагатай хэрхэн хамтарч ажиллах тухай, олон нийтийн нийгмийн ажлыг хэрэгжүүлэх аргачлал, зөвлөгөө өгөх үйлчилгээ, тэтгэмжийн зохистой байдлыг багтаасан дэмжлэг үзүүлэх ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулах аргачлал, мониторинг/үнэлгээний арга, сайн жишээ зэргийг тусгасан зүйл юм.
- Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, газрын ажилтнууд зэргийн нийгмийн ажилтанд зааж сургах чадварыг дээшлүүлэх, нийгмийн ажилтны ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилго бүхий чадавхи дээшлүүлэх сургалтыг хэрэгжүүлнэ. Хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр, сургалтын материал зэргийг боловсруулж, бие даан амьдрахад дэмжлэг болох үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэлтгэнэ.
- Бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээг нэвтрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавихын тулд туршилтын төслийг нийслэл Улаанбаатарт хэрэгжүүлнэ. Боломжтой бол, нийслэлээс очиход зам харгуй боломжийн орон нутгийн хотыг мөн хамруулах талаар судалж үзнэ. Туршилтын төсөлд хяналт тавьсанаар тулгарч байгаа хүндрэл бэрхшээл, мөн олж авсан сургамжийг нэгтгэж гаргана.
- Бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээ үзүүлэх ажиллагааг сайжруулахын тулд төрөөс орон нутаг руу чиглэсэн мониторинг/үнэлгээ хийж хэрэгжүүлэх чиглэлээр ажиллана. Мөн дэмжлэг үзүүлэх явцад үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар судалж үзэхдээ, үйлчилгээг голлон үзүүлэгч хувийн хэвшлийг бэлтгэх, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх боломжийн талаар мөн судалж үзнэ. Улмаар хувийн хэвшилд зохицуулалт хийж,

хяналт тавих үүднээс, нийгмийн халамж/хөдөлмөр эрхлэлт хариуцсан ажилтны үүргийг тодорхой болгож, мониторинг/үнэлгээ хийх тогтолцоог бэхжүүлнэ.

Ядуу, эмзэг бүлгийн иргэд бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хангамжийг тасралтгүй хөгжүүлэх зорилгоор хөрвөх боломжтой санхүүгийн эх үүсвэрийг судалж үзэх замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийг хангах, зээлийн эргэн төлөлтийг нэмэгдүүлэх зэрэг санхүүжилтийн бүтцэд дүн шинжилгээ хийж, төслийн үйл ажиллагааны тогтвортой, тасралтгүй байдлыг хангаж ажиллах шаардлагатай.

Мөн ашиглах материал, анхаарах зүйл болгон 6-р бүлэгт мөн танилцуулсан, АХБ-ны хэрэгжүүлж буй “Second Shock-Responsive Social Protection Project-Цочролд хариу үзүүлэх нийгмийн хамгааллын 2 дахь төсөл (зээл)”-ийн талаар дурьдаж байна. Энэ төслийн үзэл санаа нь өмнө өгүүлсэн, бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээтэй ижил төстэй тул төсөл хэрэгжүүлэх тал дээр, харилцан мэдээлэл солилцож, үйл ажиллагааг давхардуулахаас зайлсхийх шаардлагатай.

2021 оны 8-р сараас 2023 оны 3-р сар хүртэл АХБ-ны төсөл хэрэгжинэ. Уг төсөл нь ядуу өрхийн хүүхдэд олгох тэтгэмжийг түр хугацаанд санхүүжүүлж, коронавирусын цар тахлын үед нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөг сөрөг багасгах зорилготой. Мөн нийгмийн халамжийн хөтөлбөр, тогтолцоог бэхжүүлэхийн тулд ӨМНС болон e-halamj цахим сайтыг сайжруулахын зэрэгцээ Улаанбаатар хотын гурван дүүрэгт (Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг) амьдарч буй “Хүүхдийн мөнгө”, “Хүнсний эрхийн бичиг” хөтөлбөрт хамрагддаг хөдөлмөрийн насны 1,520 иргэнийг “тэтгэмжээс хамааралгүй бие даан амьдардаг болгох”-д чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

АХБ-ны “тэтгэмжээс хамааралгүй бие даан амьдардаг болгох” аргачлал нь голчлон (1) бэлэн мөнгө олгох, эсвэл хүнс олгох, (2) амьжиргааг дээшлүүлэх зорилгоор хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах (тухайлбал, мал, дэлгүүрийн лангуу, оёдлын машин гэх мэт), (3) технологи (тоног төхөөрөмж ашиглах арга)-ийн мэдлэг, бизнесийн чадвар, санхүүгийн мэдлэг олгох сургалт зохион байгуулах, (4) сургагч багш тогтмол дадлагжуулж, зөвлөгөө өгөх гэсэн 4 үйл ажиллагаанаас бүрддэг.

Нөгөө талаар, манай орны зүгээс тусламж үзүүлэх магадлалтай, бидний санал оруулж буй, бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээг нэвтрүүлэх үйл ажиллагаа нь коучинг хийх ба сэтгэлзүйн зөвлөгөө өгөхөөс гараагаа эхлэх ба бие даан амьдрахад чиглэсэн ганцаарчилсан төлөвлөгөөн дээр үндэслэн, дэмжлэг үзүүлэх олон төрлийн агуулгаас (орон байраар хангах, хөдөлмөрт бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, онцгой тохиолдолд дэмжлэг үзүүлэх, өрхийн санхүүг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хүүхдийн сурч боловсроход дэмжлэг үзүүлэх) сонголт хийж ажиллах аргачлал юм. Уг үйлчилгээний процест тэтгэмжийг оновчтой болгох, нийгмийн халамж болон хөдөлмөр эрхлэлтийг уялдуулах, бусад яам, хувийн хэвшилтэй хамтран ажиллах, орон нутагт түшиглэсэн хамтын ажиллагааг хөгжүүлэх, системчилсэн мониторинг, үнэлгээ хийх, санхүүгийн эх үүсвэрийг хангах зэрэг цогц арга хэмжээ, үйлчилгээ хамаарна.

Мөн, бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээ нэвтрүүлэх тал дээр, шаардлагатай бол Монголын нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, тусламжийн тогтолцоотой холбоотой зөвлөмж өгч ажиллах тохиолдол бий болж болзошгүй гэж үзэж байна. Тэр үед долоо дугаар бүлэгт

үзүүлсэнээр, засгийн газрын улс төрийн чанартай шийдвэр, коронавируст халдвар мэтийн нийгмийн нөхцөл байдлын өөрчлөлт нөлөөлж болзошгүй учраас болгоомжтой хандах шаардлагатай. Нөгөө талаар, Монголын нийгмийн хамгааллын салбар дахь дунд, урт хугацааны дэмжлэгийг хөгжүүлэхийн тулд тэтгэмж, туслалцааны тогтолцооны асуудлыг огт хөндөхгүй биш, хөндлөнгөөс зөвлөгөө өгөх, санал боловсруулж оруулах зэргээр хамтарч ажиллах магадлтай тул дараах асуудлуудыг анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

Тэтгэмжийн агуулга, олгох аргачлалыг сайжруулах чиглэлээр дэмжлэг туслалцаа үзүүлэх тохиолдолд, нийгмийн халамжийн бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмж тусламж болон үйлчилгээний талаар нарийвчилсан үнэлгээ явуулах нь чухал юм. Тэр тохиолдолд, ХНХЯ-наас эхлээд холбогдох байгууллагуудын хамт хөтөлбөр тус бүрийн үр дүнтэй, үр өгөөжтэй байдлын талаар хангалттай судалж үзэх шаардлагатай. Жишээлбэл, техникийн хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлэх зэрэг бодит дэмжлэг үзүүлэхтэй зэрэгцүүлэн, нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг үнэлэх үүрэг, функцийг тусгаж оруулж болно гэж үзэж байна.

Улмаар тэтгэмж тусламжтай холбоотой нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр, шаардлагатай бол манай орны (Японы) төрд ажилласан туршлагатай мэргэжилтнүүдийг томилон, тэтгэмжийн хэмжээ ба олгох хугацааг зохицуулахдаа, тэтгэмж хүртэгчийн хэрэгцээ ба орлогод үндэслэн тогтоох боломжийг судлах судалгааг тусад нь явуулахыг санал болгож байна. Жишээлбэл, ядуу өрхийн амьжиргааны доод түвшинг коронавирусын цар тахлын дараах нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд уялдуулан тооцож, нэг өрхөд ногдох нийгмийн халамжийн тэтгэврийн дээд хязгаар болон тэтгэврийн хэмжээг ялгаатай тогтоох боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийнэ. Энэ тохиолдолд бид Японы ядуу айл өрхөд олгодог тэтгэмжийн хэмжээ, хугацааг тодорхойлох аргыг танилцуулж, харьцуулж судлан, Монголын холбогдох ажилтнуудын чадавхийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулж ажиллана.

② Ахмад настныг дэмжих бодлого

Энэхүү тайлангийн тавдугаар бүлэгт дурдсанчлан 65-аас дээш насны хүн амын эзлэх хувь 2019 онд 4.2% байсан ба 2050 онд 12.0% болж, бага, дунд орлоготой орнуудын дундаж үзүүлэлтээс давах төлөвтэй байна. Цаашид өндөр хурдтайгаар насжилт явагдана гэсэн прогнозтой байна. Засгийн газар ахмад настан болон тэдний гэр бүлд нийгмийн даатгалын тэтгэвэр болон халамжийн тэтгэвэр, асран халамжлагчийн тэтгэмж, гэрээт ТББ, хувийн хэвшлийн компанид түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ, мэргэжлийн байгууллагуудын асрамжийн үйлчилгээ гэх мэт төрөл бүрийн дэмжлэг үзүүлж байна.

Асаргааны ажилтны мэргэшлийн тогтолцоо байхгүй, боловсон хүчинд тавигдах шаардлага хуулинд тусгагдаагүй, сургалтын тогтолцоо бүрдээгүй байна. Иймд юуны өмнө улсын асрамжийн тусламж үйлчилгээний чиглэлийг тодорхойлох алсын харааг уг судалгаагаар тодорхойлно. Холбогдох яам, агентлагуудтай холбоотой ажиллаж, алсын хараатай уялдуулан халамжийн хүний нөөцийн тогтолцоог бүрдүүлнэ. Мөн олон нийтэд түшиглэсэн халамжийн тогтолцоог бүрдүүлэхийн тулд халамжийн үйлчилгээ үзүүлдэг хувийн компани, ТББ-уудын үйл ажиллагааг дэмжиж, менежментийн тогтолцоог нь бэхжүүлж, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжиж

ажиллана. Мөн хуучирсан асрамжийн төвийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн асуудлыг шийдэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

А) Хамтын ажиллагааны өмнөх бэлтгэл судалгаа

- Асрамжийн тусламж үйлчилгээний чиглэлийг тодорхойлохын тулд холбогдох яам, агентлагуудтай уялдаа холбоотой ажиллах
- Асаргааны даатгалын тогтолцоог нэвтрүүлэх боломжийг судлахын тулд асрамжийн тусламж үйлчилгээгээр хангах бодлогын шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлж ажиллана. Тухайлбал, хөгжингүй орнууд болон Монголтой ижил төстэй бага, дунд орлоготой орнуудын асрамжийн тусламж үйлчилгээний тогтолцоо, ялангуяа нийгмийн даатгалын арга хэлбэр, татварын орлогын эх үүсвэрээр асрамжийн үйлчилгээ үзүүлэх давуу болон сул тал, тэдгээрийг Монголд хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар судлахад дэмжлэг үзүүлж ажиллана.
- Асаргааг дэмжих орчныг бүрдүүлэхийн тулд төр, хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлнэ (үүнд санхүүгийн дэмжлэг багтана) .
- Хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих хууль эрхзүйн орчинг бүрдүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг төрөл бүрийн санаачилгыг судлахын зэрэгцээ тодорхой түвшний чанар хангасан мониторинг үнэлгээ, үйл ажиллагааг дэмжих тогтолцоог бүрдүүлэхэд хамтарч ажиллана.

В) Япон дахь сургалт

- ХНХЯ, ЭМЯ, холбогдох байгууллагын төрийн албан хаагчдад зориулж Японы өндөр настны асрамжийн талаар сургалт зохион байгуулж, тэдний чадавхийг бэхжүүлэхэд анхаарч ажиллана. Тухайлбал, ЭМЯ, ХНХЯ, орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн цогцолбор төвүүд, эрүүл мэндийн төвүүд, ахмадын тусгай асрамжийн газар, хувийн асрамжийн газрууд, гэрээр ирж асаргаа үзүүлэх асрамжийн газрууд, асрамж халамжийн ажилтан бэлтгэх сургууль, нийгмийн халамжийн ажилтан бэлтгэх сургууль гэх мэт.

С) Халамжийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх техникийн хамтын ажиллагааны төсөл

Алсын хараатай уялдуулан халамжийн салбарын хүний нөөцийн тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана. Тухайлбал, халамж, эрүүл мэндийн салбарын мэргэжилтэн сургаж бэлтгэх болон мэргэшүүлэх тогтолцоо, сургалтын хөтөлбөр (лекц, дасгал ажил, практик дадлага), ажлын орчин, ажлын агуулга зэргийг судалж, дүн шинжилгээ хийн, шаардлагатай тогтолцоог бүрдүүлнэ. Мэргэшсэний дараах хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийн тулд ажилд орох болон ажлын байраа өөрчлөх, ажлаас гарсны дараа дахин ажил олох зэрэгт нь туслах механизмыг судална. Мөн эрүүл мэнд, халамж, боловсролын салбарт Японы Гадаад улстай хамтран ажиллах сайн дурынхны байгууллагатай хамтран ажиллана.

【Хавсралт】

Хавсралт 1: Нийгмийн хамгааллын салбарт дэмжлэг тусалцаа үзүүлж байгаа донор
байгууллагуудын жагсаалт

Хавсралт 2: Хувийн хөдөлмөр зуучлалын байгууллагын жагсаалт

Хавсралт 3: Эрүүл насжилт, настны эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийн үнэлгээ (албан бус орчуулга)

【Ашигласан материал】

Ашигласан материал 1: Монголд хийгдэх судалгааны хуваарь

Ашигласан материал 2: Ярилцлага авсан хүмүүсийн жагсаалт

Ашигласан материал 3: Цуглуулсан материалын жагсаалт